

Улсын бүртгэлийн  
дугаар .....

Нууцын зэрэглэл:

Аравтын бүрэн  
Ангиллын код

Төсөл гүйцэтгэх гэрээний  
дугаар: ШУС -2018/43

БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ ИННОВАЦИЙН ТӨВ

# ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ОНОЛ, АРГА ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Суурь судалгааны төслийн тайлан  
2018-2019

**Төслийн удирдагч:**

Ж.Эрхэмтөгс, Доктор (Ph.D), дэд профессор,  
Бүтээлч үйлдвэрлэл инновацийн төвийн захирал

**Санхүүжүүлэгч байгууллага:**

БШУЯ-ны Шинжлэх ухаан, технологийн сан

**Захиалагч байгууллага:**

БШУЯ-ны Шинжлэх ухааны газар

**Гүйцэтгэгч байгууллага:**

Бүтээлч үйлдвэрлэл инновацийн төв  
Улаанбаатар, Баянгол дүүрэг, 1-р хороо  
Утас: 91012144

## **АГУУЛГА**

<b>УДИРТГАЛ .....</b>	<b>3</b>
<b>ХҮСНЭГТ, ЗУРАГ, ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТУУД .....</b>	<b>4</b>
1. Хүснэгтийн жагсаалт .....	4
2. Зургийн жагсаалт .....	7
3. Хавсралтын жагсаалт .....	8
<b>БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....</b>	<b>9</b>
1.1. Төслийн төлөвлөлт, зохион байгуулалт .....	9
1.2. Судалгааны арга зүй, аргачлал .....	11
<b>БҮЛЭГ 2. ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАНАРЫГ ҮНЭЛЭХ ОНОЛ, АРГА ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ .....</b>	<b>21</b>
2.1. Дээд боловсрол .....	21
2.2. Дээд боловсролын чанар .....	24
2.3. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанар .....	29
2.4. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежмент .....	32
2.5. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн тогтолцоо .....	43
2.6. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын стандартчилал ...	49
2.7. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний систем .....	55
2.8. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний үзүүлэлтүүд .....	65
2.9. Дээд боловсролын сургалтын байгууллага ба үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны чанарын үнэлгээ .....	75
2.10. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанар ба хөдөлмөрийн зах зээлийн эрэлт .....	78

2.11. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанар ба их сургуулиудын рейтингийн үнэлгээ .....	90
2.12. Дээд боловсролын сургалтын байгууллагын судалгааны чанарын үнэлгээ.....	95
2.13. Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэл .....	106
<b>БҮЛЭГ 3. МОНГОЛЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ЧАНАРЫН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ.....</b>	<b>117</b>
3.1. Дээд боловсролын сургалтын байгууллагуудын хөгжлийн өнөөгийн төлөв байдал .....	117
3.2. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарт үнэлгээ хийж буй өнөөгийн байдал .....	139
3.3. Дээд боловсролын сургалтын байгууллагуудын чанарын төлөвшлийн үнэлгээ .....	147
3.4. Дээд боловсрол ба хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт .....	165
3.5. Дээд боловсрол ба ажил олгогчдын үнэлэмжийн судалгаа .....	173
3.6. Дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн хандлагын судалгаа .....	181
<b>БҮЛЭГ 4. НИЙГМИЙН УХААНЫ ЧИГЛЭЛЭЭР СУРГАЛТ ЯВУУЛДАГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАНАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ .....</b>	<b>192</b>
<b>ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ .....</b>	<b>247</b>
<b>НОМ ЗҮЙ .....</b>	<b>255</b>

## УДИРТГАЛ

**Төслийн нэр:** *Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл*

**Гэрээний дугаар:** ШУС -2018/43

**Төслийн захиалагч:** БШУЯ

**Төслийн санхүүжүүлэгч:** ШУТС

**Төслийн гүйцэтгэгч:** Бүтээлч үйлдвэрлэл инновацын төв

**Төслийн багийн бүрэлдэхүүн:**

**Төслийн удирдагч:** Ж.Эрхэмтөгс, доктор, дэд профессор,

**Төслийн багийн гишүүд:**

1. Ж.Тогтох, доктор, профессор,\
2. Н.Наранчимэг, доктор, профессор,
3. М.Гэрэлмаа, доктор,
4. Б.Баярмаа, докторант,
5. Б.Алтанчимэг, докторант,

**Гэрээт судлаачид:**

1. Л.Оюунцэцэг, доктор, профессор,
2. Б.Мөнхцэцэг, доктор, профессор,
3. М.Заяа, доктор
4. Д.Цэнгэл, доктор,
5. Ч.Жүгдэрнамжил, доктор,
6. Ц.Алтанцэцэг, доктор,
7. М.Энхээ, докторант,
8. А.Энхцэцэг, докторант,
9. Ж.Эрдэнэбат, докторант
10. Д.Хэрлэн, магистр,
11. Б.Хүдэрчулуун, магистр,
12. Б.Мөнгөнтуул, магистр,
13. Б.Шинэбаяр, магистр,
14. М.Энхмаа, магистр
15. Д.Амарзаяа, магистр,
16. Ш.Оюундэлгэрэх, докторант
17. Н.Туул, магистр,
18. Ц.Амархишиг, магистр,
19. Д.Амаржаргал, магистр,

## ЗУРАГ, ХҮСНЭГТ, ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТУУД

### 1. Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. 1. Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө.....	10
Хүснэгт 1.2. Судалгаа, боловсруулалтын арга зүйн матриц .....	11
Хүснэгт 1.3. ДБСБ-ын чанарын үнэлгээний судалгаа, боловсруулалтын хамрах хүрээ.....	12
Хүснэгт 1.4. ДБСБ-ын өнөөгийн байдлын судалгаа, боловсруулалтын хамрах хүрээ.....	13
Хүснэгт 1.5. ДБСБ-ын чанарт үнэлгээ хийж буй олон улсын туршлагын судалгаа, боловсруулалтын хамрах хүрээ.....	14
Хүснэгт 1.6. Тоон ба чанарын судалгааны харьцуулалт .....	15
Хүснэгт 1.7. Судалгааны өгөгдөл шинжлэх арга зүй .....	15
Хүснэгт 1.8. Социологийн судалгаа, боловсруулалтын хамрах хүрээ .....	16
Хүснэгт 1.9. Магадлалт түүвэрлэлтийн аргуудын харьцуулалт .....	17
Хүснэгт 1.10. Түүврийн хэмжээ тооцох аргачлалын харьцуулалт .....	19
Хүснэгт 1.11. Түүврийн хэмжээний хүснэгт (итгэх түвшин-95%, алдааны хязгаар-5% байх үеийн түүврийн зохимжтой хэмжээ) .....	19
Хүснэгт 2.1. Чанарын менежментийн судалгаанд ашиглаж буй судалгааны аргуудын харьцуулалт, хувиар .....	34
Хүснэгт 2.2. Чанарын менежментийн судалгааны тойм .....	35
Хүснэгт 2.3. Чанарын менежментийн онолын судалгааны тойм .....	36
Хүснэгт 2.4. Чанарын менежментийн эмпирик судалгааны тойм .....	37
Хүснэгт 2.5. Боловсролын сэтгүүлд хэвлэгдсэн чанарын менежментийн судалгааны тойм.....	38
Хүснэгт 2.6. Чанарын менежментийн хэмжээснүүдийн судалгааны тойм....	39
Хүснэгт 2.7. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн хэмжээснүүд.....	40
Хүснэгт 2.8. Дээд боловсролын сургалтын байгууллагад ISO 9001 стандарт нэвтрүүлэлтийн судалгааны тойм.....	49
Хүснэгт 2.9. ISO 9001:2015 ба ISO 21001:2018 стандартуудын харьцуулалт .....	51
Хүснэгт 2.10. ISO 21001:2018 стандартын бүтэц ба хамрах хүрээ.....	53
Хүснэгт 2.11. Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд тавих Боодрижийн шалгуур үзүүлэлт .....	61
Хүснэгт 2.12. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний хүчин зүйлийн матриц.....	68
Хүснэгт 2.13. Сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээний шалгуур, хувиар .....	69
Хүснэгт 2.14. Сургалтын орчны чанарын үнэлгээний шалгуур, хувиар.....	69
Хүснэгт 2.15. Цахим үйлчилгээний чанарын үнэлгээний шалгуур, хувиар ...	70
Хүснэгт 2.16. Багшлахуйн чанарын үнэлгээний шалгуур, хувиар .....	70
Хүснэгт 2.17. Оюутныг дэмжих үйлчилгээний чанарын үнэлгээний шалгуур, хувиар.....	70
Хүснэгт 2.18. Номын сангийн үйлчилгээний чанарын үнэлгээний шалгуур, хувиар.....	71
Хүснэгт 2.19. Захиргааны үйлчилгээний чанарын үнэлгээний шалгуур, хувиар .....	71

Хүснэгт 2.20. Дэд бүтцийн чанарын үнэлгээний шалгуур, хувиар .....	72
Хүснэгт 2.21. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин, хувиар .....	73
Хүснэгт 2.22. Хамтын ажиллагааны чанарын шалгуур .....	77
Хүснэгт 2.23. Ирээдүйн ажлын байранд шаардлагатай ерөнхий ур чадварууд .....	84
Хүснэгт 2.24. Мэргэшлийн хүрээ ба дээд боловсролын хүрээний харьцуулалт .....	87
Хүснэгт 2.25. Их, дээд сургуулиудын чансаа тогтоох зарим системүүд ....	91
Хүснэгт 2.26. Зохиогчийн түвшний нөлөөллийн индексүүдийн харьцуулалт .....	103
Хүснэгт 2.27. Сэтгүүлийн түвшний нөлөөллийг тодорхойлдог индексүүдийн харьцуулалт .....	104
Хүснэгт 3.1. Дээд боловсролын тухай хуулиуд .....	117
Хүснэгт 3.2. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо .....	124
Хүснэгт 3.3. Дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн багшийн тоо ..	126
Хүснэгт 3.4. Боловсролын олон улсын стандарт ангилал (ISCED) .....	128
Хүснэгт 3.5. Дээд боловсролын мэргэжлийн чиглэлийн шинэчлэлт .....	130
Хүснэгт 3.6. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын тоо .....	132
Хүснэгт 3.7. Нийгмийн болон зан харилцааны шинжлэх ухаан чиглэлээр сургалт явуулдаг сургууль .....	134
Хүснэгт 3.8. Нийгмийн болон зан харилцааны шинжлэх ухаан чиглэлээр сургалт явуулдаг сургууль болон тухайн хөтөлбөрөөр суралцагчдын тоо .....	136
Хүснэгт 3.9. Дээд боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийн тоо .....	137
Хүснэгт 3.10. Дээд боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийн боловсролын зэрэг .....	138
Хүснэгт 3.11. Боловсролын магадлан итгэмжлэлтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүдийн нэгтгэл .....	139
Хүснэгт 3.12. Байгууллагын магадлан итгэмжлэх үйл явцын тоон үзүүлэлтүүд	141
Хүснэгт 3.13. Дээд боловсролын салбарын магадлан итгэмжлэлийн явц .....	142
Хүснэгт 3.14. Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо .....	143
Хүснэгт 3.15. Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо .....	143
Хүснэгт 3.16. Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүйн хөтөлбөрийн магадлан итгэмжлэл .....	144
Хүснэгт 3.17. Судалгаанд оролцогчдын албан тушаал ба ажилласан жилийн хамаарал, хувиар .....	148
Хүснэгт 3.18. Судалгаанд оролцогчдын албан тушаал ба боловсролын зэргийн хамаарал, хувиар .....	149
Хүснэгт 3.19. Дээд боловсролын сургалтын байгууллагууд чанарын талаар баримтлах бодлогоо тодорхойлсон байдал, хувиар .....	150
Хүснэгт 3.20. Дээд боловсролын сургалтын байгууллагын стратеги төлөвлөгөөнд чанарын асуудал тусгагдсан байдал, хувиар .....	150
Хүснэгт 3.21. Сургуулийнхаа чанарын бодлого, зарчим, зорилготой санал нийлдэг байдал, хувиар .....	151
Хүснэгт 3.22. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын бодлого, зарчим, зорилго нь сонирхогч талуудад нээлттэй эсэх, хувиар .....	152
Хүснэгт 3.23. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын бодлого, зарчимтай хариуцаж буй ажлын нийцэл, хувиар .....	152

Хүснэгт 3.24. Хариуцаж буй ажилдаа PDCA мөчлөгийг ашиглаж хэвшсэн байдал, хувиар.....	153
Хүснэгт 3.25. Дээд боловсролын сургалтын байгууллага нь үйл ажиллагаандаа PDCA мөчлөгийг баримталдаг байдал, хувиар .....	153
Хүснэгт 3.26. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанар хариуцсан нэгжийн төлөвшил, хувиар .....	154
Хүснэгт 3.27. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын дотоод баталгаажуулалтад тулгарч буй бэрхшээлүүд, хувиар.....	154
Хүснэгт 3.28. Дээд боловсролын сургалтын байгууллагад ашиглах боломжтой чанарын дотоод баталгаажуулалтын хэлбэрүүд, хувиар.....	157
Хүснэгт 3.29. Дээд боловсролын сургалтын байгууллагад чанартай холбоотой дүрэм, журам ашигладаг байдал, хувиар .....	157
Хүснэгт 3.30. Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын гарын авлага ашигладаг байдал, хувиар.....	158
Хүснэгт 3.31. Дээд боловсролын сургалтын байгууллагад дотоод чанарын баталгаажуулалтын үнэлгээний арга хэрэгслүүд, хувиар.....	159
Хүснэгт 3.32. Дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтад ажил олгогчдын оролцоо, хувиар .....	160
Хүснэгт 3.33. Дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтад төгсөгчдийн оролцоо, хувиар .....	161
Хүснэгт 3.34. Дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтын өгөөж дээшлүүлэлт, хувиар .....	162
Хүснэгт 3.35. Дээд боловсролын сургалтын байгууллага магадлан итгэмжлэгдсэн (сургууль, хөтөлбөр)-ээр чанарт гарсан ахиц, хувиар.....	164
Хүснэгт 3.36. Их, дээд сургуулийн төгсөгчдийн судалгаанд хамрагдалт .....	166
Хүснэгт 3.37.Төгсөгчдийн эдийн засгийн идэвх, хувиар.....	166
Хүснэгт 3.38.Төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн харьцуулалт, хувиар .....	166
Хүснэгт 3.39.Төгсөгчдийн ажлын байрны хэлбэрүүд, хувиар .....	167
Хүснэгт 3.40.Төгсөгчдийн ажлын байрны харьцуулалт, хувиар .....	167
Хүснэгт 3.41.Төгсөгчдийн ажилд ороход нөлөөлсөн хүчин зүйлс, хувиар .....	168
Хүснэгт 3.42.Төгсөгчдийн мэргэжил ба ажлын байрны нийцэл, хувиар .....	168
Хүснэгт 3.43.Төгсөгчдийн эзэмшсэн ур чадвар ба ажлын байрны шаардлагын нийцэл, хувиар .....	169
Хүснэгт 3.44.Төгсөгчдийн суралцах хугацаандаа олж авсан мэдлэгийн хэрэглээ, хувиар.....	169
Хүснэгт 3.45.Төгсөгчдийн ур чадвараа эзэмшсэн байдал, хувиар .....	169
Хүснэгт 3.46.Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт ба мэргэжил, хувиар.....	170
Хүснэгт 3.47.Төгсөгчдийн мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлт, хувиар.....	170
Хүснэгт 3.48.Судалгаанд хамрагдагчдын байдал .....	174
Хүснэгт 3.49. Дээд боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийн ерөнхий ур чадварын нэгдсэн үнэлгээ .....	178
Хүснэгт 3.50.Судалгаанд хамрагдагчдын боловсролын байдал.....	183
Хүснэгт 3.51.Их, дээд сургууль төгсөгчдийн чадамжийн өөрийн үнэлгээ, хувиар	184
Хүснэгт 3.52.Ажил хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай нийтлэг ур чадварууд .....	188
Хүснэгт 3.53. Ажил хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай нийтлэг ур чадвар ба мэргэжлийн чиглэл .....	189
Хүснэгт 3.54. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад эзэмшүүлэх шаардлагатай ур чадварууд .....	190



Хүснэгт 3.55. Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын чанарыг сайжруулахад нөлөөлөх хүчин зүйлс..... 191

## 2. Зургийн жагсаалт

Зураг 1.1. Судалгааны арга зүйн суурь загвар.....	11
Зураг 2. 1. Дээд боловсролын сургалтын байгууллагын нэгдсэн.....	30
Зураг 2.2. Дээд боловсролын сургалтын байгууллагын.....	31
Зураг 2.3. Дээд боловсролын сургалтын байгууллагын.....	46
Зураг 2.4. Дээд боловсролын сургалтын байгууллагын.....	47
Зураг 2.5. ISO 21001 стандарт ба дээд боловсрол.....	51
Зураг 2.6. Чанарын үнэлгээний систем.....	56
Зураг 2.7. Чанарын үнэлгээний босоо ба хэвтээ интеграци.....	57
Зураг 2.8. 6 Сигма, түүний үе шат.....	63
Зураг 2.9. Дээд боловсролын сургалтын.....	67
Зураг 2.10. Дээд боловсролын сургалтын байгууллагын.....	73
Зураг 2.11. Олон улсын ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн.....	79
Зураг 2.12. Хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлт, ур чадварын.....	80
Зураг 2.13. Ажил байрны ирээдүйн төлөв байдал.....	81
Зураг 2.14. Ажил мэргэжил, ур чадварын ирээдүйн төлөв.....	83
Зураг 2.15. Мэргэшлийн болон боловсролын хүрээ.....	87
Зураг 2.16. Үндэсний мэргэшлийн хүрээний суурь загвар.....	89
Зураг 3.1. Дээд боловсролын сургалтын байгууллагын динамик.....	122
Зураг 3.2. Дээд боловсролын сургалтын байгууллагын.....	125
Зураг 3.3. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын динамик.....	132
Зураг 3.4. Дээд боловсролын сургалтын байгууллага.....	135
Зураг 3.5. Судалгааны түүвэрлэлтийн зарчим.....	147
Зураг 3.6. Судалгаанд оролцогчдын албан тушаал ба ажилласан жил хувиар.....	148
Зураг 3.7. Судалгаанд оролцогчдын боловсролын зэрэг ба эрдмийн цол, хувиар.....	149
Зураг 3.8. Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын удирдлагын зарчмуудаас хэрэгжиж хэвшсэн байдал, хувиар.....	151
Зураг 3.9. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын дотоод оролцогч талууд, хувиар.....	155
Зураг 3.10. Дээд боловсролын сургалтын байгууллагад ашиглаж буй чанарын дотоод баталгаажуулалтын хэлбэрүүд, хувиар.....	156
Зураг 3.11. Дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтын үнэлгээний арга хэрэгслүүд, хувиар.....	159
Зураг 3.12. Дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтын өгөөж, дээшлүүлэлт хувиар.....	162
Зураг 3.13. Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэгдсэн байдал, хувиар.....	164
Зураг 3.14. Сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн байдал, хувиар.....	164
Зураг 3.15. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт ба мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлтийн харьцуулалт, хувиар.....	172



<i>Зураг 3.16. Дээд боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийн ерөнхий ур чадварын үнэлгээ .....</i>	<i>175</i>
<i>Зураг 3.17. Дээд боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийн ерөнхий ур чадварын зөрүүний шинжилгээ .....</i>	<i>177</i>
<i>Зураг 3.18. Аж ахуйн нэгжүүд их, дээд сургуулиудтай хамтран ажиллах боломж, хувиар.....</i>	<i>180</i>
<i>Зураг 3.19. Судалгаанд хамрагдагчдын их, дээд сургууль төгсөгчдийн тоо .....</i>	<i>183</i>
<i>Зураг 3.20. Их, дээд сургууль төгсөгчдийн чадамжийн өөрийн үнэлгээ ....</i>	<i>184</i>

### **3. Хавсралтын жагсаалт**

1. Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө,
2. Төслийн судалгааны арга зүй, аргачлал,
3. Эрдэм шинжилгээний хурал, семинарын тайлан,
4. Хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллүүд,

## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **1.1. Төслийн төлөвлөлт, зохион байгуулалт**

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”* сэдэвт суурь судалгааны төслийг хэрэгжүүлэхээр БСШУСЯ болон ШУТС-тай байгуулсан “ШУС -2018/43” тоот гурван талт гэрээнд тусгагдсан *“Төслийн үр дүнгийн даалгавар”*, *“Төслөөр гүйцэтгэх ажлын календарчилсан төлөвлөгөө”* зэргийг үндэслэн төслийн зорилго, зорилтуудыг дараах байдлаар тодорхойлж хэрэгжүүлсэн.

**Төслийн зорилго, зорилт:** Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний талаарх онол, арга зүйг судалсны үндсэн дээр Монголын дээд боловсролын сургалтын байгууллагуудын чанарын төлөв байдлыг үнэлж, зөвлөмж боловсруулах.

Төслийн хүрээнд дэвшүүлсэн зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж, шийдвэрлэсэн. Үүнд:

1. Нийгмийн ухааны чиглэлээр сургалт явуулдаг дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийж буй байдлыг судалсны үндсэн дээр онол, арга зүйн үндэслэл боловсруулах,
2. Судалгааны үр дүнгээр эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлж, илтгэл хэлэлцүүлэх,
3. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарт үнэлгээ хийх онол, арга зүйн асуудлаар семинар, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах,
4. Нийгмийн ухааны чиглэлээр сургалт явуулдаг дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх талаар бодлогын зөвлөмж боловсруулах,
5. Судалгааны үр дүнгээр нэг сэдэвт бүтээл хэвлүүлэх.


Энэхүү зорилтуудын хүрээнд судалгаа, боловсруулалтын ажлыг дараах төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн (эх хувийг хавсаргав).

Хүснэгт 1. 1.Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2018 он										2019 он											
		4	5	6	7	8	9	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1	Судалгааны арга зүй боловсруулах, батлуулах	■	■																				
2	ДБСБ-ын чанарын үнэлгээний талаар эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах			■	■																		
3	Манай улсад ДБСБ-ын чанарт үнэлгээ хийж буй өнөөгийн байдлыг судлах		■	■	■	■	■	■															
4	Манай улсад нийгмийн ухааны чиглэлээр сургалт явуулдаг ДБСБ-ын өнөөгийн байдлыг судлах		■	■	■	■	■	■															
5	Төслийн үр дүнгээр эрдэм шинжилгээний эмхэтгэл хэвлэх									■	■	■											
6	Явцын тайлан бичиж, хүргүүлэх									■	■	■											
7	Олон улсад нийгмийн ухааны чиглэлээр сургалт явуулдаг ДБСБ-ын чанарт үнэлгээ хийж буй туршлагыг судлах												■	■	■	■	■						
8	Төслийн хүрээнд социологийн судалгаа авах												■	■	■	■	■						
9	Эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлж, илтгэл хэлэлцүүлэх															■	■	■	■	■	■		
10	Явцын тайлан бичиж, хүргүүлэх															■							
11	Төслийн үр дүнгээр ЭШХ зохион байгуулах																			■	■		
12	Судалгааны чиглэлээр нэг сэдэвт бүтээл хэвлэх																		■	■	■	■	■
13	Нийгмийн ухааны чиглэлээр сургалт явуулдаг ДБСБ-ын чанарт үнэлгээ хийх талаар бодлогын зөвлөмж боловсруулах																					■	■
14	Төслийн эцсийн тайлан бичиж, хүргүүлэх																					■	■

## 1.2. Судалгааны арга зүй, аргачлал

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний онол, арга зүйн судалгаа, боловсруулалтын ажлыг дараах гурван шатлалт (*Арга зүй - Судалгаа - Боловсруулалт*) судалгааны арга зүйн загварт тулгуурлан хийсэн.



**Зураг 1.1. Судалгааны арга зүйн суурь загвар**

Судалгааны аргыг i) мэдээ баримт цуглуулах арга, ii) баримт боловсруулах арга гэсэн байдлаар сонгосон. Судалгааны арга сонгох үндэслэлийг тухайн асуудлыг аль болох илрүүлж чадах хэд хэдэн аргыг хослуулах ашиглахдаа тухайн арга тус бүрийг ямар зорилгоор аль үе шатанд хэрэглэж судалгаа, боловсруулалтын ажлыг нарийн төлөвлөсөн. Судалгааны арга зүйн суурь загварт тулгуурлан төслийн хүрээнд хийх судалгаа, боловсруулалтын арга зүйн матрицыг доорх байдлаар боловсруулж, баримталж ажилласан.

**Хүснэгт 1.2. Судалгаа, боловсруулалтын арга зүйн матриц**

№	Судалгааны үндсэн чиглэлүүд	Судалгаа, шинжилгээний аргууд				
		Баримт бичгийн судалгаа	Түүвэр судалгаа	Тоон шинжилгээ	Чанарын шинжилгээ	Нөхцөл байдлын шинжилгээ
1	Нийгмийн ухааны чиглэлээр сургалт явуулдаг ДБСБ-ын өнөөгийн байдлыг судлах	≡		≡	≡	≡
2	ДБСБ-ын чанарт үнэлгээ хийж буй өнөөгийн байдлыг судлах	≡	≡	≡	≡	≡

3	Олон улсад нийгмийн ухааны чиглэлээр сургалт явуулдаг ДБСБ-ын чанарт үнэлгээ хийж буй туршлагыг судлах	‡		‡	‡	‡
4	ДБСБ-ын чанарын талаар социологийн судалгаа авах		‡	‡	‡	‡
5	Нийгмийн ухааны чиглэлээр сургалт явуулдаг ДБСБ-ын чанарт үнэлгээ хийх талаар бодлогын зөвлөмж боловсруулах					‡

Дээрх хүснэгтэд тодорхойлсон судалгаа, боловсруулалтын ажлын хүрээнд сонгосон судалгааны аргын онцлогт тохирсон зорилго, агуулга, хэрэглэх материал хэрэглэгдэхүүн (эх үүсвэр), хамрах хүрээ зэргийг дараах байдлаар боловсруулсан.

**1. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарт үнэлгээ хийж буй өнөөгийн байдлын судлах:**

Энэхүү судалгааг i) Магадлан итгэмжлэлийн бодлого, эрх зүйн орчин, ii) Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэл, iii) Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл гэсэн үндсэн чиглэлээр судалгаа, боловсруулалтын ажлыг дараах хүснэгтэд тодорхойлсон хүрээнд хийсэн.

**Хүснэгт 1.3. ДБСБ-ын чанарын үнэлгээний судалгаа, боловсруулалтын хамрах хүрээ**

№	Үндсэн чиглэлүүд	Судлах асуудлууд	Эх үүсвэр
1	Магадлан итгэмжлэлийн бодлого, эрх зүйн орчин	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хологдох хууль, тогтоомж, түүнд орсон өөрчлөлтүүд,</li> <li>✓ Олон улсын магадлан итгэмжлэлийн төлөв байдал,</li> <li>✓ Дээд боловсролын магадлан итгэмжлэлийн өнөөгийн төлөв байдал,</li> </ul>	<a href="https://legalinfo.mn/">https://legalinfo.mn/</a> <a href="https://mecss.gov.mn/">https://mecss.gov.mn/</a> <a href="http://accmon.mn/">http://accmon.mn/</a> Бусад эх сурвалжууд
2	ДБСБ-ын магадлан итгэмжлэл	<ul style="list-style-type: none"> <li>✓ Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн тоо, түүний өөрчлөлт, эзлэх хувь</li> <li>✓ Магадлан итгэмжлэгдсэн сургуульд суралцагчдын тоо, түүний өөрчлөлт, эзлэх хувь</li> </ul>	
3	Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл	<ul style="list-style-type: none"> <li>✓ Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо, түүний өөрчлөлт,</li> </ul>	

		<ul style="list-style-type: none"> <li>✓ Магадлан итгэмжлэл ба боловсролын зэрэг,</li> <li>✓ Магадлан итгэмжлэл ба мэргэжлийн чиглэл,</li> <li>✓ Магадлан итгэмжлэл ба сургуулийн өмчийн хэлбэр,</li> <li>✓ Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүйн хөтөлбөрийн магадлан итгэмжлэл төлөв байдал,</li> </ul>	
--	--	--	--

**2. Нийгмийн ухааны чиглэлээр сургалт явуулдаг Дээд боловсролын сургалтын байгууллагын өнөөгийн байдлыг судлах:**

Энэхүү судалгааг i) Дээд боловсролын бодлого, эрх зүйн орчин, ii) Дээд боловсролын сургалтын байгууллагын өнөөгийн байдал, iii) Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагч, iv) Дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт гэсэн үндсэн чиглэлээр судалгаа, боловсруулалтын ажлыг дараах хүснэгтэд тодорхойлсон хүрээнд хийсэн.

**Хүснэгт 1.4. ДБСБ-ын өнөөгийн байдлын судалгаа, боловсруулалтын хамрах хүрээ**

<b>№</b>	<b>Үндсэн чиглэлүүд</b>	<b>Судлах асуудлууд</b>	<b>Эх үүсвэр</b>
1	Дээд боловсролын бодлого, эрх зүйн орчин	<ul style="list-style-type: none"> <li>✓ Холбогдох хууль, тогтоомж, түүнд орсон өөрчлөлтүүд,</li> <li>✓ Дээд боловсролын өнөөгийн төлөв байдал,</li> </ul>	
2	ДБСБ-ын өнөөгийн байдал	<ul style="list-style-type: none"> <li>✓ Их, дээд сургуулийн тоо, түүний бүтцийн өөрчлөлт, эзлэх хувь</li> <li>✓ Их, дээд сургуулийн өмчийн хэлбэр, түүний бүтцийн өөрчлөлт</li> <li>✓ Их, дээд сургуульд ажиллагчдын тоо, түүний бүтэц, өөрчлөлт,</li> <li>✓ Их, дээд сургуулийн багшийн тоо, түүний өөрчлөлт, эзлэх хувь</li> <li>✓ Сургалтын хөтөлбөр, түүний бүтэц, өөрчлөлт,</li> <li>✓ Нийгмийн болон зан харилцааны шинжлэх ухаан чиглэлээр сургалт явуулдаг сургууль,</li> </ul>	<p><a href="https://legalinfo.mn/">https://legalinfo.mn/</a>  <a href="https://mecss.gov.mn/">https://mecss.gov.mn/</a>  <a href="https://rilsp.gov.mn/">https://rilsp.gov.mn/</a>  <a href="https://1212.mn/">https://1212.mn/</a>                      Бусад эх сурвалжууд</p>

3	ДБСБ-д суралцагч	<ul style="list-style-type: none"> <li>✓ Их, дээд сургуульд элсэгчдийн тоо, түүний өөрчлөлт,</li> <li>✓ Их, дээд сургуульд суралцагчийн тоо, түүний өөрчлөлт,</li> <li>✓ Нийгмийн болон зан харилцааны шинжлэх ухаан чиглэлээр суралцагчид (боловсролын зэрэг, хөтөлбөр, сургууль),</li> </ul>	
4	ДБСБ-ын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт	<ul style="list-style-type: none"> <li>✓ Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, түүний өөрчлөлт,</li> <li>✓ Төгсөгчдийн эдийн засгийн идэвх, түүний өөрчлөлт,</li> <li>✓ Төгсөгчдийн ажлын байрны хэлбэр, түүний өөрчлөлт,</li> <li>✓ Төгсөгчид ажилд ороход нөлөөлдөг хүчин зүйл, түүний өөрчлөлт,</li> <li>✓ Төгсөгчдийн мэргэжил ба ажлын байрны нийцэл, түүний өөрчлөлт,</li> </ul>	

**3. Олон улсад нийгмийн ухааны чиглэлээр сургалт явуулдаг ДБСБ-ын чанарт үнэлгээ хийж буй туршлагыг судлах:**

Энэхүү судалгааг i) Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын судлагдсан байдал, ii) Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлэх арга зүй гэсэн үндсэн чиглэлээр судалгаа, боловсруулалтын ажлыг дараах хүснэгтэд тодорхойлсон хүрээнд хийсэн.

**Хүснэгт 1.5. ДБСБ-ын чанарт үнэлгээ хийж буй олон улсын туршлагын судалгаа, боловсруулалтын хамрах хүрээ**

№	Үндсэн чиглэлүүд	Судлах асуудлууд	Эх үүсвэр
1	ДБСБ-ын чанарын судлагдсан байдал	<ul style="list-style-type: none"> <li>✓ Дээд боловсрол ба чанар, түүний мөн чанар,</li> <li>✓ ДБСБ-ын чанарын судлагдсан байдал (чанарын менежмент, тогтолцоо, хэмжээс, шалгуур үзүүлэлтүүд г.м),</li> <li>✓ ДБСБ-ын чанарын стандартчлал (ISO 21001) ба магадлан итгэмжлэл</li> </ul>	<a href="http://ibsc.com/">http://ibsc.com/</a> <a href="https://researchgate.net/">https://researchgate.net/</a> <a href="https://tandfonline.com/">https://tandfonline.com/</a> <a href="https://academia.edu/">https://academia.edu/</a> <a href="https://unesdoc.unesco.org/">https://unesdoc.unesco.org/</a>
2	ДБСБ-ын чанарын үнэлэх арга зүй	<ul style="list-style-type: none"> <li>✓ ДБСБ-ын чанарын үнэлгээний систем,</li> <li>✓ ДБСБ-ын чанарын менежментийн хэмжээс, шалгуур үзүүлэлтүүд,</li> <li>✓ ДБСБ-ын чанарыг үнэлэх олон талт байдал (мэргэшлийн хүрээ,</li> </ul>	Бусад эх сурвалжууд



		судалгааны чанар, рейтингийн үнэлгээний систем, г.м)	
--	--	--	--

Дээд боловсролын сургалтын байгууллага, түүний чанарын асуудалтай холбоотой БСШУСЯ болон БМИУЗ-ийн гаргасан статистик үзүүлэлтүүд болон өмнө нь судлаачдын хэвлэн нийтэлсэн бүтээл(олон мэдээллийн сан, хэвлэл бүтээл)-үүдийг судалгааны эх хэрэглэгдэхүүн болгох тул тоон ба чанарын судалгааны аргыг хослуулан хэрэглэх нь оновчтой гэж үзсэн. Тоон шинжилгээний аргаар дээд боловсролын чанарын нийтлэг шинж, үйл явц, элементүүдийн холбоо хамаарлыг хамгийн ерөнхий, ойролцоо хэлбэрээр загварчилж, тоон утгаар судалсан бол, тухайн асуудлын учир шалтгаан, мөн чанарын тодруулах үүднээс чанарын шинжилгээний аргыг ашигласан. Тоон ба чанарын судалгааны хувьд дараах үндсэн зарчмыг баримталсан.

***Хүснэгт 1.6. Тоон ба чанарын судалгааны зарчим***

<b>№</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Тоон судалгаа</b>	<b>Чанарын судалгаа</b>
1	Асуудал	Нийтлэг үзэгдэл	Өвөрмөц тухайн тохиолдол
2	Өгөгдлийн төрөл	Хувьсагчид тоон утга олгох баримт, мэдээ, г.м	Баримт бичиг, бичвэр, цагийн товчоо, г.м
3	Өгөгдөл цуглуулах арга	Асуулга, туршилт, үнэлгээ, г.м	Архив, кейс, ярилцлага, г.м
4	Шинжилгээний арга	Статистик шинжилгээ,	Агуулгын, харьцуулсан шинжилгээ
5	Үр дүн, дүгнэлт	Асуудлын шалтгаан, хамаарлыг тайлбарлана.	Асуудлыг нээн илрүүлнэ.

Түүнчлэн судалгаа, боловсруулалтын өгөгдлийн сан бүрдүүлэхдээ дараах арга зүйг баримталж ажилласан.

***Хүснэгт 1.7. Судалгааны өгөгдөл шинжлэх арга зүй***

<b>№</b>	<b>Үе шат</b>	<b>Ажилбар</b>
1	Өгөгдлийн төлөвийг тодорхойлох	✓ Судалгааны асуудал, таамаглал, ойлголтыг бүрэн төлөөлж чадах өгөгдлийн үзүүлэлт, төрөл, тоо хэмжээг тодорхойлох.
2	Өгөгдөл цуглуулах арга сонгож, аргачлал боловсруулах	✓ Өгөгдөл цуглуулах шалгуур үзүүлэлт, хамрах хүрээ, дизайн боловсруулах, ✓ Өгөгдлийн төрөл, эх үүсвэрийг тодорхойлох, ✓ Өгөгдөл цуглуулах арга сонгох,
3	Өгөгдлийн сан үүсгэх	✓ Өгөгдлийг цуглуулах, ✓ Мэдээллийн сан үүсгэх,
4	Өгөгдөлд шинжилгээ хийх	✓ Тоон болон чанарын шинжилгээ хийх, ✓ Судалгааны үр дүнг нэгтгэх боловсруулах

4. Социологийн судалгаа: Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарыг үнэлэх асуудлыг оролцогч талууд болох профессор багш, ажилтан, ажил олгогч, төгсөгч болон суралцагч нараас асуулгын аргаар судалгаа явуулж, үнэлэлт өгсөн. Судалгааны асуулгын дэс дараалалтай, бөглөхөд хялбар байлгах зарчмыг баримтлан олон хэмжээст үнэлгээний аргыг ашиглах ба тухайн хариултыг сонгох хувийн жин:  $(P'_1:P'_2: \dots P'_n)$  бол, тэдгээрийн эх олонлогт харгалзах хувийн жин  $(P_1:P_2: \dots P_n)$  гэвэл доорх нөхцөлийг  $|1-\beta|$  магадлалтай хангаж байх түүврийн хэмжээг тодорхойлох боломжтой юм.

$$\{|P_1 - P'_1| \leq e, |P_2 - P'_2| \leq e, \dots |P_n - P'_n| \leq e \}$$

Судалгааг i) Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд, ii) Дээд боловсролын сургалтын байгууллагуудын чанарын төлөвшлийн үнэлгээ, iii) Төгсөгчдийн ур чадварын үнэлгээ гэсэн үндсэн чиглэлээр судалгаа, боловсруулалтын ажлыг дараах хүснэгтэд тодорхойлсон хүрээнд хийсэн.

**Хүснэгт 1.8. Социологийн судалгаа, боловсруулалтын хамрах хүрээ**

№	Үндсэн чиглэлүүд	Судлах асуудлууд	Эх үүсвэр
1	ДБСБ-ын чанарын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд	<ul style="list-style-type: none"> <li>✓ Сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээний шалгуур,</li> <li>✓ Сургалтын орчны чанарын үнэлгээний шалгуур,</li> <li>✓ Цахим үйлчилгээний чанарын үнэлгээний шалгуур,</li> <li>✓ Багшлахуйн чанарын үнэлгээний шалгуур,</li> <li>✓ Оюутныг дэмжих үйлчилгээний чанарын үнэлгээний шалгуур,</li> <li>✓ Номын сангийн үйлчилгээний чанарын үнэлгээний шалгуур,</li> <li>✓ Захиргааны үйлчилгээний чанарын үнэлгээний шалгуур,</li> <li>✓ Дэд бүтцийн чанарын үнэлгээний шалгуур,</li> </ul>	Профессор багш, Захиргааны ажилтан, Төгсөгч, Суралцагч,
2	ДБСБ-уудын чанарын төлөвшлийн үнэлгээ	<ul style="list-style-type: none"> <li>✓ Судалгаанд оролцогчдын мэдээлэл (ажилласан жил, боловсролын түвшин, эрдмийн зэрэг, албан тушаал, г.м)</li> <li>✓ Чанарын бодлого, зарчим, зорилго,</li> <li>✓ Чанарын менежментийн зарчмууд,</li> <li>✓ PDCA мөчлөгийг баримталдаг байдал,</li> <li>✓ Дотоод чанарын баталгаажуулалт,</li> <li>✓ Чанарын нэгжийн үйл ажиллагаа,</li> <li>✓ Магадлан итгэмжлэлийн үр нөлөө,</li> </ul>	Профессор багш, Захиргааны ажилтан,

3	Төгсөгчдийн ур чадварын үнэлгээ	<ul style="list-style-type: none"> <li>✓ Төгсөгчдийн ур чадварын зөрүүний үнэлгээ,</li> <li>✓ Төгсөгчдийн ур чадварын хэрэгцээ, шаардлага,</li> </ul>	Ажил олгогч, Төгсөгч,
---	---------------------------------	---	-----------------------

Судалгааны объект (эх олонлог)-ын тодорхой хэсгийг нь статистик аргачлалд тулгуурлан сонгон авч байгаа хэсэг (түүвэр олонлог)-ийг судалж, түүний үр дүнгээр судалгааны объектын ерөнхий шинж чанарыг тодорхойлох аргыг түүвэр судалгаа гэнэ. Судалж буй юмс үзэгдлийг тодорхойлох хэмжигдэхүүнүүдийн өөрчлөлтийг шинжлэн судлахад (дундаж, хувийн жин г.м) түүвэр судалгааны аргыг ашиглах нь зохимжтой ба уг судалгаа нь:

- i) Эх олонлогийн тодорхой хэсгээс сонгон авдаг,
- ii) Түүвэрлэн авсан олонлог дээр судалгаа хийж үр дүнг ашиглан эх олонлогийн гол үр дүнг ойролцоогоор тодорхойлох,
- iii) Түүвэр олонлогийн хэмжээг үндэслэн үндсэн үзүүлэлтүүдийн алдааны хязгаарыг урьдчилан тогтоох боломжтой байдаг.

Нийгэм, эдийн засгийн хүрээний судалгаанд түгээмэл ашигладаг магадлалт түүврийн аргуудыг судалгаанд ашиглахдаа судалгааны объект, тухайн судалгааны зорилгоос хамааруулан сонгох нь оновчтой ба аргуудыг харьцуулж хүснэгтээр харуулав.

**Хүснэгт 1.9. Магадлалт түүвэрлэлтийн арга зүйн зарчим**

№	Аргууд	Давуу талууд	Сул талууд
1	Багцалсан	<ul style="list-style-type: none"> <li>✓ Бусад санамсаргүй түүврийн аргуудаас илүү энгийн, хурдан,</li> <li>✓ Эх олонлогийн элементүүдээс төвөгтэй мэдээлэл шаарддаггүй,</li> <li>✓ Судалгааг ярилцлагын аргаар явуулахад оновчтой,</li> <li>✓ Багц бүр эх олонлогийн тодорхой нэг орчныг төлөөлж чадахаар сонгогдсон байвал зохимжтой,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Бусад санамсаргүй түүврийн аргуудтай харьцуулахад алдаа гарах магадлал их,</li> <li>✓ Багцын хэмжээ бага биш бол судалгаа өртөг ихтэй байдаг,</li> <li>✓ Түүврийн хэмжээ их бол түүврийн их хэмжээний алдаатай ажиллах шаардлагатай,</li> </ul>
2	Олон шатлалт	<ul style="list-style-type: none"> <li>✓ Олон нийтийг хамарсан том хэмжээний судалгаанд хэрэглэхэд тохиромжтой,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Түүврийг байгуулахад шаардагдах мэдээллийг олж авахад төвөгтэй,</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>✓ Эх олонлогоос түүвэрлэлт хийхдээ үе шат бүрд түүвэрлэлт хийдэг,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Түүвэрлэлт хийх явцад алдаа гарах магадлал ихтэй,</li> </ul>
3	Пропорциональ магадлалт	<ul style="list-style-type: none"> <li>✓ Түүвэрлэгдсэн нэгж бүрийн хувьд түүний элементүүд нь сонгогдох ижил магадлалтай,</li> <li>✓ Өмнө сонгогдсон нэгжүүдийг эх олонлогт буцааж хийх байдлаар түүвэрлэлтийг хийх боломжтой,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Түүвэр хийхэд зориулан цуглуулах мэдээллийг авахад ажиллагаа ихтэй,</li> <li>✓ Түүврээр зөвхөн сонирхож байгаа элементүүдээ зорилгодоо нийцүүлж авах талтай,</li> </ul>
4	Энгийн санамсаргүй	<ul style="list-style-type: none"> <li>✓ Эх олонлогийн болон түүврийн алдааны үнэлгээ боломжийн сайн гардаг,</li> <li>✓ Түүврийн зохиомж нь энгийн бөгөөд тайлбарлахад хялбар,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Эх олонлогийн талаар бүрэн нарийн жагсаалт хэрэгтэй,</li> <li>✓ Томоохон хэмжээний түүвэрлэлтэд тохиромж муутай, олон дахин нягтлах шаардлагатай,</li> </ul>
5	Бүлэглэсэн	<ul style="list-style-type: none"> <li>✓ Бүлэг бүрээс нэгжүүд сонгогдох баталгаатай ба тэдгээр нь төлөөлөх чадвар сайтай,</li> <li>✓ Түүврийн алдаа бага,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Түүврийн сонголт хийхэд нэлээд төвөгтэй, эх олонлогийн талаарх сайн мэдээлэл шаардлагатай,</li> <li>✓ Үнэлгээний тооцоолол нэлээд хүндрэлтэй,</li> </ul>
6	Системчилсэн	<ul style="list-style-type: none"> <li>✓ Энгийн санамсаргүй түүвэр хийхээс хялбар,</li> <li>✓ Түүвэрлэгдсэн нэгжүүд эх олонлогийн дагуу жигд тархаадаг,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Түүвэр зохистой байрлаагүй бол цаг их зарах, хугацаа алдах талтай,</li> <li>✓ Судалгааг цаг хугацааны давтамжтайгаар авах үед оновчгүй</li> </ul>

Түүвэр судалгааны үед эх олонлогийг төлөөлөх чадвартай түүврийн зохимжтой хэмжээг тодорхойлох нь хамгийн чухал байдаг. Түүврийн хэмжээг дараах үндсэн зарчимд тулгуурлан тооцдог. Түүврийн хэмжээ нэмэгдэх тутам их тооны хуулийн дагуу эх олонлог дах янз бүрийн төрлийн нэгжүүд түүвэр судалгаанд хамрагдах магадлал нэмэгдэж, түүврийн эх олонлогийг төлөөлөх чадвар сайжирдаг.

**Хүснэгт 1.10. Түүврийн хэмжээ тооцох аргачлал**

№	Сонголтын хэлбэр	Буцаалттай	Буцаалтгүй
1	Дундаж	$n_y = \frac{\Delta^2 \delta^2}{se_y^2}$	$n_y = \frac{\Delta^2 \delta^2 N}{(Nse_y^2 + \Delta^2 \delta^2)}$
2	Харьцангуй	$n_w = \frac{\Delta^2 p(1-p)}{se_w^2}$	$n_w = \frac{\Delta^2 p(1-p)N}{(Nse_w^2 + \Delta^2 p(1-p))}$

Эх үүсвэр: Түүвэрлэлтийн арга зүйн зөвлөмж

Түүврийн хэмжээг дээрх хүснэгтэд өгөгдсөн томъёогоор тооцохдоо алдааны хязгаар, итгэх түвшнийг авч үзэх шаардлагатай. Түүврийн алдааг түүврийн үр дүнд үндэслэн эх олонлогийн параметрийг тооцоолоход хэрэглэх ба тооцооны утга болон бодит утгын зөрүүг түүврийн алдаа гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, тухайн сонгосон алдааны хязгаарын хүрээнд алдаа гарахад судалгааны үр дүнд нөлөөлөхгүй гэсэн үг юм. Иймээс түүврийн алдаа бага байвал тооцоо бодит утгатай ойролцоо гарч, судалгааны ач холбогдол сайжирдаг.

Практикт түүврийн хэмжээг тооцохдоо алдааны хязгаар, итгэх түвшнийг судлаачид өөрсдөө сонгон авах боловч нийгэм, эдийн засгийн хүрээний судалгаанд итгэх түвшнийг 90%, 95%, 99%, харин алдааны хязгаарыг  $\pm 1\%$ ,  $\pm 2\%$ ,  $\pm 3\%$ ,  $\pm 5\%$  байхаар ихэвчлэн сонгож авах хандлагатай байдаг. Мөн түүврийн хэмжээг тооцохдоо түүврийн хэмжээний хүснэгт (Sample Size Table) болон вебд суурилсан тооцооллын программ (Sample Size Calculator)-ийг ашиглах боломжтой. Тухайлбал, судалгааны итгэх түвшин 95%, алдааны хязгаар 5% байх үед шаардагдах түүврийн хэмжээг эх олонлогийн хэмжээтэй уялдуулан тооцоолсон түүврийн хүснэгтийг авч үзвэл.

**Хүснэгт 1.11. Түүврийн хэмжээний хүснэгт (итгэх түвшин-95%, алдааны хязгаар-5% байх үеийн түүврийн зохимжтой хэмжээ)**

Эх олонлог	Түүврийн хэмжээ	Эх олонлог	Түүврийн хэмжээ	Эх олонлог	Түүврийн хэмжээ
10	10	200	132	900	269
20	19	300	169	1000	278
40	36	400	196	1200	291
50	44	500	217	1500	306
75	63	600	234	6000	361
100	80	700	248	50,000	381
150	108	800	260	100,000+	385

Эх үүсвэр: Үр дүнд хүрэх зам: Хөгжлийн үнэлгээг үр дүнтэй уялдуулан явуулах нь

Дээрх хүснэгтээс харахад, эх олонлогийн хэмжээ бага үед нэлэнхий судалгаа хийх нь зохимжтой ба эх олонлогийн хэмжээ нэмэгдэх тутам түүврийн эзлэх хувь буюу хувийн жин буурдаг.

Түүвэрлэлт нь нэг болон хэд хэдэн үе шаттай байдаг бөгөөд эх олонлогийн нэгж бүр түүвэр олонлогт сонгогдох магадлал ижил байдаг. Уг магадлалаас түүврийн жин хамаардаг тул түүврийн өгөгдлийг нэгтгэн дүгнэх, шинжилгээ хийж үр дүнг гаргахад ашигладаг. Судалгааны мэдээллийг SPSS статистикийн багц программ хангамжаар боловсруулж, судалгааны үр дүнг ашиглан чанарын үнэлгээ хийхдээ жигнэсэн дунджийн аргыг ашиглахад зохимжтой ба дараах томъёогоор тооцно:

$$\bar{X} = \frac{\sum_{i=1}^n (X_i \cdot P_i)}{\sum_{i=1}^n (X_i)}$$

энд:  $\bar{X}$ -дундаж хэмжигдэхүүн буюу чанарын оноо,  $P_i$ -үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин,  $X_i$ -тухайн үзэгдлийн давтамж буюу судалгааны үр дүн,

Иймээс түүвэр судалгааг дараах үе шатаар зохион байгуулах боломжтой юм. Үүнд:

- ✓ Тухайн үзэгдлийн шинж чанарт тохируулан түүвэрлэлтийн арга, түүврийн хэмжээг урьдчилан тогтооно,
- ✓ Эх олонлогоос түүвэр олонлогийг сонгоно,
- ✓ Тодорхой аргаар сонгож авсан түүврийн олонлогт судалгаа хийж, мэдээлэл цуглуулна,
- ✓ Судалгаагаар цуглуулсан мэдээллээр статистик боловсруулалтын программ хангамж ашиглан мэдээллийн сан үүсгэнэ,
- ✓ Түүвэр судалгааны үндсэн үзүүлэлтийг тооцож гаргах, алдааг тодорхойлно,
- ✓ Судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгнө.

Төслийн хүрээнд хийгдсэн судалгаа, боловсруулалтын ажлын үр дүнд тулгуурлан нийгмийн ухааны чиглэлээр сургалт явуулдаг дээд боловсролын сургалтын байгууллагын чанарт үнэлгээ хийх талаар зөвлөмж боловсруулж санал болгосон.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАНАРЫГ ҮНЭЛЭХ ОНОЛ, АРГА ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ**

### **2.1. Дээд боловсрол**

Дэлхийн улс орнуудад мэдлэгт суурилсан нийгэм, эдийн засагт шилжих үйл явц эрчимтэй өрнөж, улмаар улс орнуудад шинжлэх ухааны мэдлэгийг үр ашигтай хэрэглээ болгон хувиргахад чиглэсэн инновацын үйл ажиллагаа ихээхэн эрчимжиж, түүнийг баримжаалах явдал хөгжлийн шинэ хандлагыг тодорхойлж байна. Улмаар мэдлэг хийгээд бүтээлч хүний нөөц нь байгалийн нөөц, биет капиталаас илүүтэй эдийн засгийн өсөлт, мэдлэгийн секторын өрсөлдөх чадварыг сайжруулахад тэргүүлэх ач холбогдолтой болжээ. Энэхүү нийгэм, эдийн засгийн хөгжлийн бүхий л хүрээний өөрчлөлтөөс улбаалан дээд боловсролын чанар, түүний үзэл баримтлалыг шинэчлэх талаар бодлого боловсруулж, хэрэгжүүлэх асуудал нь үндэсний төдийгүй бүс нутгийн түвшинд ач холбогдол өгөх болжээ. Тухайлбал: Европын холбооны хувьд Болоны процесс (Bologna process), Лисбоны стратеги (Lisbon strategy), Дээд боловсролын шинэчлэлтийн хөтөлбөр (An agenda for the modernisation of higher education) зэрэг бодлогын баримт бичгүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна<sup>1</sup>.

Хорин нэгдүгээр зуунд боловсролын систем нь нийгмийн хэрэгцээнээс илүүтэй бүтээлч эдийн засгийн чухал бүрэлдэхүүн хэсэг болж өөрчлөгдөж байна. Энэхүү өөрчлөлт нь дэлхий дахинаа мэдлэгийн эдийн засгийн эрчимжилт, технологийн орчны хурдацтай өөрчлөлт, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, шаардлагын хувьсал зэрэг гадаад хүчин зүйлүүдээс үүдэлтэй юм.

Үзэл санааны олон талт байдал нь дээд боловсролын тухай дахин эргэцүүлэн бодоход хүргэж, улмаар дээд боловсролын нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх олон үүрэг оролцоог шинэчлэн тодорхойлох шаардлага зүй ёсоор бий болжээ. Угтаа дээд боловсрол нь нийгмийн харилцааны бүхий хүрээнд сурган хүмүүжүүлэх тогтолцооны эх үүсвэр тул улс орны шинжлэх ухаан, технологи, эдийн засгийн хөгжилд шууд хамааралтай юм. Мөн дээд боловсрол нь хүмүүст нийгмийн хөгжлийн хэрэгцээнд үндэслэн мэдлэг,

---

<sup>1</sup> <https://ec.europa.eu>



чадвараа тасралтгүй дээшлүүлж насан туршдаа суралцах боломжийг олгодог. Иймээс дээд боловсрол нь нийгмийн тогтвортой хөгжилд дараах үүрэг, оролцоотой. Үүнд:

- ✓ Шинэ мэдлэгийг хайх, түгээн дэлгэрүүлэх, үнэнийг эрж олоход уриалах, татан оролцуулах, хуучин мэдлэг, итгэл үнэмшлийг шинэ хэрэгцээ, нээлтийн дагуу хөрвүүлэх;
- ✓ Хувь хүн болон нийгмийн эрх тэгш байдлыг хангах, соён гэгээрүүлэх, эерэг хандлагыг төлөвшүүлэх, сайн сайханд манлайлах;
- ✓ Нийгмийн амьдралын бүхий хүрээнд авьяаслаг залуучуудын бие бялдар, оюун ухааныг хөгжүүлэх, ёс суртахууны зөв хандлагатай болж төлөвшихөд нь дэмжих;
- ✓ Нийгмийг шинжлэх ухаан, технологийн бүхий чиглэлээр мэргэшсэн, бүтээлч хүний нөөцөөр хангах;

Түүнчлэн Роналд Барнет дээд боловсролын үндсэн зарчмыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✓ Чадварлаг хүний нөөцийн үйлдвэрлэл: Дээд боловсрол нь оюутнуудыг хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадамжтай мэргэжилтэн болгож бэлтгэдэг тул бизнес, үйлдвэрлэлийн салбарын өсөлт, хөгжлийн гол нөөц юм.
- ✓ Чадварлаг судлаач бэлтгэх орчин: Дээд боловсрол нь мэдлэгээ тасралтгүй хөгжүүлэх чадварлаг судлаачдыг бэлтгэх, чанартай судалгаа хийхийг дэмжсэн үзэл баримтлал юм.
- ✓ Чадварлаг багш бэлтгэх тогтолцоо: Боловсролын байгууллагын үйл ажиллагааны цөм нь сургах – суралцахуйн тасралтгүй үйл ажиллагааны үр ашигтай удирдлага юм.
- ✓ Амьдралын боломжийг нэмэгдүүлэх хүчин зүйл: Дээд боловсрол нь уян хатан, тасралтгүй боловсролын хэлбэрээр хувь хүний хөгжлийн үйл явцад оролцох боломж юм.

Энэ утгаараа дээд боловсролыг ерөнхийдөө “*Багшлахуй - Судлахуй - Хөгжүүлэхүй*” гэсэн ойлголтуудын нэгдэл гэж тодорхойлж болох юм. Мөн судлаач П.Алтбач, Ж.Салми нар дэлхийн жишигт нийцсэн дээд боловсролын

сургалтын байгууллагын хэв шинжийг “Авьяас чадварын нэгдэл + Сайн дэд бүтэц + Зөв засаглал”-ын нийлбэр цогц гэж тодорхойлжээ.

Улс орнуудын дээд боловсролын тогтолцоо нь дээд боловсрол эзэмших хэрэгцээ, оролцооны өсөлт, боловсрол олгох үйл явц дахь технологи болон даяаршлын нөлөө зэргээс улбаалсан дараах нийтлэг хэв шинжтэй байна. Үүнд:

- ✓ Үндэсний хөгжилд хувь нэмэр оруулах. Дээд боловсролын сургалтын байгууллага нь тогтвортой хөгжлийн нийгэм, эдийн засаг болон хүрээлэн буй орчныг хамруулсан хөгжлийн суурь үзэл баримтлалд зохицсон, улсынхаа онцлог давуу байдлыг дэмжсэн өөрчлөлт хийхэд манлайлах байдлаар үндэсний хөгжилд хувь нэмрээ оруулдаг.
- ✓ Нийгмийн үнэлэмжийн тогтолцоог төлөвшүүлэх: Дээд боловсролын сургалтын байгууллага нь хувь болон нийгэмд дэлхийн дахины соёлын нийтлэг хэв шинжийг ухамсарлах, эрх тэгш байдал, шударга ёсыг хангах үндэсний үнэт зүйлийг төлөвшүүлэхэд манлайлан оролцох.
- ✓ Хүний нөөцийн олон улсад өрсөлдөх чадавхыг дээшлүүлэх. Дээд боловсролын сургалтын байгууллага нь эдийн засгийн эрх чөлөөт байдал, даяаршлын нөлөөгөөр олон улсад болон соёл хооронд өрсөлдөх чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, нийгмийн эрх тэгш байдлыг хангахад тэргүүлэх байр суурьтай оролцох.
- ✓ Өрсөлдөх давуу талыг эрэлхийлэх: Дээд боловсролын сургалтын байгууллага нь үндэсний хөгжилд хувь нэмэр оруулах, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх давуу талыг бий болгохуйц шинжлэх ухааны мэдлэгийг үр ашигтай хэрэглээ болгон хувиргахад чиглэсэн инновацын үйл ажиллагаанд тэргүүлэх байр суурьтай оролцох.

Нийгэм, эдийн засгийн хөгжлийн бүхий л хүрээний өөрчлөлтүүд нь дээд боловсролын сургалтын байгууллагын өмнө “Сургалт - Судалгаа – Инновац” гэсэн харилцан уялдаа бүхий мэдлэгийн гурвалжныг хөгжүүлэх зорилт тулгарч байна. Улмаар дэлхий дахиныг болон бүс нутгийг хамарсан даяаршлын үйл явцын эрчимжилтээс улбаалсан хувьсан өөрчлөгдөх хэрэгцээ, шаардлагыг хангахад чиглэгдсэн дээд боловсролтой холбоотой чанарын үнэлгээ (гадаад, дотоод)-ний олон янзын системүүдийг хөгжүүлэх хандлага түгээмэл байна. Түүнчлэн улс орнууд нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээнд харилцан

хамааралтай болж хамтын ажиллагаа өргөжин тэлэхийн зэрэгцээ хамтын ажиллагааны шинэ хэлбэрүүд үүсэх болсон нь дээд боловсролын интеграцийг улам бүр эрчимжүүлэх болжээ.

Дээд боловсролын сургалтын байгууллага нь өнөөгийн хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй глобал хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэхэд анхаарах нь чухал юм. Энэ нь сургалтын технологидоо инновац нэвтрүүлж, бүтээлчээр хандах шаардлагатай болохыг харуулж байна.

Улмаар “Суралцах - Ажиллах” гэсэн харилцан уялдааг хангаж суралцагчдын цогц чадамжийг хөгжүүлэх нь ажлын байран дээрх амжилтад нь чухал боловч тохирсон үнэлэмжийн тогтолцоогүйгээр уг чадамжууд ямар ч үнэ цэнгүй юм.

Ер нь дээд боловсролын сургалтын байгууллагуудын үндсэн чиг үүргүүдийн нэг нь суралцагчдад үндэсний үнэт зүйл болон хувь хүний эрхэмлэх зүйл бүхий үнэлэмжийн тогтолцоог ойлгуулах явдал юм. Мөн түүнчлэн хүн төрөлхтний өдөр тутмын амьдралд орчин үеийн технологийн хэрэглээ нэмэгдэж, чухалчлах болсноор дээд боловсрол олгох уламжлалт аргуудыг шинэчлэх шаардлага нэгэнт бий болсон. Иймээс дээд боловсролын сургалтын байгууллагууд дэвшилтэт технологийг сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглахын сацуу байгууллагын үйл ажиллагааг технологит суурилан удирдах нь чухал болжээ.

21 дүгээр зууны боловсролын олон улсын комиссын ЮНЕСКО-ийн “Боловсролыг дахин эргэцүүлэн бодох нь \Суралцах үзэл баримтлалыг эргэцүүлэх нь: Боловсрол доторх эрдэнэс” тайланд боловсролын 4 тулгуур зарчмыг i) мэдэхийн тулд суралцах, ii) бүтээхийн тулд суралцах, iii) хамтдаа амьдрахын тулд суралцах, iv) хүн байхын/оршихуйн тулд суралцах хэмээн тодорхойлжээ.

## **2.2. Дээд боловсролын чанар**

Боловсрол чанартай байх нь боловсролоос хувь хүний болон нийгмийн хүлээж буй үр өгөөж биеллээ олж, улс орны тогтвортой хөгжил, сайн сайхан байдалд хувь нэмрээ оруулах гэж үзэж болох юм. Иймээс боловсролын салбарын макро түвшний зорилтууд биелэгдэх нь микро түвшний

үйлдвэрлэлийн үр дүн буюу боловсролын байгууллагын чанараас шууд хамаарна. Боловсролын үйлдвэрлэлийн хамгийн чухал гарц болох боловсролын чанарын үнэлгээ, баталгаажуулалтыг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх асуудалд шинжлэх ухааны үндэслэлтэй хандах шаардлага чухлаар тавигдаж байна.

ЮНЕСКО-оос боловсролын чанарт нөлөөлөх хүчин зүйлс улс орон бүрд харилцан адилгүй байдаг гэсэн бол, Barret.et.al нь боловсролын чанарт нөлөөлөх хүчин зүйлийг судлахаас өмнө боловсролын чанарын талаар нэгдсэн ойлголтод хүрэх, улмаар улс орон бүр үнэлгээний стандартыг тогтоох шаардлагатай гэжээ. Харин Verspoog нь улс орны соёлын онцлогоос шалтгаалан чанарын талаарх ойлголт өөр өөр байдаг гэж тодорхойлсон.

Эдийн засаг, менежментийн ухааны зохиол бүтээлүүдэд “Чанар (quality)” гэсэн ойлголтын мөн чанар, агуулгыг олон талтайгаар авч үзэн, янз бүрээр тодорхойлж иржээ. Ийнхүү чанарын тодорхойлолтын олон хувилбар байгаа нь түүнийг олон талт хэв шинж, агуулгатай болохыг харуулж байна. Бидний үзэж байгаагаар онол, практикийн хүрээнд чанар гэсэн ойлголтын мөн чанарыг тодорхойлсон үндсэн 2 хандлага байна. Тухайлбал:

- ✓ Релятивист буюу чанарыг ямар өнцөг (хэрэглэгч, үйлчлэгч, бүтээгдэхүүн, үйлчилгээ г.м)-өөр харах, ямар үзүүлэлтээр хэмжих зэргээс хамаарч харилцан адилгүй.
- ✓ Объективист буюу чанарыг тодорхой шинж тэмдгээр нэгдсэн аргачлалаар тайлбарлах боломжтой.

Түүнчлэн чанарын талаарх тодорхойлолтуудыг агуулгын хувьд харьцуулбал i) чанар бол хязгааргүй, ii) чанар бол харьцангуй, iii) чанар бол үйл ажиллагаа, iv) чанар бол зуршил гэсэн нийтлэг үзэл санааг илэрхийлжээ. Тухайлбал:

- i. Чанар бол хязгааргүй: чанар бол хамгийн дээд стандарт тул нэг түвшнээс нөгөө түвшин рүү, нэг зэрэглэлээс нөгөө зэрэглэл рүү ахих үргэлжилсэн үйл явц юм. Тухайлбал, энэхүү үзэл санаа “Чанар нь өндөр түвшин буюу зэрэглэл юм (Оксфордын толь бичиг, 1989)” тодорхойлолтод тусгалаа олжээ.

- ii. Чанар бол харьцангуй: бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар нь харилцан адилгүй ба тодорхой нөхцөлийн дагуу хэмжигдэнэ. Тухайлбал, бүтээгдэхүүний техникийн нөхцөл нь түүнд тавих хамгийн бага түвшин болохоос хангалттай түвшин биш, харин хангалттай түвшин нь хэрэглэгчийн сэтгэл ханамжаар тодорхойлогдох юм. Тухайлбал, энэхүү үзэл санаа “*Чанар нь бүтээгдэхүүн, үйлчилгээнд байх ёстой шинж чанар юм (ISO 9001)*” тодорхойлолтод тусгалаа олжээ.
- iii. Чанар бол үйл ажиллагаа: бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар нь тодорхой зорилгод чиглэсэн тодорхой үйл явцын тогтолцооны үр дүн юм. Тухайлбал, энэхүү үзэл санаа “*Чанар нь зөв зүйлийг анхнаас нь, цаг ямагт зөв хийх юм (ODI Consulting)*” тодорхойлолтод тусгалаа олжээ.
- iv. Чанар бол зуршил: аливаа зүйлийг эхнээс нь зөв хийж, дараагийн удаа түүнээс илүү сайн хийх дадал болгох нь чухал. Тухайлбал, энэхүү үзэл санаа “*Чанар нь зөвхөн үйлдэл бус дадал зуршил юм (Аристотель)*” тодорхойлолтод тусгалаа олжээ.

Мөн чанарыг судлаачид янз бүрээр тодорхойлсон ба эдгээрийг 5 бүлэгт ангилах боломжтой юм (Гарвин). Үүнд:

- ✓ Хийсвэр тодорхойлолт: Чанар гэдэг нь муугаас ялгаатай сайныг илэрхийлэх харьцангуй давуу нөхцөл байдал.
- ✓ Хэрэглэгчид суурилсан тодорхойлолт: Чанар гэдэг нь хэрэглэгчийн шаардлагыг хангаж, сэтгэлд нийцэх байдал.
- ✓ Үйлдвэрлэлд суурилсан тодорхойлолт: Чанар гэдэг нь стандартад тохирч, нийцэх байдал.
- ✓ Өртөгт суурилсан тодорхойлолт: Чанар гэдэг нь үнэд тохирсон сайн бүтээгдэхүүнээр хангах явдал.
- ✓ Бүтээгдэхүүнд суурилсан тодорхойлолт: Бүтээгдэхүүний чанар нь түүнийг бүрдүүлэгч хэсгүүдийн чанараас ялгагдах онцлогтой.

Ерөнхийдөө өнөөгийн байдлаар чанарын мөн чанар, агуулгыг тодорхойлох асуудал онол, практикийн хувьд нэг мөр болж шийдэгдээгүй хэмээн дүгнэж болох юм. Иймээс чанар хэмээх ойлголтын агуулгыг “*Тодорхойлсон хэрэгцээ шаардлагад нийцүүлж сэтгэл ханамжийг өгч чадах*

*бүтээгдэхүүн, үйлчилгээний шинж чанар, онцлогийн цогц*” гэж тодорхойлж болохоор байна.

Өнөөгийн бидний мэдэх чанар хэмээх ойлголт анх аж үйлдвэрийн салбарт үүссэн түүхтэй ба В.Эдуард Деминг, Жосеф М.Журан, Филипп Б.Кробси нарын судлаачид чанарын менежментийг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан.

Жосеф М.Журан нь чанарыг “Зорилгод хүрэх фитнес” гэж томъёолсон. Тэрээр чанарын менежментийг *“Чанарын төлөвлөлт - хяналт – сайжруулалт”* гэсэн гуравласан холбоо гэж тодорхойлжээ. Түүнчлэн чанар муу байх нь удирдлагын арга барилаас үүдэлтэй ба байгууллагын асуудлуудын 85 хувь нь алдаанаас, 15 хувь нь хүнээс хамааралтай гэжээ.

Филипп Ф.Кросби нь чанар бол i) сайхан, тансагт биш, ii) үнэлж болохгүй зүйл биш, iii) авч хүчрэхгүй зүйл биш ба гологдолгүй ажлын чанар нь ажилчдаас бус, удирдлагаас ихээхэн хамаардаг гэж үзжээ. Иймээс гологдолгүй ажлын үзэл баримтлалыг дараах байдлаар боловсруулсан. Үүнд:

- ✓ Удирдлагын зүгээс чанарын талаар баримтлах бодлогоо тодорхойлж, ажилтнуудад танилцуулах,
- ✓ Удирдлагаас хэрэглэгчийн шаардлагад нийцэх чанарыг тодорхойлж, уг чанарт хүрэхийг эрмэлзэж ажиллах,
- ✓ Чанарын үнэлгээг алдаа, гологдол илрүүлэхэд бус урьдчилан сэргийлэхэд чиглүүлэх,
- ✓ Чанарыг сайжруулахын тулд юу хийх, ямар үр дүнд хүрэх, үүний тулд ажилтан яах ёстойг тодорхой болгох,
- ✓ Бүхнийг эхнээс зөв хийх шаардлагатай гэжээ.

Харин В.Эдуард Деминг нь байгууллагын удирдлага чанарт хариуцлагатай хандах нь чухал төдийгүй чанартай байхын үндэс засахаас илүүтэй урьдчилан сэргийлэхэд оршино гэжээ. Тэрээр Демингийн 14 зүйл гэж нэрлэгдсэн зарчмуудыг тодорхойлсон. Үүнд:

1. *Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах зорилготой байх:* Байгууллага өрсөлдөх чадвар, тогтвортой хөгжлийг

хангахад бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын тасралтгүй сайжруулалтыг системтэй хэрэгжүүлэх.

2. *Шинэ зарчим (философи)-ыг мөрдөх*: Байгууллага өрсөлдөх чадвараа дээшлүүлэхийн тулд одоогийн менежмент, арга барилд шаардлагатай өөрчлөлтийг системтэй хийх замаар алдаа, гологдол, саатал зэргийг бууруулах боломжтойг хүлээн зөвшөөрөх.
3. *Хяналт, шалгалтаас хараат байдлаас татгалзах*: байгууллага чанарт хүрэхийн тулд хөндлөнгийн хяналт шалгалтаас хэт хамааралтай байдлаас татгалзах. Харин ажилтан бүр өөрсдийн ажлын гүйцэтгэлийн чанарын хяналт – сайжруулалтын механизм бүрдүүлж, соёл төлөвшүүлэх.
4. *Үнэ чухалчилсан шийдвэр гаргалтаас татгалзах*: Байгууллага бэлтгэн нийлүүлэлтэд зөвхөн үнийг чухалчлах бус чанарыг үнээр хэмжих (чанартай харьцуулахгүй бол үнэ чухал биш) шаардлагатайг анхаарах.
5. *Системийн байнгын сайжруулалт хийх*: Байгууллага бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах, бүтээмжийг дээшлүүлэхэд үйлдвэрлэл, үйлчилгээний төлөвлөлт, хяналт - шинжилгээ, үнэлгээний тогтолцооны байнгын сайжруулалтыг чухалчлах.
6. *Хүний нөөцийн сургалтыг тогтмолжуулах*: Байгууллага чанарыг сайжруулахад ажилтан бүрийн идэвхтэй оролцоо чухал тул хүний нөөцийн сургалтыг тогтмолжуулах.
7. *Манлайлал бий болгох*: Байгууллагын удирдлага зөвхөн хяналт тавьж ажиллах бус, үр дүнтэй манлайллыг хэрэгжүүлэх.
8. *Айдсыг арилгах*: Байгууллагын ажилтан бүр чанарын төлөө ажлынхаа өөрчлөлтийг санаачилгатай хэрэгжүүлэхийг ухамсарлах.
9. *Саад бэрхшээлийг арилгах*: Байгууллагын үйл явцын чанарын баталгаажуулалтыг тасралтгүй хангахын тулд бүтцийн нэгж болон ажилтнууд хоорондын хамтын ажиллагаанд тулгарах саад бэрхшээлийг арилгах нь чухалчлах.
10. *Хоосон уриа лоозонгоос зайлсхийх*: Байгууллагын удирдлага аливаа өөрчлөлтийг нарийн төлөвлөхгүй, хэрэгжүүлэлтийг ажилтнуудад



ойлгуулахгүйгээр чанарыг сайжруулах, бүтээмж дээшлүүлэхийг уриалахаас зайлсхийх.


11. *Стандарт тогтоох*: Байгууллагын үйл ажиллагаанд баримтлах үндсэн шаардлагыг тогтоож, нэгдсэн ойлголттой болох.
12. *Бахархах боломж олгох*: Байгууллагын ажилтан бүр өөрийн ажил дээрээ бүтээсэн зүйлээрээ, ур чадвараа бахархах эрхийг зөрчсөн саад тотгорыг арилгах.
13. *Өөрийгөө хөгжүүлэхийг дэмжих*: Байгууллагын чанарыг сайжруулахад чиглэсэн ажилтан өөрийн ур чадвараа хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх.
14. *Өөрчлөлтөд оролцохыг дэмжих*: Байгууллагын удирдлагаас чанарыг дэмжсэн өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлэхэд ажилтан бүрийн оролцоо чухал болохыг ойлгуулах, бүтээлч санаачилгуудыг дэмжих.

### **2.3. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанар**

Дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн мэдлэг, чадвар ажил олгогчдын шаардлагыг хангахгүй, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадваргүй бол дээд боловсролын чанар, үр ашгийн тухай ярих нь утгагүй асуудал юм. Иймээс дээд боловсролын сургалтын байгууллагын чанар гэдэг нь элсэлтийн чанар, хөтөлбөрийн чанар, багшлахуйн чанар, үйлчилгээний чанар зэрэг олон талт, хоорондоо харилцан уялдаа бүхий менежментийн тогтолцооны хүрээний асуудал гэж ойлгож болно. Энэ утгаараа дээд боловсролын сургалтын байгууллагын чанарыг системийн хандлагаар буюу зөвхөн дээд боловсрол эзэмшсэний дараа (төгсөгч) бус, эзэмшихээс өмнөх (элсэгч) болон эзэмших үе (суралцагч) гэсэн системийн бүхий л үе шатанд авч үзэх нь оновчтой.

Системийн орц-гарцын шинжилгээ нь эдийн засгийн тодорхой хүрээн дэх бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ашиглалтын үйл явцад тогтсон холбоо хамаарлыг илэрхийлэн гаргаж, үйлдвэрлэлийн ерөнхий тэнцвэр, үр ашгийн үзүүлэлтийн системийг тодорхойлохдоо тодорхой тооны дэд хэсгүүдэд хувааж нэг талаас үйлдвэрлэгч, нөгөө талаас хэрэглэгч гэсэн уялдаа хамаарлыг бүтээгдэхүүний урсгал байдлаар тодорхойлдог.

Дээд боловсролын сургалтын байгууллага нь нэг талаас гадаад орчны хүчин зүйлээс ихээхэн хамаарсан нээлттэй систем, нөгөө талаас харилцан уялдаа бүхий дэд систем (оролт, хувиргалт, гаралт)-үүдийн нэгдэл ба системийн зураглалыг доорх зурагт харуулав.



**Зураг 2. 1. Дээд боловсролын сургалтын байгууллагын нэгдсэн чанарын менежментийн загвар (орц - гарцын хандлага)**


Системийн орц - гарцын хандлагын хувьд: i) орц гэж хүний нөөц (оюутан, багш) болон дэд бүтэц, санхүү зэрэг бусад нөөцүүд, ii) хувиргах үйл явц гэж орцыг гарц болгох үйл явц (сургалт, эрдэм шинжилгээ г.м), дэмжих механизмууд, iii) гарц гэж төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, эрдэм шинжилгээний бүтээлүүд зэрэг багтана.

Ер нь дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын тогтолцоог орц-гарцын хандлагаар судлахдаа функциональ систем буюу гаднын орчны идэвхтэй нөлөөлөлд байнга оршиж, эргээд гаднын орчиндоо харилцан нөлөөлдөг динамик, хувьсах бүтэцтэй систем гэж үзээд, системийг бүрдүүлэгч элемент хоорондын хүчин зүйл - үр дагаврын харилцан холбоо нь субординацын хууль (системийн элементүүд орон зай, цаг хугацаа, харилцан холбооны хувьд тодорхой шат дараалалд орших)-д захирагдах ба дараах тэгшитгэлээр илэрхийлэгдэнэ.

$$Y = F(X_1, X_2, \dots, X_n,)$$

энд:  $Y$  -системийн үр дүн буюу гарц,  $X$  -системийн нөөц буюу орц,  $F$  -орцыг гарц болгон хувиргах үйл явц буюу үйлдвэрлэлийн функц,

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанар нэг талаас захиргааны ажилтан, багш бүр хариуцсан ажлын гүйцэтгэл нь чанарт нөлөөлөхийг ухамсарласан байх, нөгөө талаас доороос дээш чиглэсэн зохицуулалт бүхий чанарын тогтолцоо бүрдэхээс хамаардаг тул дотоод чанарын баталгаажуулалтын суурь зарчмыг дараах зурагт үзүүлсэн байдлаар тодорхойлж болох юм.



Зураг 2.2. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын баталгаажуулалтын систем

Дээд боловсролын сургалтын байгууллагад стандартад суурилсан чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх нь чанарын нийцлийг хангах “Үнэлгээ - Тохируулга - Сайжруулалт” бүхий дотоод чанарын баталгаажуулалтын систем бүрдэхэд түлхэц болно. Энэхүү дотоод чанарын баталгаажуулалтын системийг төлөвшүүлэхэд чанарын гарын авлага чухал үүрэгтэй ба зөвхөн захиргааны аргаар чанарын менежментийг шууд нэвтрүүлэх гэж оролдох нь чанарын зорилгод хүрэх, тасралтгүй сайжруулалт үр дүнгүй болох тул удирдлагын манлайллаар дамжуулан чанарын соёлыг төлөвшүүлэх, бүтцийн нэгжүүд чанарын тухай нэгдсэн ойлголттой болгоход онцгойлон анхаарах шаардлагатай.

Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын менежмент нь зөвхөн хариуцлага, гадаад хяналтыг хангахад чиглэгдэх аваас чанарын хяналт, үнэлгээ болон тасралтгүй сайжруулалтын үйл явц ажиллагчдын эсэргүүцэлтэй тулгарахад хүрдэг. Тиймээс хяналт ба бие даасан байдлын

тэнцвэрт байдлыг хангахад анхаарах нь чухал юм. Тухайлбал, профессор багш нарт академик эрх чөлөө олгохын сацуу, эрдэм судлалын ажилд чанарын шаардлага тогтоох нь чухал гэсэн үг.

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн талаар авч хэрэгжүүлэхэд анхаарах асуудлуудыг дараах байдлаар тодорхойлогдож байна. Тухайлбал:

1. Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын менежментийг нэвтрүүлэх, сайжруулахын тулд удирдлага, менежер, судлаачдыг хамруулсан судалгааг үндэсний хэмжээнд зохион байгуулж, өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх;
2. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн хэмжээс, түүний үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулж, найдвартай байдлыг турших, улмаар их, дээд сургуулиудын түвшинд чанарын менежментийг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тогтоох;
3. Дээд боловсролын сургалтын байгууллагуудад чанарын менежментийн нэвтрүүлэхэд удирдлага менежерүүдийг чадавхжуулах, шаардлагатай хүнийг нөөцийг мэргэшүүлэн хангах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах.

#### **2.4. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежмент**

Дээд боловсролын шинэчлэлийн баримт бичгүүдэд стандартын хамгийн бага түвшнийг хангах гэхээсээ чанартай боловсрол олгохыг чухалчлах үзэл баримтлал тусгагдах хандлага түгээмэл байна. Иймд дээд боловсролын сургалтын байгууллагууд чанарын дотоод үнэлгээний үйл явцыг үр дүнтэй удирдах, улмаар чанарын дотоод болон хөндлөнгийн үнэлгээний уялдааг хангахад чиглэсэн нэгдсэн менежментийн тогтолцоо хөгжүүлэх нь чухал юм. Тухайлбал, П.Лоуренс, Ж.Лорш нар нэгдсэн менежментийн тогтолцоог *"Байгууллага дэвшүүлсэн зорилгодоо хүрэхийн тулд бүтцийн нэгжүүд чиг*

үүрэг болон ажлын уялдаа холбоог хангах нэгдсэн тогтолцоо хөгжүүлэх нь чухал” хэмээн тодорхойлжээ<sup>2</sup>.

Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарыг чухалчлах болсныг дараах үндсэн асуудлуудтай уялдуулан авч үзэх боломжтой. Үүнд:

- ✓ *Өрсөлдөөн:* Дээд боловсролын сургалтын байгууллагуудын суралцагч болон хөрөнгө оруулалт, санхүүжилтийн төлөөх өрсөлдөөн даяарчлалаас улбаалан эрчимжиж, үүнд чанарыг чухалчлах болсон.
- ✓ *Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж.* Суралцагчид болон тэдний эцэг, эхчүүд нь мөнгө, цагаа хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, шаардлагыг хангахуйц цогц чадамжийг эзэмшүүлэх чанартай сургалтад зарцуулж байгаадаа анхаарч, боловсролын чанарыг чухалчлах болсон.
- ✓ *Стандарт тогтоолт:* Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарыг тогтвортой байлгах, жил бүр ахиц дэвшил гаргахад сургалтын үйл ажиллагаанаас гадна тоног төхөөрөмж, барилга байгууламжид стандарт тогтоож мөрдлөг болгоход анхаарах болсон.
- ✓ *Хариуцлагын тогтолцоо:* Дээд боловсролын сургалтын байгууллага нь оролцогч талуудын дэмжлэгийг хүртэх, тэдний шийдвэр гаргахад чанарын баталгаажуулалт нөлөөлдөг хэмээн чанарыг үйл ажиллагааны хяналт гэж үзэх болсон.
- ✓ *Ажилтны ёс зүйн төлөвшил:* Дээд боловсролын сургалтын байгууллага нь чанарын тогтолцоо бүрдүүлэхэд ажилтнуудын хариуцсан ажил үүргээ хариуцлагатай гүйцэтгэх ёс зүй төлөвшүүлэх нь чухал хэмээн тэднийг сэдэлжүүлэхэд онцгой анхаарах болсон.
- ✓ *Нэр хүнд, найдвартай байдал:* Дээд боловсролын сургалтын байгууллага нь чанартаа анхаарч, тасралтгүй сайжруулалт нь нэр хүндийн баталгаа, найдвартай байдлыг илэрхийлэх болсон.

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн судалгаанд 2002 оноос өмнө онолын судалгаа давамгайлж байсан бол, харин 2002 оноос хойш эмпирик судалгаа түлхүү хийгдэх болжээ. Судалгааны шинэ салбарт онолын үндэслэлийг бий болгох шинэ санааг чанарын судалгаа дээр

---

<sup>2</sup>[http://faculty.babson.edu/krollag/org\\_site/org\\_theory/Scott\\_articles/lawren\\_lorsch\\_cont.html](http://faculty.babson.edu/krollag/org_site/org_theory/Scott_articles/lawren_lorsch_cont.html)

үндэслэн холимог (тоон, чанар) судалгааны аргаар боловсронгуй болгож, улмаар дараа нь тоон судалгааны аргууд давамгайлж, онолын ажлуудыг туршиж, өргөжүүлдэг байна. Иймээс дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын судалгааны хөгжлийн энэ үе шатанд холимог судалгааны арга нь чанарын менежментийн судалгааны тэргүүлэх чиглэлүүдийн талаарх шаардлагатай ойлголт, мэдлэгийг илүүтэй өгөх боломжтой юм.

**Хүснэгт 2.1. Чанарын менежментийн судалгаанд ашиглаж буй судалгааны аргуудын харьцуулалт, хувиар**

№	Судалгааны аргууд	Сэтгүүлийн төрөл		Дундаж
		Менежмент	Боловсрол	
1	Чанарын судалгаа	25.8	66.7	46.2
2	Тоон судалгаа	41.9	7.7	24.8
3	Холимог (тоон, чанар) судалгаа	32.3	25.6	29.0
	<b>Нийт</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>

Дээрх хүснэгтээс харвал, дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн судалгаанд 46.2 хувь нь чанарын судалгааны арга, 24.8 хувь нь тоон судалгааны арга, үлдсэн 29 хувь нь холимог судалгааны аргыг тус тус ашиглажээ. Харин чанарын менежментийн чиглэлээр хэвлэгдсэн бүтээлүүдийн хувьд боловсролын сэтгүүлд чанарын судалгаа зонхилдог (66.7%) бол менежментийн сэтгүүлд тоон судалгаа дийлэнх хувь (41.9%)-ийг эзэлж байна.

Дээд боловсролын чанарын онол, практикийн хүрээнд хийгдсэн судалгааны ажлуудаас чанарын менежментийн чиглэлээр хийгдсэн зарим судлаачдын бүтээлүүдэд шинжилгээ хийсэн. Тухайлбал:

- ✓ Сила, Эбрахимпур нар 76 судалгааны бүтээлд дүн шинжилгээ хийж, үр дүнг харьцуулан дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментэд нөлөөлөх хүчин зүйл, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлжээ.
- ✓ Овлиа, Аспинвал нар АНУ болон Английн их сургуулиудад хийгдсэн 20 судалгааны бүтээл (АНУ -14, Англи -6)-д дүн шинжилгээ хийж, үр дүнг харьцуулан дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн хамрах хүрээг тодорхойлжээ.
- ✓ Грант нарын судлаачид 18 судалгааны бүтээл (АНУ –9, олон улсын 9)-

д бүтээлд дүн шинжилгээ хийж, их сургуулиудын чанарын менежментийн нөхцөл байдлыг харьцуулжээ.

- ✓ Бэкэт, Брүүкс нар дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн загваруудад шинжилгээ хийж харьцуулжээ (шалгуур үзүүлэлт, дотоод аудит, стандарт).
- ✓ Манатос нарын судлаачид 58 судалгааны бүтээлд дүн шинжилгээ хийж, үр дүнг харьцуулан дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн үндсэн зарчмуудыг тодорхойлжээ.

Дээрх судалгааны үр дүнгээс дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн онол, практикийн судалгааны үндсэн чиглэл дараах байдлаар тодорхойлогдож байна. Үүнд:

1. Чанарын менежментийн хэрэгжүүлэлт,
2. Чанарын менежментийн шалгуур үзүүлэлт,
3. Чанарын менежментийн баталгаажуулалт,
4. Чанарын менежментийн тогтолцоо,
5. Чанарын менежментийн оролцогч талууд,
6. Чанарын менежментэд нөлөөлөх хүчин зүйлс,
7. Чанарын менежментийн стандартчилал.

Энэхүү судалгааны үндсэн чиглэлийн хүрээнд менежмент болон боловсролын сэтгүүлд хэвлэгдсэн 100 орчим судалгааны нийтлэлд түлхүүр үг (*хэрэгжүүлэлт, үнэлгээний шалгуур үзүүлэлт, баталгаажуулалт, тогтолцоо, оролцогч талууд, хүчин зүйлс, стандартчилал*)-ээр сэдэвчилсэн хайлт хийхэд нийт 297 үр дүн гарснаас, 42.8 хувь нь онолын судалгаа, 57.2 хувь нь эмпирик судалгааны үр дүн ба доорх хүснэгтэд нэгтгэн харуулав.

**Хүснэгт 2.2. Чанарын менежментийн судалгааны тойм**

№	Судалгааны үндсэн чиглэл	Судалгааны хэлбэрүүд				Нийт	
		Онол		Эмпирик			
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Чанарын менежментийн хэрэгжүүлэлт	56	44.1	39	22.9	95	32.0
2	Чанарын менежментийн шалгуур үзүүлэлт	19	15.0	38	22.4	57	19.2



**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**

3	Чанарын менежментийн баталгаажуулалт	14	11.0	31	18.2	45	15.2
4	Чанарын менежментийн тогтолцоо	13	10.2	21	12.4	34	11.4
5	Чанарын менежментийн оролцогч талууд	10	7.9	16	9.4	26	8.8
6	Чанарын менежментэд нөлөөлөх хүчин зүйл	8	6.3	15	8.8	23	7.7
7	Чанарын менежментийн стандартчилал	7	5.5	10	5.9	17	5.7
	<b>Нийт</b>	<b>127</b>	<b>100</b>	<b>170</b>	<b>100</b>	<b>297</b>	<b>100</b>

Дээрх хүснэгтээс харвал, дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн онол, практикийн хүрээнд i) чанарын менежментийн хэрэгжүүлэлт (32%), ii) чанарын менежментийн шалгуур үзүүлэлт (19.2%), iii) чанарын менежментийн баталгаажуулалт (15.2%), iv) чанарын менежментийн тогтолцоо (11.4%) зэрэг асуудлууд түлхүү судлагджээ.

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн онолын судалгааны хувьд түлхүүр үгээр сэдэвчилсэн хайлт хийхэд нийт 127 үр дүн гарснаас, 46.5 хувь нь менежментийн сэтгүүлд, үлдсэн 53.1 хувь нь боловсролын сэтгүүлд хэвлэгдсэн ба доорх хүснэгтээр нэгтгэн харуулав.

**Хүснэгт 2.3. Чанарын менежментийн онолын судалгааны тойм**

№	Судалгааны үндсэн чиглэл	Сэтгүүлийн төрөл				Нийт	
		Менежмент		Боловсрол		Тоо	Хувь
		Тоо	Хувь	Тоо	Хувь		
1	Чанарын менежментийн хэрэгжүүлэлт	22	37.3	34	50.0	56	44.1
2	Чанарын менежментийн шалгуур үзүүлэлт	11	18.6	8	11.8	19	15.0
3	Чанарын менежментийн баталгаажуулалт	8	13.6	6	8.8	14	11.0
4	Чанарын менежментийн тогтолцоо	6	10.2	7	10.3	13	10.2
5	Чанарын менежментийн оролцогч талууд	5	8.5	5	7.4	10	7.9
6	Чанарын менежментэд нөлөөлөх хүчин зүйл	4	6.8	4	5.9	8	6.3
7	Чанарын менежментийн стандартчилал	3	5.1	4	5.9	7	5.5
	<b>Нийт</b>	<b>59</b>	<b>100</b>	<b>68</b>	<b>100</b>	<b>127</b>	<b>100</b>

Дээрх хүснэгтээс харвал, дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн онолын судалгааны хүрээнд i) чанарын менежментийн хэрэгжүүлэлт (44.1%), ii) чанарын менежментийн шалгуур үзүүлэлт (15%), iii) чанарын менежментийн баталгаажуулалт (11%) зэрэг

асуудлууд түлхүү судлагджээ. Харин судалгааны нийтлэл хэвлэгдсэн сэтгүүлийн төрлийн хувьд дараах үр дүн гарч байна. Үүнд:

- ✓ Менежментийн сэтгүүлд: i) Чанарын менежментийн хэрэгжүүлэлт (37.3%), ii) Чанарын менежментийн шалгуур үзүүлэлт (18.6%), iii) Чанарын менежментийн баталгаажуулалт (13.6%),
- ✓ Боловсролын сэтгүүлд: i) Чанарын менежментийн хэрэгжүүлэлт (50%), ii) Чанарын менежментийн шалгуур үзүүлэлт (11.8%), iii) Чанарын менежментийн баталгаажуулалт (8.8%) тус тус байна.

Мөн дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн эмпирик судалгааны хувьд түлхүүр үгээр сэдэвчилсэн хайлт хийхэд нийт 170 үр дүн гарснаас, 52.9 хувь нь менежментийн сэтгүүлд, үлдсэн 47.1 хувь нь боловсролын сэтгүүлд хэвлэгдсэн ба доорх хүснэгтээр нэгтгэн харуулав.

***Хүснэгт 2.4. Чанарын менежментийн эмпирик судалгааны тойм***

№	Судалгааны үндсэн чиглэл	Сэтгүүлийн төрөл				Нийт	
		Менежмент		Боловсрол		Тоо	Хувь
		Тоо	Хувь	Тоо	Хувь		
1	Чанарын менежментийн хэрэгжүүлэлт	18	20.0	21	26.3	39	22.9
2	Чанарын менежментийн шалгуур үзүүлэлт	19	21.1	19	23.8	38	22.4
3	Чанарын менежментийн баталгаажуулалт	16	17.8	15	18.8	31	18.2
4	Чанарын менежментийн тогтолцоо	12	13.3	9	11.3	21	12.4
5	Чанарын менежментийн оролцогч талууд	10	11.1	6	7.5	16	9.4
6	Чанарын менежментэд нөлөөлөх хүчин зүйл	9	10.0	6	7.5	15	8.8
7	Чанарын менежментийн стандартчилал	6	6.7	4	5.0	10	5.9
	<b>Нийт</b>	<b>90</b>	<b>100</b>	<b>80</b>	<b>100</b>	<b>170</b>	<b>100</b>

Дээрх хүснэгтээс харвал, дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн эмпирик судалгааны хүрээнд чанарын менежментийн хэрэгжүүлэлт (22.9%), чанарын менежментийн шалгуур үзүүлэлт (22.4%), чанарын менежментийн баталгаажуулалт (18.2%) зэрэг асуудлууд түлхүү судлагдсан бөгөөд судалгааны нийтлэл хэвлэгдсэн сэтгүүлийн төрлийн хувьд дараах үр дүн гарч байна. Үүнд:

- ✓ Менежментийн сэтгүүлд: i) Чанарын менежментийн хэрэгжүүлэлт (20%), ii) Чанарын менежментийн шалгуур үзүүлэлт (21.1%), iii) Чанарын

менежментийн баталгаажуулалт (17.8%),

- ✓ Боловсролын сэтгүүлд: i) Чанарын менежментийн хэрэгжүүлэлт (26.3%),  
ii) Чанарын менежментийн шалгуур үзүүлэлт (23.8%), iii) Чанарын менежментийн баталгаажуулалт (18.8%) тус тус байна.

Харин боловсролын сэтгүүлд хэвлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн судалгааны хувьд түлхүүр үгээр сэдэвчилсэн хайлт хийхэд нийт 139 үр дүн гарснаас, 42.4 хувь нь онолын судалгаа, 57.8 хувь нь эмпирик судалгааны үр дүн ба доорх хүснэгтээр нэгтгэн харуулав.

***Хүснэгт 2.5. Боловсролын сэтгүүлд хэвлэгдсэн чанарын менежментийн судалгааны тойм***

№	Судалгааны үндсэн чиглэл	Судалгааны хэлбэрүүд				Нийт	
		Онол		Эмпирик			
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Чанарын менежментийн хэрэгжүүлэлт	22	37.3	21	26.3	43	30.9
2	Чанарын менежментийн шалгуур үзүүлэлт	11	18.6	19	23.8	30	21.6
3	Чанарын менежментийн баталгаажуулалт	8	13.6	15	18.8	23	16.5
4	Чанарын менежментийн тогтолцоо	6	10.2	9	11.3	15	10.8
5	Чанарын менежментийн оролцогч талууд	5	8.5	6	7.5	11	7.9
6	Чанарын менежментэд нөлөөлөх хүчин зүйл	4	6.8	6	7.5	10	7.2
7	Чанарын менежментийн стандартчилал	3	5.1	4	5.0	7	5.0
	<b>Нийт</b>	<b>59</b>	<b>100</b>	<b>80</b>	<b>100</b>	<b>139</b>	<b>100</b>

Дээрх хүснэгтээс харвал, дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн онол, практикийн хүрээнд боловсролын сэтгүүлд чанарын менежментийн хэрэгжүүлэлт (30.9%), чанарын менежментийн шалгуур үзүүлэлт (21.6%), чанарын менежментийн баталгаажуулалт (16.5%) зэрэг асуудлууд түлхүү хэвлэгджээ.

**Чанарын менежментийн хэмжээс:** Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн хэмжээснүүдийг системтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлсон нь их, дээд сургуулиудад чанарыг системтэй үнэлэх, тасралтгүй сайжруулах суурь нөхцөлийг бүрдүүлж байна.

Ерөнхийдөө бизнес болон дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн хэмжээснүүдийн хооронд ижил төстэй, нийтлэг талууд байгаа нь бизнесийн салбарын сайн туршлагыг судлах, бэнчмаркинг нэвтрүүлэх зэргээр чанарын соёлыг төлөвшүүлэхэд хамтран ажиллах боломжтой юм.

Дээд боловсролын чанарын менежментийн онол, практикийн хүрээнд хийгдсэн судалгааны ажлуудаас дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн хэмжээсийг тодорхойлох чиглэлээр хийгдсэн 12 судалгааны нийтлэл (онол -4, эмпирик -8)-д түлхүүр үгээр сэдэвчилсэн хайлт хийсэн. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн хэмжээсийг 8 гэж 4 нийтлэлд, 7 гэж 5 нийтлэлд, 6 гэж 3 нийтлэлд тус тус тодорхойлсон ба үр дүнг нэгтгэн доорх хүснэгтэд харуулав.

**Хүснэгт 2.6. Чанарын менежментийн хэмжээснүүдийн судалгааны тойм**

№	Судлаачид	Судалгаа төрөл	Чанарын менежментийн хэмжээснүүд	
			Тоо	Хамрах хүрээ
1	Тами нар	Эмпирик	8	Манлайлал; Бодлого, төлөвлөлт; Үйл ажиллагааны менежмент; Тасралтгүй сайжруулалт; Хэрэглэгчийн төвлөрөл; Хамт олны оролцоо; Түншлэл, хамтын ажиллагаа; Гүйцэтгэлийн хяналт, үнэлгээ;
2	Байрактар нар	Онол	8	Манлайлал; Бодлого, төлөвлөлт; Үйл ажиллагааны менежмент; Гүйцэтгэлийн хяналт, үнэлгээ; Хэрэглэгчийн төвлөрөл; Чанарын баталгаажуулалт; Хөтөлбөрийн дизайн; Тасралтгүй сайжруулалт;
3	Детерт нар	Эмпирик	8	Манлайлал; Чанарын баталгаажуулалт; Гүйцэтгэлийн хяналт, үнэлгээ; Хамт олны оролцоо; Түншлэл, хамтын ажиллагаа; Бодлого, төлөвлөлт; Үйл ажиллагааны менежмент; Хэрэглэгчийн төвлөрөл;
4	Сактивел, Ражу	Онол	8	Манлайлал; Бодлого, төлөвлөлт; Үйл ажиллагааны менежмент; Хэрэглэгчийн төвлөрөл; Чанарын баталгаажуулалт; Хамт олны оролцоо; Түншлэл, хамтын ажиллагаа; Тасралтгүй сайжруулалт;
5	Дэвид нар	Эмпирик	7	Манлайлал; Тасралтгүй сайжруулалт; Үйл ажиллагааны менежмент; Хэрэглэгчийн төвлөрөл; Бодлого, төлөвлөлт; Хамт олны оролцоо; Гүйцэтгэлийн хяналт, үнэлгээ;
6	Сахни нар	Эмпирик	7	Манлайлал; Бодлого, төлөвлөлт; Нөөцийн менежмент; Гүйцэтгэлийн хяналт, үнэлгээ;

**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**

				Чанарын баталгаажуулалт; Хөтөлбөрийн дизайн; Үйл ажиллагааны менежмент;
7	Борахан, Зиарати	Эмпирик	7	Тасралтгүй сайжруулалт; Хэрэглэгчийн төвлөрөл; Үйл ажиллагааны менежмент; Хамт олны оролцоо; Нөөцийн менежмент; Чанарын баталгаажуулалт; Хөтөлбөрийн дизайн; Түншлэл, хамтын ажиллагаа;
8	Роза нар	Эмпирик	7	Хамт олны оролцоо; Гүйцэтгэлийн хяналт, үнэлгээ; Түншлэл, хамтын ажиллагаа; Үйл ажиллагааны менежмент; Тасралтгүй сайжруулалт; Манлайлал; Бодлого, төлөвлөлт;
9	Овлиа, Аспринвалл	Онол	7	Манлайлал; Түншлэл, хамтын ажиллагаа; Үйл ажиллагааны менежмент; Тасралтгүй сайжруулалт; Хэрэглэгчийн төвлөрөл; Нөөцийн менежмент; Хамт олны оролцоо;
10	Али нар	Онол	6	Бодлого, төлөвлөлт; Гүйцэтгэлийн хяналт, үнэлгээ; Хөтөлбөрийн дизайн; Чанарын баталгаажуулалт; Нөөцийн менежмент; Тасралтгүй сайжруулалт;
11	Бадри нар	Эмпирик	6	Манлайлал; Бодлого, төлөвлөлт; Хамт олны оролцоо; Тасралтгүй сайжруулалт; Гүйцэтгэлийн хяналт, үнэлгээ; Нөөцийн менежмент;
12	Канди, Тамби	Эмпирик	6	Хамт олны оролцоо; Хөтөлбөрийн дизайн; Чанарын баталгаажуулалт; Манлайлал; Нөөцийн менежмент; Хэрэглэгчийн төвлөрөл;

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн хэмжээснүүд нь үйлдвэрийн салбарт санал болгож буй чанарын хэмжээснүүдтэй ижил төстэй байгаа нь ажиглагдлаа. Судалгааны нийтлэлүүдэд чанарын менежментийн хэмжээсийг дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн хэрхэн амжилттай хэрэгжүүлж болохыг харуулжээ.

**Хүснэгт 2.7. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн хэмжээснүүд**

№	Хэмжээснүүд	Нийтлэлүүд												Нийт	
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Тоо	Хувь
1	Манлайлал	+	+	+	+	+	+	-	+	+	-	+	+	10	83.3
2	Бодлого, төлөвлөлт	+	+	+	+	+	+	-	+	-	+	+	-	9	75.0
3	Үйл ажиллагааны менежмент	+	+	+	+	+	+	+	+	+	-	-	-	9	75.0

**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**

4	Тасралтгүй сайжруулалт	+	+	-	+	+	-	+	+	+	+	+	-	9	75.0
5	Хамт олны оролцоо	+	-	+	+	+	-	+	+	+	-	+	+	9	75.0
6	Гүйцэтгэлийн хяналт, үнэлгээ	+	+	+	-	+	+	-	+	-	+	+	-	8	66.7
7	Хэрэглэгчийн төвлөрөл	+	+	+	+	+	-	+	-	+	-	-	+	8	66.7
8	Чанарын баталгаажуулалт	-	+	+	+	-	+	+	-	-	+	-	+	7	58.3
9	Түншлэл, хамтын ажиллагаа	+	-	+	+	-	-	+	+	+	-	-	-	6	50.0
10	Нөөцийн менежмент	-	-	-	-	-	+	+	-	+	+	+	+	6	50.0
11	Хөтөлбөрийн дизайн	-	+	-	-	-	+	-	-	-	+	-	+	4	33.3
	<b>Нийт</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>7</b>	<b>7</b>	<b>7</b>	<b>7</b>	<b>7</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>85</b>	<b>-</b>

Дээрх хүснэгтээс харвал, дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн 11 хэмжээс тодорхойлогдсоноос хамгийн түгээмэл гэж болох чанарын менежментийн 8 хэмжээс байна. Үүнд:

1. Манлайлал (83.3%),
2. Бодлого, төлөвлөлт (75%),
3. Үйл ажиллагааны менежмент (75%),
4. Тасралтгүй сайжруулалт (75%),
5. Хамт олны оролцоо (75%),
6. Гүйцэтгэлийн хяналт, үнэлгээ (66.7%),
7. Хэрэглэгчийн төвлөрөл (66.7%),
8. Чанарын баталгаажуулалт (58.3%) зэрэг болно.

Эдгээр чанарын менежментийн хэмжээс (*Манлайлал; Бодлого, төлөвлөлт; Үйл ажиллагааны менежмент; Тасралтгүй сайжруулалт; Хамт олны оролцоо; Гүйцэтгэлийн хяналт, үнэлгээ; Хэрэглэгчийн төвлөрөл; Чанарын баталгаажуулалт*)-үүд нь дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын менежментийн тогтолцоо хөгжүүлэх, үнэлэхэд тавигдах шаардлага шалгуур гэж дүгнэж болохоор байна.

Дээд боловсролын сургалтын байгууллага нь сургалтын явц, үр дүнг үнэлэх шалгуур гэж үздэг нийтлэг үзэл баримтлалаас боловсролын үндсэн зорилго, үнэт зүйлсийн хүрээг хамарсан үзүүлэлтүүдийг тодорхойлох нь

чанарын менежмент сайжрах нөхцөл бүрдэнэ. Ер нь чанарын менежмент нь байгууллагын амжилтад нөлөөлөх цорын ганц хүчин зүйл, эсвэл оролцогч талуудыг сэтгэл ханамжийн баталгаа хангагч бус, харин байгууллага дэвшүүлсэн зорилтоо үр дүнтэй хэрэгжүүлэх удирдлагын системийг боловсронгуй болгох менежментийн арга хэрэгсэл юм. Тухайлбал:

- ✓ “Бодлого, төлөвлөлт” чанарын хэмжээс нь байгууллагын түвшинд сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаатай холбоотой чанарын зорилт (жишээ нь: сургалтын чанар, судалгааны эшлэлийн тоо, г.м), түүний гүйцэтгэлийн үр дүнг тодорхойлох асуудал юм.
- ✓ “Үйл ажиллагааны менежмент” чанарын хэмжээс нь дээд боловсролын сургалтын байгууллага боломжит эрсдэлээ үнэлж, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад чухал байдаг.
- ✓ “Хамт олны оролцоо” чанарын хэмжээс нь хүн бүрийг идэвхжүүлэх, урамшуулах зэрэг сэдэлжүүлэлтээр дамжуулан чанарын зорилтдоо хүрэх, тасралтгүй сайжруулалтад түлхэц болдог.
- ✓ “Түншлэл, хамтын ажиллагаа” чанарын хэмжээс нь оролцогч талуудаас хангалттай мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийснээр чанарын удирдлагын зорилго, сургалт-эрдэм шинжилгээний үйл ажиллагаа болон сайжруулалтын шаардлагыг тогтооход чухал юм.

Иймээс байгууллага чанарын менежментийг нэвтрүүлснээр байгууллагын удирдлага, менежерүүд нотолгоонд суурилсан шийдвэр гаргах боломж бүрддэг. Чанарын хяналт, үнэлгээ хийхэд үйл ажиллагааны зохион байгуулалтын амжилтыг үнэлэхэд тохирсон дараах асуудлуудад анхаарах шаардлагатай. Үүнд:

- i) Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (жишээ нь: төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, бүтээлийн эшлэлийн тоо, г.м)-үүд тодорхойлох,
- ii) Үнэлгээний шалгуурын стандартыг тогтоох,
- iii) Одоогийн суурь түвшнийг үнэлэх тогтоох,
- iv) Мэдээллийн сан хөгжүүлэх,
- v) Өгөгдөлд дүн шинжилгээ хийх арга хэрэгсэл (жишээ нь: сургалтын хяналт, оюутны судалгаа, г.м) сонгох, дүн шинжилгээ хийх зэрэг болно.



## 2.5. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн тогтолцоо

Дээд боловсролын сургалтын байгууллагын өмнө нийгмийн хөгжлөөс улбаалсан суралцагчид, үр ашиг хүртэгчид болон сонирхогч талуудын ирээдүйн хэрэгцээ, хүлээлт (чанар)-д чиглэсэн инновацыг нэвтрүүлэхэд өнөөгийн уламжлалт бүтэц, үйл ажиллагааны хэв шинжийг шинэчлэх, улмаар интеграци хийх шаардлага тулгарч байна. Энэхүү интеграци нь дээд боловсролын сургалтын байгууллагад нэгдсэн менежментийн тогтолцоо нэвтрүүлэхэд чиглэх нь чухал бөгөөд бүтцийн нэгжүүд хоорондын үйл ажиллагааны уялдаа сайжрах, захиргааны зардал буурах зэргээр өрсөлдөх давуу байдлыг олж авахад түлхэц болох юм.

Харин дээд боловсролын сургалтын байгууллагын чанарыг зөвхөн төгсөгчдийн чадавх, тэдний хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвар, ажил олгогчдын хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаагаар тодорхойлох нь учир дутагдалтай юм. Нийгмийн институтийн тогтолцоонд дээд боловсролын сургалтын байгууллага нь “Сургалт - Судалгаа - Инновац” гэсэн хосолмол хэв шинжтэй үйл ажиллагаа эрхэлдэг болохыг харгалзан чанарын асуудлыг олон талт зарчмаар үнэлэх нь зохимжтой юм. Иймээс дээд боловсролын сургалтын байгууллага нэгдсэн менежментийн тогтолцоог хөгжүүлэхдээ тэнцвэржүүлсэн үнэлгээний арга (*Balanced scorecard*)-ыг ашиглахын сацуу чанарын менежментийн системтэй уялдуулах нь чухал юм.

Сүүлийн жилүүдэд байгууллагууд стандарт суурилсан нэгдсэн менежментийн тогтолцоо (*HSEQ: Health Safety, Environment and Quality*) буюу Эрүүл мэнд, аюулгүй байдал (*ISO 45001: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо*), Хүрээлэн буй орчин (*ISO 14001: Байгаль орчны менежментийн тогтолцоо*) ба Чанар (*ISO 9001: Чанарын менежментийн тогтолцоо*) нэвтрүүлэх хандлагатай байна. Тодруулбал:

- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн менежментийн тогтолцоо (*ISO 45001:2018 Occupational health and safety management systems*)<sup>3</sup>:  
Энэхүү олон улсын стандарт нь аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны гүйцэтгэлийг

<sup>3</sup> <https://www.iso.org/obp/ui/#iso:std:iso:45001:ed-1:v1:en>



идэвхжүүлэхийн тулд тавигдах шаардлагуудыг тогтоодог. Стандарт нь хэмжээ, үйл ажиллагааны чиглэл, мэргэшлийн түвшнээс үл хамааран аливаа байгууллагад хамаарах тул аж ахуйн нэгжүүд эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны бүх талыг, тухайлбал ажиллагчдын эрүүл мэнд, сайн сайхан байдалд чухал үүрэгтэй юм.

- ✓ Байгаль орчны менежментийн тогтолцоо (ISO 14001:2015 Environmental management systems)<sup>4</sup>: Энэхүү олон улсын стандарт нь аж ахуйн нэгж, байгууллагуудад байгаль орчны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн заавар бөгөөд байгаль орчны менежментийн тогтолцоо бусад менежментийн тогтолцоонуудын зарчим, зохицсон байдал зэргийг хангадаг. Энэхүү заавар нь байгаль орчны менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжүүлэх, хөгжүүлэх сонирхолтой бүх төрлийн байгууллагуудад байгууллагын том, жижгээс үл хамааран тохирно.
- ✓ Чанарын менежментийн тогтолцоо (ISO 9001:2015 Quality management systems)<sup>5</sup>: Энэхүү олон улсын стандарт нь байгууллагын ерөнхий гүйцэтгэлийг сайжруулах, тогтвортой хөгжлийн санаачилгын суурь бий болгоход дэмжлэг болно. Энэхүү стандартыг хэрэгжүүлснээр байгууллага нь дараах ашиг тус хүртэх боломжтой. Үүнд:
  - i) Хэрэглэгчийн шаардлагад нийцэж хэрэглэх боломжтой бүтээгдэхүүн, үйлчилгээг туушдаа нийлүүлэх чадвар,
  - ii) Хуулийн болон зохицуулалтын шаардлагад нийцсэн,
  - iii) Хэрэглэгчийн шаардлагыг дээшлүүлэх боломжийг хөнгөвчлөх,
  - iv) Байгууллагын шинж байдал, зорилтуудтай холбоотой эрсдэл ба боломжуудад чиглэсэн арга хэмжээ авах,
  - v) Чанарын менежментийн тогтолцооны тогтоосон шаардлагад тохирсон байдлыг харуулах чадвар зэрэг болно.

Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын менежментийг нэвтрүүлж, чанарын соёлыг төлөвшүүлэхийг дэмжсэн тогтолцоо бүрдүүлэхэд

<sup>4</sup> <https://www.iso.org/obp/ui/#iso:std:iso:14001:ed-3:v1:en>

<sup>5</sup> <https://www.iso.org/obp/ui/#iso:std:iso:9001:ed-5:v1:en>


чанарын менежмент, түүний шалгуур үзүүлэлтүүдийг стандартчилж мөрдүүлэх нь чухал юм. Ийнхүү үндэсний хэмжээнд чанарын нэгдсэн бодлого, удирдамж, аргачлалыг мөрдлөг болгосноор нэгдсэн үнэлгээ хийх байдлаар дээд боловсролын сургалтын байгууллагуудын чанарын үнэлгээг салбарын хэмжээнд хийж, гүйцэтгэлийн үр дүнг харьцуулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд түлхэц болно.

Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-аас боловсролын байгууллагуудад чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэхэд дэмжлэг болох үүднээс *“ISO 21001:2018 Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо”* стандартыг санал болгодог. Энэхүү стандартыг боловсролын байгууллага хэрэгжүүлснээр чанарын менежментийн тогтолцоогоор дамжуулан хэрэглэгчийн шаардлагыг хангах замаар сэтгэл ханамжийг дээшлүүлэх үйл явцуудыг тогтолцооны хүрээнд ойлгох, тэдгээрийн харилцан үйлчлэлийг төлөвлөх, гүйцэтгэлийг бүхэлд нь хянах, сайжруулах боломж бүрдэнэ.

Дээд боловсролын сургалтын байгууллагад менежментийн тогтолцоо төлөвшүүлэхэд байгууллагын соёл чухал үүрэгтэй байдаг. Байгууллагын соёл гэдэг нь тухайн байгууллагын ажилтнуудын нийтлэг үнэт зүйлс болон туршлагын нэгдэл юм. Байгууллагын соёлоор дамжуулан удирдлага ажилтнуудын олон янзын сонирхол, үзэл бодол, хандлагыг нэгтгэж, нэг зорилгод чиглүүлдэг. Тухайлбал:

- ✓ Байгууллагын гадаад орчны өөрчлөлтөд тогтвортой байдлыг хангах,
- ✓ Байгууллагын бусдаас ялгарах имижийг бүрдүүлж, гадаад орчинд таниулах,
- ✓ Байгууллагын гишүүдийн нэгдмэл, хамтач байдлыг бүрдүүлэх,
- ✓ Байгууллагын стратеги зорилгын биелэлтийг дэмжих үйл ажиллагаанд ажилтнуудыг чиглүүлэх, татан оролцуулах,
- ✓ Байгууллагадаа ажилтны үнэнч байх сэтгэлгээг төлөвшүүлэх,
- ✓ Байгууллагын орчинд ажилтнууд хийх, хийхгүй зүйлийнхээ хэм хэмжээ мэдрэх зэрэг болно.

Улмаар байгууллагын менежментийн тогтолцооны зарчим нь эрхэм зорилгод нийцсэн, бодлого нь алсын хараа руу чиглэгдэж, эдгээр элементүүдийн артикуляц нь стратеги болох ба менежментийн тогтолцооны суурь зарчмыг зурагт харуулав



Эх үүсвэр: ISO 21001

### **Зураг 2.3. Дээд боловсролын сургалтын байгууллагын менежментийн тогтолцооны үзэл баримтлал**

Байгууллагын чанарын бодлого, стратегийн чиглэлд нийцсэн үр дүнд хүргэх үйл явцуудын харилцан үйлчлэл, тэдгээрийг тодорхойлох, удирдах зэргийг үйл явцын арга гэнэ. Иймээс чанарын менежментийн тогтолцоонд үйл явцын аргыг хэрэглэх нь дараах боломжийг бүрдүүлдэг. Үүнд:


- i) Үндсэн шаардлагыг ойлгох, туушдаа хангаж ажиллах,
- ii) Үнэ цэнэ бий болгох талаас үйл явцыг авч үзэх,
- iii) Үйл явцын үр бүтээлтэй гүйцэтгэлийг хангах,
- iv) Үйл явцуудыг өгөгдөл, мэдээлэлд өгсөн үнэлгээнд суурилан сайжруулах зэрэг болно.

Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын менежментийн тогтолцоог эрсдэлд суурилсан сэтгэлгээ болон *PDCA* мөчлөгт тулгуурлан нэвтрүүлснээр дараах боломж бүрдэнэ. Үүнд:

- i) Боломжийг давуу тал болгон ашиглах,
- ii) Тааламжгүй үр дагавраас урьдчилан сэргийлэх,
- iii) Үйл явцыг хангалтай нөөц, зохих удирдлагаар хангах,
- iv) Тасралтгүй сайжруулалт хийх,

v) Үйл явц болон тогтолцоог бүхэлд нь удирдах зэрэг болно.

Дээд боловсролын сургалтын байгууллагын PDCA мөчлөгт суурилсан чанарын менежментийн тогтолцоог зурагт харуулав



Эх үүсвэр: ISO 21001

**Зураг 2.4. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн тогтолцооны суурь загвар**

PDCA мөчлөг (Дэминг цикл) нь чанарын менежментийн онолын үзэл баримтлал, суурь зарчим нь болох ба түүний агуулгыг тодорхойлбол. Үүнд:

- ✓ Төлөвлө (P): Хэрэглэгчийн шаардлага, байгууллагын бодлогод нийцсэн үр дүнд хүргэхэд шаардлагатай нөөцийг тодорхойлж, эрсдэл ба боломжуудыг тогтоох;
- ✓ Хэрэгжүүл (D): Төлөвлөсөн зүйлээ системтэйгээр хэрэгжүүлэх;
- ✓ Үнэл (C): Үйл явц болон бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөсөн үр дүн болон шаардлагын дагуу хянах, хэмжих.
- ✓ Сайжруул (A): Гүйцэтгэлийг шаардлагатай хэмжээнд хүртэл сайжруулах арга хэмжээ авах зэрэг болно.

Дээд боловсролын сургалтын байгууллага нь эрсдэл ба боломжид чиглэсэн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх нь дараах ач холбогдолтой байдаг. Үүнд:

- i) Чанарын менежментийн тогтолцооны үр бүтээлтэй байдлыг дээшлүүлэх,
- ii) Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүрд нь хэрэгжүүлэх,
- iii) Аливаа асуудлаас улбаалсан сөрөг үр дагаврыг бууруулах,
- iv) Аливаа боломжийг бүрэн ашиглах боломж бүрдүүлэх зэрэг болно.

Ерөнхийдөө хяналт шаардлагатай газар мониторинг, хэмжилт хийх цэгүүд үйл явц болгонд онцлог байх ба холбогдох эрсдэлээс хамаардаг. Иймд боломжит асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний хувьд эрсдэлийг тооцох шаардлагатай. Эрсдэл нь ирээдүйд үүсэх тодорхой бус байдлын сөрөг нөлөөлөл юм. Гэхдээ аливаа тодорхойгүй байдал нь эерэг эсвэл сөрөг нөлөө үзүүлдэг.

Дээд боловсролын сургалтын байгууллагын менежментийн тогтолцоонд дараах зарчмуудыг баримталдаг. Үүнд:

- ✓ Суралцагч болон бусад сонирхогч талуудад анхаарал хандуулах,
- ✓ Алсын хараатай манлайлал,
- ✓ Хүмүүсийн бүтээлч оролцоо,
- ✓ Үйл явцын хандлага,
- ✓ Тасралтгүй сайжруулалт,
- ✓ Нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт,
- ✓ Харилцааны менежмент,
- ✓ Нийгмийн хариуцлага,
- ✓ Хүртээмжтэй, шударга байдал,
- ✓ Боловсролын ёс зүй,
- ✓ Мэдээллийн аюулгүй байдал, хамгаалалт зэрэг болно.

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн тогтолцоо нь чанарын зорилгыг хангахуйц олон талт, сайн хэрэгжихүйц, системчлэгдсэн байх шаардлагатай.

Эцэст нь дээд боловсролын сургалтын байгууллагын удирдлагын зүгээс магадлан итгэмжлэлийн гэрчилгээ авахын тулд өөрийн үнэлгээний тайлан бичих байдлаар чанарын менежментийг ёс төдий нэвтрүүлэх нь байгууллагыг эрсдэлд оруулах магадлалтай байдаг. Ер нь зөвхөн төрийн захиргааны болон магадлан итгэмжлэлийн байгууллагуудын шаардлагыг хангахад анхаарч ажилладаг удирдлагын арга барилаас татгалзах нь чухал юм.

## **2.6. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын стандартчилал**

Дээд боловсролын сургалтын байгууллагууд чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэхдээ бусад байгууллагуудын адил ISO 9001:2015 стандартыг баримталдаг. Гэхдээ ISO 9001:2015 стандартын ерөнхий нэр томьёо нь үйлдвэрлэлийн компаниудад шууд чиглэсэн байдаг тул боловсролын байгууллагад ашиглахад хоёрдмол утгатай, зарим хүндрэлтэй асуудлуудтай тулгарч иржээ. Иймээс Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)<sup>6</sup>-аас ISO 21001:2018 менежментийн тогтолцооны шинэ стандартыг гаргасан нь ISO 9001:2015 стандартаас боловсролын байгууллагуудад зориулан тавигдах шаардлагыг нарийвчлан тодорхойлжээ. Дээд боловсролын сургалтын байгууллагад ISO 9001 стандарт нэвтрүүлэлт, түүний үзүүлэх нөлөөллийн талаар цөөнгүй судалгаа хийгдсэнээс зарим судалгааны үр дүнг хураангуйлан хүснэгтэд харуулав.

### ***Хүснэгт 2.8. Дээд боловсролын сургалтын байгууллагад ISO 9001 стандарт нэвтрүүлэлтийн судалгааны тойм***

<b>№</b>	<b>Судлаачид</b>	<b>Судлагдахуун</b>
1	Гамбоа ба бусад (2012)	ISO 9001 стандартад тулгуурлан дээд боловсролын сургалтын байгууллагын стратеги төлөвлөлтийг боловсруулах
2	Эл-Морси ба бусад (2014)	ISO 9001 стандартад тулгуурлан дээд боловсролын сургалтын байгууллагын нэгдсэн менежментийн тогтолцоо болон эрдэм шинжилгээний магадлан итгэмжлэлийн хэрэгжүүлэх

<sup>6</sup> <https://www.iso.org/home.html>

3	Мотури ба бусад (2015)	ISO 9001 стандартаар дээд боловсролын сургалтын байгууллагын мэдээллийн ил тод байдал болон төгсөгчийн чанарыг үнэлэх
4	Сари ба бусад (2017)	Дээд боловсролын сургалтын байгууллагуудад ISO 9001:2008 стандартыг ISO 9001:2015 стандартад шилжүүлэх арга зүй
5	Хуссэйн ба бусад (2017)	ISO 9001 стандартад дээд боловсролын сургалтын байгууллагын профессорын академик эрх чөлөөг авч үзэх боломж
6	Андива ба бусад (2018)	ISO 9001 стандартыг хэрэгжүүлэлтийн явцад дээд боловсролын сургалтын байгууллагын судлаачдын ур чадвар ба сургалтын чанарын хамаарлыг үнэлэх

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн хүрээний судалгаанууд ихэвчлэн ISO 9001 стандарттай холбоотой асуудлыг судалсан бол, харин ISO 21001 стандартын талаар төдийлөн сайн судлагдаагүй байна.

Олон улсын стандартчиллын байгууллага боловсролын байгууллагад санал болгож буй “ISO 21001:2018 Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо” стандарт<sup>7</sup> нь суралцагчид болон бусад оролцогч талуудын шаардлагад нийцсэн, боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад зориулсан менежментийн хэрэгсэл юм. Энэхүү стандартад суурилсан чанарын менежментийн тогтолцоог дээд боловсролын сургалтын байгууллага нэвтрүүлсний ач холбогдол дараах байдлаар тодорхойлогдож байна (EQUAF). Үүнд:


- ✓ Бодлоготой зорилт, үйл ажиллагааг илүү сайн зохицуулах;
- ✓ Бүх талын хүртээмжтэй, чанартай боловсрол олгох замаар нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх;
- ✓ Үр дүнтэй байдал, үр ашгийг нэмэгдүүлж, харуулахад чиглэсэн байнгын үйл явц ба үнэлгээний хэрэгсэл;
- ✓ Боловсролын байгууллагын найдвартай байдлыг дээшлүүлэх;
- ✓ Чанарын менежментийн үр дүнтэй хэрэгжүүлж буй туршлагыг харуулах;
- ✓ Байгууллагын сайжруулалтын соёлыг хөгжүүлэх;
- ✓ Олон улс, бүс нутгийн түвшний стандарт болон тогтолцоонд нийцүүлэх;

<sup>7</sup> <https://www.iso.org/obp/ui/#iso:std:iso:21001:ed-1:v1:en>

- ✓ Сонирхогч талуудын оролцоог өргөжүүлэх;
- ✓ Төгс байдал, инновацыг урамшуулах;

“ISO 21001:2018 Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо” стандартын бүх шаардлагууд нь ерөнхий бөгөөд сургах, суралцах, судалгаа шинжилгээ хийх замаар мэдлэг чадварыг хөгжүүлэхэд сургалтын хөтөлбөр ашиглаж, дэмжлэг үзүүлдэг ямар ч байгууллагууд төрөл, хэмжээ, хүргэх арга зэргээс үл хамааран хэрэглэх боломжтой тул байгууллагад сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлтийг ойлгож мэдрэх боломж олгодог.

Дээд боловсролын хувьд стандартын шаардлага нь “Суралцагч – Хөдөлмөрийн зах зээл – Засаглал” гэсэн гурвалсан холбооны хүрээнд сэтгэл ханамжийг бий болгох юм



Эх үүсвэр: EQAF

### Зураг 2.5. ISO 21001 стандарт ба дээд боловсрол

Энэхүү стандарт нь боловсролын байгууллага, суралцагч, хэрэглэгч, бусад сонирхогч талуудын хоорондын өвөрмөц харилцан үйлчлэл дээр төвлөрсөн биеэ даасан стандарт боловч бусад менежмент (ISO 9001, ISO 14001)-ийн стандартуудтай суурь зарчим, бүтцийн хувьд уялддаг.

Иймээс чанарын менежментийн стандартууд болох ISO 9001:2015 болон ISO 21001:2018 стандартуудыг сонгон авч бүтэц болон агуулгын хувьд харьцуулалт хийж, гол үр дүнгүүдийг нэгтгэн хүснэгтээр харуулав.

### Хүснэгт 2.9. ISO 9001:2015 ба ISO 21001:2018 стандартуудын харьцуулалт

№	Хэмжээс	ISO 9001:2015	ISO 21001:2018
1	Байгууллагын төлөв байдал	4; 2 (4.4)	4; 2 (4.4)



2	Манлайлал	3; 2 (5.1), 2 (5.2) ✓ Хэрэглэгч,	3; <b>3 (5.1)</b> , 2 (5.2) ✓ Суралцагч ба бусад үр ашиг хүртэгчид, ✓ Тусгай хэрэгцээт боловсрол
3	Төлөвлөлт	3; 2 (6.1), 2 (6.2)	3; 2 (6.1), 2 (6.2) Суралцахуйн нөөцийг чухалчилсан
4	Дэмжих үйл явц	5; 6 (7.1), 3 (7.5); 2 (7.1.5), 2 (7.5.3) ✓ Хүмүүс, ✓ Дэд бүтэц, ✓ Нийгэм + сэтгэл зүй,	5; 6 (7.1), <b>2 (7.2)</b> , <b>3 (7.4)</b> , 3 (7.5); <b>2 (7.1.1)</b> , <b>2 (7.1.2)</b> , <b>3 (7.1.3)</b> , 2 (7.1.5), <b>2 (7.1.6)</b> , <b>2 (7.4.3)</b> , 2 (7.5.3) ✓ Хүний нөөц ✓ Факультет (Дижитал орон зай г.м) ✓ Сэтгэлзүй, ✓ Баримтжуулсан мэдээлэл (сургалтын хөтөлбөр г.м),
5	Үйл ажиллагаа	7; <b>4 (8.2)</b> , 6 (8.3), 3 (8.4), 6 (8.5), 2 (8.7); <b>2 (8.2.3)</b> ✓ Бүтээгдэхүүн, үйлчилгээ,	7; <b>3 (8.1)</b> , 3 (8.2), 6 (8.3), 3 (8.4), 6 (8.5), <b>3 (8.7)</b> ; <b>4 (8.3.4)</b> , <b>6 (8.5.1)</b> ; <b>2 (8.3.4.1)</b> , <b>2 (8.5.1.2)</b> , <b>4 (8.5.1.6)</b> ✓ Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ (суралцахуйн үр дүн, үнэлгээ гэх мэт), ✓ Суралцагчдын мэдээллийн нууцлал, илт тод байдал,
6	Гүйцэтгэлийн үнэлгээ	3; 3 (9.1), 2 (9.2), 3 (9.3)	3; <b>5 (9.1)</b> , 2 (9.2), 3 (9.3); <b>2 (9.1.2)</b> , <b>2 (9.1.4)</b> ✓ Гомдол, саналын шийдвэрлэлт, ✓ Ажилтны санал хүсэлт, үнэлгээ нь удирдлагын дүн шинжилгээний нэг хэлбэр болох,
7	Сайжруулалт	3; <b>2 (10.2)</b>	3; <b>2 (10.1)</b>

ISO 9001:2015 болон ISO 21001:2018 стандартуудын харьцуулалтын үр дүнг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

- ✓ *Нэр томъёо, агуулгын хувьд:* ISO 21001:2018 стандарт нь ISO 9001:2015 стандарттай харьцуулахад шинэ нэр томъёоны агуулгын өөрчлөлтийг тодруулсан, тухайлбал: *“Тусгай хэрэгцээт боловсрол” гэсэн хэллэг анх оруулсан* гэх мэт.
- ✓ *Бүтцийн хувьд:* ISO 21001:2018 стандарт нь ISO 9001:2015 стандарттай харьцуулахад бүтцэд гарсан өөрчлөлтийг тодруулж тод хар (Bold)-аар тэмдэглэсэн, тухайлбал: *“5; 6 (7.1), **2 (7.2)** - ISO 21001:2018 стандартын “Дэмжих үйл явц” хэмжээс нь 5 шалгуур ба 7.1 нь 6 үзүүлэлттэй, харин 7.2 шалгуур нь 2 үзүүлэлттэй ба ISO 9001:2015 стандарттай харьцуулахад өөрчлөгдсөн* гэх мэт.

ISO 21001:2018 стандарт нь 7 хэмжээс, 28 шалгуур бүхий бүтэцтэй ба хүснэгтээр нэгтгэн харуулав.

**Хүснэгт 2.10. ISO 21001:2018 стандартын бүтэц ба хамрах хүрээ**

№	Хэмжээс	Шалгуур
1	Байгууллагын төлөв байдал	4.1. Байгууллагын төлөв байдлыг ойлгох (1), 4.2. Сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлтийг мэдрэх (1), 4.3. Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны хамрах хүрээг тогтоох (1), 4.4. Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо (2),
2	Манлайлал	.1. Манлайлал ба үүрэг амлалт (3), .2. Бодлого (2), .3. Зохион байгуулалтын үүрэг, хариуцлага, эрх мэдэл (1),
3	Төлөвлөлт	6.1. Эрсдэл болон боломжуудыг авч үзэх (2), 6.2. Боловсролын байгууллагын зорилтууд, тэдгээрийн хэрэгжүүлэлтийн төлөвлөлт (2), 6.3. Өөрчлөлтийн төлөвлөлт (1),
4	Дэмжих үйл явц	1.1. Нөөц (6), 1.2. Чадамж (2), 1.3. Мэдлэг ойлголт (1), 1.4. Харилцаа холбоо (3), 1.5. Баримтжуулсан мэдээлэл (3),
5	Үйл ажиллагаа	8.1. Үйл ажиллагааны төлөвлөлт ба хяналт (3), 8.2. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих шаардлага (3), 8.3. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний дизайн ба хөгжүүлэлт (6), 8.4. Гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт (3), 8.5. Боловсролын бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэх (6), 8.6. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргах (1), 8.7. Боловсролын үл тохирол бүхий гаралтын хяналт (3),
6	Гүйцэтгэлийн үнэлгээ	9.1. Хяналт, хэмжилт, шинжилгээ ба үнэлгээ (5), 9.2. Дотоод аудит (2), 9.3. Удирдлагын дүн шинжилгээ (3),
7	Сайжруулалт	10.1. Үл тохирол ба залруулах арга хэмжээ (2), 10.2. Тасралтгүй сайжруулалт (1), 10.3. Сайжруулалт хийх боломжууд (1),

ISO 9001 болон ISO 21001 стандартуудыг харьцуулсан чанарын шинжилгээнээс дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Стандартуудын бүтэц 10 бүлэг бүхий ижил бүтэцтэй тул шууд харьцуулах боломжтой байна. Харин ISO 21001 стандартыг ISO 9001 стандарттай харьцуулахад өргөн хүрээнд нарийвчлан авч үзжээ.

2. ISO 21001 стандарт нь боловсролын байгууллагад зориулагдсан тул "суралцагч" ("бусад ашиг хүртэгчид") "сургалтын хөтөлбөр", "сургалтын үр дүн" гэх мэт салбарын онцлогийг илэрхийлсэн нэр томъёо түгээмэл ашиглажээ. Мөн боловсролын байгууллагын үйлчлүүлэгчид нь бизнесийн байгууллагын үйлчлүүлэгчдээс ялгаатай нь үйл ажиллагаанд тогтмол идэвхтэй оролцдог болохыг онцлон тусгасан.
3. Боловсролын байгууллагын менежмент нь бусад байгууллагын менежментээс илүү төвөгтэй болохыг тодотгож, улмаар “тусгай хэрэгцээт боловсрол”-ыг нарийвчлан тусгажээ.
4. Боловсролын байгууллагууд чанарын менежментийн тогтолцооны хувьд ISO 21001 стандартыг нэвтрүүлэх нь чухал юм.

ISO 21001 стандартын гэрчилгээ нь уг байгууллагын зохион байгуулалт сайн, хэрэгжүүлж буй хөтөлбөр, түүний үр дүн нь дэвшүүлсэн зорилго, зорилт болон хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд бүрэн нийцэж буйг баталгаажуулах хэдий ч тухайн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлж буй сургалтын агуулга нь боловсролын тодорхой стандартад нийцэж буй эсэхийг батламжилдаггүй.

Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын нэгдсэн удирдлагыг нэвтрүүлэхэд анхаарал хандуулах нь чухал юм. Чанарын нэгдсэн менежмент (Total quality management) нь бүтээгдэхүүний чанарыг тогтоох, хангах, хүрсэн түвшинд хадгалах зорилгоор түүнийг бий болгох, ашиглах буюу хэрэглэх үед нөлөөлөх бүхий хүчин зүйлсийг харгалзан үзэх байдлаар хэрэгжүүлэлтийн үйл ажиллагааны нэгдлийг илэрхийлдэг. Иймээс бүтээгдэхүүний амьдралын орчлын үе шат бүрд чанарын менежментийн нэгдсэн тогтолцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх нь чухал юм.

Харин чанарын нэгдсэн менежментийн систем гэдэг нь үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд бүтээгдэхүүний амьдралын орчлын үе шатуудад дахь менежментийн зарчим, чиг үүргүүдийн болон менежментийн объект, субъектийн нэгдэл юм. Чанарын нэгдсэн менежментийн үндсэн объект нь бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үе шатуудад чанарыг бүрдүүлж хангаж буй түүний үнэт зүйл, нөлөөлөх хүчин зүйл, үйл явц болно. Чанарын менежментийн субъект нь удирдлагын болон нийтээр хүлээн зөвшөөрсөн

зарчмын дагуу чанарын менежментийг шаталсан янз бүрийн түвшинд хэрэгжүүлж байгаа байгууллага, хүмүүс багтана.

## **2.7. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний систем**

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээг үр дүнтэй байлгахын тулд, түүний үйл явцыг тухайн байгууллагын эрхэм зорилгод нийцүүлэх байдлаар “*Бүтцийн нэгж - Байгууллага -Нийгэм*” гэсэн гурван түвшинд цогц байдлаар авч үзэх нь чухал юм. Энэхүү босоо интеграцийн хүрээнд чанарын үнэлгээ, сайжруулалтыг тасралтгүй системтэй хэрэгжүүлэх нь дээд боловсролын сургалтын байгууллагын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд түлхэц болдог. Пинеиро нарын судлаачид дээд боловсролын сургалтын байгууллагын чанар нь иргэний нийгэмтэй хэрхэн хамтарч, нийгмийн эрэлт хэрэгцээг яаж хангаж, үр өгөөжийг дээшлүүлэхэд хир зэрэг манлайлалтай оролцож байгаагаас хамаарах тул дараах асуудлуудыг харгалзах шаардлагатай гэжээ. Үүнд:

- ✓ Мэдлэгийн солилцоо нь заах арга зүй, судалгаа хийхтэй холбоотой байх,
- ✓ Сонирхогч талуудын хүртэх үр ашиг нь бүтээгдэхүүн, үйлчилгээ эсвэл агуулгаар дамжин хүрдэг байх,
- ✓ Хамтын ажиллагаа нь үндсэн үйл ажиллагааг дэмжих, нөөцийг бүрдүүлэх чухал хэрэгсэл болдог байх,
- ✓ Үндсэн үйл ажиллагааны сайжруулалтын хамрах хүрээ нь чанараар тодорхойлогдог байх зэрэг болно.

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ нь хүчтэй болон давуу талуудаа тодорхойлох, улмаар үйл ажиллагаагаа сайжруулахад чиглэгддэг болохоор чанарын нэгдсэн менежментийн хүрээний стратеги болдог тул “Чанарын үнэлгээ = Системчлэл + Хэмжилт + Менежмент” (Хиллман) гэсэн зарчимд тулгуурладаг. Свенссон нарын судлаачид дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний системийг дараах зурагт харуулсан байдлаар тодорхойлжээ.



**Зураг 2.6. Чанарын үнэлгээний систем**

- ✓ Чанарын дотоод баталгаажуулалт: Чанарын үнэлгээтэй холбоотой сайжруулалтад чиглэгдсэн үйл явц.
- ✓ Чанарын хөндлөнгийн үнэлгээ: Чанарын үнэлгээнд сонирхогч талуудын оролцох үйл явц.
- ✓ Магадлан итгэмжлэл: Албан ёсны эрх бүхий гуравдагч этгээд чанарыг батламжлах үйл явц.


Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний систем нь тасралтгүй үргэлжлэх үйл явц болохоос нэг удаагийн магадлан итгэмжлэгдэх үйл ажиллагаа гэж ойлгож болохгүй тул дээр дурдсан чанарын үнэлгээний уялдаа, тэнцвэрт байдлыг хангахад анхаарах нь чухал юм.

Түүнчлэн дээд боловсролын сургалтын байгууллагын эрхэм зорилго нь мэдлэгийн гурвалжин буюу “Сургалт - Судалгаа – Инновац” гэсэн үзэл баримтлалтай уялдах болсноор дотоод болон хөндлөнгийн чанарын үнэлгээг хэрхэн, яаж үр дүнтэй хийх, үнэлгээний шалгуур, аргачлалыг оновчтой сонгох

асуудал чухлаар тавигдаж байна. Блэкморын авч үзсэнээр дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээг дараах үндсэн гурван зарчимд тулгуурлан хийхэд анхаарах нь чухал гэжээ. Үүнд:

1. Чанарын баталгаажуулалтын системд нийцэж байгаа эсэхийг нягтлах,
2. Үндэсний стандартын шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгах,
3. Байх ёстой хэм хэмжээнд нь хүргэх зэрэг болно. Дээд боловсролын хувьд стандартын шаардлага нь “Суралцагч – Хөдөлмөрийн зах зээл – Засаглал” гэсэн гурвалсан холбооны хүрээнд сэтгэл ханамжийг бий болгох юм

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын баталгаажуулалтыг дотоод болон хөндлөнгийн гэж ангилдаг. Харин хөндлөнгийн чанарын баталгаажуулалтыг эрх бүхий хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагаар магадлан итгэмжлүүлэх үйл явц юм. Ерөнхийдөө магадлан итгэмжлэлийг сайн дурын үндсэн дээр хийлгэдэг боловч чанарын менежментийн тогтолцоо, үйл явцад баталгаажуулалт хийж, батламжлах үйл явц тул тухайн байгууллагын чанарт суралцагч болон сонирхогч талуудад итгэл үнэмшил төрүүлж, итгэлцэл бий болгох, өрсөлдөх давуу талыг олж авахад чухал нөлөө үзүүлдэг. Түүнчлэн магадлан итгэмжлэл нь дотоод чанарын баталгаажуулалтай уялдаатай төдийгүй чанарын сайжруулалттай холбож ойлгох нь чухал юм.



Зураг 2.7. Чанарын үнэлгээний босоо ба хэвтээ интеграц

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний босоо ба хэвтээ интеграци нь чанарын үнэлгээ ба стратеги хоорондын зөрүүг арилгах, менежментийн тогтолцоонд нэгтгэх боломжтой болдог. Чанарын үнэлгээний хэвтээ интеграци нь дээд боловсролын сургалтын байгууллагын үзэл баримтлал болох “Сургалт - Судалгаа – Инновац”-ын уялдааг хангах, гүйцэтгэлийг чанарын үнэлгээний системээр дамжуулан үнэлэх буюу чанарын үнэлгээ ба стратеги (эрхэм зорилго) хоорондын уялдааг хангахад чиглэгдэнэ. Харин чанарын үнэлгээний босоо интеграци нь дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээний систем бий болгох, чанарын үнэлгээнд сонирхогч талуудын оролцоог хангахад түлхэц болно.

Иймээс дотоод чанарын баталгаажуулалт болон хөндлөнгийн чанарын үнэлгээний уялдааг хангахад анхаарал хандуулах нь чухал юм. Дотоод чанарын баталгаажуулалт нь байгууллага өөрийн хүрээнд хийсэн дотоод аудит (хөндлөнгийн оролцоогүй эсвэл өөрсдийн оролцоогүй)-ын үйл явц юм. Харин хөндлөнгийн чанарын үнэлгээ нь байгууллага болон хөтөлбөрийн хувьд чанарын төлөв байдал, ерөнхий дүр төрхийг тодорхойлох хөндлөнгийн аудитын үйл явц болно. Ер нь дотоод чанарын баталгаажуулалт болон хөндлөнгийн чанарын үнэлгээг амжилттай хэрэгжүүлэхэд үнэлгээний үйл явцад оролцогч талуудын оролцоог хангах, гүйцэтгэх үүрэгт анхаарах нь тэднийг өөрсдийнхөн зорилгоор дамжуулан чанарын зорилго руу чиглүүлэхэд оршино.

**Бенчмаркинг ба чанарын үнэлгээ:** Бенчмаркинг нь боловсролын салбарын хувьд харьцангуй шинэ ойлголт бөгөөд чанарыг тасралтгүй сайжруулахад маш чухал ач холбогдолтой. Учир нь салбарын хамгийн сайн туршлагыг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэх үйл явц тул чанарыг сайжруулах менежментийн арга хэрэгслүүдийн нэг болдог. Иймээс дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын менежментийн хүрээнд бенчмаркинг хэрэгжүүлэх үндсэн хоёр хандлага байна. Үүнд:

- i) Салбарын тэргүүлэгч байгууллагуудын чанарын сайн туршлага (бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явц)-аас суралцаж, нутагшуулах,
- ii) Бусад салбарт амжилттай хэрэгжүүлж байгаа чанарын үнэлгээний систем, аргачлалыг нэвтрүүлэх.

Ерөнхийдөө чанарын олон талт хэв шинжээс улбаалан бүс нутаг, улс орон болон байгууллагын онцлогтой уялдуулсан чанарын үнэлгээний өөр өөр загварыг дэлхий дахинд ашиглаж байна. Эдгээр загварууд нь ихэвчлэн үйл ажиллагааны явцад чиглэж чанарын үнэлгээний системийг бий болгохыг чухалчилдаг ба практикт түгээмэл ашигладаг дараах загваруудыг авч үзлээ. Үүнд:

- i) Малколм Боодрижийн загвар,
- ii) Чадвар төлөвшлийн загвар,
- iii) 6 Сигма загвар,
- iv) Чанарын үнэлгээний хэрэгсэл.

Боодрижийн загвар: АНУ-ын Конгрессоос 1987 онд үндэсний чанарын мэдлэгийг дээшлүүлэх, чанарын баталгаажуулалтыг дээшлүүлэх зорилгоор “Малколм Боодрижийн үндэсний чанарын шагнал” бий болгожээ. Энэхүү боловсролын чанарын баталгаажуулалтын шалгуур нь боловсролын байгууллагуудад нэгдсэн чанарын менежмент нэвтрүүлэхийг дэмжих зорилгоор нэгдсэн үнэлгээний аргачлалыг ашигласнаар дараах үр дүнд хүрнэ хэмээн тодорхойлжээ. Үүнд:

- ✓ Боловсролын чанарын сайжруулалт нь суралцагч болон сонирхогч талуудын хүртэх үнэ цэнэ, өгөөжийг тасралтгүй нэмэгдүүлэхэд дэмжлэг болох,
- ✓ Чанарын менежментийн тогтолцоо нь байгууллагын үр ашиг, чадавхыг сайжруулахад дэмжлэг болох,
- ✓ Чанарын баталгаажуулалт нь байгууллага болон хувь хүний сургалтын чанарыг дээшлүүлэхэд дэмжлэг болох.

Боодрижийн загвараар боловсролын байгууллагын чанарын үнэлгээ нь 7 хэмжээс, 19 шалгуураар нийт 1000 хүртэлх оноогоор үнэлдэг ба үнэлгээний зарчмыг долоон хэмжээсний хувьд тодруулбал. Үүнд:

1. *Манлайлал*: Байгууллагын удирдлага нь хэрхэн байгууллагынхаа тогтвортой хөгжлийг хангаж, хууль эрх зүй болон нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж байгааг дараах шалгуураар үнэлнэ:



- ✓ Удирдлагын манлайлал,
  - ✓ Нийгмийн хариуцлага,
2. *Стратеги*: Байгууллагын стратегийн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө болон түүний хэрэгжилт, шинэчлэл өөрчлөлт, гарч буй ахиц дэвшлийг дараах шалгуураар үнэлнэ:
- ✓ Стратеги боловсруулалт,
  - ✓ Стратегийн хэрэгжүүлэлт,
3. *Шаардлага, хүлээлт*: Суралцагч, сонирхогч талууд болон зах зээлийн шаардлага, хүлээлтийг тодорхойлж буй байдал болон тэдгээртэй тогтоосон харилцааг дараах шалгуураар үнэлнэ:
- ✓ Суралцагч, сонирхогч талууд, болон зах зээлийн талаарх мэдлэг, ойлголт,
  - ✓ Суралцагч болон сонирхогч талуудын харилцаа, сэтгэл ханамж,
4. *Сайжруулалт*: Байгууллага үйл ажиллагааны гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийн санг бүрдүүлж, улмаар дүн шинжилгээ хийх байдлаар сайжруулалт хийж байгааг дараах шалгуураар үнэлнэ:
- ✓ Байгууллагын үйл ажиллагааны хэрхэн явагдаж буйг тодорхойлох, дүн шинжилгээ хийж, нягтлах байдал,
  - ✓ Мэдээлэл, мэдлэгийн менежмент,
5. *Оролцоо*: Байгууллагын удирдлагын зүгээс хувь хүн болон байгууллагын хөгжлийг хангахад чиглэсэн сургалт болон урамшууллын тогтолцоо, таатай орчин, уур амьсгалыг бүрдүүлснийг дараах шалгуураар үнэлнэ:
- ✓ Ажил үүргийн тогтолцоо,
  - ✓ Багш, ажилтнуудад чиглэсэн сургалт, урамшууллын систем,
  - ✓ Багш, ажилтнуудын сэтгэл ханамж,
6. *Үйл явц*: Суралцагчдад санал болгож буй сургалтын хөтөлбөрийн зохион байгуулалт, үйлчилгээ, үйл явцын менежментийг дараах шалгуураар үнэлнэ:
- ✓ Сургалтад чиглэсэн үйл ажиллагаа,

- ✓ Мониторинг, дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа,
- 7. *Гүйцэтгэл*: Суралцагчийн сургалтын үр дүн, багш ажилтнуудын бүтээмж, манлайлал болон нийгмийн хариуцлагын асуудлыг дараах шалгуураар үнэлнэ:
  - ✓ Суралцагчийн үр дүн,
  - ✓ Суралцагч болон сонирхогч талуудад чиглэсэн үйл ажиллагааны үр дүн,
  - ✓ Төсөв, санхүү болон зах зээл рүү чиглэсэн үйл ажиллагааны үр дүн,
  - ✓ Багш, ажилтнуудын үйл ажиллагааны ажиглалтын үр дүн,
  - ✓ Байгууллагын үр ашгийн үр дүн,
  - ✓ Манлайлал, нийгмийн хариуцлагын ажиглалтын үр дүн.

Боловсролын байгууллын чанарын менежментийг дээрх 7 хэмжээсээр үнэлэхдээ тодорхой оноо бүхий шалгуур үзүүлэлтүүдийг ашигладаг ба доорх хүснэгтээр харуулав.

***Хүснэгт 2.11. Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд тавих  
Боодрижийн шалгуур үзүүлэлт***

№	Хэмжээс	Үнэлгээ	
		Тоо	Хувь
1	Манлайлал	120	12.0
2	Стратеги	85	8.5
3	Шаардлага, хүлээлт	85	8.5
4	Сайжруулалт	90	9.0
5	Оролцоо	85	8.5
6	Үйл явц	85	8.5
7	Гүйцэтгэл	450	45.0
	<b>Нийт үнэлгээ</b>	<b>1000</b>	<b>100</b>

*Чадвар төлөвшлийн загвар*: АНУ-ын нисэх хүчинд “Чадвар төлөвшлийн загвар”-ыг программ хангамжийн төсөл хэрэгжүүлэхийн тулд гэрээт компаниудын чадавхыг тогтоох зорилгоор анх боловсруулан ашиглажээ. Уг загварыг байгууллага эрхэм зорилгоо биелүүлэхэд чиглэсэн үндсэн үйл ажиллагааг үнэлэх, чадавхыг дээшлүүлэхэд ашиглах боломжтой. Энэхүү загварт байгууллагуудыг “*Төлөвшсөн - Төлөвшөөгүй*” гэж ангилдаг. Үүнд:

- ✓ Төлөвшсөн байгууллага: Байгууллага удирдлага нь аливаа асуудлыг бүрэн шийдвэрлэх чадвартай буюу урьдчилан төлөвлөсөн чанарын үр дүнд хүргэх тогтвортой үйл ажиллагаа явуулдаг,
- ✓ Төлөвшөөгүй байгууллага: Байгууллагын удирдлага нь гэнэтийн асуудал, бэрхшээлийг шийдвэрлэх байдлаар үйл ажиллагаа нь тухайн үүссэн нөхцөл байдлаас хамаарч явагддаг, бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанарыг урьдчилан таамаглахад хэцүү.


Энэхүү загварт процессын болон чадавхын үнэлгээг 6 үе шатаар гүйцэтгэдэг. Үүнд:

- ✓ Үнэлгээ, тодорхойлолтыг гүйцэтгэх багийг бүрдүүлэх.
- ✓ Үнэлгээ, тодорхойлолт хийлгэх байгууллагын төлөвшлийг тодорхойлох түүвэр асуумжийг боловсруулах.
- ✓ Тайлбарлах шаардлагатай гол чиглэлийг тодорхойлохын тулд хариултуудад дүн шинжилгээ хийх.
- ✓ Үндсэн үйл ажиллагааны зорилго биелсэн эсэхийг тогтоохын тулд багийн гишүүд ярилцлага хийх, бичиг баримттай танилцаж нягтлах зорилгоор үнэлгээ, тодорхойлолт хийлгэх байгууллага дээр ажиллах.
- ✓ Давуу, сул талуудыг тодорхойлсон жагсаалт гаргах.
- ✓ Хүсэлт гаргагч байгууллагын үндсэн үйл ажиллагааны зорилго биелсэн болон биелээгүй тохиолдлуудыг талаар танилцуулахаар бэлтгэх.

6 сигма загвар: Энэхүү загварыг 1980-аад оны эхээр чанарын үнэлгээ хийх зорилгоор Motorola компани боловсруулсан ба General electric, Ford, Delphi, Texas Instruments, Sony, Polaroid, 3M болон American Express зэрэг томоохон компаниуд өргөн ашигладаг. Мөн томоохон их сургуулиуд сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээ, сайжруулалтад уг загварыг ашиглаж байна.

Энэ загвар нь харилцагчдад тавих анхаарал ба үйл явцын бүтээлч сайжруулалтын уялдааг хангах буюу үйл ажиллагааны зөрчил нь өртөг болон үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшинд хүчтэй нөлөөлдөг гэсэн үзэл баримтлалд тулгуурладаг. Энэ нь голчлон үйлдвэрлэлийн болон бизнесийн процесст алдаа, дутагдлыг илрүүлэх, засч залруулахад ашиглагддаг. Арга

зүйн хувьд байгууллагын одоо байгаа ажлын системийн сайжруулалтыг зурагт харуулсан дараалсан аргаар гүйцэтгэдэг.



**Зураг 2.8. 6 Сигма, түүний үе шат**

Иймээс 6 Сигмагийн үе шатыг одоо байгаа ажлын тогтолцоог сайжруулах, шинэ систем бий болгох, ажлыг удирдах гэсэн нөхцөлт байдлаар гурван бүлэгт хувааж болно. Үүнд:

- ✓ Тодорхойлох: Төслийн баг бүрдүүлж, зорилго, зорилтуудтай тодорхойлж, түүнийгээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, эрх мэдэл болон хариуцлагын механизм бүрдүүлнэ.
- ✓ Хэмжих: Одоо байгаа үйл явцыг хэмжих шалгуур үзүүлэлт, стандарт боловсруулж, мэдээлэл цуглуулж, асуудлыг шийдвэрлэхэд гажуудсан шалтгааныг тодорхойлно.
- ✓ Дүн шинжилгээ хийх: Тодорхойлсон хазайлтыг шинжилж, түүний шалтгааныг тодруулж, арилгах арга замыг тодорхойлно. Энэ үе шатанд шалтгаан ба үр дагаврын диаграмм, шүүмжлэлт сэтгэлгээ, мөн үйл ажиллагааны график (scatter plots), таамаглалыг шалгах, зөрчлийн дүн шинжилгээ зэрэг статистик арга хэрэгслийг ашигладаг.
- ✓ Сайжруулах: Ажлын явц, системийг сайжруулах арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлнэ. Энэ үе шатанд ажилтнуудын сургалт, ажлын

шинэ аргуудыг нэвтрүүлэх, туршлага солилцох, өмнөх шатанд сонгосон шинэ аргуудыг хэрэгжүүлэх арга хэмжээ авах боломжтой.

- ✓ Хянах: Сайжруулсан үйл явцыг стандартжуулах ажил хийгдэх ба чанарын байнгын хяналт тавина.

Чанарын үнэлгээний хэрэгсэл: Чанарын баталгаа бол ухамсартай, төлөвлөсөн процесс бөгөөд тиймээс бид чанарыг хангах зарим хэрэгсэл, механизмтай байх ёстой. Хэдийгээр чанар нь хийсвэр ойлголт боловч чанарыг баталгаажуулах олон хэмжээс бүхий хэрэгслүүд байдаг. Эдгээр арга хэрэгсэл, техникийг ашигласнаар бид дээд боловсролын сургалтын байгууллагуудын чанарыг баталгаажуулдаг. Ишикава (1982) нь баг, хувь хүмүүс хамгийн их мэдээлэл олж авах боломжтой мэдээллийг тайлбарлахад ашиглаж болох хэрэгслийг тодорхойлжээ. Үүнд:

- ✓ Үйл явцын зураглал: Энэ аргачлал нь үйл явцын үе шатуудын дүрслэл юм. Энэ нь үйл явц дахь цуврал үйл ажиллагаа, үйл явдлын харилцаа хамаарлыг шуурхай, ойлгомжтой байдлаар харуулдаг. Асуудлыг системтэй харах шаардлагатай байгаа тохиолдолд график схем нь маш их ашиг тустай байдаг. Урсгалын хүснэгт нь чухал үе шатуудыг тодорхойлоход тусалдаг бөгөөд бүх үе шатуудыг алдаагүй, чанартай явагдах байдлыг хангадаг.
- ✓ Парето шинжилгээ: Энэ аргачлал нь асуудлын 80 хувь нь шалтгааны 20 хувийг эзэлдэг ба “80-20 дүрэм” гэж нэрлэдэг. Тиймээс 20 хувьд анхаарлаа төвлөрүүлснээр бид 80 хувийн үр дүнг сайжруулж чадна. Энэ бол чанарын баталгааны маш чухал зарчим бөгөөд ингэснээр 80 хувийн шийдэл, сэтгэл ханамжийг авчирдаг гүйцэтгэлийн 20 хувийг тодорхойлох нь чухал.
- ✓ Загасан нуруу диаграмм (Ишикавагийн диаграмм): Энэ аргачлал нь учир шалтгаан ба үр дагаврын хоорондох хамаарлыг тодорхойлдог. Энэ диаграмм нь хоёр төрлийн параметрийн нэгдлийн хэв маягийг харуулдаг.
- ✓ Шалгах хуудас: Энэ аргачлал нь үйл явцын гүйцэтгэлийн байдлыг хэмжихийн тулд шалгах хуудас эсвэл диаграмм байдлаар ашигладаг. Энэ нь стандартын дагуу бүх зүйл эмх цэгцтэй байх боломжийг олгодог.

Зарим тохиолдолд энэ нь чанарын хяналтын төхөөрөмж болдог бөгөөд зарим шаардлага хангахгүй бүтээгдэхүүнийг танихад хэрэглэгддэг.

- ✓ Хяналтын бүдүүвч: Энэ аргачлал нь бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжүүлэлт болон үйлдвэрлэлийн бүх гарц хэлбэлзлийн хязгаарт байгаа эсэхийг хянах үйл ажиллагаанд статистик шинжилгээ хэрэглэгддэг. Тиймээс хяналтын графикууд нь хазайлтыг хоёр аргаар харуулдаг: i) зайлшгүй буюу зөвшөөрөгдөх хазайлт; ба ii) хүлээн зөвшөөрөх боломжгүй хазайлт.
- ✓ Оюуны зураглал: Энэ аргачлал нь асуудлыг шийдэх санаа, шийдлийн боломжит хувилбарыг тодорхойлох суурь үйл явц юм. Харин оролцогчдын бүтээлч санаачилга, багаар ажиллах нь чухал байдаг.

## 2.8. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний үзүүлэлтүүд

Дэлхий дахиныг хамарсан даяаршлын нөхцөлд нэр хүндтэй, томоохон дээд боловсролын сургалтын байгууллагад суралцах хүсэлтэй оюутнуудын тоо эрс нэмэгдэхийн сацуу, хүн амд тасралтгүйгээр боловсрол олгох, түүний хүртээмжийг хангах асуудалд ихээхэн анхаарал хандуулах болжээ. Улмаар дээд боловсролын сургалтын байгууллагын оршин тогтнох, өрсөлдөх чадварын асуудал нь чанар хэмээх хүчин зүйлээс ихээхэн хүчтэй хамаарах хандлагатай байна.

Энэхүү дэлхий дахиныг хамарсан дээд боловсролын даяаршлаас улбаалан дээд боловсролын сургалтын байгууллагууд өрсөлдөхүйц давуу талыг олж авахын тулд технологид суурилсан сургалтыг хөгжүүлэх, сургалтын зохион байгуулалтын хэлбэр, арга зүйг өөрчлөх зэргээр сургалтын технологийн шинэчлэл, инновац нэвтрүүлэхийг чухалчлах болжээ. Иймээс дэлхийн улс орнуудын Засгийн газраас дээд боловсролын сургалтын байгууллагуудад чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх, чанарын соёл төлөвшүүлэх, чанарын үнэлгээний нэгдсэн систем хөгжүүлэх болон чанарыг үнэлэх, сайжруулахад чиглэсэн зорилтот бодлогыг хэрэгжүүлэх байдлаар үндэсний дээд боловсролын чанарын түвшнийг дээшлүүлэхэд ихээхэн анхаарах болсон.

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарыг зөвхөн төгсөгчдийн хөдөлмөр эрэлт, магадлан итгэмжлэл (сургууль, хөтөлбөр)-ийн хүрээнд ойлгох нь учир дутагдалтай төдийгүй үйлчилгээний чанарыг анхаарах нь чухал юм. Харин онолын хувьд үйлчилгээний чанар гэдгийг үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж ба хүлээлт болон хүлээн авсан үйлчилгээний ялгаатай байдлын харьцаа (К.Гронрос) гэж тодорхойлогдож байна. Иймээс дээд боловсролын сургалтын байгууллагын чанарыг оюутнуудын эрэлт, шаардлагад нийцэх байдал, сэтгэл ханамжийн түвшнээр тодорхойлох нь оновчтой байдаг.

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанар, түүнийг үнэлэх арга зүйн асуудлаар томоохон их сургууль болон судлаачдын зүгээс цөөнгүй судалгаа, шинжилгээний ажил хийж гүйцэтгэжээ. Тухайлбал:

- ✓ М.С.Овлия, Э.М.Аспиналл (1996) нар Их Британийн дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний хэмжүүр, түүний хамрах хүрээний судалгаа,
- ✓ Р.Ф.Вааб (2001) нь Австралийн дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын удирдлагын судалгаа,
- ✓ М.Лалобис (2002) нь Сербийн дээд боловсролын сургалтын байгууллагын чанарыг 6 Сигма арга зүйгээр үнэлэх судалгаа,
- ✓ С.Ларгосен, Р.С.Хашеми, М.Литнер (2004) нар Австрали, Шведийн дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн харьцуулсан судалгаа,
- ✓ З.Яанг, Л.Ян-Пин, Т.Жиэ (2006) нар Хятадын дээд боловсролын сургалтын байгууллагын чанарыг SERVQUAL загвараар үнэлэх арга зүйн судалгаа,
- ✓ М.Цинидоу, В.Герогианнис, П.Фицилис (2010) нар Грекийн дээд боловсролын сургалтын байгууллагын чанарыг оюутны оролцоотой үнэлэх судалгаа,
- ✓ А.Р.Арокиясами (2012) нь Малайзын дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн судалгаа,

- ✓ Амин Ю.Ноаман, Абдул Хамид М.Рагаб, Айман Г.Файуми (2014) нар Саудын Арабын дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын стандартын судалгаа зэргийг дурдаж болох юм.

Дээрх судалгааны үр дүнгээс харвал, дээд боловсролын сургалтын байгууллага эрхэм зорилгоо хэрэгжүүлэхэд нөөц (орчин, технологи, мэдээлэл, санхүү болон хүний нөөц ...)-ийн чанар нь тохиромжтой, тогтвортой байх нь чухал гэж дүгнэж болохоор байна. Ерөнхийдөө бид өмнөх судалгааны үр дүнг харьцуулан дээд боловсролын сургалтын байгууллагын чанарт нөлөөлөх 8 хүчин зүйл (Зураг 1), 50 шалгуур үзүүлэлт (Хүснэгт 1)-ийг тодорхойлсон.



**Зураг 2.9. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний загвар**

Энэхүү загварт тодорхойлогдсон дээд боловсролын сургалтын байгууллагын чанар нь үндсэн найман хүчин зүйлээс хамаарах ба түүнийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийн эрэмбэ, ач холбогдлын түвшнийг тодорхойлохдоо АНР (Analytic Hierarchy Process) буюу задлан шинжилгээний аргыг ашигласан. Задлан шинжилгээний арга нь бүтэц, зохион байгуулалт, технологийн хувьд хоорондоо нарийн уялдаатай процессын уялдааг нь харгалзан хүчин зүйл тус бүрийн эцсийн үр дүнд үзүүлэх нөлөөг тоон



үзүүлэлтээр илэрхийлж, тэдгээрийг ач холбогдлоор нь эрэмбэлэхэд ашиглахад тохиромжтой байдаг. Харин шинжилгээ хийхэд шаардлагатай тоон мэдээллийг түүвэр судалгааны аргаар багш, оюутан болон төгсөгчдөөс асуулгын судалгаа хэлбэрээр цуглуулсан.

**Чанарын үнэлгээ:** Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлох зорилгоор тандан судалгааг санамсаргүй түүврийн аргаар зохион байгуулсан. Судалгаанд нийт 200 хүнийг хамруулснаас их сургуулийн багш, ажилтан 50 хүн (25%), оюутан 100 хүн (50%) болон төгсөгч 50 хүн (25%) тус тус байв.

Зураг 8.1-д тодорхойлогдсон найман хүчин зүйлийн хувьд цуглуулсан мэдээллийг ашиглан АНР шинжилгээгээр дээд боловсролын сургалтын байгууллагын чанарт нөлөөлөх хүчин зүйлийг ач холбогдлоор нь үнэлсэн.

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарт нөлөөлөх найман хүчин зүйл (Хүснэгт 8.1)-ийн ач холбогдлын хувьд хамгийн өндөр нь сургалтын хөтөлбөр (19.7%), хамгийн бага нь дэд бүтэц (6.0%) байна. Бидний тооцоогоор чанарт нөлөөлөх хүчин зүйлийн  $CR=0.095164$  байгаа нь үнэлгээг үндэслэлтэй болохыг харуулах ба үр дүнг дор хүснэгтэд харуулав.

***Хүснэгт 2.12. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний хүчин зүйлийн матриц***

№	Хүчин зүйлс	Сургалтын хөтөлбөр	Сургалтын орчин	Цахим үйлчилгээ	Багшлахуйн	Оюутныг дэмжих үйлчилгээ	Номын сангийн үйлчилгээ	Захиргааны үйлчилгээ	Дэд бүтэц	Ач холбогдол, хувиар	Шалгуур үзүүлэлт
1	Сургалтын хөтөлбөр	1.00	1.00	1.00	2.00	2.00	2.00	3.00	3.00	<b>19.7</b>	<b>6</b>
2	Сургалтын орчин	1.00	1.00	1.00	1.00	2.00	2.00	2.00	3.00	<b>17.2</b>	<b>6</b>
3	Цахим үйлчилгээ	1.00	1.00	1.00	1.00	1.00	2.00	2.00	3.00	<b>16.0</b>	<b>6</b>
4	Багшлахуйн	0.50	1.00	1.00	1.00	1.00	1.00	2.00	2.00	<b>12.8</b>	<b>7</b>
5	Оюутныг дэмжих үйлчилгээ	0.50	0.50	1.00	1.00	1.00	1.00	2.00	2.00	<b>11.6</b>	<b>5</b>
6	Номын сангийн үйлчилгээ	0.50	0.50	0.50	1.00	1.00	1.00	1.00	2.00	<b>9.8</b>	<b>7</b>
7	Захиргааны үйлчилгээ	0.33	0.50	0.50	0.50	0.50	1.00	1.00	1.00	<b>7.1</b>	<b>7</b>
8	Дэд бүтэц	0.33	0.33	0.33	0.50	0.50	0.50	1.00	1.00	<b>6.0</b>	<b>6</b>
	<b>Нийт дүн</b>	-	-	-	-	-	-	-	-	<b>100</b>	<b>50</b>

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

Сургалтын хөтөлбөрийн чанарыг үнэлэх 6 шалгуур үзүүлэлтээс i) Сургалтын хөтөлбөр боловсруулалтын шинжлэх ухааны үндэслэл (22.2), ii) Сургалтын хөтөлбөрийн хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцтэй байдал (20.1) нь ач холбогдлын түвшин хамгийн өндөр ба үр дүнг нэгтгэн доорх хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 2.13. Сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээний шалгуур, хувиар*

№	Үнэлгээний шалгуур	Эзлэх хувь	Хувийн жин
1	Сургалтын хөтөлбөр боловсруулалтын шинжлэх ухааны үндэслэл	22.2	4.4
2	Сургалтын хөтөлбөрийн хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцтэй байдал	20.1	4.0
3	Сургалтын хөтөлбөр нь оюутны ур чадвар, өөрийгөө хөгжүүлэх чадварыг дэмждэг байдал	16.3	3.2
4	Сургалтын хөтөлбөр нь суралцах хугацаанд мэргэжлээр дадлагажихыг боломж	15.1	3.0
5	Хичээлийн зохион байгуулалтын оновчтой байдал	13.4	2.6
6	Сургалтын хөтөлбөрийн нарийн мэргэшүүлэх боломж	12.9	2.5
	<b>Нийт дүн</b>	<b>100</b>	<b>19.7</b>
	<b>Дундаж үзүүлэлт</b>	<b>-</b>	<b>3.3</b>

Сургалтын орчны чанарыг үнэлэх 6 шалгуур үзүүлэлтээс i) Анги танхим, лабораторийн тохижилт (20.6), ii) Сургуулийн орчны тав тухтай байдал (18.6) нь ач холбогдлын түвшин хамгийн өндөр ба үр дүнг нэгтгэн доорх хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 2.14. Сургалтын орчны чанарын үнэлгээний шалгуур, хувиар*

№	Үнэлгээний шалгуур	Эзлэх хувь	Хувийн жин
1	Анги танхим, лабораторийн тохижилт	20.6	3.6
2	Сургуулийн орчны тав тухтай байдал	18.6	3.2
3	Хоолны газрын үйлчилгээ	18.0	3.1
4	Спортын заалны үйлчилгээ	16.4	2.8
5	Оюутны чөлөөт цагт чиглэсэн үйлчилгээ	14.7	2.5
6	Оюутны байрны тав тухтай байдал	11.7	2.0
	<b>Нийт дүн</b>	<b>100</b>	<b>17.2</b>
	<b>Дундаж үзүүлэлт</b>	<b>-</b>	<b>2.9</b>

Цахим үйлчилгээний чанарыг үнэлэх 6 шалгуур үзүүлэлтээс i) Сургуулийн орчинд өндөр хурдны интернэт нэвтрүүлсэн байдал (25.2), ii) Компьютерын лабораторийн хүртээмж (21.6) нь ач холбогдлын түвшин хамгийн өндөр ба үр дүнг нэгтгэн доорх хүснэгтэд харуулав.

***Хүснэгт 2.15. Цахим үйлчилгээний чанарын үнэлгээний шалгуур, хувиар***

<b>№</b>	<b>Үнэлгээний шалгуур</b>	<b>Эзлэх хувь</b>	<b>Хувийн жин</b>
1	Сургуулийн орчинд өндөр хурдны интернэт нэвтрүүлсэн байдал	25.2	4.0
2	Компьютерын лабораторийн хүртээмж	21.8	3.5
3	Сургалтад дэвшилтэт технологи нэвтрүүлсэн байдал	19.5	3.1
4	Нийгмийн сүлжээгээр мэдээлэл авах боломж	11.8	1.9
5	Онлайн сургалтын хөгжүүлэлт, хүртээмжийн байдал	11.7	1.9
6	Сургуулийн цахим үйлчилгээний хүртээмж	10.0	1.6
	<b>Нийт дүн</b>	<b>100</b>	<b>16.0</b>
	<b>Дундаж үзүүлэлт</b>	<b>-</b>	<b>2.7</b>

Багшлахуйн чанарыг үнэлэх 7 шалгуур үзүүлэлтээс i) Мэргэжлийн мэдлэг, ур чадвар (21.7), ii) Хичээл заах арга зүй (16.3) нь ач холбогдлын түвшин хамгийн өндөр ба үр дүнг нэгтгэн доорх хүснэгтэд харуулав.

***Хүснэгт 2.16. Багшлахуйн чанарын үнэлгээний шалгуур, хувиар***

<b>№</b>	<b>Үнэлгээний шалгуур</b>	<b>Эзлэх хувь</b>	<b>Хувийн жин</b>
1	Мэргэжлийн мэдлэг, ур чадвар	21.7	2.8
2	Хичээл заах арга зүй	16.3	2.1
3	Харилцааны соёл	15.5	2.0
4	Эрдэм шинжилгээ, судалгааны арга барил эзэмшилт	15.0	1.9
5	Манлайлал	13.4	1.7
6	Оюутантай ажиллах арга барил	10.5	1.3
7	Зарчимч байдал	7.6	1.0
	<b>Нийт дүн</b>	<b>100</b>	<b>12.8</b>
	<b>Дундаж үзүүлэлт</b>	<b>-</b>	<b>1.8</b>

Оюутныг дэмжих үйлчилгээний чанарыг үнэлэх 5 шалгуур үзүүлэлтээс i) Гадаадад суралцах боломж (25.8), ii) Тэтгэлэгт хамрагдах боломж (22.5) нь ач холбогдлын түвшин хамгийн өндөр ба үр дүнг нэгтгэн доорх хүснэгтэд харуулав.

***Хүснэгт 2.17. Оюутныг дэмжих үйлчилгээний чанарын үнэлгээний шалгуур, хувиар***

<b>№</b>	<b>Үнэлгээний шалгуур</b>	<b>Эзлэх хувь</b>	<b>Хувийн жин</b>
1	Гадаадад суралцах боломж	25.8	3.0
2	Тэтгэлэгт хамрагдах боломж	22.5	2.6
3	Оюутны хөдөлмөр зуучлалын үйлчилгээ	19.6	2.3
4	Оюутнуудын хамтын ажиллагааг дэмжсэн үйл ажиллагаа	17.1	2.0
5	Байгууллагын бизнесийн холбоос	14.9	1.7
	<b>Нийт дүн</b>	<b>100</b>	<b>11.6</b>
	<b>Дундаж үзүүлэлт</b>	<b>-</b>	<b>2.3</b>

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

Цахим үйлчилгээний чанарыг үнэлэх 7 шалгуур үзүүлэлтээс i) Цахим номын сангийн нэвтрүүлэлт, ашиглах боломж (20.2), ii) Номын сангийн орчны тохижилт, тав тухтай байдал (18.2) нь ач холбогдлын түвшин хамгийн өндөр ба үр дүнг нэгтгэн доорх хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 2.18. Номын сангийн үйлчилгээний чанарын үнэлгээний шалгуур, хувиар*

№	Үнэлгээний шалгуур	Эзлэх хувь	Хувийн жин
1	Цахим номын сангийн нэвтрүүлэлт, ашиглах боломж	20.0	2.0
2	Номын сангийн орчны тохижилт, тав тухтай байдал	18.2	1.8
3	Номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломж	17.5	1.7
4	Номын сангийн фондын шинэчлэл, хүртээмж	13.7	1.3
5	Номын сангийн суудлын хүртээмж	12.5	1.2
6	Ажлын цагийн тохиромжтой байдал	10.2	1.0
7	Номын сангийн хамтын ажиллагаа	8.0	0.8
	<b>Нийт дүн</b>	<b>100</b>	<b>9.8</b>
	<b>Дундаж үзүүлэлт</b>	<b>-</b>	<b>1.4</b>

Захиргааны үйлчилгээний чанарыг үнэлэх 7 шалгуур үзүүлэлтээс i) Үр дүнтэй, шуурхай үйлчилгээ (23.3), ii) Ажилтнуудын харилцааны соёл, найрсаг байдал (15.8) нь ач холбогдлын түвшин хамгийн өндөр ба үр дүнг нэгтгэн доорх хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 2.19. Захиргааны үйлчилгээний чанарын үнэлгээний шалгуур, хувиар*

№	Үнэлгээний шалгуур	Эзлэх хувь	Хувийн жин
1	Үр дүнтэй, шуурхай үйлчилгээ	23.3	1.7
2	Ажилтнуудын харилцааны соёл, найрсаг байдал	15.8	1.1
3	Сургуулийн вэбсайт дахь захиргааны үйлчилгээний хүртээмж	14.6	1.0
4	Захиргааны мэдээллийн нээлттэй, ил тод байдал	13.1	0.9
5	Ажлын цагийн тохиромжтой байдал	11.2	0.8
6	Үйлчилгээнд зориулсан дэвшилтэт технологийн бэлэн байдал	11.2	0.8
7	Тодорхой удирдамж, зөвлөмж	10.8	0.8
	<b>Нийт дүн</b>	<b>100</b>	<b>7.1</b>
	<b>Дундаж үзүүлэлт</b>	<b>-</b>	<b>1.0</b>

Дэд бүтцийн чанарыг үнэлэх 6 шалгуур үзүүлэлтээс i) Сургуулийн гадна орчны аюулгүй байдал (20.3), ii) Сургуулийн гадна орчны тохижилт, тав тухтай

байдал (18.5) нь ач холбогдлын түвшин хамгийн өндөр ба үр дүнг нэгтгэн доорх хүснэгтэд харуулав.


*Хүснэгт 2.20. Дэд бүтцийн чанарын үнэлгээний шалгуур, хувиар*

<b>№</b>	<b>Үнэлгээний шалгуур</b>	<b>Эзлэх хувь</b>	<b>Хувийн жин</b>
1	Сургуулийн гадна орчны аюулгүй байдал	20.3	1.2
2	Сургуулийн гадна орчны тохижилт, тав тухтай байдал	18.5	1.1
3	Сургуулийн гадна талбай, авто зогсоолын хүртээмж	18.1	1.1
4	Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмж	16.2	1.0
5	Сургуулийн байр хооронд зорчих байдал	14.9	0.9
6	Дэд бүтцийн хөгжил	12.0	0.7
	<b>Нийт дүн</b>	<b>100</b>	<b>6.0</b>
	<b>Дундаж үзүүлэлт</b>	<b>-</b>	<b>1.0</b>

Судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэвэл, дээд боловсролын сургалтын байгууллагын чанарыг үнэлгээнд ач холбогдлын түвшин өндөр шалгуур үзүүлэлтүүдийг авч үзвэл. Үүнд:

1. Сургалтын хөтөлбөр боловсруулалтын шинжлэх ухааны үндэслэл (1.1),
2. Сургалтын хөтөлбөрийн хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцтэй байдал (1.2),
3. Сургуулийн орчинд өндөр хурдны интернэт нэвтрүүлсэн байдал (3.1),
4. Анги танхим, лабораторийн тохижилт (2.1),
5. Компьютерын лабораторийн хүртээмж (3.2),
6. Сургалтын хөтөлбөр нь оюутны ур чадвар, өөрийгөө хөгжүүлэх чадварыг дэмждэг байдал (1.3),
7. Сургуулийн орчны тав тухтай байдал (2.2),
8. Хоолны газрын үйлчилгээ (2.3),
9. Сургалтад дэвшилтэт технологи нэвтрүүлсэн байдал (3.3),
10. Гадаадад суралцах боломж (5.1),
11. Сургалтын хөтөлбөр нь суралцах хугацаанд мэргэжлээр дадлагажих боломжийг олгодог (1.4),

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*



**Зураг 2.10. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд**

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний 50 шалгуур үзүүлэлтүүдээс ач холбогдлын түвшин өндөр гэж 11 үзүүлэлт, дунд гэж 12 үзүүлэлт, сул гэж 20 үзүүлэлт, ач холбогдолгүй гэж 7 үзүүлэлт тус тус үнэлэгдсэн ба доорх хүснэгтээр нэгтгэн харуулав.

***Хүснэгт 2.21. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин, хувиар***

<b>№</b>	<b>Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд</b>	<b>Эрэмбэ</b>
1.1	Сургалтын хөтөлбөр боловсруулалтын шинжлэх ухааны үндэслэл	4.4
1.2	Сургалтын хөтөлбөрийн хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцтэй байдал	4.0
3.1	Сургуулийн орчинд өндөр хурдны интернэт нэвтрүүлсэн байдал	4.0
2.1	Анги танхим, лабораторийн тохижилт	3.6
3.2	Компьютерын лабораторийн хүртээмж	3.5
1.3	Сургалтын хөтөлбөр нь оюутны ур чадвар, өөрийгөө хөгжүүлэх чадварыг дэмждэг байдал	3.2
2.2	Сургуулийн орчны тав тухтай байдал	3.2
2.3	Хоолны газрын үйлчилгээ	3.1

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

3.3	Сургалтад дэвшилтэт технологи нэвтрүүлсэн байдал	3.1
5.1	Гадаадад суралцах боломж	3.0
1.4	Сургалтын хөтөлбөр нь суралцах хугацаанд мэргэжлээр дадлагажих боломжийг олгодог	3.0
2.4	Спортын заалны үйлчилгээ	2.8
4.1	Мэргэжлийн мэдлэг, ур чадвар	2.8
1.5	Хичээлийн зохион байгуулалтын оновчтой байдал	2.6
5.2	Тэтгэлэгт хамрагдах боломж	2.6
1.6	Сургалтын хөтөлбөрийн нарийн мэргэшүүлэх боломж	2.5
2.5	Оюутны чөлөөт цагт чиглэсэн үйлчилгээ	2.5
5.3	Оюутны хөдөлмөр зуучлалын үйлчилгээ	2.3
4.2	Хичээл заах арга зүй	2.1
5.4	Оюутнуудын хамтын ажиллагааг дэмжсэн үйл ажиллагаа	2.0
4.3	Харилцааны соёл	2.0
2.6	Оюутны байрны тав тухтай байдал	2.0
6.1	Цахим номын сангийн нэвтрүүлэлт, ашиглах боломж	2.0
3.4	Нийгмийн сүлжээгээр мэдээлэл авах боломж	1.9
3.5	Онлайн сургалтын хөгжүүлэлт, хүртээмжийн байдал	1.9
4.4	Эрдэм шинжилгээ, судалгааны арга барил эзэмшилт	1.9
6.2	Номын сангийн орчны тохижилт, тав тухтай байдал	1.8
4.5	Манлайлал	1.7
6.3	Номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломж	1.7
7.1	Үр дүнтэй, шуурхай үйлчилгээ	1.7
5.5	Байгууллагын бизнесийн холбоос	1.7
3.6	Сургуулийн цахим үйлчилгээний хүртээмж	1.6
6.4	Номын сангийн фондын шинэчлэл, хүртээмж	1.3
4.6	Оюутантай ажиллах арга барил	1.3
6.5	Номын сангийн суудлын хүртээмж	1.2
7.2	Ажилтнуудын харилцааны соёл, найрсаг байдал	1.1
4.7	Зарчимч байдал	1.0
6.6	Ажлын цагийн тохиромжтой байдал	1.0
7.3	Сургуулийн вэбсайт дахь захиргааны үйлчилгээний хүртээмж	1.0



**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**

8.1	Сургуулийн гадна орчны аюулгүй байдал	1.2
8.2	Сургуулийн гадна орчны тохижилт, тав тухтай байдал	1.1
8.3	Сургуулийн гадна талбай, авто зогсоолын хүртээмж	1.1
8.4	Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмж	1.0
8.5	Сургуулийн байр хооронд зорчих байдал	0.9
7.4	Захиргааны мэдээллийн нээлттэй, ил тод байдал	0.9
6.7	Номын сангийн хамтын ажиллагаа	0.8
7.5	Ажлын цагийн тохиромжтой байдал	0.8
7.6	Үйлчилгээнд зориулсан дэвшилтэт технологийн бэлэн байдал	0.8
7.7	Тодорхой удирдамж, зөвлөмж	0.8
8.6	Дэд бүтцийн хөгжил	0.7

Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын менежментийг нэвтрүүлж, чанарын соёлыг төлөвшүүлэхийг дэмжсэн тогтолцоо бүрдүүлэхэд чанарын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас үндэсний хэмжээнд чанарын менежментийн хэмжээс, түүний шалгуур үзүүлэлтүүдийг стандартчилах, дээд боловсролын сургалтын байгууллагуудад зориулан чанарын менежментийн удирдамж боловсруулж мөрдүүлэхэд анхаарах шаардлагатай. Ийнхүү үндэсний хэмжээнд чанарын нэгдсэн бодлого, удирдамж, аргачлалыг мөрдлөг болгосноор нэгдсэн үнэлгээ хийх байдлаар их, дээд сургуулиудын чанарын үнэлгээг салбарын хэмжээнд хийж, гүйцэтгэлийн үр дүнг харьцуулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд түлхэц болно.

**2.9. Дээд боловсролын сургалтын байгууллага ба үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны чанарын үнэлгээ**

Дээд боловсролын сургалтын байгууллага ба үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны үзэл баримтлал нь стратегийн түншлэлийн бүхий л хүрээг хамардаг. Иймээс хамтын ажиллагааны амжилтын хүчин зүйлүүд нь “Сургалт – Судалгаа - Инновац” бүхий уялдааг хангах, “Дээд боловсрол - Үйлдвэрлэл”-ийн салбар хоорондын соёлын ялгаат байдлыг багасгах, итгэлцэл тууштай байдлыг бий болгоход дэмжлэг үзүүлэх, нөгөө талаас хамтын ажиллагаа нь зохион байгуулалттай, үр бүтээлтэй байдлаар явагдах орчныг бүрдүүлэхэд чиглэсэн олон талт байдлыг хамардаг байна.



Дээд боловсролын сургалтын байгууллага ба үйлдвэрлэлийн хамтын ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлийг үнэлэх чиглэлээр хийгдсэн зарим судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэвэл, хамтын ажиллагааны амжилтад нөлөөлөх 10 хүчин зүйл тодорхойлогдож байна. Үүнд:

- i) Олон талт байдал: Түншлэлийг олон талт байдлаар хэрэгжүүлэх (Рорбек ба Арнольд (2006), Батчер ба Жеффри (2007), Д'Эсте ба Пател (2007), Плева ба Квестер (2007), Брунель (2010), Аараожа (2012), Плева (2013)),
- ii) Түншүүдийн нийцэл: Түншлэлийг төлөвлөхдөө стратеги болон соёлын тохирол, газар зүйн ойр байдал зэрэг асуудалд анхаарал хандуулах (Мэйд (1999), Барнс (2002), Мора-Валентин (2004), Плева ба Квестер (2007), Тун (2011), Д'Эсте (2012), Барри ба Фентон (2013)),
- iii) Үүрэг, хариуцлагын тогтолцоо: Хамтын ажиллагааны үүрэг, хариуцлагыг тодорхой болгож харилцан ойлголцох (Барнс (2002), Рорбек ба Арнольд (2006), Барболла ба Корредера (2009), Нильсен (2013)),
- iv) Оюуны өмчийн бодлого: Оюуны өмчийн тогтсон бодлого, түүний үйл явцын ил тод байдал, харилцан тохиролцох (Рорбек ба Арнольд (2006), Барболла ба Корредера (2009), Брунель (2010), Бстэйлер (2015)),
- v) Түүштай байдал: Байгууллагын удирдлага нь хамтран ажиллахад шаардлагатай нөөцийг хуваарилж, манлайлан оролцох (Барнс (2002), Мора-Валентин (2004), Рорбек ба Арнольд (2006), Батчер ба Жеффри (2007), Плева ба Квестер (2007), Тун (2011), Шуберт ба Бьорн-Андерсен (2012), Барри ба Фентон (2013), Плева (2013)),
- vi) Харилцаа холбоо: Байгууллага хооронд мэдээлэл солилцох сувгуудыг идэвхтэй ашиглах (Мэйд (1999), Барнс (2002), Мора-Валентин (2004), Батчер ба Жеффри (2007), Карлсон (2007), Барри ба Фентон (2013), Плева (2013)),
- vii) Соёлын нийцэл: Ажлын арга нь хоёр талдаа үнэ цэнэ бий болгоход дэмжлэг үзүүлэх (Барнс (2002), Рорбек ба Арнольд (2006), Барболла ба Корредера (2009), Шуберт ба Бьорн-Андерсен (2012)),

- viii) Байгууллагын хоорондын итгэлцэл: Харилцан итгэлцэл нь хамтын ажиллагааны амжилтад хүрэх үндсэн нөхцөл болох (Барнс (2002), Рорбек ба Арнольд (2006), Плева ба Күестер (2007), Барболла ба Корредера (2009), Брунель (2010), Шуберт ба Бьорн-Андерсен (2012), Нильсен (2013), Плева (2013), Бстэйлер (2015)),
- ix) Түншлэлийн өгөөж: Хоёр тал хамтын ажиллагааны зорилгыг ойлгож, ижил байр суурьтай байх (Мэйд (1999), Барнс (2002), Рорбек ба Арнольд (2006), Батчер ба Жеффри (2007), Нилсен (2013), Плева (2013)),
- x) Хамтын ажиллагааны туршлага: Өмнөх туршлага нь хамтын ажиллагааг амжилтад хүргэх урьдач нөхцөл болох (Барнс (2002), Мора-Валентин (2004), Батчер ба Жеффри (2007), Брунель (2010)),

Тодорхойлсон амжилтын хүчин зүйлсийг Европын чанарын менежментийн сангийн загвар болон Оулугийн их сургуулийн дэргэдэх нийгмийн шинжлэх ухааны судалгааны байгууллага болох Оулу Биотөв (Biocenter Oulu)-ийн туршилт судалгааны үр дүнтэй харьцуулах замаар Дээд боловсролын сургалтын байгууллага ба үйлдвэрлэлүүдийн хамтын ажиллагааны чанарын үнэлгээний шалгуурыг тодорхойлов. Үнэлгээний оновчтой байдлыг зорилтот байгууллагын хамтын ажиллагааны гүйцэтгэлийн түвшинд тохируулах боломжтой.

Дээд боловсролын сургалтын байгууллага ба үйлдвэрлэлүүдийн хамтын ажиллагааг үнэлж, тасралтгүй хөгжүүлэх гол чиглэлүүд нь үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой ба эдгээр чиглэлүүд нь бусад шалгуур үзүүлэлттэй, тухайлбал: хамтын ажиллагааны стратеги, түүнийг хэрэгжүүлэлт нь манлайлалтай нягт холбоотой байдаг.

Санал болгож буй үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд нь дээд боловсролын сургалтын байгууллагын хамтын ажиллагааны явцыг үнэлэх, сайжруулах боломжтой хувилбар ба түүний зургаан хэмжээс, 18 шалгуур үзүүлэлтээр үнэлэх боломжтой ба доорх хүснэгтээр харуулав.

***Хүснэгт 2.22. Хамтын ажиллагааны чанарын шалгуур***

<b>№</b>	<b>Хэмжээс</b>	<b>Шалгуур үзүүлэлтүүд</b>
1	Хамтын ажиллагааны манлайлал	✓ Удирдлага нь байгууллагын зорилго, алсын харааг хөгжүүлэхэд хамтын ажиллагааны ач холбогдлыг хүлээн зөвшөөрдөг,

**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**


		<ul style="list-style-type: none"> <li>✓ Удирдлага нь үйлчлүүлэгчид, түншүүд, нийгмийн төлөөллүүдтэй харилцдаг,</li> <li>✓ Удирдлага нь хамтын ажиллагааны идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг,</li> </ul>
2	Хамтын ажиллагааны стратеги	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хамтын ажиллагаанд байгууллагын стратеги, оролцогч талуудын эрэлт, хүлээлтийг харгалзан үздэг,</li> <li>✓ Хамтын ажиллагааны зорилго, стратеги нь дотоод гүйцэтгэл, чадавхад суурилдаг,</li> <li>✓ Хамтын ажиллагааны стратеги, төлөвлөгөө, үйл явцыг тогтвортой хэрэгжүүлдэг,</li> </ul>
3	Хамтын ажиллагаанд оролцогчид	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хамтын ажиллагаанд оролцогчдын үүрэг, хариуцлага тодорхой байдаг,</li> <li>✓ Хамтын ажиллагаанд шаардлагатай хүний нөөцийн мэдлэг, чадварыг хөгжүүлдэг,</li> <li>✓ Ажиллагчид байгууллага болон хамтын ажиллагааны хүрээнд үр дүнтэй харилцдаг,</li> <li>✓ Хамтын ажиллагаанд оролцогчдыг урамшуулдаг,</li> </ul>
4	Хамтын ажиллагааны түншлэл ба нөөц	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хамтын ажиллагааны санхүүжилт, эх үүсвэрийн тогтвортой байдлыг хангах,</li> <li>✓ Технологи нь хамтын ажиллагааг дэмжихэд чиглэдэг,</li> <li>✓ Мэдээлэл, мэдлэг, оюуны өмч нь хамтын ажиллагааг дэмжихэд чиглэдэг,</li> </ul>
5	Хамтын ажиллагааны үйл явц	<ul style="list-style-type: none"> <li>✓ Үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хамтын ажиллагаанд чиглэдэг,</li> <li>✓ Хамтын ажиллагааны төслүүдийг идэвхтэй дэмждэг,</li> </ul>
6	Хамтын ажиллагааны үр дүн	<ul style="list-style-type: none"> <li>✓ Гүйцэтгэлийн үзүүлэлт нь хамтын ажиллагааны зорилготой уялддаг,</li> <li>✓ Амжилтын янз бүрийн хэмжүүрийг шалгуур үзүүлэлт, зорилгоо харгалздаг,</li> <li>✓ Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, зорилгыг идэвхтэй удирдаж, ашигладаг,</li> </ul>

Энэхүү үнэлгээний хүрээг эрдэм шинжилгээний болон бусад салбарын хамтын ажиллагаанд ашиглах боломжтой юм.

### **2.10. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанар ба хөдөлмөрийн зах зээлийн эрэлт**

“Дэлхийн боловсрол 2030” хөтөлбөрийг Тогтвортой хөгжлийн зорилтын дөрөвдүгээр зарчмыг хэрэгжүүлэх үйл явцыг НҮБ манлайлан, “Сурч боловсрох нь бүхий л амьдралынхаа туршид эдлэх хүний үндсэн эрх бөгөөд чанартай боловсрол эзэмшихэд хүн бүр тэгш эрхээр хангагдах ёстой” хэмээн тодорхойлон "мэдэхэд суралцах, хийхэд суралцах, оршин байхад суралцах,

хамтдаа амьдрахад суралцах" гэсэн дөрвөн тулгуурт зарчмыг мөрдлөг болгож байна. Орчин үед дээд боловсролын салбарын бодлого хөдөлмөрийн зах зээл болон дэлхийн хөгжлийн чиг хандлагыг баримжаалан сургалтын хөтөлбөрүүдээ үнэлэх, үр дүнд суурилсан хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэх, хөдөлмөрийн зах зээлийн мэдрэмжтэй байх зэрэг асуудлуудад чиглэгдэх болжээ.




Эх үүсвэр. ЮНЕСКО-ийн дэлхий дахины тайлан илтгэл

### **Зураг 2.11. Олон улсын ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн**

Өнөөгийн даяарчлагдсан дэлхий ертөнцөд улс орнуудын харилцаа хамаарал нэмэгдсэн нь ажиллах хүчний дэлхий дахиныг хамарсан чөлөөт урсгал бий болсон. Энэхүү олон улсын ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний шинэ хэв шинжээс улбаалан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн чадварлаг мэргэжилтэн бэлтгэх үйл явц нь олон улсын чиг хандлагатай болсон. Түүнчлэн аж үйлдвэрийн IV хувьсгалаас улбаалан ирээдүйн хөдөлмөр эрхлэлт, ур чадварыг тодорхойлох асуудал дэлхийн дахины анхаарах шаардлагатай асуудлын нэг болж байна. Тухайлбал, Дэлхийн эдийн засгийн форумаас 2016 онд эдийн засгийн салбарыг үндсэн 9 салбарт хувааж, уг салбаруудын хувьд ойрын ирээдүйд хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлт, ур чадварын тогтвортой байдлыг дараах байдлаар тодорхойлжээ.

**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**



Эх үүсвэр: World Economic Forum

**Зураг 2.12. Хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлт, ур чадварын тогтвортой байдал, салбараар**

Дэлхийн олон улсын боловсролын тогтолцоогоо улам бүр өсөн нэмэгдэж буй бараа, үйлчилгээний чөлөөт худалдаа, капитал, ур чадварын чөлөөт хөдөлгөөн, мэдээллийн технологийн хурдацтай өсөлт бүхий глобал эдийн засгийн орчинд нийцүүлэн шинэчлэх үйл явц эрчимтэй өрнөж байна.

Мөн түүнчлэн шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хурдац нь шинээр гарч ирэх мэргэжил, түүнтэй холбоотой ур чадваруудыг урьдчилан таамаглах ажлыг хүндрэлтэй болгож байна. Энэ нь илүү уян хатан боловсролын систем бий болгох, хурдацтай өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагад мэргэжлийн мэдлэгийг хэрэглэх тал бүрийн ерөнхий дадал чадварыг хөгжүүлэхэд түлхэц болох, ажилтан хүн гаднын нөхцөл байдалд илүү уян хатан зохицох, өөрийгөө үр дүнтэй хөгжүүлэх чадвартай, тодорхой мэргэжлийн ажилд шаардлагатай мэргэшлийн ур чадварыг амьдрал дээр хэрэгжүүлэх чадвартай байхыг шаардах болжээ.


Иймээс XXI зууны ажлын байрны төлөв нь мэдлэгийн эдийн засаг болон үйлчилгээний цогцоор тодорхойлогдож байна. Тухайлбал, ОХУ-ын “Global Education Futures” болон “World Skills Russia” зэрэг байгууллагууд Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO), “BRICS Business Council”-тай хамтран дэлхийн 77 оронд явуулсан “Skills of the future: How to thrive in the complex new



**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл” суурь судалгааны төслийн тайлан**

world” судалгааны тайланд XXI зуунд нийгэм, эдийн засагт гарч байгаа өөрчлөлт, технологийн хурдацтай хөгжилтэй холбоотойгоор ажлын байрны ирээдүйн ерөнхий хэв шинжийг дараах байдлаар тодорхойлжээ.

Олон улсын байгууллага болон өндөр хөгжилтэй орнууд дэлхий дахины даяаршил, нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, технологийн дэвшилтэй уялдан хөдөлмөрийн зах зээлд гарах өөрчлөлт, ирээдүйн дүр төрхийг тодорхойлох хандлагатай байна. Тухайлбал, Дэлхийн эдийн засгийн форумаас 2016 онд үндэстэн дамнасан корпорац, томоохон компани болон олон улсын байгууллагуудын удирдах ажилтнуудыг хамруулсан “Ирээдүйн ажил мэргэжил: аж үйлдвэрийн дөрөвдөх хувьсгалын үеийн ажил мэргэжлийн чиг хандлага ба ур чадвар, хөдөлмөр эрхлэлт” судалгааны тайланд ойрын ирээдүйд ажил мэргэжил, түүнд шаардлагатай ур чадварт гарах хувьсал өөрчлөлт, төлөв байдлыг тодорхойлжээ.




Эх үүсвэр: Skills of the future

**Зураг 2.13. Ажил байрны ирээдүйн төлөв байдал**


“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан

### Чиглүүлэгчийн өөрчлөлт

Хамгийн шилдэг нөлөө үзүүлж буй бизнесийн загвар



### Ажилчдын ур чадварт нөлөөлөх нөлөө



### Боловсон хүчний учруулах саад

Дундаж үйлдвэрлэл



### Үндсэн ажил

Ажил	Хүлээгдэж буй өөрчлөлт	Ур чадвар	Эмэгтэй ажилчдын эзлэх хувь	Одоогийн ажилд авах нөхцөл	Ажилд авах нөхцөл
<b>Соёл урлаг, Дизайн, Энтертаймент, Спорт ба Медиа</b> Зар сурталчилгаа олон нийттэй харилцах Харилцаа холбоо дамжуулах технологи	тогтвортой - 0.59%	66%	49%	маш хэцүү	илүү хэцүү
<b>Компьютер ба математик</b> Өгөгдлийн анализ Хэрэглээний болон програм хангамжийг хөгжүүлэгчид ба анализ	тогтвортой өсөлт 6.94%	88%	23%	хэцүү	илүү хэцүү
<b>Борлуулалт</b> Кассчин, билсийн касс Сонин ба гудамжны худалдаачин	өсөлт 2.69%	86%	39%	төвийг сахисан	төвийг сахисан
<b>Менежмент</b> Ерөнхий үйл ажиллагааг хариуцсан Бизнесийн үйлчилгээ	өсөлт 1.67%	67%	12%	хэцүү	төвийг сахисан

### Ажлын байрны хүлээгдэж буй нөлөө



**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**

**Ур чадвар**

**Ур чадварын өөрчлөлт, ерөнхий үйлдвэрлэл**



**Шинээр гарч ирж буй ажлын байр: Менежмент**

мэргэжил	2020 оны гол ур чадвар	Ур чадвар
Захирлууд болон гүйцэтгэх удирдлагууд	Бүтээлч сэтгэлгээ	Боловсруулах ур чадвар
Байгууллагын хөгжлийн мэргэжилтнүүд	Хүмүүсийн менежмент	Нөөцийн менежментийн чадвар
Ерөнхий ба үйл ажиллагааны менежерүүд	Асуудал шийдвэрлэх	Асуудал шийдвэрлэх чадвар
	Өөрийгөө болон бусдыг хянах	Боловсруулах ур чадвар
	Санхүүгийн нөөцийн менежмент	Нөөцийн менежментийн чадвар

Эх үүсвэр: World Economic Forum

**Өөрчлөлтийн менежмент болон ирээдүйн ажиллах хүчний төлөвлөлт**

**Саад бэрхшээлүүд**

- Хувьцаа эзэмшигчдийн дарамт, богино хугацааны ашигт ажиллагаа.... 64%
- Инновацийн стратегид ажиллах хүчний стратеги тохирохгүй байх ..... 50%
- Нөөцийн хязгаарлалт ..... 36%
- Уналтын өөрчлөлтийн талаарх ойлголт хангалтгүй .....36%
- Анхан шатны менежментийн талаарх ойлголт хангалтгүй .....21%
- Мэдэхгүй .....14%

**69%**  
ирээдүйн ажиллах хүчний төлөвлөлт бол манлайлал

**Стратеги**



**46%**  
өөртэй итгэлтэй байх стратегитэй тохирсон

**Зураг 2.14. Ажил мэргэжил, ур чадварын ирээдүйн төлөв**



Түүнчлэн дэлхий дахины даяаршил, технологийн хурдацтай хөгжлийн улмаас зарим ажлын байрнууд шаардлагагүй болж, шинэ ажлын байр, ажил мэргэжлүүд бий болж байна. Иймээс Дэлхийн эдийн засгийн форумаас санаачлан хөдөлмөрийн зах зээлийн хувьсал өөрчлөлтөд дасан зохицоход чухалд тооцогдож буй мэргэжлийн ур чадвартай нэгэн адил ач холбогдол өгөх болсонтой холбоотойгоор энэхүү ерөнхий ур чадварыг суурь болон нийтлэг гэсэн үндсэн 2 бүлэгт хувааж, 8 багц бүхий 35 ур чадварыг тодорхойлсон ба хүснэгтээр нэгтгэн харуулав.

***Хүснэгт 2.23. Ирээдүйн ажлын байранд шаардлагатай ерөнхий ур чадварууд***

<b>Суурь ур чадварууд</b>		<b>Нийтлэг ур чадварууд</b>	
<b>Танин мэдэхүйн чадвар</b>	<b>Боловсруулах чадвар</b>	<b>Харилцааны чадвар</b>	<b>Зохион байгуулах чадвар</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Танин мэдэхүйн уян хатан байдал,</li> <li>• Бүтээлч хандлага,</li> <li>• Логик сэтгэлгээ,</li> <li>• Асуудлын мөн чанарыг ойлгох,</li> <li>• Тооцон бодох,</li> <li>• Хийсвэрлэх,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Суралцах арга барил,</li> <li>• Өөрийгөө илэрхийлэх,</li> <li>• Уншиж ойлгох,</li> <li>• Найруулан бичих,</li> <li>• Мэдээллийн технологи эзэмшилт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Бусадтай харилцах,</li> <li>• Сэтгэл зүй,</li> <li>• Хэлэлцээр хийх,</li> <li>• Хүлээцтэй хандах,</li> <li>• Бусдад зааж зөвлөх,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн менежмент,</li> <li>• Үйл ажиллагааны менежмент,</li> <li>• Багийн менежмент</li> <li>• Цагийн менежмент,</li> </ul>
<b>Бие бялдрын хөгжил</b>	<b>Оюуны хөгжил</b>	<b>Системийн сэтгэлгээ</b>	<b>Техникийн чадвар</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Биеийн зөв хөгжил,</li> <li>• Уян хатан байдал,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Бусдыг сонсох,</li> <li>• Шүүмжлэлт сэтгэлгээ,</li> <li>• Өөрийгөө болон бусдыг мэдрэх,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргах,</li> <li>• Системийн шинжилгээ хийх,</li> <li>• Асуудлыг системчилж, шийдэл гаргах,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Техник хэрэгсэл ашиглах</li> <li>• Тоног төхөөрөмжтэй ажиллах,</li> <li>• Мэргэжлийн программ хангамж ашиглах,</li> <li>• Чанарын хяналт тавих,</li> <li>• Технологи ба бүтээгдэхүүний дизайны хөгжүүлэх,</li> <li>• Эвдрэлийг оношилж засах,</li> </ul>

*Эх үүсвэр: World Economic Forum*

Энэхүү ирээдүйн ажил мэргэжил болон шаардлагатай ур чадваруудыг 5 жилийн давтамжтайгаар тогтмол тодорхойлж байх нь салбарын хөдөлмөрийн зах зээлийн ирээдүйн эрэлт, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангахад чухал юм.

Дээд боловсролын чанарыг хангах асуудлыг дэлхийн улс орнууд мэргэшлийн хүрээ боловсруулах замаар хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан ур чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэх үндсэн нөхцөлийг дээд боловсролын сургалтын байгууллагад бий болгож байна.

Мэргэшлийн хүрээ (qualification framework) гэдэг нь суралцахуйн үр дүнг сургалтын түвшин тодорхойлогч болон мэргэшлийн талаас нь тодорхойлон ангилсан бүтэц юм<sup>8</sup>. Энэ нь өөр өөр орчин нөхцөлд ур чадварыг хөгжүүлэх, боловсролын чанарыг үнэлэх болон сайжруулах боломжийг бий болгодог<sup>9</sup> гэж чөлөөт цахим нэвтэрхий тольд тодорхойлсон бол Олон улсын хөдөлмөрийн байгууллагын тайлан (2007)-д *“Мэргэшлийн хүрээ нь логик уялдаа бүхий, дэс дараалсан, тогтоосон түвшнүүдийн дагуу мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлох, ангилан бүлэглэх, мөн таньж мэдэн, хүлээн зөвшөөрөх, харьцуулахад ашиглагддаг хэрэгсэл”* хэмээн тодорхойлжээ.

Мэргэшлийн хүрээ нь боловсролын чанарыг дээшлүүлэх, хүртээмжийг өргөтгөх, боловсролын янз бүрийн түвшингийн хоорондын болон боловсрол ба зах зээлийн уялдаа холбоог сайжруулах, мэргэшлийн эх орондоо төдийгүй олон улсад хүлээн зөвшөөрүүлэх зорилготой юм<sup>10</sup>. Мэргэшлийн үндэсний хүрээ, кредит системд мэргэшлийн хүрээний бүрдэл хэсгүүдийг дараах 3 элемент болгон авч үздэг. Үүнд:

- **Түвшин**: Суралцагч боловсролын шат ахин суралцахын хэрээр өсөн нэмэгдэх оюуных нь эрэлт хэрэгцээ болон суралцахуйн хүндрэлийн түвшнийг мэргэшлийн хүрээний түвшнүүд илтгэдэг.
- **Кредит**: Кредит нь мэргэшлийн түвшин бүрээрх сургалтын агуулгын багтаамжийг тоон талаас нь илэрхийлдэг.

<sup>8</sup> <https://unevoc.unesco.org/go.php?q=TVETipedia+Glossary+A-Z&id=333>

<sup>9</sup> Keevy, James; Chakroun, Borhene. *Level-setting and recognition of learning outcomes: The use of level descriptors in the twenty-first century(PDF)*. Paris, UNESCO.2015., -P.10

<sup>10</sup> “Дээд боловсролын бодлогын өөрчлөлт цуврал зөвлөмж” дугаар 9.-УБ., 2018. -Х2

- Суралцахуйн хүрээ: Суралцахуйн хүрээг мэргэшлийн түвшин бүрээр тодорхойлсон байдаг ба энэ хүрээнд суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, дадал, хандлага зэргийг нарийвчлан тодорхойлдог.

Мэргэшлийн тогтолцоо гэдэг нь мэргэшлийн талаар баримтлах бодлого, стратеги боловсруулах, хэрэгжүүлэх; чанарын баталгаажуулалт хийх; мэргэшил эзэмшсэн эсэхийг үнэлэн дүгнэх; боловсролын зэрэг дэв, диплом, гэрчилгээ олгох зэрэг сурах үйлийн үр дүнг тогтоох, хүлээн зөвшөөрч, баталгаажуулахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг багтаасан өргөн хүрээтэй ойлголт. Өөрөөр хэлбэл, мэргэшлийн хүрээ нь мэргэшлийн тогтолцооны нэг л бүрэлдэхүүн хэсэг юм хэмээн тодорхойлжээ<sup>11</sup>.

Мэргэшлийн хүрээг боловсруулж хэрэгжүүлэх зорилго нь насан туршийн боловсролыг дэмжих юм. Насан туршийн боловсрол бол хүний амьдралын туршид шаардагдах мэдлэг, чадвар, ойлголт, зан чанарыг олгох, улмаар түүнийгээ ямар ч орчин нөхцөлд өөртөө итгэлтэй, урам зоригтой бүтээлчээр хэрэглэж чадах чадамжийг суулгах замаар хувь хүнийг нийгэмд идэвхтэй байр суурь эзлэхэд нь дэмжлэг үзүүлж чадавхжуулах тасралтгүй үйл ажиллагаа юм гэжээ. Насан туршийн боловсрол нь боловсролын системийн янз бүрийн түвшин, сургалт, мэргэшлийн тогтолцоо хоорондын зохицлыг ахиц дэвшил гаргах байдлаар босоо чиглэлд (мэргэшил дээшлүүлэх, чадамжийг сайжруулах), эсвэл хэвтээ чиглэлд (дахин суралцах эсвэл суралцах арга замыг өөрчлөх) зэргээр уялддаг. Тухайлбал, Европын холбооны орнууд Болоний процесс (ЕНЕА - Дээд боловсролын хүрээ) болон Копенгагений процесс (EQF - Европын мэргэшлийн хүрээ, VET – мэргэшлийн ур чадвар) гэсэн хүрээг бий болгожээ. Дээд боловсролын хүрээнд ECTS (кредит цуглуулах, шилжүүлэх) аргачлалыг ашигладаг бол ур чадварын боловсролын хүрээнд ECVET-ийг ашигладаг.

---

<sup>11</sup> ILO (2007). *The implementation and impact of National Qualifications Frameworks: Report of a study in 16 countries*, Geneva.p.6



**Зураг 2.15. Мэргэшлийн болон боловсролын хүрээ**

Мэргэжлийн боловсрол сургалтаар олж авсан ур чадварыг кредит шилжүүлэн мэргэшлийн хүрээнд нэгтгэх (ECVET) аргачлалыг 2009 онд боловсруулсныг харахад дээрх хоёр аргачлал хэрэгжээд өдгөө арван жил болсон байна

**Хүснэгт 2.24. Мэргэшлийн хүрээ ба дээд боловсролын хүрээний харьцуулалт**

	Мэргэшлийн хүрээ	Дээд боловсролын хүрээ
Агуулга	Бүх мэргэшлийг багтаасан. Хөтөлбөрийн хугацаа эсвэл тэдгээрийн үргэлжлэх хугацаа байдаггүй. Боловсролын талаарх мэдэгдэл байхгүй. Сургалтын үр дүнг мэдлэг, ур чадвар, чадамж гэж тодорхойлдог.	Диплом, боловсролын зэрэг олгох дээд боловсролын хүрээнд. Кредит шилжүүлэх, цуглуулах (ECTS) хүрээнд эхний үе шат 3-4 жил, хоёрдох үе шат нь 1-2 жил байна. Суралцахуйн үр дүнг мэдлэг, мэдлэгээ ашиглах ба ойлгох; үнэлэлт дүгнэлт өгөх, харилцааны ур чадвар; суралцах ур чадвар хэмээн тодорхойлдог.
Хэрэгжилт	Улс орнууд өөрийн үндэсний мэргэшлийн хүрээгээ олон улс болон бүс нутгийн мэргэшлийн хүрээг баримжаа болгон боловсруулдаг.	Үндэсний мэргэшлийн хүрээтэй байх шаардлагатай. Дээд боловсролын хүрээний тодорхойлогчтой тухайн улсын дээд боловсролын мэргэшлүүдийг нийцэж байгаа эсэхийг батлах.

Суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагын үнэлгээ нь харьцангуй мэргэжлийн түвшинд хэлэлцэгддэг, техникийн шинжтэй олон асуудлыг агуулдаг ч мэргэшлийн хүрээ боловсруулан, хэрэгжүүлэхийг зорьж буй нөхцөлд үнэлгээнд тавигдах үндсэн шалгуурууд, тэдгээртэй холбоотой үүсэж болох асуудлыг урьдчилан мэдэж байх нь чухал. Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагын үнэлгээний хамгийн гол шалгууруудад үнэлгээ үнэн зөв, бодитой, найдвартай, практикт хэрэгжүүлж болохуйц, үр ашигтай байх зэрэг


багтдаг. Тодорхой стандарт, шалгуурт суурилсан үнэлгээний механизм нь мэргэшлийн хүрээний нэг үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох суралцагчийн өмнө нь эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагын түвшнийг тогтоож, хүлээн зөвшөөрөх үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Энэхүү мэргэшлийн хүрээг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг Шинэ Зеланд, Австрали, Шотланд зэрэг орнууд анх санаачилсан ба өнөөгийн байдлаар дэлхийн 160 орчим оронд мэргэшлийн хүрээг төлөвшүүлэх ажил идэвхтэй өрнөж байна. Дэлхийн олон оронд иргэдийн мэргэшсэн байдал ажлын байранд тавьж буй мэдлэг, чадварын шаардлагад хүрэхгүй, боловсролын байгууллагын сургалтын бодлого нь ажил олгогчдын хэрэгцээ шаардлагатай нийцэхгүй байх, албан бус боловсролыг албан боловсролын системтэй уялдуулан хөгжүүлэх зэрэг олон асуудлыг шийдвэрлэх суурь нөхцөл болж байна. Мэргэшлийн хүрээг тухайн нэг салбар төдийгүй, үндэсний, бүс нутгийн зэрэг олон хэв шинжээр хэрэгжүүлэх байна. Тухайлбал, Европын мэргэшлийн хүрээ, Зүүн өмнөд азийн холбоо (ASIEN)-ийн мэргэшлийн хүрээ, Карибын хамтын ажиллагааны нийгэмлэгийн мэргэшлийн хүрээ зэргийг дурдаж болох юм. Эдгээрээс Европын холбооны мэргэшлийн хүрээг олон улс орны хувьд харьцуулсан жишиг баримт бичиг болгон ашиглах хандлага түгээмэл байна.

Манай улсын хувьд дээд боловсролын тогтвортой хөгжлийг хангах, төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвартай мэргэжилтэн болгон хөгжүүлэх, олон улсын хөдөлмөрийн зах зээлийн системд нэгдэх боломжийг үндэсний мэргэшлийн хүрээгээр дамжуулан хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Өнгөрсөн хугацаанд манай улсын хувьд үндэсний мэргэшлийн хүрээг боловсруулан гаргах зорилгоор байгуулагдсан Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам ба Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж, 10 түвшин бүхий үндэсний мэргэшлийн хүрээний хувилбарыг санал болгожээ.

Иймээс үндэсний мэргэшлийн хүрээг боловсруулахдаа хөдөлмөрийн зах зээлд оролцогч талууд болох төрийн захиргааны байгууллага,

боловсролын байгууллага болон ажил олгогчдын оролцоог тэгш хангах нь чухал ба дараах байдлаар зохион байгуулах боломжтой.



**Зураг 2.16. Үндэсний мэргэшлийн хүрээний суурь загвар**

Ер нь мэргэшлийн хүрээ нь тодорхой шатлал бүхий түвшний дагуу ангилдаг үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн мэргэшлийн хөтөлбөрийг багтаасан байдаг. Ер нь үндэсний мэргэшлийн хүрээ нь:

- i) Чанарын баталгаатай, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, харилцан нийцтэй сургалтын стандартуудыг бий болгон мөрдүүлэх,
- ii) Мэдлэг, чадвар эзэмшин, багц цаг цуглуулах суралцахуйн бүх хэлбэрийг хүлээн зөвшөөрсөн систем юм.

Иймээс үндэсний мэргэшлийн хүрээг логик уялдаа бүхий шатлан тогтоосон түвшний дагуу мэдлэг, чадвар, дадлыг тодорхойлох, ангилан бүлэглэх, харьцуулан шинжлэх үйл явц гэж үзэж болно. Нөгөө талаас, тодорхой мэргэжлээр мэргэшихийн тулд ямар замаар хэрхэн шатлан суралцах

мэргэшлүүдийн уялдаа холбоо, нэг түвшнээс нөгөө түвшинд ахиж дэвших боломжийг харуулдаг давуу талтай.

Үндэсний мэргэшлийн хүрээг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг төрийн захиргааны байгууллагаас нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэн ирээдүйд шаардлагатай болох ажил мэргэжил, ур чадварыг тодорхойлоход манлайлан оролцож, үндэсний түвшний бодлого боловсруулж хэрэгжүүлэх нь чухал юм. Үндэсний мэргэшлийн хүрээ нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурлан ирээдүйд шаардлагатай ур чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэх, тэдний мэргэшил, ур чадварын талаар нэгдсэн ойлголтой болох, ажил олгогч, дээд боловсролын сургалтын байгууллагууд хамтран ажиллах зэрэг нь дээд боловсролын байгууллага сургалтын чанараа үнэлэх, төгсөгчид нь хөдөлмөрийн зах зээлийн шаардлага хангаж буй эсэхийг нягтлах суурь нөхцөл бүрдэх юм.

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ, магадлан итгэмжлэл нь тухайн байгууллагын тогтвортой хөгжил, өрсөлдөх чадварыг дэмжих байдлаар хэрэгжүүлэхийн тулд үндэсний мэргэшлийн хүрээг хөгжүүлэхээс эхлэх нь зүйтэй юм.

### **2.11. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанар ба их сургуулиудын рейтингийн үнэлгээ**

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарыг зөвхөн сургалтын үйл ажиллагааны үр дүн болох төгсөгчдийн цогц чадамж, тэдний хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвар, ажил олгогчдын хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаагаар үнэлэх нь учир дутагдалтай юм. Иймээс нийгмийн институтийн тогтолцоонд дээд боловсролын сургалтын байгууллага нь “Сургалт – Судалгаа – Инновац”-ын хосолмол хэв шинжтэй үйл ажиллагаа эрхэлдэг болохыг харгалзан чанарын асуудлыг олон талт зарчмаар үнэлэх нь зохимжтой.

Энэ утгаараа дээд боловсролын сургалтын байгууллагын судалгааны чанар, чансааг үнэлэх нь чухал ач холбогдолтой. Анх 1983 онд U.S. News & World Report сэтгүүлд АНУ-ын шилдэг коллежийн жил бүрийн эрэмбийг тогтоож эхэлсэн бол 2003 оноос их сургуулиудын хувьд, 2009 оноос их сургууль болон

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

судалгааны институтүүдийг нийтэд нь хамруулан төрөл бүрийн аргачлалуудаар чансаа тогтоож байна. Энэхүү их, дээд сургуулиуд чансаа тогтоох нь олон улсын шинжтэй болж олон улсын нэр хүнд бүхий байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл тогтмол зохион байгуулах болжээ.

Дэлхий дахинд их сургуулиудын чансаа тогтоох систем нэлээдгүй олон байгаа боловч нэгдсэн систем, аргачлал бий болгож чадаагүй байна. Эдгээр системүүд шалгуур үзүүлэлт, үзүүлэлтийн жин, үзүүлэлтийн өгөгдлийг цуглуулах, нэгтгэх аргачлалаараа хоорондоо ялгардаг. Олон улсад түгээмэл ашиглагдаж байгаа зарим үнэлгээний аргачлалуудыг хүснэгтээр харьцуулан харуулав.

*Хүснэгт 2.25. Их, дээд сургуулиудын чансаа тогтоох зарим системүүд*

№	Үнэлгээний систем	Үнэлгээний шалгуурууд	Хувийн жин, %	Шалгуур үзүүлэлтүүд
1	Times Higher Education (THE), World University Rankings	Сургалтын чанар	30	<ul style="list-style-type: none"> <li>✓ Сургалтын нэр хүнд</li> <li>✓ Сургалтын орлого</li> <li>✓ Оюутан ба нийт ажиллагчдын харьцаа</li> <li>✓ Бакалавр болон доктор оюутны харьцаа</li> <li>✓ Профессор багш ба төгссөн доктор оюутны харьцаа</li> </ul>
		Академик нэр хүнд	30	<ul style="list-style-type: none"> <li>✓ Судалгааны нэр хүнд</li> <li>✓ Судалгааны орлого</li> <li>✓ Судалгааны бүтээмж</li> </ul>
		Бүтээлийн эшлэлийн индекс	30	<ul style="list-style-type: none"> <li>✓ Эшлэлийн үр нөлөө</li> <li>✓ Нэг өгүүллийн дундаж эшлэл</li> </ul>
		Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байдал	7.5	<ul style="list-style-type: none"> <li>✓ Дотоод болон гадаад оюутны харьцаа</li> <li>✓ Дотоодын болон гадаадын зочин профессор, судлаачийн харьцаа</li> <li>✓ Олон улсын хамтын ажиллагаа</li> </ul>
		Инновацын чадавх	2.5	<ul style="list-style-type: none"> <li>✓ Үйлдвэрийн газрын орлого</li> <li>✓ Мэдлэг дамжуулалт</li> </ul>
		<b>Нийт</b>	<b>100</b>	
2	Academic ranking of world universities (ARWU)	Сургалтын чанар	10	<ul style="list-style-type: none"> <li>✓ Нобелийн шагнал авсан төгсөгч</li> <li>✓ Салбарын медаль авсан төгсөгч</li> </ul>
		Багшлах бүрэлдэхүүний чадавхи	40	<ul style="list-style-type: none"> <li>✓ Нобелийн шагнал авсан судлаач</li> <li>✓ Салбарын медаль авсан судлаач</li> <li>✓ Өндөр эшлэлтэй судлаачид</li> </ul>



*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

		Судалгааны ажлын түвшин	40	✓ Инфакт фактортай сэтгүүлд хэвлүүлсэн бүтээл ✓ Эшлэлийн индекс
		Судалгааны бүтээмж	10	✓ Судлаач бүрийн академик гүйцэтгэл
		<b>Нийт</b>	<b>100</b>	
3	Performance Ranking of scientific for World Universities	Судалгааны бүтээмж	20	✓ Сүүлийн 11 жилд хэвлүүлсэн өгүүллийн тоо ✓ Тухайн жилийн өгүүллийн тоо
		Судалгааны үр нөлөө	30	✓ Сүүлийн 11 жилийн эшлэлийн тоо ✓ Сүүлийн жилийн эшлэлийн тоо ✓ Сүүлийн 11 жилийн дундаж эшлэл
		Судалгааны чанар	50	✓ Сүүлийн 2 жилийн h-индекс ✓ Өндөр эшлэгдсэн өгүүллийн тоо ✓ Мэргэжлийн сэтгүүлд тухайн жилд хэвлүүлсэн өгүүллийн тоо
		<b>Нийт</b>	<b>100</b>	
4	High Impact Universities: Research Performance Index	G-индекс	50	✓ Судлаачийн бүтээлийн эшлэлийг гол үндэс болгодог
		H-индекс	50	✓ Судлаачийн бүтээлийн бүтээмж, эшлэлийн үр нөлөө, хэрэглээг хэмжихэд чиглэгддэг
		<b>Нийт</b>	<b>100</b>	
5	QS World university rankings	Академик нэр хүнд	40	✓ Олон улсын түвшинд судлаачдын дунд явуулсан судалгааны үр дүн
		Ажил олгогчийн нэр хүнд	10	✓ Олон улсын түвшинд ажил олгогчдын дунд явуулсан судалгааны үр дүн
		Оюутан ба багшийн харьцаа	20	✓ Нийт багш, судлаач болон оюутны тооны харьцаа
		Нэг процессор багшид ногдох эшлэл	20	✓ Thomson Reuters-ийн индекстэй сэтгүүлийн эшлэлийн тоо
		Гадаад хамтын ажиллагаа	10	✓ Гадаад оюутны эзлэх хувь ✓ Гадаадын зочин профессор, судлаачийн эзлэх хувь
		<b>Нийт</b>	<b>100</b>	
6	Higher Education Evaluation and Accreditation Council of	Судалгааны ажлын бүтээмжтэй байдал	20	✓ Өнгөрсөн жилд хэвлүүлсэн өгүүллийн тоо ✓ Тухайн жилд хэвлүүлсэн өгүүллийн тоо
		Судалгааны ажлын үр	30	✓ Өнгөрсөн жилийн эшлэлийн тоо ✓ Өнгөрсөн 2 жилийн эшлэлийн тоо

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

	Taiwan (HEEACT)	нөлөөтэй байдал		✓ Өнгөрсөн 11 жилийн эшлэлийн дундаж тоо
		Судалгааны ажлын шилдэг байдал	50	✓ Өнгөрсөн 2 жилийн h-индекс ✓ Хамгийн их эшлэгдсэн өгүүллийн тоо ✓ Тухайн жилийн өндөр индекстэй сэтгүүлд хэвлэгдсэн өгүүллийн тоо
		<b>Нийт</b>	<b>100</b>	
7	U.S.News and World report	ARWU	50	✓ Багш, судлаачдын чадавх ✓ Судалгааны ажлын үр дүн ✓ SCIE болон SSCI индекстэй өгүүлэл
		THE & QS	40	✓ Багш, судлаач болон оюутны харьцаа ✓ Нэг багш, судлаачид оногдох эшлэл ✓ Гадаад харилцаа ✓ Гадаад багш, судлаачийн эзлэх хувь
		Судалгааны материалын хүртээмж	10	✓ Номын сангийн нийт ном, сурах бичиг, сэтгүүлийн тоо
		<b>Нийт</b>	<b>100</b>	

Дээрх рейтинг тогтоох системүүдийг харьцуулбал, “THE” аргачлалын хувьд их сургуулийн эрдэм шинжилгээ, инновацын үйл ажиллагааг үнэлэх үзүүлэлт нь нийт үзүүлэлтийн 61.5 хувийг, үзүүлэлтийн ач холбогдлын хувийн жингийн 70 хувийг эзэлж байна. Мөн ARWU аргачлалын хувьд 5 үзүүлэлтийн 4 нь эрдэм шинжилгээ, инновацын гүйцэтгэлийг үнэлж, үзүүлэлтүүдийн ач холбогдлын хувийн жингийн 90 хувийг эзэлж байна. Үүнээс гадна судалгааны их сургууль болон их сургуулийн судалгааны үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлдэг 2 систем (Performance Ranking of Scientific Papers for World Universities, High Impact Universities; Research Performance Index) байгаа ба тэдгээрт хэвлүүлсэн өгүүллийн тоо болон эшлэлийн тоо чухал үзүүлэлт болдог байна. Харин QS систем нь Английн Quacquarelli Symonds компаниас дэлхийн шилдэг 500 их сургуулийг шалгаруулдаг ба дэлхийн болон Ази, Африк, Европ зэрэг бүс нутгийн хувьд чансаа тогтоож байна. Харин 2012 оноос их сургуулийн элсэгчдэд зориулан мэргэжлийн хөтөлбөрийн хувьд рейтинг тогтоож эхэлсэн ба инженерийн салбар, анагаах ухаан, байгалийн ухаан, нийгмийн ухаан, урлаг хүмүүнлэг гэсэн 5 ангилалд хамаарах 29 мэргэжлийг хамруулжээ. Тухайлбал, Art and design, Performing arts, Engineering and technology гэх мэт.

Мөн G-factor үзүүлэлтээр их, дээд сургуулиудад чансаа тогтоож байна. Энэ үзүүлэлтийг тооцохдоо Google search engine ашиглан тухайн их, дээд сургуулийн цахим хуудсанд бусад сургуулийн хуудаснаас хандах холбоосны тоогоор үнэлж байгаа нь тухайн их сургуулийн нийгэмд түгээж байгаа мэдээллийн ач холбогдол, чанарыг тодорхойлох хөндлөнгийн үнэлгээний аргачлал болж байна.

“Тогтвортой хөгжил - дээд боловсрол” улсын II зөвлөгөөнөөс гаргасан зөвлөмжид i) Дотооддоо дээд боловсролын байгууллагын чанарын эрэмбэ тодорхойлох шалгуур үзүүлэлт, арга зүйг тодорхойлон баталж, чансаа тогтоох ажлыг хэрэгжүүлэх; ii) Олон улсын чанарын байгууллагуудаар их, дээд сургуулиудын олон улсын түвшинд чансаа тогтоолгох, дээшлүүлэх зорилгоор сургууль бүр стратеги төлөвлөгөө боловсруулах ажлыг 2018 онд багтаан хэрэгжүүлэх; зэрэг тодорхой саналууд туссан нь дээд боловсролын салбарын тулгамдсан, ойрын хугацаанд шийдвэрлэх шаардлагатай асуудал болох нь харагдаж байна.

Манай улсын хувьд төрөөс дээд боловсролын талаар баримтлах бодлогод 4 их сургуулийг азийн шилдэг 100 сургуулийн эгнээд багтаана гэж зорилт дэвшүүлсэн нь төрийн өмчийн их сургуулиуд хөгжлийн мастер төлөвлөгөөгөө өөрчлөх үндэслэл болж, улмаар THE болон QS системээр олон улсын чансаа тогтоолгох гэж тусгасан нь олон улсын хөгжлийн хандлагыг баримжаалсан бодлого боловсруулагдах эх суурь болсон нь сайшаалтай юм. Гэвч салбарын хэмжээнд энэхүү дэвшүүлсэн зорилттой холбоотой хэрэгжүүлэлтийн нэгдсэн төлөвлөгөө байхгүй, өнөөгийн нөхцөлд азийн шилдэг 100 сургуулийн эгнээнд багтах чадавхтай их сургууль байгаа эсэх, бид олон улсад их сургуулийн чансаа тогтоож байгаа ямар системийг сонгох нь оновчтой эсэх зэрэг нэн яаралтай шийдвэрлэх шаардлагатай асуудлууд шийдлээ хүлээж байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын асуудал нь сургалтын чанар (төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт), байгууллагын чанарын удирдлагын тогтолцоо (магадлан итгэмжлэл), сургуулийн зэрэглэл (олон улсад зэрэглэл тогтоох), судалгааны чанар (олон улсад хүлээн зөвшөөрөгдөх байдал), сургуулийн профессор багшийн чадавх (олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өндөр түвшний судлаач) гэсэн нийлмэл шинжтэй юм. Иймээс

дээд боловсролын сургалтын байгууллагын чанарыг үнэлэхдээ олон талт, хөндлөнгийн үнэлгээний системийг нэг хүчин зүйл байдлаар олон улсад их сургуулиудын чансаа тогтоож байгаа аргачлал, үр дүнг ашиглах боломжтой юм.

## 2.12. Дээд боловсролын сургалтын байгууллагын судалгааны чанарын үнэлгээ

Мэдлэгт суурилсан, тогтвортой хөгжил бүхий нийгмийн тогтолцоог бий болгоход шинэ мэдлэг бүтээх “судалгаа”-ны их сургуулийн гүйцэтгэх үүрэг чухал юм. Инновац буюу шинэ мэдлэг бүтээхэд чиглэсэн судалгааг амжилттай хөгжүүлэх нь дээд боловсролын сургалтын байгууллагын хувьд хөрөнгө оруулалт татах оновчтой эх сурвалж төдийгүй тухайн байгууллагын нэр хүнд, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үндсэн нөхцөл мөн. Ерөнхийдөө дээд боловсролын сургалтын байгууллага нь i) сургалтад суурилсан мэргэжилтэн бэлтгэх, ii) судалгаанд суурилсан шинжлэх ухааныг хөгжүүлэх, iii) зөвлөгөөнд суурилсан нийгэмд үйлчлэх гурван гол чиг үүрэгтэй.

Сургалт, судалгааны байгууллага бүр өөрийн онцлогт тохирсон судалгааны чанарын үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулсан байдаг. Олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий сургалт, судалгааны байгууллагууд судалгааны чанарыг үнэлэхдээ тоон шинжилгээнд суурилсан ном зүйн үнэлгээний аргыг (*Bibliometrics*) түгээмэл хэрэглэж байна.

1960-аад оны “хэвлэх үү эсвэл устах уу” (*publish or perish*) хэмээх академик хандлагын улмаас барууны орнуудад эрдэм шинжилгээний байгууллагын хэвлэл, нийтлэлийн тоо огцом өссөнөөр судалгааны бүтээлийн тоон болон чанарын үзүүлэлтийг тооцоолох, шилдэг судалгаа, судлаачийг тодорхойлох хэрэгцээ үүсжээ. Ингээд 1961 онд АНУ-ын эрдэмтэн Э.Гарфийлд шинжлэх ухааны эшлэлийн индексийг (*Science citation index*)<sup>7</sup> боловсруулснаар судалгааны чанарын үнэлгээнд статистик аргачлалд суурилсан ном зүйн үнэлгээний аргыг түгээмэл хэрэглэх болсон. Судлаач Э.Гарфийлд шинжлэх ухааны эшлэлийн индексийн үндсэн зарчим нь тодорхой нэг судлаач салбартаа чухалд тооцогдох судалгааны бүтээлээс эш татсан дараа үеийн судалгааны ажлыг ялган тодорхойлоход оршино.

Ном зүйн үнэлгээний арга нь тухайн салбарт хийгдэж буй бүхий л судалгаа, хуримтлагдсан өгөгдлийн санд суурилсан тойм ба дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан, судалгааны чанарын талаарх хувь хүний субъектив хандлагаас ангид, тухайн нэг судлаачид ногдох өгүүллийн тоо ба өгүүлэл тус бүрийн эшлэлийн тоон харьцаанд суурилдгаараа давуу талтай. Эл учир ном зүйн үнэлгээний арга буюу эшлэлийн индекс нь судалгааны чанарын үнэлгээний объектив, тоон үзүүлэлт болохоос гадна үнэлгээнд шаардлагатай нэмэлт мэдээлэл болдог байна. Мөн ном зүйн үнэлгээний арга нь тодорхой судлаач, судалгаа эрхэлдэг байгууллагын хэвлэсэн нийтлэлийн тархалт, үр нөлөө, чанарын үнэлгээ хийхийн зэрэгцээ судалгааны салбар, судалгааг хөгжүүлж буй улс орон, бүс нутаг гэх мэтчилэн олон талт үзүүлэлтээр баяжиж байна.

Өнөөдөр судалгаа ба судлаачийн чанарыг эшлэлийн индексээр тодорхойлдог *Web of Science*, *Scopus*, *Google Scholar* зэрэг томоохон мэдээллийн сангийн тусламжтайгаар судлаач импакт фактор бүхий сэтгүүл сонгохоос эхлээд чансаа өндөртэй эрдэмтэн судлаач, судалгааны баг, судалгааны царааг салбар тус бүрээр тодорхойлох боломжтой болжээ. АНУ-ын Үндэсний Шинжлэх Ухааны Сан, Европын Комисс, Францын Шинжлэх ухаан, Техникийн хороо, Японы Үндэсний мэдээллийн институт зэрэг шинжээчдийн баг бүхий ном зүйн үнэлгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж буй улс орон олон байна.

**Түгээмэл хэрэглэдэг эшлэлийн индексүүд:** Судалгааны үр нөлөөг өөр өөр түвшинд, өөр өөр индексээр хэмждэг. Тухайлбал, тодорхой нэг судалгааг сэдвээр нь эсвэл зохиогчоор нь хэчнээн удаа эшилж байгаагаар судлаач ба судалгааны нөлөөллийг тодорхойлдог бол зарим индексээр тодорхой сэтгүүлд хэвлэгдсэн өгүүллийг хэдэн удаа эшилж байгаагаар тухайн сэтгүүлийн ач холбогдол, салбар ухаанд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлдог. АНУ-ын эрдэмтэн *Э.Гарфийлд* шинжлэх ухааны эшлэлийн индексийг анх боловсруулснаар судалгааны чанарын үнэлгээнд статистик математикийн аргачлалд суурилсан ном зүйн үнэлгээний аргыг түгээмэл хэрэглэх болжээ. Ном зүйн үнэлгээний аргын эшлэлийн индексийг i) зохиогчийн түвшний, ii) сэтгүүлийн түвшний, iii) нийтлэлийн түвшний гэсэн гурван хэсэгт ангилж байна.

Зохиогчийн түвшний нөлөөллийн индекс: Зохиогчийн түвшний хэмжүүр нь тухайн нэг судлаачийн шинжлэх ухааны салбар болон судлаачдын дунд оруулж буй хувь нэмэр буюу нөлөөллийг үнэлэхэд чиглэнэ. Ингэхдээ хэвлүүлсэн судалгааны ажлыг нь бусад судлаачид эш татсан тоон үзүүлэлтэд тулгуурлана. Мөн тухайн нийтлэлийн шинэлэг байдал, эшлэлийн өндөр эсвэл бага давтамж зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлох тооцооллын алгоритмыг ашиглана. Зохиогчийн түвшний нөлөөллийг хэмжихдээ нэгдүгээрт, *h*-индекс, хоёрдугаарт, *g*-индекс, гуравдугаарт, *i10*- индексийг түгээмэл хэрэглэдэг нь ажиглагдлаа.

- ✓ *h*-индекс: Калифорнийн их сургуулийн судлаач, физикч *Jorge E. Hirsch*-ийн 2005 онд дэвшүүлсэн *h*-индекс нь *Nature*, *Science* зэрэг томоохон сэтгүүлийн голлох индекс болдог. *h*-индекс нь судлаачийн судалгааны бүтээлийн чансаа, эшлэлийн нөлөөллийг хэмжих зорилготой. Энэхүү индекс нь судлаачийн хамгийн олон эш татагдсан бүтээл ба эш татсан дараагийн бүтээлийн дахин эшлэл татагдсан нийт тоон үзүүлэлтэд тулгуурлан судлаачийн нөлөөллийг хэмжих бөгөөд дан ганц судлаач төдийгүй эрдэм шинжилгээний сэтгүүл, судалгааны баг, тэнхим, их сургууль цаашилбал улс орны судалгааны чансааг тодорхойлдог байна. *Web of Science*, *Google Scholar* зэрэг өгөгдлийн сангийн тусламжтайгаар судлаачийн *h*-индексийг тодорхойлох бүрэн боломжтой. Мөн *h*-индексийг тоон (хэвлүүлсэн өгүүллийн тоо) ба чанар (өгүүллийн нөлөөлөл ба эшлэл)-ыг хослуулсан үнэлгээний аргачлал гэж үздэг. Харин *h*-индексийн сул тал нь тухайн судлаачийн эшлэл татагдсан нийт өгүүллийн дотроос хамгийн цөөн эшлэгдсэн өгүүллийн *n* эшлэлийг гол үзүүлэлт болгодог тул хамгийн олон эшлэгдсэн өгүүллийн эшлэлийн тоог тооцолгүй орхидог байна. Үүнээс гадна *h*-индекс нь судлаач буюу судалгааны байгууллагын нас болон судлаачийн тухайн салбартаа ажилласан жилээс ихээхэн хамаардаг төдийгүй, өөр өөр салбарын судлаачдыг харьцуулан судлахад тохиромж муутай хэмжүүр гэж үзэх тал бий.
- ✓ *g*-индекс: 2006 онд эрдэмтэн *Леогийн* дэвшүүлсэн *g*-индекс нь эшлэлийн дунджийг тооцоолдгоороо өмнөх *h*-индексээс шинэлэг юм. *h*-индексийн хувьд хамгийн цөөхөн эшлэгдсэн нийтлэлийн нийт эшлэлийн

хамгийн бага эшлэлийн  $n$  тоог гол үзүүлэлт болгодог тул олон эшлэл бүхий нийтлэлийг орхигдуулдаг байна.  $g$ -индекс нь хамгийн олон эшлэгдсэн нийтлэлийн тоонд үндэслэн чанарын босгыг давсан хамгийн цөөн эшлэгдсэн нийтлэлийн үнэлгээний баталгаажуулалт болдог.  $g$ -индексийн тооцоолол: Нийтлэлийн хүлээн авсан эшлэлийн тоог буурах дарааллаар эрэмбэлэхэд нийт шилдэг  $g$  нийтлэлүүдийн хамгийн багадаа  $g^2$  зэрэгт эшлэл хүлээн авсан хамгийн их тоо нь  $g$ -индекс юм.

- ✓ i10-индекс: *Google Scholar*-ийн боловсруулсан i10-индекс нь зөвхөн *Google-ийн My Citations*-д ашиглагддаг. Тооцооллын хувьд маш энгийн: i10-индекс = Хамгийн багадаа 10 эшлэл бүхий нийтлэлүүдийн тоо, Тодруулбал: i10-индекс нь хамгийн багадаа арван эх сурвалжийн ашигласан тодорхой нэг судлаачийн бичсэн нийтлэлийн тоо юм.

Сэтгүүлийн түвшний нөлөөллийн индекс: Сэтгүүлийн түвшний хэмжүүрийг тодорхой нэг сэтгүүлийн судалгааны салбарт үзүүлэх нөлөөллийг тодорхойлоход ашиглана. Сэтгүүлийн нөлөөллийн хэмжүүр нь тухайн сэтгүүлийн шинжлэх ухааны тодорхой салбар дахь ач холбогдлыг тодорхойлох төдийгүй жил бүр тухайн сэтгүүлд хэвлэгдсэн нийтлэлийн тоо болон тэдгээр хэвлэгдсэн нийтлэлийн эшлэлийн тоог хэмжихэд чиглэнэ. Сэтгүүлийн түвшний нөлөөлөлд импакт фактор (*Impact Factor*), сэтгүүлийн эшлэлийн тайлан (*Journal Citation Reports*), эигенфактор оноо (*Eigenfactor Score*), SCImago сэтгүүлийн зэрэглэл (*SCImago Journal Rank*), h5-индекс, эшлэлийн оноо (*CiteScore*), шинэлэг байдлын индекс (*Immediacy Index*) зэрэг хэмжүүрийг түгээмэл хэрэглэж байна.

- ✓ Импакт фактор: Импакт фактор буюу нөлөөллийн коэффициент нь сэтгүүлийн түвшний ном зүйн үнэлгээний хамгийн түгээмэл хэрэглэгддэг хэмжүүр бөгөөд шинжлэх ухааны сэтгүүлийн чансааг илтгэсэн тоон үзүүлэлт юм. Импакт факторыг тодорхой сэтгүүлд хоёр жилийн хугацаанд хэвлэгдсэн нийтлэлийн нийт эшлэлийг өгүүллийн тоонд харьцуулсан дундаж үзүүлэлтээр тооцдог. Жишээ нь 2018 онд тухайн нэг сэтгүүл 3 импакт фактортай байна гэж үзвэл уг сэтгүүлд өнгөрсөн хоёр жилийн хугацаанд хэвлэгдсэн нийт нийтлэлүүд дунджаар 3 удаа эш татагдсан байна гэж дүгнэж болно. Импакт факторыг сэтгүүлийн эшлэлийн тайланд (*Journal Citation Reports*) жил бүр нийтэлдэг бөгөөд



тухайн сэтгүүлийн веб хуудаснаас мөн олох боломжтой. Үүнээс гадна сэтгүүлийн чансааг илүү нарийвчлалтай тодорхойлох зорилгоор 5 жилийн дунджаар импакт факторыг хэмжиж байна (Academy, 2018).

- ✓ Сэтгүүлийн эшлэлийн тайлан: буюу Сэтгүүлийн эшлэлийн тайлан нь ISI Web of Knowledge-ийн бүтээгдэхүүн бөгөөд импакт факторыг тодорхойлох албан ёсны эх сурвалж юм. Мэдээллийн сан дахь олон сая эшлэлд тулгуурлан байгалийн ухаан болон нийгмийн ухааны чиглэлийн сэтгүүлүүдийн импакт фактор ба зэрэглэлийг тодорхойлдог. Сэтгүүлийн эшлэлийн тайлан нь нийт эшлэл, нийт өгүүлэл, шинэлэг байдлын индекс зэрэг олон талын хэмжилтийг нэгэн зэрэг хийх боломжтой. Мөн сэтгүүлийн ишлэлийн тайлан нь импакт фактор болон мэдээллийн чиг хандлагыг 5 жилийн дунджаар харуулна.
- ✓ Эигенфактор оноо: Вашингтоны Их Сургуулийн эрдэмтэн *Женев Вест, Карл Бергстром* нарын боловсруулсан эигенфактор оноо нь нөлөө бүхий эрдэм шинжилгээний сэтгүүлийн чансааг тодорхойлох зорилготой. Нийтлэл дэх эшлэлийн тоонд үндэслэн сэтгүүлүүдийн зэрэглэлийг тогтоох бөгөөд өндөр зэрэглэл бүхий сэтгүүлийн нийтлэлээс эшлэл татсан тохиолдолд эигенфактор оноо өндөр гардаг байна. Тооцооллыг гаргахдаа сүүлийн 5 жилийн хугацаанд хэвлэгдсэн сэтгүүлийн эшлэлийн тайлан буюу сэтгүүлийн эшлэлийн тайлан дахь эшлэлийн дунджид үндэслэнэ.
- ✓ Сэтгүүлийн зэрэглэл. Сэтгүүлийн зэрэглэл нь нөлөө бүхий сэтгүүлийн эшлэлд илүүтэй ач холбогдол өгдөг. Тухайн жилийн нөлөө бүхий эшлэлийн дундаж тоог өнгөрсөн гурван жилийн хугацаанд хэвлэгдсэн нийтлэлийн тоонд харьцуулсан үзүүлэлт юм. Сэтгүүлийн зэрэглэлийн үнэ нь төлбөргүй бөгөөд сэтгүүлийн нөлөөллийг тодорхойлохын тулд Scopus-ийн эрдэм шинжилгээний өгөгдлийн санг ашигладаг. Мөн сэтгүүлийг эрхлэн гаргаж буй улс орон, сэтгүүлийн нөлөөллийн өгөгдлийг олон янзын үзүүлэлтээр харуулдаг. Зэрэглэлийн аргачлал нь Google-ийн PageRank алгоритмд суурилна.



- ✓ Н5-индекс: Энэхүү хэмжүүр нь хамгийн багадаа (h) тооны эшлэл бүхий сүүлийн таван жилд хэвлэгдсэн нийтлэлүүдийн тоо юм. *Google Scholar* хуудаснаас ашиглах боломжтой.
- ✓ Эшлэлийн оноо: Скопусийн боловсруулсан шинэ хэмжүүр бөгөөд CiteScore Tracker, CiteScore Percentile, Citation Count гэх мэт найман нэмэлт үзүүлэлттэй.
- ✓ Шинэлэг байдлын индекс: Энэхүү индекс нь анх удаа хэвлэгдсэн нийтлэлийн эшлэлийн дундаж тоо юм. Уг индексээр тухайн нийтлэл хэвлэгдсэн цагаасаа хэр богино хугацаанд эшлэгдэж буйг хэмждэг. Энэхүү индекс нь Web of Science-ийн мэдээллийн сангаас эх сурвалжаа татдаг ба сэтгүүлийн эшлэлийн тайланд жил бүр нийтлэгддэг.
- ✓ Сэтгүүлийн түвшний нөлөөллийг тодорхойлдог. Онолын нөлөөллийн оноо (*Article Influence Score*), хугацаанд суурилсан эшлэлийн зэрэглэл (*Age-weighted citation rate*), m коэффициент (*m quotient*), Краун үзүүлэлт (*Crown Indicator*) зэрэг индекс хэрэглэж байна.

Нийтлэлийн түвшний нөлөөллийн индекс: Нийтлэлийн түвшний нөлөөллийн хэмжүүр нь хэвлэгдсэн нийтлэлийн нөлөөлөл ба тухайн судалгаа эрдэмтдийн анхаарлыг хэр хэмжээнд татаж, бие биедээ дамжуулж буй тоон үзүүлэлтэд тулгуурлан тооцоолдог байна. Нийтлэлийн түвшний нөлөөллийн хэмжүүр нь олон янзын мэдээллийн эх сурвалжийг ашигладаг. Түгээмэл хэрэглэгддэг хэмжүүрүүд нь Алтиметр, Нийтлэлийн түвшний хэмжүүр юм.

- ✓ Алтиметр (Altmetrics): Алтиметр нь уламжлалт эшлэлийн хэмжүүрийн шинэчилсэн хувилбар бөгөөд мэргэжлийн түвшний, Википедиа ба төрийн бодлогын баримт бичгүүд дэх эшлэл, судалгааны блогуудын хэлэлцүүлэг, хэвлэл мэдээллийн тайлбар, Twitter гэх мэт нийгмийн сүлжээн дэх тайлбар зэргээс бүрдэнэ. Иймд алтиметрийг тооцоолох өгөгдлийн эхийг веб хуудаснаас авдаг ба нийтлэл хэвлэгдэн гарахтай зэрэгцэн өөр өөр салбарт тухайн судалгааны үр дүн хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох боломжтой болно.
- ✓ Нийтлэлийн түвшний хэмжүүр (Article-level metrics): PLOS компанийн нийтлэлийн түвшний хэмжүүр нь тодорхой судалгааны нөлөөллийг эшлэгдэхээс өмнөх түвшинд нь хэмждэгээрээ онцлог юм. Энэхүү

хэмжүүрээр академик бие бүрэлдэхүүн ба олон нийтийн оролцооны түвшинг харуулах зорилгоор судалгааны ажлын эрдэм шинжилгээний болон нийгмийн үнэлгээг цугт нь тодорхойлоход чиглэнэ. 21000 гаруй сэтгүүлээс бүрдсэн хамгийн том эшлэлийн сан бүхий Scopus нь нийтлэлийн түвшний хэмжүүрийг өөрийн индексүүдтэй холбосон байна. Мөн Nature Publishing Group нь өгүүллийн үр нөлөөг хэмжих үзүүлэлтдээ нийтлэлийн түвшний хэмжүүрийг давхар ашиглаж байна.

Олон улсын хэмжээнд судалгаа ба судлаачийн чансааг тодорхойлоход статистикт суурилсан ном зүйн үнэлгээний хэмжүүр чухал үүрэг гүйцэтгэсэн хэдий ч үнэлгээний үр дүнг илүү оновчтой болгоход одоо хэрэглэж буй үзүүлэлтүүдийг боловсронгуй болгох, үнэлгээний шинэ индексийг загварчлах, үзүүлэлтүүдийн судалгааг гүнзгийрүүлэх хэрэгцээ ч байсаар байна. Шинжлэх ухааны судалгаа, хэвлэн нийтлэл нэмэгдэхийн хэрээр түүгээр дамжих харилцаа улам бүр нарийн болж байна.

Судлаачийн хувийн мэдлэг, туршлага тухайн салбарын сүүлийн үеийн чиг хандлагыг тодорхойлдог цаг үе нэгэнт өнгөрч байна. Түүнчлэн өнөө үед ирээдүйтэй, үр дүнтэй судалгааны чиглэл, төслийг оновчтой тодорхойлсны үндсэн дээр санхүүжилтийг шийдвэрлэх хэрэгцээ сургалт, судалгааны байгууллагын удирдлагын тулгамдсан асуудал болж байна. Судалгааны чанарын үнэлгээ нь судалгааны оновчтой чиглэл, төслийг дэмжих стратегийн шийдвэрийг гаргахад чухал нөлөөтэй төдийгүй тухайн байгууллагын үндэсний болон олон улсын хэмжээнд эзлэх байр суурь, чансааг тодорхойлох ач холбогдолтой юм.

**Монгол Улсын судалгааг дэмжиж буй бодлого:** Монгол улсын төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2015)-д дээд боловсролын сургалтын байгууллагын судалгааны үйл ажиллагааг дэмжих, 4-өөс доошгүй их сургуулийг Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд хүргэх, Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого (2017)-д судалгааг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэхэд санхүүжилт, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэхээр заасан байна.

Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам (БСШУЯ, 2014)-ын 2.8-д их, дээд сургуулийн багш нь “суралцах, судалгаа хийх үйлийг үр дүнтэй удирдах технологи, арга зүйг эзэмшсэн байх”, 2.9-д төгсөгч нь “идэвхтэй судлаач байж, шинэ мэдлэг, мэдээллийг бий болгон шинжлэх ухаанд хувь нэмрээ байнга оруулах”, 3.1.5-д “Томсон Ройтерс, Скопус зэрэг дэлхийн шинжлэх ухааны мэдээллийн санд бүртгэлтэй болон бусад хөндлөнгийн магадалгаа хийгддэг мэргэжлийн эрдэм шинжилгээний дотоод, гадаадын сэтгүүл”-д бүтээл хэвлүүлсэн байх шинэ шаардлагыг тавьжээ.

Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шаардлага, шалгуур (2015)-ын 8 дахь шалгуур “судалгаа, инновац”-ын үзүүлэлтүүд:

- ✓ Гадаад, дотоодын мэргэжлийн сэтгүүлд гаргасан бүтээлийн тоо, чанар
- ✓ Сургалт, судалгааны шинэ үр дүнг үндэсний болоод олон улсын түвшинд сурталчилж, баталгаажуулсан байдал;
- ✓ Импакт фактортай сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлийн тоо;

Гэхдээ манай улсын томоохон их сургуулиуд дэлхийн чиг хандлагатай нийцүүлэн, судалгаанд суурилсан их сургуулийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр тодорхой зорилтуудыг хэрэгжүүлж эхлээд байна.

Манай улсын их, дээд сургуулиуд дэлхийн чиг хандлагыг даган судалгаанд суурилсан их сургууль болох зорилго тавьж, их сургуулийн чансааг тодорхойлох гол чиглэл болох “судалгаа”-г олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх бодлого баримтлан, ажиллаж байна. Нөгөө талаар шинжлэх ухааны судалгаа, хэвлэн нийтлэл нэмэгдэхийн хэрээр сургуулиудын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, өөрсдийн судалгааны байр суурийг тодорхойлох шаардлага бий болсон энэ цаг үед олон улсад түгээмэл хэрэглэх болсон *Шинжлэх Ухааны Веб (Web of Science)*, *Гүүгл Сколап (Google Scholar)* зэрэг мэдээллийн сангийн ном зүйн үнэлгээний аргад суурилсан эшлэлийн индексийн шалгуур үзүүлэлтүүдийг судлан, хэрэгжүүлэх нь нэн чухал болж байна. Гэсэн ч судалгааны үр дүн төдийгүй үр нөлөөг өндөржүүлж, шинжлэх ухааны хөгжилд хэдийнээ түлхэц болж чадсан эдгээр шалгуур үзүүлэлтүүд, аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, өргөн хэрэглээ болгох хэрэгцээ манай орны их, дээд сургуулиудад өдгөө бий болчихоод байна. Үүнд:

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

- ✓ Судлаачийн судалгаа, эрдэм шинжилгээний ажлын чансааг тодорхойлно,
- ✓ Тухайн их, дээд сургуулийн нэр хүндийг илэрхийлнэ,
- ✓ Улсын хэмжээнд их, дээд сургуулиудын сургалт, судалгааны чансаагаар нь эрэмбэлэх боломж бүрдэнэ,
- ✓ Судлаач, их, дээд сургууль болон улс орон өөрсдийн эрдэм шинжилгээний цар хүрээ, шинжлэх ухаанд оруулж буй хувь нэмэр, үзүүлж буй нөлөөллөө үндэсний хэмжээнд болон дэлхий дахинаа харж үнэлэх, өргөжүүлэн баяжуулах, өсгөн дэвжүүлэх өргөн боломж нээгдэх юм.

Дэлхийн шилдэг их, дээд сургуулиудын чансааг тодорхойлдог суурь үзүүлэлтийн нэг нь судалгааны чанарын үзүүлэлт байдаг. Манай орны хувьд судалгааны чанарын үзүүлэлтүүдийг ашиглан их, дээд сургуулиудад магадлан итгэмжлэл хийх, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас их, дээд сургуулиудын чансааг үнэлэн үндэсний хэмжээнд эрэмбэлэх, сургуулиуд үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нэн шаардлагатай байна.

*Хүснэгт 2.26. Зохиогчийн түвшний нөлөөллийн индексүүдийн харьцуулалт*

Ном зүйн үзүүлэлт	Тодорхойлолт	Давуу тал	Сул тал
<b>Н индекс</b>	АНУ-ын эрдэмтэн Хорх Хирш 2005 онд боловсруулсан. Хэрэв судлаачийн бичсэн N өгүүллээс h ширхэг нь багадаа h удаа ишлэгдсэн бөгөөд үлдсэн (N—h) ширхэг өгүүлэл нь тус бүрдээ h-ээс олонгүй ишлэгдсэн бол уг судлаач h индекстэй байна	Тухайн нэгж өгөгдлөөр тоон (өгүүллийн тоо) ба чанарын (нийтлэлийн нөлөөлөл) үнэлгээг хослуулан гаргадаг  Тухайн салбарт шууд харьцуулалт хийх боломжтой	Судлаачийн нас эсвэл судлаачийн эрдэм шинжилгээний салбарт ажилласан хугацаанаас хамааралтай тул эрт үеийн судлаачдын хувьд оновчтой хэмжүүр болдоггүй. Зөвхөн Шинжлэх ухааны веб сангийн индекс бүхий нийтлэлийн үнэлгээг тооцоолдог тул судлаачийн уг сангийн жагсаалтад ороогүй сэтгүүлд хэвлүүлсэн нийтлэл ба түүнээс татсан аливаа эшлэлийг тооцоолох боломжгүй

**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**

<b>i10 индекс</b>	Google корпорац 2011 онд <i>Google Scholar</i> өгөгдлийн сангийн ажлын хүрээнд боловсруулсан	Тооцоолоход маш энгийн <i>Google Scholar</i> дахь <i>My Citations</i> индекс нь үнэ төлбөргүй	Зөвхөн Гүүгл Сколар өгөгдлийн санд ашигладаг
<b>G индекс</b>	Leo Egghe 2006 онд боловсруулсан. Нийтлэлийн хамгийн олон эшлэл татагдсан $g$ тоо нь $g^2$ буюу хамгийн олон эшлэл байна	Судлаачийн шилдэг нийтлэлийг гүйцэтгэлийг тооцоолдог Судлаач тус бүрийн чансааны ялгааг илүү тодорхой харуулдаг. G-индекс нь өндөр эшлэл бүхий нийтлэлийн утгыг тооцоолохын зэрэгцээ хамгийн цөөн эсвэл огт эшлэгдээгүй нийтлэлийн утгыг мөн тооцоолдог	2006 онд анх дэвшүүлсэн үеэс эхлэн $g$ -индексийг $h$ -индексээс давуу талтай эсэх талаар мэтгэлцээн үргэлжилсээр байгаа бөгөөд харьцангуй $h$ -индексийн түвшинд хүлээн зөвшөөрөгдөөгүй

**Хүснэгт 2.27. Сэтгүүлийн түвшний нөлөөллийг тодорхойлдог индексүүдийн харьцуулалт**

Ном зүйн үзүүлэлт	Тодорхойлолт	Давуу тал	Сул тал
Онолын нөлөөллийн оноо (Article Influence Score)	Тухайн сэтгүүлд нийтлэгдсэн өгүүлэл тус бүрийн нөлөөллийн дунджийн тооцоолол буюу стандарт Эигенфактор оноо	Импакт факторын салбар тус бүр дээр илэрдэг зөрүүг бууруулах буюу арилгана	Хэвлэгдсэн нийтлэлийн тооноос хамаарна
Age-weighted citation rate (AWCR)	Тодорхой судалгааны явц дахь өгүүлэл тус бүрийн хэвлэгдсэн цаг хугацаанаас хамааралтай нийт эшлэлийн дундаж	Эшлэлийн бодит тоог харгалздаг Нийтлэлийн хэвлэгдсэн хугацааг харгалзан үздэг Тооцооллыг илүү нарийвчлалтай болгох зорилгоор $h$ -индекстэй хавсран хэрэглэнэ	Хэвлэгдсэн хугацаанаас үл хамаарах эх сурвалжид ашиглах боломжгүй
	$h = h$ -индекс ба жил = анхны нийтлэлээс	Зэрэглэлийн ялгаатай багш нарыг	Олон эшлэл бүхий бүтээлд мэдрэг бус

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

<p align="center">m <u>коэффициент</u> (m quotient)</p>	<p>хойших жилүүдийн тоотой = үед <math>m = h / \text{жил}</math></p>	<p>харьцуулах боломжийг h-индекс олгодог</p>	<p>Хэвлэлийн хугацааг харгалздаг тул залуу судлаачдад тохиромжгүй. h-индекс багахан өөрчлөлт ороход m коэффициентын хэлбэлзэл их байна.</p>
<p align="center">Краун үзүүлэлт (Crown Indicator)</p>	<p>Leiden их сургуулийн Шинжлэх ухаан, технологийн судалгааны төв (CWTS) боловсруулсан. Судлаач эсвэл судалгааны багаас хүлээн авсан эшлэлийн дундаж тоог тухайн салбарын сэтгүүлд хэвлэгдсэн ижил төстэй нийтлэлийн тооцоолж буй эшлэлийн дундаж тоонд хуваах</p>	<p>Өөр өөр салбарын судлаачдыг харьцуулах боломжтой Судалгааны салбар дахь эшлэлийн хувь, нийтлэлийн төрөл, хэвлэгдсэн он зэргийг хянах боломжтой бөгөөд ингэснээр импакт факторын хязгаарлалтыг давах боломжтой</p>	<p>Хүртээмж бага Өөр өөр салбарын сэтгүүлд нийтлэгдсэн нэг салбарын өгүүллүүдийг тооцоололд хамруулдаггүй Зөвхөн ижил хэмжээний эрдэм шинжилгээний багуудыг харьцуулах боломжтой</p>
<p align="center">Импакт фактор (Impact Factor)</p>	<p>Шинжлэх ухааны мэдээллийн институтыг үүсгэн байгуулагч Южин Гарфильд боловсруулсан.</p>	<p>Сэтгүүлийн импакт факторын хэмжүүр нь чанарын талаарх уламжлалт ойлголттой илүүтэй нийцдэг</p>	<p>Салбар хоорондын харьцуулалт хийхэд тохиромжгүй</p>
<p align="center">Эйгенфактор оноо (Eigenfactor Score)</p>	<p>Нөлөө бүхий сэтгүүлд хэвлүүлсэн нэг нийтлэл ба жижиг сэтгүүлд хэвлүүлсэн олон нийтлэлийн харьцааг тодорхойлох зорилготой.</p>	<p>Үнэ төлбөргүй Эшлэлийн тоог тоолох бус харин эшлэлийн ач холбогдлыг оновчтой тодорхойлохыг зорьдог</p>	<p>Eigenfactor нь сэтгүүлүүдийг нэг ангилалд авч үздэг тул өөр өөр салбарын сэтгүүлийг харьцуулах боломж хомс Эшлэлийн тооноос өөрцгүй гэсэн шүүмжлэлд өртдөг</p>

### **2.13. Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэл**

Манай орны хувьд дээд боловсролын чанар, дотоод чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэл, чанарын менежментийн тогтолцоо, тэдгээрийн харилцан хамаарал, мөн чанарын талаар дээд боловсролын сургалтын байгууллагын оролцогч болон сонирхогч талуудад үндэсний хэмжээнд нэгдсэн ойлголттой болох нь чухал ба дээрх ойлголтын агуулгыг дараах байдлаар тодорхойлогдож байна. Тухайлбал:

- ✓ Чанарын баталгаажуулалт гэдэг нь хичээлийн хөтөлбөрийн стандарт, жишиг үзүүлэлтийн хэрэгжилтийг сайжруулах зорилготой үйл явц юм. Өөрөөр хэлбэл чанарын баталгаажуулалт нь амжилтыг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, түүний стандартын нийцлийг тасралтгүй хангах үйл явц юм.
- ✓ Магадлан итгэмжлэл гэдэг нь магадлан итгэмжлэлийн байгууллагаас тогтоосон шалгуур, шаардлага (стандарт)-ыг ханган биелүүлсэн байгууллага (хөтөлбөр)-ын өөрийн үнэлгээнд тулгуурлан бие даасан хараат бус шинжээчид хөндлөнгийн үнэлгээ хийж, ахиц дэвшлийг дэмжин мэргэжлийн хүрээнд хүлээн зөвшөөрснөөр чанарыг нь баталгаажуулах үйл ажиллагаа юм (Боловсролыг магадлан итгэмжлэх комиссын үйл ажиллагааны журам, 2017).

Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэл нь: i) нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн чанар, зохих сургалт, эрдэм шинжилгээний стандартын дагуу боловсролын зэрэг, мэргэжлийн ур чадвар олгож буй эсэх; ii) зохих журмын дагуу зэрэг олгох хууль ёсны эрх мэдлээ хэрэгжүүлж буй эсэхийг баталгаажуулна. Иймээс шинжээчийн баг “*бүрэн хангасан*”, “*гүйцэтгэл дутуу*” эсвэл “*хангалтгүй*” гэсэн үнэлгээ өгдөг. Ерөнхийдөө магадлан итгэмжлэл нь “*Өөрийн үнэлгээ - Хөндлөнгийн хяналт, мониторинг – Батламжлал*” гэсэн үндсэн зарчимд тулгуурласан дараах үе шатаар явагдаж байна. Үүнд:

- ✓ *Өөрийн үнэлгээ*: Магадлан итгэмжлэх байгууллагын стандарт шалгуур үзүүлэлтүүдийн дагуу магадлан итгэмжлүүлэх хүсэлтэй боловсролын байгууллага өөрийн үнэлгээний тайлан бичнэ;

- ✓ *Үнэлгээний баг ажиллах:* Шинжээчийн баг боловсролын байгууллагаас ирүүлсэн өөрийн үнэлгээний тайлантай танилцана;
- ✓ *Газар дээр ажиллах:* Хүсэлт гаргасан боловсролын байгууллагаас ирүүлсэн өөрийн үнэлгээний тайланд дурдсан үзүүлэлтүүдийг магадлахын тулд үнэлгээний баг тухайн боловсролын байгууллага дээр ажиллана;
- ✓ *Магадлан итгэмжлэх байгууллагын арга хэмжээ:* Магадлан итгэмжлэлийн байгууллага хүсэлт гаргасан боловсролын байгууллага (хөтөлбөр)-ыг магадлан итгэмжлэх эсэхийг шийдвэрлэнэ;
- ✓ *Хөндлөнгийн хяналтын тайлан:* Байгууллага, хөтөлбөрийг дахин магадлан итгэмжлэх зорилгоор цаашид тодорхой хугацаанд хянаж шалгана.

Улс орнуудад дээд боловсролын сургалтын байгууллага (хөтөлбөр)-ын магадлан итгэмжлэлийн үйл явцад оролцогч болон сонирхогч талуудад нээлттэй, ил тод байхын сацуу дараах үндсэн зарчмыг баримталж байна. Үүнд:

- ✓ Сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээний зарчим:
  - Үнэлгээний үйл явц нь тодорхой, түүний журам, стандарт нь олон нийтэд нээлттэй байна. Санал болгож буй сургалтын хөтөлбөрийг нарийвчилсан судалгаанд үндэслэн боловсруулсан, дүгнэлтүүд нь бодитой байх,
  - Санал болгож буй сургалтын хөтөлбөрийг бүх мэргэжил болон мэргэшлийн салбаруудыг оролцуулан бүхэлд нь үнэлнэ. Хөтөлбөрт нэмэгдэх шинэ мэргэжил/мэргэшилд үнэлгээ хийх,
  - Санал болгож буй хөтөлбөр бүрийг тухайн салбарт туршлагатай шинжээчдийн хараат бус баг хянах,
  - Үнэлгээний явц: i) Дээд боловсролын сургалтын байгууллагын бичгээр гаргасан санал, ii) Сургуулийн зүгээс дэмжигчидтэй хийсэн хэлэлцүүлэг, iii) тухайн сургууль дээр очиж үзэх (шаардлагатай үед), iv) Шинжээчдийн бичсэн тайлан, v) Шинжээчийн тайланд дээд боловсролын сургалтын байгууллагаас хариу өгөх,



- Шинэ сургалтын хөтөлбөрийн үр дүн стандартыг хангаж байгаа эсэхийг тогтоох зорилгоор үнэлгээний явцад оюутны оролцоог хангах, .
  - Шинэ сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх дээд боловсролын сургалтын байгууллагууд нь журамд заасан шаардлагуудыг хатуу баримтлан өөрийн үнэлгээний тайлангаа бичнэ.
- ✓ Боловсролын байгууллага чанарын үнэлгээний зарчим:
- Үнэлгээний үйл явц нь тодорхой байж, түүний журам, стандарт нь олон нийтэд нээлттэй байх. Дээд боловсролын сургалтын байгууллагын тухай нарийвчилсан судалгаанд үндэслэн гаргасан дүгнэлтүүд нь шударга, тууштай байх,
  - Сургалтын байгууллагын хяналт шинжилгээг нэгж буюу үйл ажиллагааны чанарын талаар дүгнэлт өгөх чадвартай ахлах ажилтан болон шинжээчдээс бүрдсэн хараат бус баг гүйцэтгэх,
  - Шаардлагатай тохиолдолд, сургалтын байгууллагаас санал болгож буй хөтөлбөрүүдэд тэдгээрийн хүртээмж болон тогтвортой байлгах санхүүгийн чадавхын үнэлгээг хийх.

Боловсролын чанарын баталгаажуулалтын тогтолцооны сул талуудыг тодорхойлж, чанарын баталгаажуулалтын хувьд тасралтгүй сайжруулалт хийх нь дээд боловсролын чанарын амин чухал зүйл юм. Дээд боловсролын магадлан итгэмжлэл, чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлж буй тогтолцооны гол оролцогч нь суралцагч бол, харин чанарын тасралтгүй сайжруулалтыг байгууллагын соёл болгож төлөвшүүлэхэд дотоод чанарын баталгаажуулалтын нэгж чухал үүрэг гүйцэтгэдэг гэдгийг анхаарах нь чухал. Ерөнхийдөө дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэхийн ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлж болох юм. Үүнд:

- i) Оюутнууд болон тэдний эцэг эхчүүдийн хувьд тэдний эрх ашгийг хамгаалдаг,
- ii) Тухайн сургууль, хөтөлбөрийн хүчин төгөлдөр байдлыг хүлээн зөвшөөрч, стандартыг хангаж байгааг баталгаажуулдаг.

- iii) Ирээдүйн ажил олгогчдын хувьд сургалтын хөтөлбөр нь өнөөгийн ажлын байранд шаардагдах ур чадвар, мэдлэгийг багтаасан гэдэгт баталгаа болдог,
- iv) Тухайн байгууллагын үндэсний нэр хүндийг өсгөх болон бусад салбарт хүлээн зөвшөөрөгдөхөд тусалдаг,
- v) Засгийн газар болон бусад олон нийтийн санхүүжилтийн агентлагуудаас оюутны санхүүгийн тусламж авах эрх болон санхүүжилттэй хөтөлбөрийг тодорхойлох суурь болдог,
- vi) Их, дээд сургуулийн хувьд, элсэлт ба кредит шилжүүлэх боломж олгосон хамтын ажиллагааны найдвартай тулгуур болдог,
- vii) Мэргэшил бүрийн стандартыг сайжруулах, мэргэшсэн сургалт бэлтгэлийг хангах замаар салбарын өсөлт хөгжлийг дэмждэг зэрэг болно.

Гэхдээ улс орнуудын боловсролын тогтолцооны ялгаатай байдлаас улбаалсан магадлан итгэмжлэлийн өөр хоорондоо ялгаатай механизм, зохицуулалт болон арга хэрэгсэл (дүрэм, журам)-ийн зөрүүтэй байдал нь бүс нутгийн болон олон улсын харилцан ойлголцол бий болгох чанарын баталгаажуулалтын агентлагуудыг үүсгэн байгуулах суурь нөхцөл болсон. Энэхүү олон улсын агентлагууд нь үндэсний магадлан итгэмжлэлийн агентлагуудыг чадавхжуулах, тэдний үнэлгээг дүйцүүлэх, оюутны шилжилт хөдөлгөөн, кредит цагийг дүйцүүлэн тооцох, боловсролын зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх зэргийг зохицуулдаг. Иймээс олон улсад нэр хүнд бүхий зарим магадлан итгэмжлэлийн байгууллагууд талаар дурдвал:

*Нэг. Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын агентлагуудын олон улсын сүлжээ (INQAАНЕ):* Энэ сүлжээ нь 1991 онд дээд боловсролын чанарыг сайжруулах, үнэлэх чиглэлээр гарч буй онол практикийн мэдээллийг цуглуулах, түгээн дэлгэрүүлэх зорилготой байгуулагдсан. Өнөөгийн байдлаар наяд орны 300 гишүүнтэй, 21 стратегийн түнштэй болж бэхжиж, дээд боловсролын чанарын талаар хамтын ажиллагааг дэмждэг байгууллага болжээ. Уг байгууллага нь чанарын талаар судалгаа хийх, сургалт явуулах, чанарын соёлыг түгээх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг ба түүнчлэн чанарын баталгаажуулалтын тэргүүн туршлагад үндэслэн магадлан

итгэмжлэлийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлбэл зохих зөвлөмжийг боловсруулдаг. Тус байгууллагын зорилго нь:

- ✓ Уг сүлжээ нь дээд боловсролын чанарын нийцэл, сайжруулалтын сайн туршлагыг сурталчлах;
- ✓ Дээд боловсролын чанарын менежментийн практик, түүний үр өгөөжийг судлахад дэмжлэг үзүүлэх;
- ✓ Чанарын баталгаажуулалтын шинэ агентлагуудад зөвлөгөө өгөх, туршлага хуваалцах, чадавхжуулах;
- ✓ Гадаад улс оронтой хамтран ажилладаг байгууллагуудын стандартыг боловсруулахад гишүүдэд туслах;
- ✓ Мэргэшлийн хувьд олон улсын хэмжээнд илүү сайн танигдах боломжийг олгох;
- ✓ Дотоод болон гадаадын их, дээд сургуульд шилжин суралцах оюутны хөдөлгөөнийг дэмжих зорилгоор кредит цаг шилжүүлэх журам, аргачлалыг боловсруулж, дэмжлэг үзүүлэх;
- ✓ Эргэлзээ бүхий магадлан итгэмжлэх үйл ажиллагаа, байгууллагуудын талаар гишүүдэд сэрэмжлүүлэх чадвартай зэрэг болно.

Хоёр. Ази, Номхон далайн бүсийн чанарын сүлжээ (APQN): Энэ сүлжээ нь 2003 онд Хонг Конгод байгуулагдсан. Тус байгууллагын эрхэм зорилго нь “*Чанарын баталгаажуулалтын агентлагуудын ажлыг бэхжүүлэх, тэдний хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар Ази, Номхон далайн бүс нутгийн дээд боловсролын чанарыг сайжруулах*” гэж тодорхойлж, дараах зорилтуудыг хэрэгжүүлдэг. Үүнд:

- ✓ Ази, Номхон далайн бүсийн дээд боловсролын чанарын нийцэл, сайжруулалтын сайн туршлагыг сурталчлах;
- ✓ бүс нутгийн дээд боловсролын чанарын менежментийн практик болон чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх;
- ✓ бүс нутгийн чанарын баталгаажуулалтын шинэ агентлагуудад зөвлөгөө өгөх, туршлага хуваалцах;

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

- ✓ чанарын баталгаажуулалтын агентлаг харилцан ойлголцол, шийдвэр, дүгнэлтийг харилцан хүлээн зөвшөөрөх уялдаа холбоог сайжруулах;
- ✓ бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн мэргэшлийг олон улсын хэмжээнд илүү сайн танигдах боломжийг бүрдүүлэх;
- ✓ дотоод болон гадаадын их, дээд сургуульд шилжин суралцах оюутны хөдөлгөөнийг дэмжих зорилгоор кредит цаг шилжүүлэх журам, аргачлалыг боловсруулж ашиглахад туслалцаа үзүүлэх;
- ✓ Эргэлзээ бүхий магадлан итгэмжлэх үйл ажиллагаа, байгууллагуудын талаар гишүүдэд сэрэмжлүүлэх;
- ✓ Бүс нутгийг төлөөлөх, шаардлагатай, өөрөөр хэлбэл бусад сүлжээ, олон улсын байгууллагуудтай харилцах тохиолдолд бүс нутгийн ашиг сонирхлыг илэрхийлэх, хамгаалах зэрэг болно.

Гурав. Дээд боловсролын чанарын үнэлгээний европын холбоо (ENQA): Энэ холбоо нь Европын холбооны зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн дагуу 2000 онд байгуулагдсан бөгөөд 8 орны 51 агентлаг, 6 гишүүн багтдаг. Тус байгууллага нь европт үйл ажиллагаа явуулдаг чанарын баталгаажуулалтын агентлагуудын талаарх тодорхой, найдвартай мэдээллийг олон нийтэд хүргэдэг төдийгүй дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- ✓ Байгууллагынхаа цахим хуудсаар дамжуулан дээд боловсролын үнэлгээнд гарсан сүүлийн үеийн хөгжил, сайжруулалтын тухай мэдээлэл түгээх;
- ✓ Сургалт, семинар зохион байгуулж, зөвлөгөө өгөх;
- ✓ Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын чиглэлээр сайн туршлага хуваалцах;
- ✓ Европын чанарын баталгаажуулалтын мэргэжилтнүүдтэй гэрээ байгуулж ажиллах;
- ✓ Европын холбооны чанарын баталгаажуулалтын агентлагийн жишиг загвар боловсруулах зэрэг болно.

Дөрөв. Насан туршийн боловсролын магадлан итгэмжлэл (RVA): Өнөөдөр албан бус боловсрол, насан туршийн боловсролыг улс орнууд бүх талаар

дэмжиж байна. өгөөд албан бус болон, амьдралын орчноос олж авсан боловсролын үр дүнг үнэлж, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах асуудал чухлаар тавигдах боллоо. Европын дийлэнх орнуудад албан бус болон амьдралын орчноос олж авсан боловсролын үр дүнг үнэлж, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах янз бүрийн механизмууд хэрэгжиж байна. Франц, Косово зэрэг улсуудад тусгайлсан хуулиар зохицуулж байхад зарим улс оронд үндэсний хэмжээний бодлоготой байна. Дийлэнх улс оронд Засгийн газраас санаачлан албан бус болон амьдралын орчноос олж авсан боловсролын үр дүнг үнэлж, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах системийг мэргэшлийн үндэсний хүрээтэй уялдуулан улмаар кредит тооцох, мэргэжлийн диплом олгох, зарим хичээлээс чөлөөлөх зэргээр албан боловсролтой холбох стратеги боловсруулж хэрэгжүүлж байна.

2012 онд ЮНЕСКО-ийн насан туршийн боловсролын хүрээлэнгээс албан бус болон амьдрах орчноос олж авсан боловсролын үр дүнг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах талаар зөвлөмж боловсруулан гаргасан байна. Энэхүү зөвлөмж нь албан бус болон амьдрах орчноос олж авсан боловсролын талаарх нэгдсэн ойлголтыг бий болгох, боловсролын үр дүнг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, баримтжуулах арга зам, стандартыг боловсруулахад гишүүн орнуудад туслалцаа үзүүлэх зорилготой ажээ.

Тав. Нээлттэй, зайны болон цахим сургалт: Нээлттэй, зайны болон цахим сургалтыг баримтжуулах системийг албан боловсрол, сургалтын нэг хэлбэр юм. Албан боловсрол бол тодорхой хугацаатай, тодорхой сэдэвтэй, тодорхой байршилд явагддаг. Харин албан бус болон амьдрах орчноос суралцагч өөрийн сонирхол, авьяасаар сэдэлжин мэдлэг, чадвар олж авах, түүнийгээ баталгаажуулах юм. Иймээс албан болон албан бус боловсролын уян хатан уялдаа холбоог тогтоох, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах үндэсний тогтолцоог бий болгох нь чухал юм.

Технологийн дэвшлийн нөлөөгөөр уламжлалт танхимын сургалтаас гадна зайны болон цахим сургалтаар дээд боловсрол олгох, эзэмших боломжтой ба хөтөлбөрийг хэрэгжүүлэх олон хэлбэрүүд байна (Стелла, Гнанам, 2004). Үүнд:

- ✓ Зайны сургалт

- ✓ Шилжих хөтөлбөр,
- ✓ Оюутан солилцоо,
- ✓ Гадаад улс дахь салбар оюутны хотхон,
- ✓ Сургалтын хэрэглэгдэхүүний худалдаа,
- ✓ Франчайзинг,
- ✓ Их сургуулиудын түншлэл,
- ✓ Виртуал их сургууль,

Технологийн хөгжлийн түвшин, хүртээмжээс шалтгаалан дээрх арга хэлбэрүүдээс зайны сургалт нь цахим (виртуал) сургалтаас давамгайл хөгжиж байна. Өнөө үед оюутнууд байрандаа эсвэл бусад орчноос цахим сургалтын хэрэглэгдэхүүн ашиглан суралцаж буй хөтөлбөрийнхөө тодорхой хэсгийг судлах боломжтой болжээ. Зайны сургалт нь өнөөгийн өрсөлдөөнт нийгэмд шинээр мэргэжил, ур чадвар эзэмших хэрэгсэл болж байна. Иймээс боловсрол олгох шинэлэг сургалтын чанарыг баталгаажуулах нь нэн чухал, эс тэгвээс сургалт, хөтөлбөрүүдийн уялдаа холбоо алдагдаж, зайн болон цахим сургалтын хөтөлбөрүүд чанаргүй, муу гэсэн шүүмжлэлд өртөх болно.

Хөгжиж буй улс орнуудын хүн амын боловсролын эрэлт, хэрэгцээг хангах чухал шийдэл болсон зайны боловсрол нь чанаргүй бол харин эсрэгээрээ маш том асуудал болж болзошгүй юм (В.С. Прасад). Иймээс зайны боловсролын хөтөлбөр хэрэгжүүлдэг байгууллагууд үүнийг ухамсарлаж, чанарын баталгааг хангах олон үйл ажиллагаа хийдэг байна. Тухайлбал:

- ✓ Үе шаттай багийн ажил бус байдлаар хичээлийг удирдаж явуулах курсийн багийн арга хандлага, төсөл материал дээр дахин ажиллах;
- ✓ Сургалтад нэвтрүүлэхээс өмнө сургалтын материалыг турших;
- ✓ Сургалтын залгамж холбоонд тавих хяналт (оюутны даалгавар);
- ✓ Багш нарын оюутантай ажиллах ажилд мониторинг хийх;
- ✓ Багш болон зөвлөх ажилтны үйл ажиллагааг хянан шалгах, дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- ✓ Суралцагчаас тогтмол хугацаанд санал асуулга авах зэрэг болно.

Нээлттэй, зайны сургалтын хувьд сургалтын материал, хэрэглэгдэхүүн нь уг сургалтын чанарын гол шалгуур үзүүлэлт болох хэдий ч сайн сурах бичиг, сургалтын материал, хэрэглэгдэхүүнээс илүүтэй суралцах арга барилыг чухалчилдаг. Робинсон нээлттэй, зайны сургалтын чанарын менежментийн хүрээг тодорхойлжээ. Үүнд:

- ✓ *Хэрэглэгдэхүүн*: сургалтын материал, хэрэглэгдэхүүн, медиа материал, эцсийн үр дүн (төгсөгчдийн тоо, хөтөлбөрийг дүүргэсэн амжилтын хувь хэмжээ, ур чадвар эзэмшсэн эсэх);
- ✓ *Үйлчилгээ*: бүртгэл, зөвлөх үйлчилгээ, сургах, удирдан чиглүүлэх, сургалтын талаарх санал хүсэлт, удирдамж, суралцагчийн ахиц дэвшилд дэмжлэг үзүүлэх;
- ✓ *Үйл явц*: энэ нь дээр дурдсан хоёрыг дэмжих ба сургалтын систем, бүртгэл хөтлөх, хуваарь гаргах, нөөцийн хяналт, чанарын баталгаажуулалт;
- ✓ *Ерөнхий үзэл баримтлал*: Бодлого, эрхэм зорилго, байгууллагын ёс зүй, соёл, ажилтнуудын хандлага, тэдний үүрэг хариуцлага гэх мэт.

*Зургаа. Дээд боловсролын чанарын кодекс*: Дээд боловсролын чанар, стандартыг баталгаажуулахын тулд Их Британид “Дээд боловсролын чанарын кодекс”-ыг хэрэглэдэг. Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын агентлагаас эрхлэн гаргасан чанарын кодексыг их дээд сургуулиуд оюутнууддаа өндөр чанартай боловсрол олгоход зориулан хэрэглэдэг. Энэхүү кодекс нь дээд боловсролын бүх байгууллагуудын мөрдөх, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрсөн сургалтын стандарт, чанарын түвшнийг тодорхойлж байна.

Улс орнуудын боловсролын тогтолцооны онцлогоос хамаарч боловсролын магадлан итгэмжлэлийн тогтолцоо харилцан адилгүй байна. Тухайлбал:

**Герман**: 1948 онд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын мужуудын хооронд байгуулсан гэрээний дагуу Ладнерын боловсрол, соёлын асуудал эрхэлсэн сайд нарын байнгын чуулган байгуулагдсан. Үндсэн үүргийнхээ хүрээнд дээд боловсролын чанар, тасралтгүй байдлыг хангана. Магадлан итгэмжлэлийн зөвлөл нь итгэмжлэлийн байгууллагыг баталгаажуулж, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийн итгэмжлэлийн

удирдамж, шалгуурыг баталдаг. Одоогийн байдлаар дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг дараах байгууллагууд хэрэгжүүлж байна. Үүнд:

- ✓ Тусгай боловсрол, арчилгаа, эрүүл мэндийн шинжлэх ухаан, нийгмийн ажлын сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх агентлаг (AHPGS),
- ✓ Чанарыг баталгаажуулах агентлаг ба судалгааны хөтөлбөрийг магадлан итгэмжлэх байгууллага (AKAST),
- ✓ Магадлан итгэмжлэл, гэрчилгээжүүлэлт болон чанарыг баталгаажуулах хүрээлэн (ACQUIN),
- ✓ Сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх Чанарыг баталгаажуулах агентлаг (AQAS),
- ✓ Инженерийн, Мэдээллийн технологийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн байгууллага (ASIIN),
- ✓ Баден-Вюрттемберг үнэлгээний агентлаг (Evalag),
- ✓ Олон улсын бизнесийн удирдлагын итгэмжлэлийн сан (FIBAA),
- ✓ Дээд боловсролын магадлан итгэмжлэл, чанарын баталгаажуулалтын төв (OAQ),
- ✓ Төвийн үнэлгээ ба магадлан итгэмжлэлийн агентлаг (ZEVA).

**Энэтхэг:** Энэтхэгийн их дээд сургуулиуд нь үндсэн хуулийн хүрээнд Засгийн газрын удирдамжийн дагуу боловсролын магадлан итгэмжлэлийг дараах агентлагууд хэрэгжүүлдэг. Үүнд:

- ✓ Энэтхэгийн чанарын зөвлөл (QCI),
- ✓ Зайн боловсролын зөвлөл (DEC),
- ✓ Багш нарын боловсролын үндэсний зөвлөл (NCTE),
- ✓ Энэтхэгийн хөдөө аж ахуйн судалгааны зөвлөл (ICAR),
- ✓ Энэтхэгийн барын зөвлөл (BCI),
- ✓ Шинжлэх ухааны хүрээлэн ба судалгааны байгууллагууд (SIROs),
- ✓ Багш нарын боловсролын үндэсний зөвлөл (NCTE),



- ✓ Энэтхэгийн сэргээн засах зөвлөл (RCI),
- ✓ Энэтхэгийн анагаах ухааны зөвлөл (MCI),

**Америкийн нэгдсэн улс:** АНУ-д дээд боловсролын хөтөлбөрийн болон байгууллагын магадлан итгэмжлэлийг АНУ-ын Боловсролын яам, Дээд боловсролын магадлан итгэмжлэлийн зөвлөл (USDE ба CHEA)-өөс албан ёсны гэж хүлээн зөвшөөрөгдсөн хувийн, ашгийн бус гишүүнчлэлтэй холбоо, агентлагууд хэрэгжүүлдэг. Тухайлбал:

- ✓ Ажил мэргэжлийн коллежийн магадлан итгэмжлэлийн комисс (ACCSC),
- ✓ Боловсрол ба тасралтгүй боловсролын магадлан итгэмжлэх зөвлөл (ACCET),
- ✓ Бие даасан коллеж, сургуулиудын итгэмжлэлийн зөвлөл (ACICS),
- ✓ Мэргэжлийн боловсрол, сургалтын зөвлөл (COE),
- ✓ Зайны боловсролыг итгэмжлэх комисс (DEAC).

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ЧАНАРЫН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

### 3.1. Дээд боловсролын сургалтын байгууллагуудын хөгжлийн өнөөгийн төлөв байдал

Манай улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн харилцаанд амжилттай шилжсэн үеийн нэг амжилт нь Монгол Улсын дээд боловсролын тогтолцоо хурдацтай өргөжих үндсэн нөхцөл бүрдсэн юм. Төрөөс нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, хөдөлмөр эрхлэлтээр дамжуулан ядуурлыг бууруулах зэрэг Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дээд боловсролын тогтолцооны шинэчлэлд тэргүүлэх ач холбогдол өгч байна.

1990 оноос хойш дээд боловсролын зах зээлд хувийн хэвшлийн сургуулиуд олноор байгуулагдаж төр түүнийг зохицуулах, сургуулиудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зарчмаар ажиллаж байна. Зах зээлийн эдийн засагт шилжин орсны дараахан буюу 1990-2013 онуудад хууль эрх зүйн актуудыг боловсруулсан байдаг.

#### Хүснэгт 3.1. Дээд боловсролын тухай хуулиуд

№	Хууль	Гол өөрчлөлтүүд
1	БНМАУ-ын ардын боловсролын хууль (1991)	- Хувийн хэвшлийн боловсролын байгууллага байгуулагдах боломжийг бий болгосон - Сургалтын төлбөр, санхүүжилтийн эх үүсвэрийн олон хэлбэр
2	Боловсролын тухай хууль (1995)	- Боловсролын байгууллагын тусгай зөвшөөрөл олгох, татан буулгах, ангилал - Магадлан итгэмжлэлийн тогтолцоог бий болгох суурийг тавьсан
3	Дээд боловсролын тухай хууль (1995)	- Дээд боловсролын зэргийн шатлалыг бий болгосон - Кредит цагаар хэмжих тухай хуульд оруулсан
4	Боловсролын тухай” хууль (шинэчилсэн найруулга, 1998, 2000) “Дээд боловсролын тухай” хууль (шинэчилсэн найруулга, 1998, 2000)	- Дээд боловсролын зэрэг бүрийн кредит цагийн хэмжээг тодорхойлсон - Удирдлагын төвлөрлийг сааруулахад шийдвэрлэх алхам хийж, боловсролын байгууллагын удирдах зөвлөлийн эрх үүргийг хуульчлав.

Эх сурвалж: [legalinfo.mn](http://legalinfo.mn)

Дээрх хуулиудын зэрэгцээ УИХ, Засгийн газраас боловсролын талаар баримтлах бодлогыг тодорхой хөтөлбөрүүд, үндсэн чиглэлүүдэд тусган тодорхойлж иржээ. УИХ-аас баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-д:

- ✓ 1995 онд *“Боловсрол нь Монгол Улсын иргэн бүрийг бүх талаар хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн дэвшил, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгах, материаллаг болон оюуны баялгийг бүтээх чухал эх сурвалж, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа мөн. Үүнийг үндэслэн боловсролыг төрөөс нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ”* гэсэн бол,
- ✓ 2015 онд *“Боловсрол нь иргэн бүрийн насан туршийн амьдралын чанарыг дэмжин баталгаажуулах, улс орны нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түлхүүр хүчин зүйл, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа хэмээн үзэж, Монгол Улсын төрөөс боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ”* гэжээ.

Энэ бүхнээс үзэхэд манай улс нь төгс төгөлдөр буюу оюун ухаан, бие бялдар, ёс суртахууны өндөр хөгжилтэй, чадварлаг, хүнлэг иргэнийг төлөвшүүлэхэд чиглэгдэх болсон. Энэхүү “төгс иргэд”-ийг бий болгох буюу хүний хөгжлөөр дамжуулан нийгэм - эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах, боловсролын чанарыг олон жишигт хүргэх, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлэхэд боловсролын байгууллагын оролцоог нэмэгдүүлэх зэрэг олон нарийн уялдаатай зорилтуудыг дэвшүүлсэн байдаг. Улмаар дээд боловсролын салбарыг зах зээлийн харилцаанд хөгжүүлэх өмчийн олон байдлыг дэмжих, нийгэм эдийн засгийн хувь нэмрийг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлж буй үзэл баримтлалууд бий болсон. Тухайлбал:

- ✓ ***Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010):***  
Энэхүү үзэл баримтлалд үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын үзэл бодлын үндэс нь эх оронч үндэсний үзэл байна гэж үзээд, Монгол Улс нь эдийн засаг, соёл, шинжлэх ухаан-технологи, боловсролын зэрэг салбарт өрсөлдөх чадвартай байхыг чухалчлах ёстойг заасан. Үндэсний аюулгүй байдлын чухал үндсэн хэсэг болох шинжлэх ухаан технологийн

аюулгүй байдлыг хангах нэг арга зам нь “боловсролын тогтолцоог байнга чанаржуулж, авьяасыг тэтгэн хөгжүүлэх” явдал, орчин цагийн жишигт нийцсэн боловсролын тогтолцоог бүрдүүлж, үндэснийхээ оюуны чадавхыг хамгаалан бэхжүүлэх” явдал гэж үзсэн;

- ✓ **“Монголын боловсрол, хүний хүчин зүйл” мастер төлөвлөгөө (1994-1998):** Дээд боловсролын шинэчлэлд ихээхэн түлхэц өгсөн энэхүү мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд дээд боловсролын салбарын эрхэм зорилго, үүргийг оновчтой тогтоох, өөрийн үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээний тогтолцоог төлөвшүүлэх, дээд боловсролын үр ашгийг дээшлүүлэх, боловсролын удирдлагыг боловсронгуй болгох, чадавхыг дээшлүүлэх, дээд боловсролын байгууллагыг хувьчлах талаар богино хугацаанд мэдэгдэхүйц амжилтад хүрсэн;
- ✓ **Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (1996):** Энэхүү бодлогод “Боловсрол нь Монгол Улсын иргэн бүрийг бүх талаар хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн дэвшил, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгах, материаллаг болон оюуны баялгийг бүтээх чухал эх сурвалж, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа мөн. Үүнийг үндэслэн боловсролыг төрөөс нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ” хэмээн төрөөс боловсролд хандах өнөө үеийн хандлагыг тодорхойлжээ;
- ✓ **Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал (1996-2020):** Энэхүү үзэл баримтлалд “Монгол Улсын хөгжил, дэвшлийн эх сурвалж бол тасралтгүй хөгжиж байх бүтээлч хүн, эрдэм боловсрол, оюуны болон мэргэжлийн өндөр чадвар бүхий Монгол Улсын иргэд мөн”, “Үндэсний оюуны чадавх нь Монгол Улсын хөгжлийн үндэс болно” гэж тодорхойлсон нь боловсролын бодлого тодорхойлох үндэс болсон байна. Хөгжлийн энэ шинэ үеийн нэг гол зорилт нь “Монгол хүнийг бүх талаар боловсрон хөгжих нөхцөлөөр хангахад” оршино гэж үзжээ. Боловсрол нь иргэн бүрийг бүх талаар хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн дэвшил, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгах, баялгийг бүтээх эх сурвалж учраас түүнийг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ хэмээн үзэл баримтлалд тунхагласан байна. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог хувь хүний сонирхол,


нийгмийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлж, дээд боловсролоор орчин үеийн мэдлэг олгох нөхцөл бүрдүүлнэ гэж үзсэн нь дээд боловсролын эрх зүйн орчныг бүрдүүлэхэд ач холбогдолтой байв;

- ✓ **Монгол Улсын 21 дүгээр зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр (1998):** Энэхүү стратегийн баримт бичигт байгаль орчноо дээдэлсэн, тогтвортой эдийн засагтай, нийгмээрээ баян чинээлэг, бүх нийтээрээ тогтвортой хөгжих стратегийн зорилтыг дэвшүүлсэн байна. Энэ хөтөлбөрт “Тогтвортой хөгжилд хүрэхэд Монгол хүнд шаардлагатай оюуны хэрэгцээг дээд зэргээр хангахуйц шинжлэх ухаан боловсролын салбарыг хөхүүлэн дэмжих”, “хүн амын боловсролын хэрэгцээг хангахуйц орчныг бүрдүүлэх”, “Монголын иргэд дэлхий нийтийн мэдээллийн нээлттэй сүлжээнд чөлөөтэй оролцох боломжийг бүрдүүлэх”, “хүний эрх, эрх чөлөө, амьдралын чанарын баталгааг хангах хууль эрх зүй, эдийн засгийн орчныг бүрдүүлэх” зорилтуудыг тодорхойлсон нь цаашид дээд боловсролын бодлогод харгалзах чиглэлүүд болсон байна;
- ✓ **”Монголын боловсролын салбарыг 2000-2005 онд хөгжүүлэх стратеги”:** Энэхүү баримт бичигт “дээд боловсролын салбарт хийгдэж буй шинэчлэлийг эрчимжүүлэн гүнзгийрүүлж, дээд боловсролын тогтвортой хөгжлийн үндсийг бүрдүүлж, сургалтын чанар, үр ашигт ахиц гаргаж, олон улсын жишигт хүрэх нөхцөлийг буй болгоход оршино” хэмээн тодорхойлж, дээд боловсролын стандартуудыг буй болгох замаар дээд боловсролын сургалт, эрдэм шинжилгээ, бизнесийн үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг хэрэгжүүлэх замаар чанарын хяналтыг буй болгох, удирдлагын тогтолцоог улам төгөлдөржүүлэх, эрдэм шинжилгээний бааз, чадавхыг нэмэгдүүлэх зорилтууд тавигдаж байгааг тэмдэглэсэн. Энэхүү баримт бичигт дээд боловсролын салбарт дараах 3 стратеги дэвшүүлсэн:
  - Дээд боловсролын байгууллагын удирдлага, санхүүжилт, аж ахуйн үйл ажиллагааг боловсронгуй болгох стратегийн хүрээнд 4 төсөл, үйл ажиллагааг

- Дээд боловсролын салбар дахь шинэчлэлийг гүнзгийрүүлэх, чанар үр ашгийг дээшлүүлэх стратегийн хүрээнд 8 төсөл, үйл ажиллагааг
- Дээд боловсролын салбарт төрийн бодлогыг хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгох стратегийн хүрээнд 2 төсөл, үйл ажиллагааг санал болгосон;
- ✓ **Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө (2006):** Энэхүү төлөвлөгөөнд 2015 он хүртэлх дээд боловсролын зорилтод i) хүртээмжийг “дээд боловсролын хамран сургалтын зохицуулалтыг сайжруулах”, ii) чанарыг “дээд боловсролын сургалтын чанарын баталгааг хангах таатай нөхцөлийг бүрдүүлнэ”, iii) менежментийг “дээд боловсролын удирдлага, санхүүгийн тогтолцоог оновчтой болгоно” гэсэн бодлогын зорилго дэвшүүлж, инженер технологи, байгалийн шинжлэл, багш, хөдөө аж ахуйн чиглэлээр бэлтгэх мэргэжилтний тоог нь ихэсгэх байдлаар дэмжих, дээд боловсролын сургалтын байгууллагын сургалт судалгааны ажил, сургалтын орчны стандартуудыг боловсруулж хэрэгжүүлэх, “Нээлттэй их сургууль байгуулах” үүсгэл санаачилгыг дэмжих” товлосон зорилтуудыг баталсан. “Монгол улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд “Их сургуулийн болон шинжлэх ухааны төрөлжсөн хотхон, кампус байгуулахыг төрөөс дэмжин хэрэгжүүлэх” гэж заажээ;
- ✓ **Дээд боловсролын шинэчлэлийн зураглал (2010-2021):** “Дээд боловсролын тогтолцоо, агуулга, стандартыг байнга шинэчлэн сайжруулж, олон улсад өрсөлдөх чадвартай, олон улсын жишигт нийцсэн их, дээд сургуулиудыг бий болгосны үндсэн дээр улс орны хөгжилд шаардлагатай хүний нөөц, мэдлэг, технологийг тасралтгүй нийлүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд эрх зүйн орчин, засаглал, удирдлагын бүтэц, чанарын баталгаажуулалт, сургалт болон эрдэм шинжилгээний стандарт, агуулга, элсэлт, хүний нөөц, багшийн хөгжил, сургалт ба судалгааны орчин, санхүүжилтийн шинэчлэлийн бодлого, стратегийг багцлан томъёолсноос гадна дээд боловсролын өнөөгийн байдалд шинжилгээ, үнэлгээ хийж, шинэчлэх бодлогын чиглэлүүдийг тодорхойлж, хэрэгжүүлж эхлэхээр тусгасан.

- ✓ **Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2010):** Энэхүү баримт бичигт бүх нийтэд тэгш, хүртээмжтэй, чанартай, олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байх, боловсролын салбарт сайн засаглал, боловсролын салбарын удирдлагын мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, иргэн бүрд боловсролын үйлчилгээг хүргэх, насан туршдаа боловсрол эзэмших орчин, нөхцөл, боломжийг бүрдүүлэх, боловсролд мэдээллийн технологийг ашиглах, сургалтын нээлттэй эхийг дэмжих, гадаад хэлний сургалтын үндэсний бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх, мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрийг ажлын байранд тавигдах шаардлага, техник, технологийн дэвшилтэй уялдуулан тасралтгүй хөгжүүлэх, боловсролын байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэх, бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ, мониторингийн тогтолцоог хөгжүүлэх, шийдвэр гаргахад мэргэжлийн холбоо, олон нийт, иргэдийн оролцоог хангах, боловсролын байгууллагын үйл ажиллагааны ил, тод, нээлттэй байдлыг хангах зэрэг асуудлыг тусгасан байна.

Манай улс боловсролын шаталсан системийг 1942 онд Монголын анхны их сургууль болох Монгол Улсын их сургууль үүсгэн байгуулагдсан үеэс бий болсон гэж үздэг. 1989 онд 8 их, дээд сургууль, 46 техникум, техник мэргэжлийн сургууль үйл ажиллагаа явуулж байжээ. Ийнхүү зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжихэд өндөр мэргэшлийн ур чадварын эрэлт нь дээд боловсрол эзэмших хэрэгцээг нэмэгдүүлсэн, хувийн хэвшлийг оролцоог 1991 онд хуульчилсан зэрэг нь хувийн өмчийн их, дээд сургуулиуд бий болж дээд боловсролын сургалтын байгууллагын бүтцэд өөрчлөлт орсон.



**Зураг 3.1. Дээд боловсролын сургалтын байгууллагын динамик**

Сүүлийн 15 жилийн хувьд дээд боловсролын сургалтын байгууллагын тооны өөрчлөлтийн динамикаас харвал, их дээд сургуулийн тоо 2002 онд хамгийн оргил цэгтээ буюу 185-д хүрч, улмаар 2005-2006 оны хичээлийн жилд 180, харин 2018-2019 оны хичээлд жилд 94 болсон нь 2005-2006 оны хичээлийн жилтэй харьцуулахад 1.91 дахин, жилд дунджаар 3.78 хувиар тус тус буурчээ. Энэхүү бууралтад зах зээлийн өрсөлдөөнд чанаргүй их дээд сургуулиудын элсэлт буурч зарим хувийн дээд сургууль зах зээлээс шахагдсан, мөн Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоолоор төрийн өмчийн 42 сургуулийг 16 болгон бүтцийн өөрчлөлт хийсэн зэрэг хүчин зүйлс нөлөөлжээ.

Дээд боловсролын сургалтын байгууллагыг бүтцийн хувьд авч үзвэл:

- ✓ 2005-2006 оны хичээлийн жилд 180 их, дээд сургуулийн 27.2 хувийг (49) төрийн өмчийн сургууль, 69.4 хувийг (125) төрийн өмчийн бус сургууль, 3.3 хувийг (6) гадаадын их сургуулийн салбар сургууль бүрдүүлж байсан бол,
- ✓ 2010-2011 оны хичээлийн жилд төрийн өмчийн 42 сургуулийг 16 болгон бүтцийн өөрчлөлт хийснээр 113 их, дээд сургууль болж, түүний 14.2 хувийг (16) төрийн өмчийн сургууль, 81.4 хувийг (92 нь 2004-2005 оны хичээлийн жилтэй харьцуулахад 37-оор буурсан)-ийг төрийн өмчийн бус сургууль, 4.4 хувийг (5) гадаадын их сургуулийн салбар сургууль бүрдүүлэх болжээ,
- ✓ 2018-2019 оны хичээлийн жилд 94 их, дээд сургуулийн 19.1 хувийг (18) төрийн өмчийн сургууль, 77.7 хувийг (73 нь 2010-2011 оны хичээлийн жилтэй харьцуулахад 19-өөр буурсан) төрийн өмчийн бус сургууль, 3.2 хувийг (3) гадаадын их сургуулийн салбар сургууль байна.




*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

*Хүснэгт 3.2. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо*

№	Үзүүлэлт	Хичээлийн жил													
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
		2005-2006		2006-2007		2007-2008		2008-2009		2009-2010		2010-2011		2011-2012	
1	Төрийн өмчийн сургууль	49	27.2	48	28.2	47	29.0	48	31.2	42	28.8	16	14.2	15	14.9
2	Төрийн бус өмчийн сургууль	125	69.4	116	68.2	109	67.3	101	65.6	99	67.8	92	81.4	81	80.2
3	Гадаадын их сургуулийн салбар	6	3.3	6	3.5	6	3.7	5	3.2	5	3.4	5	4.4	5	5.0
	<b>Нийт тоо</b>	<b>180</b>	<b>100</b>	<b>170</b>	<b>100</b>	<b>162</b>	<b>100</b>	<b>154</b>	<b>100</b>	<b>146</b>	<b>100</b>	<b>113</b>	<b>100</b>	<b>101</b>	<b>100</b>
	<b>Өөрчлөлт, хувиар</b>	(2.2)	-	(5.6)	-	(4.7)	-	(4.9)	-	(5.2)	-	(22.6)	-	1.0	-
		<b>2012-2013</b>		<b>2013-2014</b>		<b>2014-2015</b>		<b>2015-2016</b>		<b>2016-2017</b>		<b>2017-2018</b>		<b>2018-2019</b>	
1	Төрийн өмчийн сургууль	15	15.2	16	16.0	16	15.8	17	17.0	17	17.9	18	18.8	18	19,1
2	Төрийн бус өмчийн сургууль	79	79.8	79	79.0	80	79.2	78	78.0	74	77.9	75	78.1	73	77,7
3	Гадаадын их сургуулийн салбар	5	5.1	5	5.0	5	5.0	5	5.0	4	4.2	3	3.1	3	3,2
	<b>Нийт тоо</b>	<b>99</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>101</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>95</b>	<b>100</b>	<b>96</b>	<b>100</b>	<b>94</b>	<b>100</b>
	<b>Өөрчлөлт, хувиар</b>	(2.0)	-	1.0	-	1.0	-	(1.0)	-	(5.0)	-	1.1	-	(2.0)	-

2018-2019 оны хичээлийн жилд 94 их, дээд сургуульд 6668 үндсэн багш ажиллаж, нийт ажиллагчдын 52.8 хувийг бүрдүүлж байгаа нь 2005-2006 оны хичээлийн жилтэй харьцуулахад 151 үндсэн багшаар нэмэгдсэн боловч, нийт ажиллагчдад эзлэх хувь нь 3.03 хувиар буурчээ. Дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн багшийн динамикийг үндсэн багшийн тоо, нийт ажиллагчдад үндсэн багшийн эзлэх хувь болон нэг сургуульд ногдох дундаж багшийн тоо гэсэн үзүүлэлтээр 15 жилийн хугацаагаар тодорхойлж зурагт харуулав.



**Зураг 3.2. Дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн багшийн динамик**

2018-2019 оны хичээлийн жилд 94 их, дээд сургуульд 6668 үндсэн багш ажиллаж байгаагаас 4183 багш (62.7%) нь төрийн өмчийн 18 сургуульд, 2473 багш (37.1%) нь төрийн бус өмчийн 73 сургуульд, үлдсэн 12 багш (0.2%) нь гадаадын их сургуулийн салбар 3 сургуульд тус тус багшилж байна. Харин эрдмийн зэрэг, цолны хувьд 2033 нь доктор (30.5%), 4236 нь магистр (63.6%), 395 нь бакалавр (6.0%), үлдсэн 4 нь дипломын (0.05%) боловсролтой байна<sup>12</sup>.

<sup>12</sup> Дээд боловсролын үндсэн үзүүлэлтийн төлөв байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ

**Хүснэгт 3.3. Дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн багшийн тоо**

№	Үзүүлэлт	Хичээлийн жил						
		2005-2006	2006-2007	2007-2008	2008-2009	2009-2010	2010-2011	2011-2012
1	Ажиллагчдын тоо	11,676	12,175	12,492	12,555	12,849	12,824	13,021
2	Үндсэн багшийн тоо	6,517	6,818	6,892	7,020	7,219	7,183	7,295
3	Багшийн дундаж тоо	36.2	40.1	42.5	45.6	49.4	63.6	72.2
4	Үндсэн багшийн эзлэх хувь	55.8	56.0	55.2	55.9	56.2	56.0	56.0
5	Өөрчлөлт, хувиар	2.8	4.6	1.1	1.9	2.8	(0.5)	1.6
		<b>2012-2013</b>	<b>2013-2014</b>	<b>2014-2015</b>	<b>2015-2016</b>	<b>2016-2017</b>	<b>2017-2018</b>	<b>2018-2019</b>
1	Ажиллагчдын тоо	13,175	13,212	13,360	13,057	12,740	12,705	12,633
2	Үндсэн багшийн тоо	7,331	7,385	7,528	7,121	6,917	6,724	6668
3	Багшийн дундаж тоо	74.1	73.9	74.5	71.2	72.8	70.0	70.9
4	Үндсэн багшийн эзлэх хувь	55.6	55.9	56.3	54.5	54.3	52.9	52,8
5	Өөрчлөлт, хувиар	0.5	0.7	1.9	(5.4)	(2.9)	(2.8)	(0.1)

Эх үүсвэр: ҮСХ

2013 онд ЮНЕСКО-оос Боловсролын ангиллын олон улсын стандартыг шинэчлэн гаргасан бөгөөд уг стандартын дагуу Монгол Улсад мэргэжлийн чиглэл (хөтөлбөр)-ийн ангиллыг тогтоосон. Энэхүү зорилго нь i) боловсролын ангиллын талаар олон улсын түвшинд нэгдмэл ойлголт, нэр томъёо хэрэглэх, ii) боловсролын талаар харьцуулж болохуйц мэдээлэл цуглуулах боломж бүрдэх /нэгдсэн мэдээллийн систем бий болно/, iii) улс бүр өөрийн онцлогт тохируулан тухайн ангиллыг тогтвортой нэг байдлаар мөрдөх гэж тодорхойлсон. Тухайн улс ангиллыг нэвтрүүлснээр дараах ач холбогдолтой гэжээ. Үүнд:

- ✓ Нэгдсэн бодлого, нэг нэршил, ойлголт, уялдаа холбоо сайжрах,
- ✓ Сургалтын хөтөлбөр боловсруулахад хялбар дөхөм болох,

- ✓ Нэгдсэн кредит систем бий болох нөхцөл бүрдэх,
- ✓ Мэргэжлийн чадавхын өрсөлдөөн нэмэгдэх,
- ✓ Олон улсын чиг хандлагад нийцэх гадаад орнуудтай боловсролын/диплом хүлээн зөвшөөрөх/ харилцаа сайжрах,
- ✓ Боловсролын агуулгын хувьд бусад орнуудтай жишихүйц болох.

Боловсролын олон улсын стандарт ангилал (ISCED) 2013 нь ажил мэргэжлийн олон улсын стандарт ангилал (ISCO-08)-тай зарим талаар ижил боловч өөр хоорондоо ялгаатай статистик нэгж, шалгууртай юм. Боловсролын олон улсын стандарт ангилал нь боловсролын олон улсын стандартын ангилал нь сургалтын хөтөлбөрийн агуулгад суурилсан байдаг бол ажил мэргэжлийн олон улсын ангилал нь мэргэжлийн түвшин, ур чадварын мэргэшил дээр суурилсан байдаг. Тиймээс мэргэжлийн болон боловсролын салбарын ангилал нь заавал шууд тодорхой холбоотой байх албагүй юм. Харин шинжлэх ухаан технологийн ангилал нь судалгаа ба туршин хөгжүүлэлтээр ангилагдах бөгөөд эдийн засгийн хамтын ажиллагааны хамтын байгууллагын Frascati гарын авлагын хэсэг юм. шинжлэх ухаан технологийн ангиллын шаардлагагүй зарим ялгааг давтахгүйн үүднээс боловсролын олон улсын стандартын ангиллын зарим хэсгээ харьцуулж хийсэн. Гэхдээ энэ нь шинжлэх ухаан технологийн ангилал болон боловсролын олон улсын стандартын ангилал нь өөр өөр зорилготой тул хоорондоо шууд хамааралтай байдлыг хангах нь тийм ч оновчтой биш юм. Шинжлэх ухаан технологийн ангилал нь 2 шатлалт 6 чиглэл бүхий 40 орчим бүлэгт хуваагддаг байна. Үүнд:

1. Байгалийн шинжлэх ухаан,
2. Инженер технологи,
3. Эрүүл мэндийн шинжлэх ухаан,
4. Хөдөө аж ахуйн шинжлэх ухаан,
5. Нийгмийн шинжлэх ухаан,
6. Хүмүүнлэг,

Боловсролын олон улсын стандарт ангиллыг доорх хүснэгтээр харуулав.

**Хүснэгт 3.4. Боловсролын олон улсын стандарт ангилал (ISCED)**

<b>Салбар</b>	<b>Төрөлжсөн мэргэжил</b>	<b>Нарийвчилсан мэргэжил</b>
<b>00</b> Ерөнхий хөтөлбөрүүд ба мэргэжил	<b>01</b> Суурь хөтөлбөрүүд болон мэргэжил <b>02</b> Бичиг үсгийн болон тооны чадвар <b>03</b> Хувь хүний чадвар	0011 Суурь хөтөлбөрүүд болон мэргэжил 0021 Бичиг үсгийн болон тооны чадвар 0031 Хувь хүний чадвар
<b>01</b> Боловсрол	<b>011</b> Боловсрол	0111 Боловсролын шинжлэх ухаан 0112 Багш, сургуулийн өмнөх насны хүүхдийн 0113 Багш, бага ангийн 0114 Багш, мэргэжлийн
<b>02</b> Урлаг, хүмүүнлэг	<b>021</b> Урлаг	0211 Дуу, дүрс бичлэгийн урлаг, хэвлэл мэдээлэл 0212 Загвар зохион бүтээх, дотоод болон үйлдвэрлэлийн зориулалттай дизайн 0213 Дүрслэх урлаг 0214 Гар урлал 0215 Хөгжим, театрын урлаг
	<b>022</b> Хүмүүнлэг (хэлнээс бусад)	0221 Шашин судлал 0222 Түүх, археологи 0223 Философи, ёс зүй
	<b>023</b> Хэл	0231 Хэл эзэмших 0232 Уран зохиол, хэл шинжлэл
<b>03</b> Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй	<b>031</b> Нийгмийн болон зан харилцааны шинжлэх ухаан	0311 Эдийн засаг 0312 Улс төр, иргэн судлал 0313 Сэтгэл судлал 0314 Социологи, соёл судлал
	<b>032</b> Сэтгүүл зүй, мэдээлэл	0321 Сэтгүүл зүй 0322 Номын сан, мэдээлэл, архив судлал
<b>04</b> Бизнес, удирдахуй, хууль, эрх зүй	<b>041</b> Бизнес ба удирдлага	0411 Нягтлан бодох бүртгэл, татвар 0412 Санхүү, банк, даатгал 0413 Удирдахуйн ба захиргааны ухаан 0414 Маркетинг, зар сурталчилгаа 0415 Нарийн бичиг, оффисын ажил 0416 Бөөнөөр болон жижиглэнгийн худалдаа 0417 Ажлын байрны чадвар
	<b>042</b> Хууль, эрх зүй	0421 Хууль, эрх зүй
<b>05</b> Байгалийн шинжлэх ухаан,	<b>051</b> Биологи ба биологийн холбогдох шинжлэх ухаан	0511 Биологи 0512 Биохими

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

математик, статистик	<b>052</b> Хүрээлэн байгаа орчин	0521 Хүрээлэн байгаа орчны судлал 0522 Унаган байгаль орчин ба амьд амьтад
	<b>053</b> Физикийн шинжлэх ухаан	0531 Хими 0532 Газар зүй, геологи 0533 Физик
	<b>054</b> Математик, статистик	0541 Математик 0542 Статистик
<b>06</b> Мэдээлэл, мэдээлэл харилцааны технологи	<b>061</b> Мэдээлэл, харилцаа холбооны технологи	0611 Компьютерын хэрэглээ 0612 Сүлжээний дизайн, өгөгдлийн бааз, удирдлага 0613 Программ хангамж, өгөгдлийн хөгжил, түүний шинжилгээ
<b>07</b> Инженер, үйлдвэрлэл барилга угсралт	<b>071</b> Инженерчлэл, инженерийн худалдаа	0711 Химийн инженерчлэл ба үйл ажиллагаа 0712 Байгаль орчны хамгааллын технологи 0713 Цахилгаан, эрчим хүч 0714 Электроникс, автоматжуулалт 0715 Механик, төмөрлөгийн худалдаа 0716 Автомашин, хөлөг онгоц, онгоц
	<b>072</b> Үйлдвэрлэл болон боловсруулах үйл ажиллагаа	0721 Хүнсний үйлдвэрлэл 0722 Материал боловсруулалт (шил, цаас, хуванцар, мод) 0723 Сүлжмэл (хувцас, гутал болон арьс шир) 0724 Уул уурхай, олборлолт
	<b>073</b> Архитектур ба барилга	0731 Архитектур, хот төлөвлөлт 0732 Барилга, иргэний байгууламж
<b>08</b> Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлэг	<b>081</b> Хөдөө аж ахуй	0811 Үр тариа ба малын гаралтай бүтээгдэхүүн 0812 Жимс ногооны аж ахуй
	<b>082</b> Ойн аж ахуй	0821 Ойн аж ахуй
	<b>083</b> Загасны аж ахуй	0831 Загасны аж ахуй
	<b>084</b> Мал эмнэлэг	0841 Мал эмнэлэг
<b>09</b> Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	<b>091</b> Эрүүл мэнд	0911 Нүүр ам судлал 0912 Анагаах ухаан 0913 Сувилахуй ба эх барихуй 0914 АУ-ны оношилгоо ба эмчилгээний технологи 0915 Эрчимт эмчилгээ ба сэхээн амьдруулах 0916 Эм зүй 0917 Уламжлалт анагаах ухаан

**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**

	<b>092</b> Нийгмийн хамгаалал	0921 Ахмад настан ба хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчдийн тусламж үйлчилгээ 0922 Хүүхэд асрах болон залуучуудын тусламж үйлчилгээ 0923 Нийгмийн ажил ба зөвлөх үйлчилгээ
<b>10</b> Үйлчилгээ	<b>101</b> Хувь хүнд зориулсан үйлчилгээ	1011 Гэрийн болон ахуйн үйлчилгээ 1012 Үсчин, гоо сайхан 1013 Зочид буудал, ресторан, цайны газар 1014 Спорт 1015 Аялал жуулчлал, чөлөөт цаг
	<b>102</b> Эрүүл ахуй, мэргэжлийн эрүүл мэндийн үйлчилгээ	1021 Нийтийн эрүүл ахуй 1022 Мэргэжлийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа
	<b>103</b> Аюулгүй байдал, хамгаалалтын үйлчилгээ	1031 Цэрэг, батлан хамгаалах 1032 Иргэд ба тэдний өмч хөрөнгийн хамгаалах
	<b>104</b> Тээврийн үйлчилгээ	1041 Тээвэр

2014 онд БСШУ-ны сайдын 78 дугаар тушаалаар Боловсролын олон улсын стандарт ангиллыг баримтлан мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн баталснаар БСШУ-ны сайдын 2010 оны 235 дугаар тушаал баталсан бакалаврын 817 мэргэжил нь 10 багц 181 мэргэжлийн чиглэл (хөтөлбөр) болсон ба доорх хүснэгтээр харуулав.

**Хүснэгт 3.5. Дээд боловсролын мэргэжлийн чиглэлийн шинэчлэлт**

№	Төрөлжсөн чиглэл (БШУЯ-ны сайдын 2014 оны 78-р тушаал)		Төрөлжсөн чиглэл (БШУЯ-ны сайдын 2010 оны 235-р тушаал)	
	Хөтөлбөрийн нэр	Тоо	Мэргэжлийн нэр	Тоо
01	Боловсрол	14	Боловсрол	31
02	Урлаг, хүмүүнлэг	31	Хүмүүнлэг, урлаг	47
03	Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй	9	Нийгмийн ухаан, бизнес, хууль зүй	53
04	Бизнес, удирдлага, эрх зүй	13	-	-
05	Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик	13	Шинжлэх ухаан	41
06	Мэдээлэл, харилцаа холбооны технологи	10	-	-
07	Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт	42	Инженер	117

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

08	Хөдөө аж ахуй, ой загасны аж ахуй мал эмнэлэг	9	Хөдөө аж ахуй	24
09	Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	14	Эрүүл мэнд	51
10	Үйлчилгээ	26	Нийгмийн халамж, үйлчилгээ	53
	<b>Нийт</b>	<b>181</b>	<b>Нийт</b>	<b>817</b>

Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй (03) салбар нь үндсэн төрөлжсөн 2 мэргэжил болон нарийвчилсан 6 мэргэжилд хуваагддаг. Үүнд:

✓ Нийгмийн болон зан харилцааны шинжлэх ухаан (031):

- Эдийн засаг (0311),
- Улс төр, иргэн судлал (0312),
- Сэтгэл судлал (0313),
- Социологи, соёл судлал (0314),

✓ Сэтгүүл зүй, мэдээлэл (032):


- Сэтгүүл зүй (0321),
- Номын сан, мэдээлэл, архив судлал (0322),

Их, дээд сургуульд суралцагчдын хувьд 2004-2005 оны хичээлийн жилд 67.9 хувь нь төрийн өмчийн сургуульд, 31.8 хувь нь төрийн бус өмчийн сургуульд сурч байсан бол, 2017-2018 оны хичээлийн жилд 57.6 хувь нь төрийн өмчийн сургуульд (2004-2005 оны хичээлийн жилтэй харьцуулахад 10.3 нэгжээр буурсан), 42.3 хувь нь төрийн бус өмчийн сургуульд (2004-2005 оны хичээлийн жилтэй харьцуулахад 10.5 нэгжээр өссөн) сурч байна.

Нийт их, дээд сургуульд суралцагчдад төрийн өмчийн сургуульд суралцагчдын эзлэх хувийн жин жилд дунджаар 0.7 хувиар буурч байгаагаас төрийн өмчийн сургуулиуд зах зээлд эзлэх байр сууриа алдаж байгааг харуулж байна.



**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**



**Зураг 3.3. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын динамик**

**Хүснэгт 3.6. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын тоо**

№	Үзүүлэлт	Хичээлийн жил						
		2005-2006	2006-2007	2007-2008	2008-2009	2009-2010	2010-2011	2011-2012
1	Суралцагчдын тоо	138,019	142,411	150,326	161,111	164,773	170,126	172,798
	Өөрчлөлт, хувиар	11.5	3.2	5.6	7.2	2.3	3.2	1.6
2	Төрийн өмчийн сургуульд суралцагчид	91,755	93,478	99,037	106,611	100,581	104,431	104,101
	Нийт суралцагчдад эзлэх хувь	66.5	65.6	65.9	66.2	61.0	61.4	60.2
3	Төрийн бус өмчийн сургуульд суралцагчид	45,784	48,552	50,878	54,114	63,835	65,306	68,302
	Нийт суралцагчдад эзлэх хувь	33.2	34.1	33.8	33.6	38.7	38.4	39.5
4	Гадаадын их сургуулийн	480	381	411	386	357	389	395

**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**

	салбарт суралцагчид							
	Нийт суралцагчдад эзлэх хувь	0.3	0.3	0.3	0.2	0.2	0.2	0.2
5	Шинээр элсэгчдийн тоо	42,854	39,460	43,897	46,692	43,829	44,472	44,484
	Нийт суралцагчдад эзлэх хувь	31.0	27.7	29.2	29.0	26.6	26.1	25.7
		<b>2012-2013</b>	<b>2013-2014</b>	<b>2014-2015</b>	<b>2015-2016</b>	<b>2016-2017</b>	<b>2017-2018</b>	<b>2018-2019</b>
1	Суралцагчдын тоо	175,591	174,045	178,295	162,626	157,138	155,248	157,625
	Өөрчлөлт, хувиар	1.6	(0.9)	2.4	(8.8)	(3.4)	(1.2)	(0,8)
2	Төрийн өмчийн сургуульд суралцагчид	105,751	101,855	103,650	95,033	91,798	89,473	87,992
	Нийт суралцагчдад эзлэх хувь	60.2	58.5	58.1	58.4	58.4	57.6	55,8
3	Төрийн бус өмчийн сургуульд суралцагчид	69,353	71,689	74,233	67,276	65,075	65,628	69,370
	Нийт суралцагчдад эзлэх хувь	39.5	41.2	41.6	41.4	41.4	42.3	44.0
4	Гадаадын их сургуулийн салбарт суралцагчид	487	531	412	317	265	147	263
	Нийт суралцагчдад эзлэх хувь	0.3	0.3	0.2	0.2	0.2	0.1	0.2
5	Шинээр элсэгчдийн тоо	47,744	47,182	43,834	29,023	41,195	45,480	44,094
	Нийт суралцагчдад эзлэх хувь	27.2	27.1	24.6	17.8	26.2	29.3	27.9

Дээрх хүснэгтээс харвал, 2018-2019 оны хичээлийн жилд их, дээд сургуульд 157,625 оюутан суралцаж байгаа нь 2005-2006 оны хичээлийн жилтэй харьцуулахад суралцагчдын тоо 20.2 хувиар өссөн байна. Харин бүтцийн хувьд 55.8 хувь буюу 87.992 оюутан төрийн өмчийн сургуульд, 44.0 хувь буюу 69,370 оюутан төрийн бус өмчийн сургуульд, үлдсэн 0.2 хувь буюу 263 оюутан гадаадын их сургуулийн салбар сургуульд тус тус суралцаж байна.

**Хүснэгт 3.7. Нийгмийн болон зан харилцааны шинжлэх ухаан чиглэлээр сургалт явуулдаг сургууль**

№	Үзүүлэлтүүд	Эдийн засаг	Социологи	Сэтгэл судлал	Улс төр	Соёл судлал	Антропологи
1	Бакалавр	26	2	7	4	1	1
2	Магистр	9	1	3	5	2	1
3	Доктор	2	1	2	1	2	1
	<b>Нийт</b>	<b>26</b>	<b>2</b>	<b>8</b>	<b>5</b>	<b>2</b>	<b>1</b>


2018-2019 оны хичээлийн жилд Нийгмийн болон зан харилцааны шинжлэх ухаан чиглэлээр 4291 оюутан суралцаж байгаагаас Эдийн засаг хөтөлбөрөөр 26 сургуульд 2816 оюутан (67%), Социологи хөтөлбөрөөр 2 сургуульд 193 оюутан (4.5%), Сэтгэл судлал хөтөлбөрөөр 8 сургуульд 841 оюутан (21.9%), Улс төр судлал хөтөлбөрөөр 5 сургуульд 148 оюутан (3.4%), Соёл судлал хөтөлбөрөөр 2 сургуульд 99 оюутан (2.2%), Антропологи хөтөлбөрөөр 1 сургуульд 37 оюутан (0.9%) тус тус бакалавр, магистр, докторын зэргээр суралцаж байна (хүснэгт 14.8).

2018-2019 оны хичээлийн жилд их, дээд сургуулийг 23,038 оюутан төгссөн нь нийт суралцагчдын 15.5 хувь болж байна. Харин 2005-2006 оны хичээлийн жилийн төгсөгчидтэй харьцуулахад 5506 төгсөгчөөр нэмэгдсэн байна. Нийт төгсөгчдийн 25,2 мянга 86,3 хувь нь бакалавр, 3,9 мянга 13,3 хувь нь магистр, 131 буюу 0,4 хувь нь докторын зэрэг эзэмшсэн байна. Нийт төгсөгчдийг 2013/2014 онтой харьцуулахад бакалаврынх 4,5 мянга (15.4 хувь), магистр 128 (3.3 хувь)-аар тус тус буурсан бол доктор оюутны тоо 13 (11.0 хувь)-аар өссөн байна (хүснэгт 14.9).

Нийгмийн ухаан, бизнес ба хуулийн мэргэжлийн чиглэлээр 2016-2017 оны хичээлийн жилд 11,048 оюутан төгссөн нь нийт төгсөгчийн 36.6 хувь болж байна. Боловсролын зэргийн хувьд бакалавр 36.5 хувь, магистр 42.7 хувь, докторантур 21.2 хувийг тус тус дүүргэжээ. Харин боловсролын олон улсын стандарт ангилал баримтлан Нийгмийн болон зан харилцааны шинжлэх ухаан (031) салбараар төгсөгчдийг нарийвчлан судалбал, нийгэм, эдийн засаг мэргэжлээр 1758 оюутан төгссөн нь нийт төгсөгчдийн 5.1 хувь болж байна. Боловсролын зэргийн хувьд дипломын дээд төгсөөгүй, бакалавр 1613 оюутан

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

буюу 91.8 хувь, магистр 114 оюутан буюу 6.5 хувь, докторантур 8 оюутан буюу 0.4 хувийг тус тус дүүргэжээ (хүснэгт 14.10).



**Зураг 3.4. Дээд боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт**

Дээрх зурагт төгсөгчдийн ажлын байртай болсон хувийн жинг сүүлийн 15 жилийн хувьд харуулав. Нийт төгсөгчдийн 34.4 хувь буюу 10.029 төгсөгч ажлын байртай болсон нь өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад 2.2 хувиар өсжээ. Боловсролын зорилтууд төрийн үүрэгтэй холбоотой нийгмийн шударга байдлыг хангахад чиглэдэг байсан бол өнөө үед тодорхой хөгжлийн зорилтуудыг агуулдаг болжээ. Энэхүү нийгмийн зорилтууд нь улс орны урт хугацааны хөгжлийн зорилтууд байх бөгөөд ихэнх нийгмийн хамгийн гол зорилт нь нийгмийн сайн сайхан байдлыг бүтээж, иргэдээ аз жаргалтай амьдруулахад чиглэгдэж байна. Дээд боловсролын талаар баримтлах бодлогыг олон улсын хөгжлийн хандлагыг баримжаалсан, улс орны тогтвортой хөгжилд түлхэц болохуйц салбар болоход чиглэгдсэн байхаар тодорхойлох, улмаар судалгаанд суурилсан бодлого боловсруулах соёлыг төлөвшүүлэхэд анхаарах цаг болжээ. Ихэнх дээд боловсролын сургалтын байгууллагуудад 2014 оноос эхлэн үр дүнд суурилсан боловсролын онол арга зүй нэвтэрч хөтөлбөр боловсруулах, сургалтын шинэ арга зүй нэвтрүүлэх, сургалтын үнэлгээ, чанарын баталгаажуулалтын чиглэлээр багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулж эхэлсэн хэдий ч сургалтын материал дутмаг; шинэ арга зүйд суралцах багш нарын хандлага сул; төлөвлөлт, зохион байгуулалт тааруу; санхүүгийн эх үүсвэр хангалтгүй; төрөөс баримтлах бодлого, эрх зүйн орчин бүрдээгүй зэрэг шалтгаанаар үр дүн хангалтгүй түвшинд байна.

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

*Хүснэгт 3.8. Нийгмийн болон зан харилцааны шинжлэх ухаан чиглэлээр сургалт явуулдаг сургууль болон тухайн хөтөлбөрөөр суралцагчдын тоо*

№	Сургуулийн нэр	Эдийн засаг			Социологи			Сэтгэл судлал			Улс төр			Соёл судлал			Антропологи		
		D	E	F	D	E	F	D	E	F	D	E	F	D	E	F	D	E	F
1	БХИС	278	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
2	МУБИС	0	13	0	0	0	0	222	79	50	0	8	7	0	0	0	0	0	0
3	МУИС	503	96	30	85	19	15	215	86	20	1	61	44	0	0	0	24	12	1
4	СУИС	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	54	23	1	0	0	0
5	УБИС	16	0	0	1	0	0	0	0	0	3	0	0	0	0	0	0	0	0
6	ХААИС	114	5	6	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
7	ХҮИС	20	0	0	0	0	0	8	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
8	ХСИС	31	0	0	0	0	0	42	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
9	ХААИС \дархан\	61	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
10	ИЗИС	529	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
11	МУЭИС	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	10	8	0	0	0
12	МҮИС	160	33	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
13	ОУУБИС	81	0	0	73	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
14	ОТИС	0	0	0	0	0	0	17	0	0	7	3	0	0	0	0	0	0	0
15	СИЗИС	202	35	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
16	УБЭИС	0	36	24	0	0	0	0	36	0	0	0	0	0	0	0	0	0	0
17	ХУИС	150	29	0	0	0	0	144	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
18	БДС	25	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
19	ГДС	26	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
20	ЖДС	28	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	МДС	15	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
22	НССДС	17	11	0	0	0	0	17	0	0	8	1	0	0	0	0	0	0	0
23	ОУЭЗБДС	38	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**

24	СДС	44	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
25	УЗНАДС	0	0	0	0	0	0	5	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
26	ХНХДС	90	60	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
27	ЧХДС	2	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
28	ЭЗҮДС	6	0	0	0	0	0	0	0	0	0	5	0	0	0	0	0	0	0
29	ХНХДС \Увс\	23	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
30	ОЭЗДС	39	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	<b>Нийт</b>	<b>2498</b>	<b>318</b>	<b>60</b>	<b>159</b>	<b>19</b>	<b>15</b>	<b>670</b>	<b>201</b>	<b>70</b>	<b>19</b>	<b>78</b>	<b>51</b>	<b>54</b>	<b>33</b>	<b>9</b>	<b>24</b>	<b>12</b>	<b>1</b>
	<b>Хувь</b>	<b>86.9</b>	<b>11.1</b>	<b>2.1</b>	<b>82.4</b>	<b>9.8</b>	<b>7.8</b>	<b>71.2</b>	<b>21.4</b>	<b>7.4</b>	<b>12.8</b>	<b>52.7</b>	<b>34.5</b>	<b>56.3</b>	<b>34.4</b>	<b>9.4</b>	<b>64.9</b>	<b>32.4</b>	<b>2.7</b>
	<b>4291</b>	<b>2876</b>			<b>193</b>			<b>941</b>			<b>148</b>			<b>96</b>			<b>37</b>		
	<b>100</b>	<b>67.0</b>			<b>4.5</b>			<b>21.9</b>			<b>3.4</b>			<b>2.2</b>			<b>0.9</b>		

**Хүснэгт 3.9. Дээд боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийн тоо**

№	Үзүүлэлтүүд	Хичээлийн жил						
		2005-2006	2006-2007	2007-2008	2008-2009	2009-2010	2010-2011	2011-2012
1	Суралцагчдын тоо	138,019	142,411	150,326	161,111	164,773	170,126	172,798
2	Төгсгөгчдийн тоо	23,628	25,938	29,599	33,007	34,211	35,847	37,749
	Нийт суралцагчдад эзлэх хувь	17.1	18.2	19.7	20.5	20.8	21.1	21.8
3	Төгсгөгчдөөс ажлын байртай болсон	7,606	9,562	10,496	13,038	13,906	12,975	15,534
	Нийт төгсөгчдөд эзлэх хувь	32.2	36.9	35.5	39.5	40.6	36.2	41.2
		<b>2012-2013</b>	<b>2013-2014</b>	<b>2014-2015</b>	<b>2015-2016</b>	<b>2016-2017</b>	<b>2017-2018</b>	<b>2018-2019</b>
1	Суралцагчдын тоо	175,591	174,045	178,295	162,626	157,138	157,625	148,446
2	Төгсгөгчдийн тоо	37,243	33,850	35,181	35,889	34,681	29,164	23,038

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

	Нийт суралцагчдад эзлэх хувь	21.2	19.4	19.7	22.1	22.1	18,5	15,5
3	Төгсгөгчдөөс ажлын байртай болсон	15,559	10,587	11,573	11,072	11,164	10,029	-
	Нийт төгсөгчдөд эзлэх хувь	41.8	31.3	32.9	30.9	32.2	34.4	-

*Хүснэгт 3.10. Дээд боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийн боловсролын зэрэг*

№	Салбар, мэргэжлийн чиглэл	Боловсролын түвшин							Нийт		
		Диплом	Бакалавр		Магистр		Докторантур		Тоо	Хувь	
			Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь			
1	Боловсрол	-	4,587	15.1	603	16.0	3	2.7	<b>5,193</b>	<b>15.0</b>	
2	Хүмүүнлэгийн ухаан ба урлаг	-	1,767	5.8	235	6.2	6	5.3	<b>2,008</b>	<b>5.8</b>	
3	Нийгмийн ухаан, бизнес ба хууль	-	11,048	36.5	1,611	42.7	24	21.2	<b>12,683</b>	<b>36.6</b>	
3.1	<b>Нийгэм, эдийн засаг</b>	-	<b>1,636</b>	<b>5.4</b>	<b>114</b>	<b>3.0</b>	<b>8</b>	<b>7.1</b>	<b>1,758</b>	<b>5.1</b>	
3.2	<i>Мэдээлэл, сэтгүүл зүй</i>	-	483	1.6	19	0.5	-	-	<b>502</b>	<b>1.4</b>	
3.3	<i>Бизнес, удирдлага</i>	-	7,490	24.7	1,147	30.4	15	13.3	<b>8,652</b>	<b>24.9</b>	
3.4	<i>Хууль, эрх зүй</i>	-	1,439	4.7	331	8.8	1	0.9	<b>1,771</b>	<b>5.1</b>	
4	Байгалийн шинжлэх ухаан	39	1,280	4.2	75	2.0	6	5.3	<b>1,400</b>	<b>4.0</b>	
5	Техник, үйлдвэрлэл ба барилга	81	5,660	18.7	317	8.4	16	14.2	<b>6,074</b>	<b>17.5</b>	
6	Хөдөө аж ахуй	3	737	2.4	93	2.5	15	13.3	<b>848</b>	<b>2.4</b>	
7	Эрүүл мэнд, нийгмийн халамж	187	3,726	12.3	441	11.7	11	9.7	<b>4,365</b>	<b>12.6</b>	
8	Үйлчилгээний салбар	-	1,483	4.9	241	6.4	11	9.7	<b>1,735</b>	<b>5.0</b>	
9	Бусад	185	13	0.0	156	4.1	21	18.6	<b>375</b>	<b>1.1</b>	
<b>Нийт</b>		<b>Тоо</b>	<b>495</b>	<b>30,301</b>	100	<b>3,772</b>	100	<b>113</b>	100	<b>34,681</b>	<b>100</b>
		<b>Хувь</b>	<b>1.4</b>	<b>87.4</b>	-	<b>10.9</b>	-	<b>0.3</b>	-	<b>100</b>	-

### 3.2. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарт үнэлгээ хийж буй өнөөгийн байдал

Манай улсад дээд боловсролын сургалтын байгууллага болон сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх үйл ажиллагаа УИХ-аас 1995 онд баталсан Боловсролын тухай багц хуульд анх удаа боловсролын магадлан итгэмжлэлийн асуудлыг тусгаснаар эхэлжээ. Мөн 1997 онд Засгийн газрын 240 дугаар тогтоолоор Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын дүрэм батлагдаж, Гэгээрлийн сайдын 1998 оны 24 дугаар тушаалаар дээд боловсролын сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх үүрэг бүхий Дээд боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийг 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ. Мөн Боловсролын тухай багц хуульд дараах зохицуулалтууд тусгагджээ. Тухайлбал:

- ✓ 2002 онд мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарт хөндлөнгийн мэргэжлийн үнэлгээ хийх,
- ✓ 2003 онд магадлан итгэмжлэх байгууллага магадлан шинжилгээ хийх ажлыг гэрээний үндсэн дээр төлбөртэй явуулах ба төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишгийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах,
- ✓ 2016 онд байгууллагын магадлан итгэмжлэлийг заавал хийлгэх, шинэ хөтөлбөрөөр сургалт эрхлэхийн өмнө урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэж байхыг тус тус тусгажээ.

Өнөөгийн байдлаар манай улсад боловсролын байгууллага, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой мөрдлөг болгож буй эрх зүйн баримт бичгүүдийг хүснэгтээр харуулав.

**Хүснэгт 3.11. Боловсролын магадлан итгэмжлэлтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүдийн нэгтгэл**

№	Эрх зүйн баримт бичгийн нэр	Батлагдсан огноо	Холбогдох заалт
1	Боловсролын тухай хууль	1995.06.13	22-р зүйл
2	Дээд боловсролын тухай хууль	1995.06.13	5.2, 6.5
3	Боловсролын тухай хууль	2002.05.30	26-р зүйл



*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

4	Дээд боловсролын тухай хууль	2002.05.30	5.5
5	Боловсролын тухай хууль	2003.11.13	26-р зүйлд нэмэлт оруулсан
6	Боловсролын тухай хууль	2009.02.13	26-р зүйлд өөрчлөлт оруулсан
7	Боловсролын тухай хууль	2016.04.14	26-р зүйлд өөрчлөлт, нэмэлт
8	Дээд боловсролын тухай хууль	2016.04.14	4.6, 8.11-12 өөрчлөлт, нэмэлт
9	Монгол Улсын Засгийн газрын тогтоол	1997.12.15	240 тоот
10	Монгол Улсын Засгийн газрын тогтоол	2000.07.05	104 тоот
11	Монгол Улсын Засгийн газрын тогтоол	2000.12.13	194 тоот
12	Монгол Улсын Засгийн газрын тогтоол	2003.12.31	276 тоот
13	Монгол Улсын Засгийн газрын тогтоол	2018.09.05	281 тоот

1999-2018 оны хугацаанд 111 сургууль анх удаа магадлан итгэмжлүүлсэн бол, 2004 оноос эхэлж сургуулиуд хоёр дахь удаагийн магадлан итгэмжлэл хийлгэж эхэлсэн ба нийт 79 сургууль магадлан итгэмжлүүлжээ. Харин гурав дах удаагийн магадлан итгэмжлэлийг 2018 онд 19 сургууль хийлгэсэн байна. Байгууллагын магадлан итгэмжлэх үйл явцыг хүснэгтээр харуулав.

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

**Хүснэгт 3.12. Байгууллагын магадлан итгэмжлэх үйл явцын тоон үзүүлэлтүүд**

Он	Хүсэлт ирүүлсэн	Өөрийн үнэлгээний тайлан ирүүлсэн	Шинжээч ажилласан	БМИҮЗ-ийн хуралдаанд хэлэлцүүлсэн	Магадлан итгэмжлэгдсэн сургуулийн тоо								
					Анх удаа		Хоёр дахь удаа		Гурав дахь удаа		Тухайн онд		Нийт
1999	14	14	14	14	14	12.6	-	-	-	-	14	6.7	14
2000	11	10	10	9	7	6.3	-	-	-	-	7	3.4	21
2001	7	11	11	11	11	9.9	-	-	-	-	11	5.3	32
2002	15	13	13	13	8	7.2	-	-	-	-	8	3.8	40
2003	20	21	21	16	16	14.4	-	-	-	-	16	7.7	56
2004	26	20	22	23	14	12.6	9	11.5	-	-	23	11.1	68
2005	13	13	20	22	12	10.8	7	9.0	-	-	19	9.1	85
2006	22	26	15	16	6	5.4	10	12.8	-	-	16	7.7	88
2007	24	22	8	8	4	3.6	4	5.1	-	-	8	3.8	88
2008	21	28	21	16	9	8.1	7	9.0	-	-	16	7.7	91
2009	16	15	16	16	1	0.9	15	19.2	-	-	16	7.7	86
2010	13	11	12	6	-	-	6	7.7	-	-	6	2.9	86
2011	3	12	8	15	2	1.8	10	12.8	-	-	12	5.8	68
2012	4	4	6	6	2	1.8	4	5.1	-	-	6	2.9	67
2013	6	5	4	-	-	-	-	-	-	-	-	-	67
2014	-	-	7	7	2	1.8	5	6.4	-	-	8	3.8	63
2015	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	63
2016	23	14	-	-	-	-	-	-	-	-	-	-	63
2017	14	24	3	-	-	-	-	-	-	-	-	-	63
2018	8	11	20	23	3	2.7	1	1.3	19	100	23	11.1	73
<b>Нийт</b>	-	-	-	-	<b>111</b>	<b>100</b>	<b>78</b>	<b>100</b>	<b>19</b>	<b>100</b>	<b>208</b>	<b>100</b>	-

**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**

2018 оны байдлаар Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй төрийн өмчийн 18 сургууль, төрийн бус өмчийн 75 сургууль, гадаадын сургуулийн салбар 3 сургууль, нийт 96 их, дээд сургууль, коллежуудаас 73 байгууллага буюу 78 хувь нь магадлан итгэмжлэгдсэн. Магадлан итгэмжлэгдсэн сургуулиудад нийт суралцагчдын 98 хувь нь буюу 151 мянга гаруй оюутан суралцаж байна. 2018 онд 73 сургалтын байгууллага магадлан итгэмжлэгдсэнээс анх удаа магадлан итгэмжлэгдсэн 9 сургууль, хоёр дахь удаа магадлан итгэмжлэгдсэн 45 сургууль, гурав дахь удаа магадлан итгэмжлэгдсэн 19 сургууль байна. Магадлан итгэмжлэгдсэн их сургуулийн эзлэх хувийн жин жил бүр нэмэгдэж байна. Тухайлбал, 2002 онд 22 хувь, 2006 онд 52 хувь, 2014 онд 62 хувь, 2018 онд 76 хувь тус тус байна.

**Хүснэгт 3.13. Дээд боловсролын салбарын магадлан итгэмжлэлийн явц**

Үзүүлэлтүүд		2002	2006	2010	2014	2018
Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо		185	170	113	101	96
Үүнээс:	Төрийн	42	48	16	16	18
	Төрийн бус	136	116	92	80	75
	гадаадын	7	6	5	5	3
Суралцагчдын тоо		98453	142411	170126	178295	155248
Үүнээс:	Төрийн	66834	93478	104431	103650	89473
	Төрийн бус	29893	48552	65306	74233	65628
	гадаадын	369	381	389	412	147
Магадлан итгэмжлэгдсэн сургуулийн тоо		40	88	86	63	73
Магадлан итгэмжлэгдсэн сургуулийн эзлэх хувь		22	52	76	62	76
Магадлан итгэмжлэгдсэн сургуульд суралцагчдын тоо		65627	123609	161304	170272	151591
Магадлан итгэмжлэгдсэн сургуульд суралцагчдын эзлэх хувь		67	87	95	96	98

Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл нь 2002 онд Боловсролын зэрэг олгох хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн журам, хөтөлбөрт тавигдах урьдчилсан шаардлагууд, баримтлах шалгуурууд, өөрийн үнэлгээ хийх чиглэлүүд, хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталж, 2003 оноос сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх ажил эхэлжээ. 2004-2018 онд дээд боловсролын сургалтын байгууллагын нийт 236 хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэнээс төрийн өмчийн сургуулийн 184, төрийн бус өмчийн сургуулийн 52 хөтөлбөр байна.

**Хүснэгт 3.14. Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо**

Он	Хөтөлбөрийн н тоо	Төрийн өмчийн сургууль	Төрийн бус өмчийн сургууль	Бакалавр	Магистр	Доктор	Анх удаа	Хоёр дахь удаа
2004	3	3	-	2	1	-	3	-
2005	4	1	3	4	-	-	4	-
2006	8	7	1	8	-	-	8	-
2008	6	5	1	4	2	-	6	-
2009	16	15	1	16	-	-	15	1
2010	10	10	-	8	2	-	10	-
2011	41	37	4	38	3	-	41	-
2012	31	17	14	25	6	-	29	2
2013	37	35	2	35	2	-	32	5
2014	34	24	10	30	3	1	34	-
2015	29	13	16	28	1	-	29	-
2017	1	1	-	1	-	-	-	1
2018	16	16	-	16	-	-	10	6
<b>Нийт</b>	<b>236</b>	<b>184</b>	<b>52</b>	<b>215</b>	<b>20</b>	<b>1</b>	<b>221</b>	<b>15</b>
<b>Хувь</b>	<b>100</b>	<b>78.0</b>	<b>22.0</b>	<b>91.1</b>	<b>8.5</b>	<b>0.4</b>	<b>93.6</b>	<b>6.4</b>

2014-2018 оны хугацаанд нийт 11 мэргэжлийн чиглэлээр 80 хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэнээс 25 хувь буюу 20 хөтөлбөр нь Бизнес, удирдлага, 23.8 хувь буюу 19 хөтөлбөр Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт, 13.8 хувь буюу 11 хөтөлбөр нь Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал чиглэлээр байгаа бол Үйлчилгээ чиглэлээр хөтөлбөр магадлан итгэмжлэгдээгүй байна. Харин нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй чиглэлээр 6 хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэнээс 2014 онд 2 хөтөлбөр, 2015 онд 4 хөтөлбөр байна.

**Хүснэгт 3.15. Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо**

№	Мэргэжлийн чиглэл	2014	2015	2016	2017	2018	Нийт	Хувь
1	Боловсрол	3	5	0	0	1	9	11.3
2	Урлаг, хүмүүнлэг	2	2	0	0	0	4	5.0
3	Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй	2	4	0	0	0	6	7.5
4	Бизнес, удирдлага	9	11	0	0	0	20	25.0
5	Хууль, эрх зүй	6	0	0	0	0	6	7.5
6	Байгалийн шинжлэх ухаан, математик статистик	0	1	0	0	0	1	1.3

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

7	Мэдээлэл, харилцаа холбооны технологи	0	0	0	0	1	1	1.3
8	Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт	10	2	0	0	7	19	23.8
9	ХАА, ой, загасны аж ахуй, мал эмнэл зүй	1	0	0	0	2	3	3.8
10	Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	1	4	0	1	5	11	13.8
11	Үйлчилгээ	0	0	0	0	0	0	0.0
	<b>Нийт</b>	34	29	0	1	16	80	100
	<b>Хувь</b>	42.5	36.3	0.0	1.2	20.0	100	-

2013 оноос хойш Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүйн чиглэлээр 7 сургуулийн 10 хөтөлбөр магадлан итгэмжлэл хийлгэснээс сэтгүүл зүйн 6 хөтөлбөр, эдийн засгийн 2 хөтөлбөр, соёл судлалын 1 хөтөлбөр, номын сан судлалын 1 хөтөлбөр тус тус байна.

*Хүснэгт 3.16. Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүйн хөтөлбөрийн магадлан итгэмжлэл*

Мэргэжил		Хөтөлбөр	Он	Сургууль
Төрөлжсөн	Нарийвчилсан			
031 Нийгмийн болон зан харилцааны шинжлэх ухаан	0311 Эдийн засаг	Олон улсын эдийн засгийн харилцаа	2013	МУИС
		Бизнесийн эдийн засаг	2015	МУИС
	0312 Улс төр, иргэн судлал	-	-	-
	0313 Сэтгэл судлал	-	-	-
	0314 Социологи, соёл судлал	Соёл судлал	2014	СУИС
032 Сэтгүүл зүй, мэдээлэл	0321 Сэтгүүл зүй	Сэтгүүл зүй	2013	ХИС
		Сэтгүүл зүй	2013	МУБИС
		Сэтгүүл зүй	2013	МУИС
		Сэтгүүл зүй	2015	ОТИС
		Сэтгүүл зүй	2015	ЗДС
	Сэтгүүл зүй	2015	МУИС	
	0322 Номын сан, мэдээлэл, архив судлал	Номын сан судлал	2014	СУИС

2016 онд Боловсролын тухай хуулийн 21.6-д орсон нэмэлт өөрчлөлт орж “Боловсролын сургалтын байгууллага шинэ хөтөлбөрөөр сургалт эрхлэхийн өмнө Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагаар урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэнэ” гэж зааснаар Монгол Улсын боловсролын салбарт шинэ

хөтөлбөрийг нээхийн өмнө урьдчилсан магадлан итгэмжлэл хийх эрх зүйн орчин бүрдсэн. 2017-2018 оны хичээлийн жилд 24 их, дээд сургуулиас 98 шинэ хөтөлбөрт урьдчилсан магадлан итгэмжлэл хийж, шинээр сургалт эрхлэх боломжтой 42 хөтөлбөрийг БСШУСЯ-д хүргүүлжээ.

Мөн дээд боловсролын сургалтын байгууллага, хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг олон улсын түвшинд дараах чанарын хөндлөнгийн үнэлгээний байгууллагуудаар хийлгэжээ. Үүнд:

- ✓ Ази, Номхон далайн бүс нутагт мэргэжлийн боловсролын магадлан итгэмжлэл (APACC),
- ✓ АНУ-ын Бизнесийн сургууль, хөтөлбөрүүдийн магадлан итгэмжлэл (ACBSP),
- ✓ Герман улсын олон улсын дээд боловсролын магадлан итгэмжлэл (ASIIN),
- ✓ АНУ-ын Инженер, технологийн магадлан итгэмжлэл (ABET),
- ✓ Номхон далайн баруун бүсийн орнуудын анагаахын боловсролын магадлан итгэмжлэл (AMFWPR),

Дээд боловсролын сургалтын байгууллагууд чанарын баталгаажуулалтын асуудлыг зөвхөн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлээр төсөөлж ойлгож ирсэн гэхэд хилсдэхгүй. Өөрөө хэлбэл боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлд тухайн хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэхдээ зөвхөн магадлан итгэмжлэлийн гэрчилгээ авахын тулд л тухайн цаг хугацаанд өөрийн үнэлгээний тайлан бичиж сургалтын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийдэг, бусад үед нь чанарын асуудлыг бараг ярьдаггүй жишиг манай их, дээд сургуулиудад тогтсон гэж хэлж болно.

Үр дүнд суурилсан боловсролын тогтолцооны үед сургалтын хөтөлбөр зорьсон үр дүндээ хүрсэн эсэхийг сургалтын “Орц - Үйл явц - Гарц” бүрд үнэлэх, үнэлгээндээ суурилан чанарын сайжруулалтыг тогтмол хийдэг болох шаардлагатай байна. Угтаа зөвхөн магадлан итгэмжлэлээр бус чанарын дотоод баталгаажуулалтаар сургалтын чанарыг тасралтгүй дээшлүүлэх арга зүйг нэвтрүүлж хэвшүүлэхэд анхаарах шаардлагатай болжээ. Чанарын дотоод

баталгаажуулалт нь хөтөлбөр болон байгууллагын менежментийн тогтолцоог үнэлэх гэсэн хоёр үндсэн чиглэлээр хэрэгждэг.

Хөтөлбөрийн сургалтын чанарыг тасралтгүй үнэлж, сайжруулдаг чанарын соёлыг хэвшүүлэх үндсэн арга зам нь их, дээд сургуулиудын чанарын дотоод баталгаажуулалтын албаны үйл ажиллагаа учраас энэ талаар дээд боловсролын байгууллагуудын түвшинд зохион байгуулалттайгаар томоохон ажлууд хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дээд боловсролтой чанартай мэргэжилтэн бэлтгэхэд ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд, тулгуурлан сургалтын агуулга, арга зүй орчноо сайжруулах, үнэлгээний аргачлалыг өөрчлөн, үр дүнгээ тасралтгүй хянаж чанарын баталгаажуулалтыг хийдэг цогц үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд анхаарах цаг болжээ. Ингэснээр сургалтын үр дүнг зөвхөн оюутны мэдлэгийн үнэлгээгээр бус ажил олгогчийн шаардлагад нийцсэн мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшсэн байдлаар нь үнэлдэг системд шилжих боломж бүрдэх юм.

Дээд боловсролын талаар цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай асуудлуудыг 2018 онд зохион байгуулагдсан “Тогтвортой хөгжил - дээд боловсрол” улсын II зөвлөгөөнөөс гаргасан зөвлөмжөөс дээд боловсролын чанартай холбоотой хэсгийг түүвэрлэн дор харуулав. Үүнд:

- ✓ Сургалтын чанарыг дээшлүүлэх, ажил олгогч, төгсөгчдийн хамтын ажиллагаа, эргэх холбоог шинэ шатанд гаргах, хөдөлмөрийн зах зээлд дээд боловсролын уялдаа, хамаарлыг бэхжүүлэх зохицуулалт хийх;
- ✓ Хөтөлбөр бүрд ажил олгогч, төгсөгчдөөс бүрдсэн мэргэжлийн зөвлөл байгуулж, тэдэнд хөтөлбөрийн сургалтын чанар, үр дүнг тайлагнаж санал, зөвлөмж авдаг тогтолцоог бий болгох;
- ✓ Дээд боловсролын сургалтын чанарын удирдлага, хөндлөнгийн хяналт - үнэлгээний тогтолцоог олон улсын жишигт хүргэх;
- ✓ Дотооддоо дээд боловсролын байгууллагын чанарын эрэмбэ тодорхойлох шалгуур үзүүлэлт, арга зүйг тодорхойлон баталж, эрэмбэ тогтоох ажлыг хэрэгжүүлэх;
- ✓ Дээд боловсролын сургалтын байгууллагын бүтцэд чанарын дотоод баталгаажуулалт хариуцсан нэгж, алба, хэлтэс бий болгох асуудлыг

бодлогоор дэмжих, түүний бүтэц, ажиллах хүрээг тодорхойлох, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах;

- ✓ Боловсролын магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх чиглэлээр:
  - ЮНЕСКО-гийн Ази, Номхон далайн улсын дээд боловсролын эрдмийн зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн 2011 оны шинэчилсэн конвенцод нэгдэх хуулийг соёрхон батлуулах;
  - Магадлан итгэмжлэлийн үндэсний байгууллага, шинжээчдийг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлж, чадавхжуулах, мэргэшүүлэх арга хэмжээ авах;
  - Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагыг олон улсын байгууллагын шалгуурын түвшинд хүргэж, сайжруулах;
  - Гадаадын магадлан итгэмжлэлийн байгууллагаар магадлан итгэмжлэл хийлгэсэн хөтөлбөрийг дотоодод дүйцүүлэн магадлан итгэмжлэлийн гэрчилгээ олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх;

### **3.3. Дээд боловсролын сургалтын байгууллагуудын чанарын төлөвшлийн үнэлгээ**

**Судалгаанд оролцогчдын мэдээлэл:** Манай улсын дээд боловсролын сургалтын байгууллагуудад чанарын менежментийн тогтолцоо болон дотоод чанарын баталгаажуулалтын өнөөгийн байдал, төлөвшлийг үнэлэх зорилгоор хийгдсэн түүвэр судалгаанд 25 их, дээд сургуульд ажилладаг 320 хүн (захиргааны ажилтан, профессор багш)-ийг хамруулсан.



**Зураг 3.5. Судалгааны түүвэрлэлтийн зарчим**


Судалгааны зорилтот бүлэг болгон урьдчилан хүсэлт илгээх байдлаар 9 их сургуулийн 128 хүн (40%), харин санамсаргүй байдлаар 20 их, дээд



**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл” суурь судалгааны төслийн тайлан**

сургуулийн 198 хүн (60%)-ийг хамруулж, урьдчилан бэлдсэн асуулгын хуудсаар мэдээлэл цуглуулсан.

Судалгаанд оролцогчдын 43.7 хувь нь профессор багш, үлдсэн 56.3 хувь захиргааны ажилтан (үүнээс: 25 хувь нь салбар, тэнхимийн эрхлэгч, 11.7 хувь нь сургалт, чанарын албаны дарга, 10.9 хувь нь сургалт, чанарын албаны мэргэжилтэн, 8.6 хувь нь захирал, дэд захирал) тус тус байна.




**Зураг 3.6. Судалгаанд оролцогчдын албан тушаал ба ажилласан жил, хувиар**

Дээрх зургаас харвал, судалгаанд оролцогчдын 73.9 хувь 5-25 жил ажилласнаас 16.1 хувь нь 5-10 жил, 26.2 хувь нь 11-15 жил, 12.8 хувь нь 16-20 жил, 18.8 хувь нь 21-25 жил ба “Албан тушаал – Ажилласан жил”-ийн хамаарлыг доорх хүснэгтээр нарийвчлан харуулав.

**Хүснэгт 3.17. Судалгаанд оролцогчдын албан тушаал ба ажилласан жилийн хамаарал, хувиар**

Албан тушаал	Ажилласан жил						
	4 хүртэл	5-10	11-15	16-20	21-25	26-30	31-ээс дээш
Захирал, дэд захирал	0.0	0.0	18.2	9.1	36.4	9.1	27.3
Сургалт, чанарын албаны дарга	6.7	13.3	33.3	6.7	26.7	6.7	6.7
Сургалт, чанарын албаны мэргэжилтэн	7.1	35.7	35.7	7.1	0.0	7.1	7.1
Салбар, тэнхимийн эрхлэгч	3.1	6.3	18.8	25.0	18.8	12.5	15.6
Профессор багш	3.6	25.0	25.0	16.1	12.5	14.3	3.6
<b>Дундаж</b>	<b>4.1</b>	<b>16.1</b>	<b>26.2</b>	<b>12.8</b>	<b>18.8</b>	<b>9.9</b>	<b>12.0</b>

“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл” суурь судалгааны төслийн тайлан



**Зураг 3.7. Судалгаанд оролцогчдын боловсролын зэрэг ба эрдмийн цол, хувиар**

Судалгаанд оролцогчдын 63.3 хувь нь эрдмийн цолгүй гэж хариулжээ. Харин боловсролын зэргийн хувьд 51.4 хувь нь доктор, 38.3 хувь нь магистр, 10.3 хувь нь бакалавр ба “Албан тушаал – Боловсролын зэрэг”-ийн хамаарлыг доорх хүснэгтээр нарийвчлан харуулав.

**Хүснэгт 3.18. Судалгаанд оролцогчдын албан тушаал ба боловсролын зэргийн хамаарал, хувиар**

Албан тушаал	Доктор	Магистр	Бакалавр
Захирал, дэд захирал	90.9	9.1	0.0
Сургалт, чанарын албаны дарга	40.0	53.3	6.7
Сургалт, чанарын албаны мэргэжилтэн	7.1	50.0	42.9
Салбар, тэнхимийн эрхлэгч	65.6	34.4	0.0
Профессор багш	53.6	44.6	1.8
<b>Дундаж</b>	<b>51.4</b>	<b>38.3</b>	<b>10.3</b>

**Чанарын менежментийн тогтолцооны өнөөгийн байдал:** Манай улсын их, дээд сургуулиудад чанар, чанарын менежмент, чанарын соёлын талаарх ойлголт, төлөвшлийг дараах үндсэн асуудлуудын хүрээнд үнэлсэн. Үүнд:

- ✓ Байгууллагын стратеги ба чанарын бодлого,
- ✓ Чанарын бодлого ба сонирхогч талууд, ажиллагчдын хандлага,
- ✓ Чанарын менежментийн тогтолцоо ба дотоод чанарын баталгаажуулалтын төлөвшил,

Эдгээр үндсэн асуудлуудын хүрээнд судалгааг явуулж, үр дүнг боловсруулав.

**Хүснэгт 3.19. Дээд боловсролын сургалтын байгууллагууд чанарын талаар баримтлах бодлогоо тодорхойлсон байдал, хувиар**

Албан тушаал	Нэгдсэн чанарын бодлоготой	Тодорхойлж байгаа	Тодорхойлохоор төлөвлөсөн	Шинэчлэх шаардлагатай	Тодорхойлоогүй	Сайжруулж байгаа	Зарим нэгж өөрсдийн чанарын бодлоготой	Мэдэхгүй
Захиргааны ажилтан	63.7	6.4	0.0	10.3	1.7	8.1	2.3	7.6
Профессор багш	28.6	26.8	5.4	14.3	3.6	10.7	0.0	10.7
<b>Дундаж</b>	<b>48.4</b>	<b>15.3</b>	<b>2.3</b>	<b>12.1</b>	<b>2.5</b>	<b>9.2</b>	<b>1.3</b>	<b>9.0</b>

Дээрх хүснэгтээс харвал, дээд боловсролын сургалтын байгууллагууд чанарын талаар баримтлах бодлогын хувьд судалгаанд оролцогчдын i) 48.4 хувь нь нэгдсэн чанарын бодлоготой, ii) 15.3 хувь нь бодлогоо тодорхойлж байгаа гэж хариулсан ба үр дүнг нарийвчлан авч үзвэл:

- ✓ Захиргааны ажилтнуудын 63.7 хувь нь нэгдсэн чанарын бодлоготой гэсэн бол,
- ✓ Профессор багш нарын хувь нь нэгдсэн чанарын бодлоготой, 26.8 хувь нь тодорхойлж байгаа гэжээ.

**Хүснэгт 3.20. Дээд боловсролын сургалтын байгууллагын стратеги төлөвлөгөөнд чанарын асуудал тусгагдсан байдал, хувиар**

Албан тушаал	Тусгагдсан	Тусгагдаагүй	Тусгагдах шаардлагагүй	Мэдэхгүй
Захиргааны ажилтан	89.2	3.5	0.0	7.4
Профессор багш	67.9	8.9	0.0	23.2
<b>Дундаж</b>	<b>79.9</b>	<b>5.8</b>	<b>0.0</b>	<b>14.3</b>

Дээрх хүснэгтээс харвал, дээд боловсролын сургалтын байгууллагын стратеги төлөвлөгөөнд чанарын асуудал тусгагдсан байдлыг судалгаанд оролцогчдын i) 79.9 хувь нь тусгагдсан, ii) 14.3 хувь нь мэдэхгүй гэж хариулсан ба үр дүнг нарийвчлан авч үзвэл:

- ✓ Захиргааны ажилтнуудын 89.2 хувь нь тусгагдсан гэсэн бол,
- ✓ Профессор багш нарын 67.9 хувь нь тусгагдсан, 23.2 хувь нь мэдэхгүй гэжээ.

**Хүснэгт 3.21. Сургуулийнхаа чанарын бодлого, зарчим, зорилготой санал нийлдэг байдал, хувиар**

Албан тушаал	Санал нийлж байна	Ер нь шинэчлэх хэрэгтэй	Чухал асуудал биш	Бодит амьдрал дээр хэрэгждэггүй	Мэдэхгүй
Захиргааны ажилтан	58.7	8.1	3.5	2.6	27.2
Профессор багш	53.6	8.9	0.0	7.1	30.4
<b>Дундаж</b>	<b>56.5</b>	<b>8.4</b>	<b>1.9</b>	<b>4.6</b>	<b>28.6</b>

Дээрх хүснэгтээс харвал, сургуулийнхаа чанарын бодлого, зарчим, зорилготой судалгаанд оролцогчдын i) 56.5 хувь нь санал нийлдэг, ii) 28.6 хувь нь мэдэхгүй гэж хариулсан ба үр дүнг нарийвчлан авч үзвэл:

- ✓ Захиргааны ажилтнуудын 58.7 хувь нь санал нийлж, 27.2 хувь нь мэдэхгүй гэж хариулсан бол,
- ✓ Профессор багш нарын 53.6 хувь нь санал нийлж байна, 30.4 хувь нь мэдэхгүй гэжээ.



**Зураг 3.8. Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын удирдлагын зарчмуудаас хэрэгжиж хэвшсэн байдал, хувиар**

Дээрх зургаас харвал, дээд боловсролын сургалтын байгууллагад хэрэгжиж хэвшсэн чанарын менежментийн зарчмууд нь i) Байнгын сайжруулалт (62.5%), ii) хэрэглэгчдэд төвлөрөх (60.8%), iii) хамт олныг татан оролцуулах (56.9%) гэжээ.

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

Харин хэрэгжиж хэвшээгүй чанарын менежментийн зарчмууд нь i) нийлүүлэгчтэй харилцан ашигтай харилцах (59.8%), ii) удирдлагын манлайлал (50.4%), iii) үйл явцын хандлага (49.7%) гэж тус тус тодорхойлжээ.

*Хүснэгт 3.22. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын бодлого, зарчим, зорилго нь сонирхогч талуудад нээлттэй эсэх, хувиар*

Албан тушаал	Бүрэн нээлттэй	Хүсэлт гаргавал мэдээлэл авах боломжтой	Нууцын зэрэглэлтэй асуудал	Сургуулийн дотоод асуудал тул	Мэдээлэл авахад хүндрэлтэй	Зөвхөн сургуулийн удирдлагын түвшинд нээлттэй	Ер нь сонирхож байгаагүй	Мэдэхгүй
Захиргааны ажилтан	63.2	25.3	0.8	0.0	1.7	2.4	2.4	4.1
Профессор багш	32.1	28.6	0.0	3.6	8.9	5.4	5.4	16.1
<b>Дундаж</b>	<b>49.6</b>	<b>26.8</b>	<b>0.4</b>	<b>1.6</b>	<b>4.8</b>	<b>3.7</b>	<b>3.7</b>	<b>9.3</b>

Дээрх хүснэгтээс харвал, дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын бодлого зарчим, зорилго нь сонирхогч талуудад нээлттэй байдлыг судалгаанд оролцогчдын i) 49.6 хувь нь бүрэн нээлттэй, ii) 26.8 хувь нь хүсэлт гаргавал мэдээлэл авах боломжтой гэж хариулсан ба үр дүнг нарийвчлан авч үзвэл:

- ✓ Захиргааны ажилтнуудын 63.2 хувь нь бүрэн нээлттэй, 25.3 хувь нь хүсэлт гаргавал мэдээлэл авах боломжтой гэсэн бол,
- ✓ Профессор багш нарын 32.1 хувь нь бүрэн нээлттэй, 28.6 хувь нь хүсэлт гаргавал мэдээлэл авах боломжтой гэжээ.

*Хүснэгт 3.23. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын бодлого, зарчимтай хариуцаж буй ажлын нийцэл, хувиар*

Албан тушаал	Бүрэн нийцдэг	Ерөнхийдөө нийцдэг	Бараг нийцдэггүй	Нийцдэггүй	Нийцэх шаардлагагүй	Мэдэхгүй
Захиргааны ажилтан	<b>49.7</b>	<b>38.8</b>	0.0	3.2	0	8.2
Профессор багш	19.6	<b>58.9</b>	7.1	0.0	0	14.3
<b>Дундаж</b>	<b>36.6</b>	<b>47.6</b>	<b>3.1</b>	<b>1.8</b>	<b>0.0</b>	<b>10.9</b>

Дээрх хүснэгтээс харвал, дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын бодлого зарчимтай хариуцаж буй ажлын гүйцэтгэлийн нийцтэй

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

байдлыг судалгаанд оролцогчдын i) 47.6 хувь нь ерөнхийдөө нийцдэг ii) 36.6 хувь нь бүрэн нийцдэг гэж хариулсан ба үр дүнг нарийвчлан авч үзвэл:

- ✓ Захиргааны ажилтнуудын 49.7 хувь нь бүрэн нийцдэг, 38.8 хувь нь ерөнхийдөө нийцдэг гэж үзсэн бол,
- ✓ Профессор багш нарын 58.9 хувь нь ерөнхийдөө нийцдэг, 19.6 хувь нь бүрэн нийцдэг гэжээ.

***Хүснэгт 3.24. Хариуцаж буй ажилдаа PDCA мөчлөгийг ашиглаж хэвшсэн байдал, хувиар***

Албан тушаал	Ашиглаж хэвшсэн	Ашиглахыг зорьдог	Ашиглах шаардлагагүй	Ашиглах боломжгүй	Энэ талын ойлголт муу	Мэдэхгүй
Захиргааны ажилтан	38.5	49.8	1.7	4.9	0.0	5.1
Профессор багш	33.9	46.4	0.0	8.9	0.0	10.7
<b>Дундаж</b>	<b>36.5</b>	<b>48.3</b>	<b>0.9</b>	<b>6.7</b>	<b>0.0</b>	<b>7.6</b>

Дээрх хүснэгтээс харвал, судалгаанд оролцогчид хариуцаж буй ажилдаа PDCA мөчлөгийг ашиглаж хэвшсэн гэж 36.5 хувь, ашиглахыг зорьдог гэж 48.3 хувь нь хариулсан ба үр дүнг нарийвчлан авч үзвэл:

- ✓ Захиргааны ажилтнуудын 38.5 хувь нь ашиглаж хэвшсэн, 49.8 хувь нь ашиглахыг зорьдог гэсэн бол,
- ✓ Профессор багш нарын 33.9 хувь нь ашиглаж хэвшсэн, 46.4 хувь нь ашиглахыг зорьдог гэжээ.

***Хүснэгт 3.25. Дээд боловсролын сургалтын байгууллага нь үйл ажиллагаандаа PDCA мөчлөгийг баримталдаг байдал, хувиар***

Албан тушаал	Баримталж хэвшсэн	Баримталж эхэлж байгаа	Баримтлахаар төлөвлөж байгаа	ОГТ баримталдаггүй	Баримтлах шаардлагагүй	Мэдэхгүй
Захиргааны ажилтан	34.6	42.9	9.4	1.7	2.3	9.1
Профессор багш	16.1	44.6	10.7	3.6	0.0	25.0
<b>Дундаж</b>	<b>26.5</b>	<b>43.6</b>	<b>10.0</b>	<b>2.5</b>	<b>1.3</b>	<b>16.1</b>

Дээрх хүснэгтээс харахад дээд боловсролын сургалтын байгууллага нь үйл ажиллагаандаа PDCA мөчлөгийг судалгаанд оролцогчдын i) 26.5 хувь нь

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

баримталж хэвшсэн, ii) 43.6 хувь нь баримталж эхэлж байгаа гэж хариулсан ба үр дүнг нарийвчлан авч үзвэл:

- ✓ Захиргааны ажилтнуудын 34.6 хувь нь баримталж хэвшсэн, 42.9 хувь нь баримталж эхэлж байгаа гэсэн бол,
- ✓ Профессор багш нарын 44.6 хувь нь баримталж эхэлж байгаа, 25.0 хувь нь мэдэхгүй гэжээ.

***Хүснэгт 3.26. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанар хариуцсан нэгжийн төлөвшил, хувиар***

Албан тушаал	Жигдэрсэн	Жигдрээгүй	Эхлэл төдий	Байгуулахаар төлөвлөсөн	Огт байхгүй	Мэдэхгүй
Захиргааны ажилтан	45.0	11.1	33.5	1.7	0.0	8.7
Профессор багш	30.4	21.4	28.6	1.8	3.6	14.3
<b>Дундаж</b>	<b>38.6</b>	<b>15.6</b>	<b>31.3</b>	<b>1.7</b>	<b>1.6</b>	<b>11.2</b>

Дээрх хүснэгтээс харахад дээд боловсролын сургалтын байгууллагад чанар хариуцсан нэгжийн үйл ажиллагааг судалгаанд оролцогчдын i) 38.6 хувь нь жигдэрсэн, ii) 31.3 хувь нь эхлэл төдий гэж хариулсан ба үр дүнг нарийвчлан авч үзвэл:

- ✓ Захиргааны ажилтнуудын 45 хувь нь жигдэрсэн, 33.5 хувь нь эхлэл төдий гэсэн бол,
- ✓ Профессор багш нарын 33.5 хувь нь жигдэрсэн, 28.5 хувь нь эхлэл төдий гэжээ.

***Хүснэгт 3.27. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын дотоод баталгаажуулалтад тулгарч буй бэрхшээлүүд, хувиар***


Албан тушаал	Санхүүгийн бэрхшээл	Арга зүйн мэдлэг дутмаг	Мэргэшсэн Хүний нөөц дутмаг	Удирдлагын мэдээллийн систем	Чанарын соёл төлөвшөөгүй	Мэдэхгүй
Захиргааны ажилтан	12.8	24.6	31.2	9.5	5.1	16.8
Профессор багш	19.6	17.9	21.4	5.4	10.7	25.0
<b>Дундаж</b>	<b>15.8</b>	<b>21.6</b>	<b>26.9</b>	<b>7.7</b>	<b>7.6</b>	<b>20.4</b>

Дээр хүснэгтээс харахад дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын дотоод баталгаажуулалтад тулгарч буй бэрхшээлийг судалгаанд

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

оролцогчдын i) 26.9 хувь нь мэргэшсэн хүний нөөц дутмаг, ii) 21.6 хувь нь арга зүйн мэдлэг дутмаг, iii) 20.4 хувь нь мэдэхгүй гэж хариулсан ба үр дүнг нарийвчлан авч үзвэл:

- ✓ Захиргааны ажилтнуудын 24.6 хувь нь арга зүйн мэдлэг дутмаг, 31.2 хувь нь мэргэшсэн хүний нөөц дутмаг, 16.8 хувь нь мэдэхгүй гэсэн бол,
- ✓ Профессор багш нарын 17.9 хувь нь арга зүйн мэдлэг дутмаг, 21.4 хувь нь мэргэшсэн хүний нөөц дутмаг, 25 хувь нь мэдэхгүй гэжээ.



**Зураг 3.9. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын дотоод оролцогч талууд, хувиар**

Судалгаанд оролцогчид дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын дотоод оролцогч талуудыг i) сургуулийн захирал гэж 77.9 хувь, ii)




*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

сургалтын албаны дарга гэж 72.1 хувь, iii) сургуулийн дэд захирал гэж 71 хувь хариулсан байна.

Харин оролцогч талуудад байх шаардлагагүй гэж i) аж ахуйн албаны мэргэжилтэн гэж 69.2 хувь, ii) санхүүгийн албаны мэргэжилтэн гэж 68.8 хувь, iii) бүтцийн сургуулийн дэд захирал гэж 64.3 хувь нь тус тус хариулжээ.

**Дотоод чанарын баталгаажуулалтын өнөөгийн байдал:** Дээд боловсролын сургалтын байгууллагуудад дотоод чанарын баталгаажуулалтын ойлголт, төлөвшлийг дараах үндсэн асуудлуудын хүрээнд үнэлсэн. Үүнд:

- ✓ Сургах - суралцахуйн болон судлалын чанар,
- ✓ Ажил олгогч ба гадаад шаардлагын нийцэл,
- ✓ Хүртээмж, чанарын баталгаажуулалт,
- ✓ Дэд бүтэц (орчин), нөөцийн хүртээмж, чанар зэрэг болно.



**Зураг 3.10. Дээд боловсролын сургалтын байгууллагад ашиглаж буй чанарын дотоод баталгаажуулалтын хэлбэрүүд, хувиар**

Судалгаанд оролцогчид дээд боловсролын сургалтын байгууллагад ашиглаж буй чанарын дотоод баталгаажуулалтын хэлбэрүүдийг i) багшлахуйн чанарын баталгаажуулалт гэж 51.9 хувь, ii) суралцахуйн чанарын баталгаажуулалт гэж 47.8 хувь, iii) эрдэм судлалын чанарын баталгаажуулалт гэж 36 хувь нь хариулсан байна.

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

Харин дээд боловсролын сургалтын байгууллагад ашигладаггүй (мэдэхгүй) чанарын дотоод баталгаажуулалтын хэлбэрүүдийг i) гадаад шаардлагад нийцлийн баталгаажуулалт гэж 75.1 хувь, ii) дэд бүтэц (орчин)-ийн хүртээмж, чанарын баталгаажуулалт гэж 69.3 хувь, iii) нөөцийн хүртээмж, чанарын баталгаажуулалт гэж 66 хувь нь тус тус хариулжээ.

***Хүснэгт 3.28. Дээд боловсролын сургалтын байгууллагад ашиглах боломжтой чанарын дотоод баталгаажуулалтын хэлбэрүүд, хувиар***

<b>№</b>	<b>Баталгаажуулалтын хэлбэрүүд</b>	<b>Маш чухал</b>	<b>Чухал</b>	<b>Чухал биш</b>	<b>Дундаж</b>
1	Суралцахуйн чанарын баталгаажуулалт	78.2	19.5	2.3	<b>4.52</b>
2	Багшлахуйн чанарын баталгаажуулалт	76.4	20.9	2.7	<b>4.47</b>
3	Ажил олгогчдын хэрэгцээнд нийцлийн баталгаажуулалт	57.9	39.7	2.4	<b>4.11</b>
4	Гадаад шаардлагад нийцлийн баталгаажуулалт	57.9	39.7	2.4	<b>4.11</b>
5	Эрдэм судлалын чанарын баталгаажуулалт	55.1	42.5	2.4	<b>4.05</b>
6	Дэд бүтэц (орчин)-ийн хүртээмж, чанарын баталгаажуулалт	53.5	41.7	4.8	<b>3.98</b>
7	Нөөцийн хүртээмж, чанарын баталгаажуулалт	48.5	46.2	5.3	<b>3.86</b>

Дээрх хүснэгтээс харвал, дээд боловсролын сургалтын байгууллагад ашиглах боломжтой чанарын дотоод баталгаажуулалтын хэлбэрүүдийг i) Суралцахуйн (4.52), ii) Багшлахуй (4.47), iii) Ажил олгогчдын хэрэгцээнд нийцэл (4.11), iv) Гадаад шаардлагад нийцэл (4.11) гэж тус тус үнэлжээ.

***Хүснэгт 3.29. Дээд боловсролын сургалтын байгууллагад чанартай холбоотой дүрэм, журам ашигладаг байдал, хувиар***

<b>Албан тушаал</b>	<b>Байдаг</b>	<b>Боловсруулж байгаа</b>	<b>Байгаа ч ашигладаггүй</b>	<b>Огт байхгүй</b>	<b>Мэдэхгүй</b>
Захиргааны ажилтан	54.2	22.2	3.9	5.0	14.6
Профессор багш	35.7	21.4	5.4	3.6	33.9
<b>Дундаж</b>	<b>46.1</b>	<b>21.9</b>	<b>4.6</b>	<b>4.4</b>	<b>23.1</b>

Дээрх хүснэгтээс харахад дээд боловсролын сургалтын байгууллагад чанартай холбоотой дүрэм, журмын талаар судалгаанд оролцогчдын i) 46.1 хувь нь ашигладаг, ii) 23.1 хувь нь мэдэхгүй гэж хариулсан ба үр дүнг нарийвчлан авч үзвэл:

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

- ✓ Захиргааны ажилтнуудын 54.2 хувь нь ашигладаг, 22.2 хувь нь боловсруулж байгаа гэсэн бол,
- ✓ Профессор багш нарын 35.7 хувь нь ашигладаг, 33.9 хувь нь мэдэхгүй гэжээ.

*Хүснэгт 3.30. Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын гарын авлага ашигладаг байдал, хувиар*

Албан тушаал	Нэгдсэн журмаар ашигладаг	Боловсруулж байгаа	Зарим нэгж ашигладаг	Байгаа ч ашигладаггүй	Огт байхгүй	Мэдэхгүй
Захиргааны ажилтан	34.0	16.0	25.5	2.4	3.2	18.8
Профессор багш	30.4	16.1	14.3	1.8	10.7	26.8
<b>Дундаж</b>	<b>32.4</b>	<b>16.0</b>	<b>20.6</b>	<b>2.2</b>	<b>6.5</b>	<b>22.3</b>


Дээрх хүснэгтээс харвал, дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын гарын авлагыг судалгаанд оролцогчдын i) 32.4 хувь нь нэгдсэн журмаар ашигладаг, ii) 22.3 хувь нь мэдэхгүй гэж хариулсан ба үр дүнг нарийвчлан авч үзвэл:

- ✓ Захиргааны ажилтнуудын 34 хувь нь нэгдсэн журмаар ашигладаг, 25.5 хувь нь зарим нэг нь ашигладаг, 18.8 хувь мэдэхгүй гэсэн бол,
- ✓ Профессор багш нарын 30.4 хувь нь нэгдсэн журмаар ашигладаг, 26.8 хувь нь мэдэхгүй гэжээ.

Доорх зургаас харвал, судалгаанд оролцогчид дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтад ашигладаг үнэлгээний арга хэрэгслүүдийг i) хичээлийн үнэлгээ гэж 83.7 хувь, ii) оюутны үнэлгээ гэж 82.9 хувь, iii) багшийн үнэлгээ гэж 82 хувь нь хариулсан байна.

Харин дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтад ашигладаггүй үнэлгээний арга хэрэгслүүдийг i) хүний нөөцийн хөгжлийн үнэлгээ гэж 74.6 хувь, ii) хөдөлмөрийн зах зээлийн шинжилгээ гэж 59 хувь, iii) бүтцийн нэгжийн хөндлөнгийн үнэлгээ гэж 56.5 хувь нь гэж хариулжээ.

**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**



**Зураг 3.11. Дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтын үнэлгээний арга хэрэгслүүд, хувиар**

**Хүснэгт 3.31. Дээд боловсролын сургалтын байгууллагад дотоод чанарын баталгаажуулалтын үнэлгээний арга хэрэгслүүд, хувиар**

№	Үнэлгээний арга хэрэгслүүд	Маш чухал	Чухал	Чухал биш	Эрэмбэ
1	Хичээлийн үнэлгээ	73.8	24.8	1.4	<b>4.45</b>
2	Хөтөлбөрийн үнэлгээ	73.8	24.8	1.4	<b>4.45</b>
3	Багшийн үнэлгээ	68.9	27.6	3.5	<b>4.31</b>
4	Элсэгчдэд тавигдах чанарын үнэлгээ	67.4	30.0	2.6	<b>4.30</b>
5	Гүйцэтгэлийн үнэлгээ	67.0	30.2	2.8	<b>4.28</b>
6	Хөдөлмөрийн зах зээлийн шинжилгээ	63.9	33.6	2.5	<b>4.23</b>
7	Судалгааны ажлын үнэлгээ	62.2	34.8	3.0	<b>4.19</b>
8	Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа	63.3	32.0	4.7	<b>4.17</b>
9	Оюутны үнэлгээ	62.5	28.8	8.7	<b>4.08</b>
10	Төгсөгчдийн мөшгөх судалгаа	56.9	39.8	3.3	<b>4.07</b>
11	Хүний нөөцийн хөгжлийн үнэлгээ	59.1	35.1	5.8	<b>4.07</b>
12	Ажил олгогчдын үнэлгээ	55.6	40.6	3.8	<b>4.04</b>
13	Магадлан итгэмжлэл	58.4	35.0	6.6	<b>4.04</b>

**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**

14	Оюутны чадамжийн шалгалтын үнэлгээ	54.8	40.6	4.6	<b>4.00</b>
15	Төгсөгчдийн үнэлгээ	55.3	37.2	7.5	<b>3.96</b>
16	Бүтцийн нэгжийн өөрийн үнэлгээ	50.1	44.2	5.7	<b>3.89</b>
17	Бүтцийн нэгжийн хөндлөнгийн үнэлгээ	48.2	42.9	8.9	<b>3.79</b>
18	Дотоод аудит	45.1	47.0	7.9	<b>3.74</b>

Дээрх хүснэгтээс харвал, судалгаанд оролцогчид дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтад i) хичээлийн үнэлгээ (4.45), ii) хөтөлбөрийн үнэлгээ (4.45), iii) багшийн үнэлгээ (4.31), iv) элсэгчдэд тавигдах чанарын үнэлгээ (4.30) зэрэг үнэлгээний арга хэрэгслүүд хамгийн чухал гэж үнэлжээ.

Харин дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтад i) төгсөгчдийн үнэлгээ (3.96), ii) бүтцийн нэгжийн өөрийн үнэлгээ (3.89), iii) бүтцийн нэгжийн хөндлөнгийн үнэлгээ (3.79), iv) дотоод аудит (3.74) зэрэг арга хэрэгслүүд ач холбогдлын түвшин сул тодорхойлогджээ.

**Хүснэгт 3.32. Дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтад ажил олгогчдын оролцоо, хувиар**

№	Оролцооны хэлбэрүүд	Маш чухал	Чухал	Чухал биш	Эрэмбэ
1	Сэтгэл ханамжийн судалгаа авах	65.7	31.7	2.6	<b>4.26</b>
2	Хөтөлбөрийг сайжруулахтай холбоотой санал авах	55.7	41.6	2.7	<b>4.06</b>
3	Оюутны дадлагажих хөтөлбөр удирдуулах	49.6	48.1	2.3	<b>3.95</b>
4	Хөтөлбөрийн хороонд оролцуулах	46.2	38.4	15.5	<b>3.61</b>
5	Дотоод чанарын баталгаажуулалтын явцад оролцуулах	35.1	50.2	14.7	<b>3.41</b>
6	Хичээлийн хөтөлбөрийг шинэчлэхэд оролцуулах	35.6	36.1	28.3	<b>3.15</b>
7	Ажил олгогч, төгсөгчдөөс бүрдсэн зөвлөх хороо байгуулах	25.6	52.6	21.8	<b>3.08</b>
8	Сургалтын үр дүнгийн үнэлгээ хийхэд оролцуулах	25.9	51.5	22.6	<b>3.07</b>
9	Сургалтын үйл ажиллагаанд оролцуулах	24.8	44.9	30.3	<b>2.89</b>

Дээрх хүснэгтээс харвал, дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтад ажил олгогчдыг i) сэтгэл ханамжийн судалгаа авах (4.26), ii) хөтөлбөрийг сайжруулахтай холбоотой санал авах (4.06) зэрэг хэлбэрүүдээр оролцуулах нь маш чухал, харин сургалтын үйл ажиллагаанд оролцуулахыг чухал бус (2.89) гэж тодорхойлжээ.

**Хүснэгт 3.33. Дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтад төгсөгчдийн оролцоо, хувиар**

№	Оролцооны хэлбэрүүд	Маш чухал	Чухал	Чухал биш	Эрэмбэ
1	Сэтгэл ханамжийн судалгаа авах	69.7	30.3	0.0	<b>4.39</b>
2	Хөтөлбөрийг сайжруулахтай холбоотой санал авах	55.2	39.8	5.0	<b>4.00</b>
3	Оюутны дадлагажих хөтөлбөр удирдуулах	50.6	39.0	10.4	<b>3.80</b>
4	Хөтөлбөрийн хороонд оролцуулах	42.0	41.8	16.2	<b>3.52</b>
5	Дотоод чанарын баталгаажуулалтын явцад оролцуулах	35.2	45.5	19.3	<b>3.32</b>
6	Ажил олгогч, төгсөгчдөөс бүрдсэн зөвлөх хороо байгуулах	26.3	48.4	25.3	<b>3.02</b>
7	Сургалтын үйл ажиллагаанд оролцуулах	26.5	47.2	26.3	<b>3.00</b>
8	Хичээлийн хөтөлбөрийг шинэчлэхэд оролцуулах	33.7	32.1	34.2	<b>2.99</b>
9	Сургалтын үр дүнгийн үнэлгээ хийхэд оролцуулах	22.7	51.1	26.2	<b>2.93</b>

Дээрх хүснэгтээс харвал, дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтад төгсөгчдийг i) сэтгэл ханамжийн судалгаа авах (4.39), ii) хөтөлбөрийг сайжруулахтай холбоотой санал авах (4.00) зэрэг хэлбэрүүдээр оролцуулах нь маш чухал, харин i) хичээлийн хөтөлбөрийг шинэчлэхэд оролцуулах (2.99), ii) сургалтын үр дүнгийн үнэлгээ хийхэд оролцуулах (2.93) зэргийг чухал бус гэж тус тус үнэлжээ.

Дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтад ажил олгогч болон төгсөгчдийг оролцуулах чухал хэлбэрүүд (дундаж үнэлгээ):

- ✓ Сэтгэл ханамжийн судалгаа авах -4.27,
- ✓ Хөтөлбөрийг сайжруулахтай холбоотой санал авах -4.03,

Харин дотоод чанарын баталгаажуулалтад ажил олгогч болон төгсөгчдийг сургалтын үйл ажиллагаанд оролцуулах (2.94)-ыг чухал бус гэж тодорхойлогдож байна.

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл” суурь судалгааны төслийн тайлан*

Хүснэгт 16.16 ба 16.17-ын үр дүнг нэгтгэн доорх зурагт дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтад ажил олгогч болон төгсөгчдийг оролцуулах хэлбэрүүдийг харуулав.



**Зураг 3.12. Дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтад ажил олгогч ба төгсөгчдийн оролцоо**

**Хүснэгт 3.34. Дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтын өгөөж дээшлүүлэлт, хувиар**

№	Хүчин зүйлс	Маш чухал	Чухал	Чухал биш	Эрэмбэ
1	Чанарын менежментийн тогтолцоонд үзүүлэх удирдлагын дэмжлэг	66.8	33.2	0.0	<b>4.34</b>
2	Чанарын бодлого, зарчим, зорилгын ил тод байдал	60.3	39.2	0.5	<b>4.20</b>
3	Дотоод чанарын баталгаажуулалтын үнэлгээ хийх арга хэрэгслүүдийн шинжлэх ухааны үндэслэл	58.0	41.6	0.5	<b>4.15</b>
4	Үндэсний магадлан итгэмжлэлийн шаардлага	60.0	36.9	3.1	<b>4.14</b>
5	Чанарын менежментийн тогтолцоог төлөвшүүлэх	58.0	41.1	0.9	<b>4.14</b>
6	Дотоод чанарын баталгаажуулалтын арга хэмжээн дэх оролцогч талуудын идэвхтэй оролцоо	56.9	43.1	0.0	<b>4.14</b>

**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**


7	Дотоод чанарын баталгаажуулалтын үнэлгээний аргачлалыг оновчтой сонгох	56.2	43.8	0.0	<b>4.12</b>
8	Дотоод чанарын баталгаажуулалтын нэгжид ажиллах үнэлгээний багийг чадавхжуулж бэлтгэх	56.8	40.6	2.5	<b>4.09</b>
9	Чанарын соёлыг багш, ажилтан бүрд ойлгуулж, оролцуулах	55.8	41.3	2.9	<b>4.06</b>
10	Хөтөлбөрийн чанарын үнэлгээнд гол анхаарлаа хандуулах	55.8	41.3	2.9	<b>4.06</b>
11	Дотоод чанарын баталгаажуулалтын чиглэлээр ажиллах хүний нөөцийг бэлтгэх	57.5	37.2	5.3	<b>4.04</b>
12	Олон улсын магадлан итгэмжлэлийн шаардлага	53.7	42.7	3.6	<b>4.00</b>
13	Дээд боловсролын сургалтын байгууллагын бие даасан байдал	52.9	43.4	3.7	<b>3.98</b>
14	Нотолгоонд суурилсан удирдлагын шийдвэр гаргах соёлыг хэвшүүлэх	51.6	45.1	3.3	<b>3.97</b>
15	Дотоод чанарын баталгаажуулалтын үнэлгээ хийх тогтсон цикл боловсруулах	52.4	43.8	3.9	<b>3.97</b>
16	Удирдлагын мэдээллийн системийг чанарын дотоод баталгаажуулалтын гол хэрэглүүр болгон хөгжүүлэх	50.2	46.5	3.3	<b>3.94</b>
17	Дотоод чанарын баталгаажуулалтын нэгжийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	45.2	49.1	5.7	<b>3.79</b>
18	Дотоод чанарын баталгаажуулалтын ба хөдөлмөр эрхлэлтийн уялдаа холбоог хангах	40.8	53.9	5.3	<b>3.71</b>

Дээрх хүснэгтээс харвал, дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтын өгөөжийг дээшлүүлэх 18 үзүүлэлтээс 12 үзүүлэлтийг маш чухал гэж үнэлсэн ба тухайлбал: i) чанарын менежментийн тогтолцоонд үзүүлэх удирдлагын дэмжлэг (4.34), ii) чанарын бодлого, зарчим, зорилгын ил тод байдал (4.20), iii) дотоод чанарын баталгаажуулалтын үнэлгээ хийх арга хэрэгслүүдийн шинжлэх ухааны үндэслэл (4.20) зэрэг нь хамгийн өндөр үнэлгээтэй байна.

Харин дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтын өгөөжийг дээшлүүлэхэд 6 үзүүлэлт чухал буюу i) удирдлагын мэдээллийн системийг дотоод чанарын баталгаажуулалтын гол хэрэглүүр болгон хөгжүүлэх (3.94), ii) дотоод чанарын баталгаажуулалтын нэгжийн үйл ажиллагааг эрчимжүүлэх (3.79), iii) дотоод чанарын баталгаажуулалтын ба хөдөлмөр эрхлэлтийн уялдаа холбоог хангах (3.79) зэрэг үзүүлэлтүүд хамгийн бага үнэлгээтэй байна.




*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл” суурь судалгааны төслийн тайлан*



**Зураг 3.13. Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэгдсэн байдал, хувиар**

Дээрх зургаас харвал, дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэгдсэн байдлыг судалгаанд оролцогчдын i) 75.8 хувь нь үндэсний хэмжээнд, ii) 22.6 хувь нь олон улсын хэмжээнд, харин 56.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.



**Зураг 3.14. Сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн байдал, хувиар**

Дээрх зургаас харвал, дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн байдлыг судалгаанд оролцогчдын i) 55.9 хувь нь үндэсний хэмжээнд, ii) 35.5 хувь нь олон улсын хэмжээнд, харин 48.8 хувь нь мэдэхгүй гэжээ.

***Хүснэгт 3.35. Дээд боловсролын сургалтын байгууллага магадлан итгэмжлэгдсэн (сургууль, хөтөлбөр)-ээр чанарт гарсан ахиц, хувиар***

Албан тушаал	Чанар сайжирсан	Чанар өөрчлөгдөөгүй	Мэдэхгүй
Захиргааны ажилтан	70.8	9.7	19.4
Профессор багш	60.9	14.1	25.0
<b>Дундаж</b>	<b>66.5</b>	<b>11.6</b>	<b>21.9</b>

Дээрх хүснэгтээс харвал, дээд боловсролын сургалтын байгууллага магадлан итгэмжлэгдсэн (сургууль, хөтөлбөр)-ээр чанарт ахиц гарсан байдлыг судалгаанд оролцогчдын i) 66.5 хувь нь чанар сайжирсан, ii) 21.9 хувь нь мэдэхгүй гэж хариулсан ба үр дүнг нарийвчлан авч үзвэл:

- ✓ Захиргааны ажилтнуудын 70.8 хувь нь чанар сайжирсан, 19.4 хувь нь мэдэхгүй гэсэн бол,
- ✓ Профессор багш нарын 60.9 хувь нь чанар сайжирсан, 25 хувь нь мэдэхгүй гэжээ.

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын төлөвшлийн өнөөгийн байдлын судалгааны гол үр дүнгүүдийг нэгтгэн дүгнэвэл. Үүнд:

- ✓ *Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн тогтолцооны хувьд дээд боловсролын сургалтын байгууллага нэгдсэн чанарын бодлоготой гэж 48.4 хувь (захиргааны ажилтнуудын 63.7%, профессор багш нарын 28.6%), стратеги төлөвлөгөөнд чанарын асуудал тусгагдсан гэж 79.9 хувь (захиргааны ажилтнуудын 89.2%, профессор багш нарын 67.9%), харин сургуулийнхаа чанарын бодлого, зарчим, зорилготой санал нийлдэг гэж 56.5 хувь (захиргааны ажилтнуудын 58.7%, профессор багш нарын 53.6%) ба чанарын бодлого бүрэн нээлттэй гэж 49.6 хувь (захиргааны ажилтнуудын 63.2%, профессор багш нарын 32.1%) хариулжээ.*
- ✓ *Дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтын хувьд:*
  - *Чанарын менежментийн хэлбэрүүд нь i) байнга сайжруулалт (62.5%), ii) хэрэглэгчдэд төвлөрөх (60.8%), iii) хамт олныг татан оролцуулах (56.9%) бол,*
  - *Чанарын баталгаажуулалтад гол оролцогчид нь i) захирал (77.9%), ii) сургалтын албаны дарга (72.1%), iii) дэд захирал (71%) гэжээ,*
  - *Дотоод чанарын баталгаажуулалт нь i) багшлахуй (51.9%), ii) суралцахуй (47.8%), iii) эрдэм судлал (36%) хэлбэрээр түлхүү хэрэгждэг, түүний өгөөжийг дээшлүүлэхэд удирдлагын дэмжлэг чухал (4.34) байна.*

#### **3.4. Дээд боловсрол ба хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтаас 2013 оноос эхлэн жил бүр “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-г зохион байгуулдаг. Уг судалгаа нь төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл дэх өөрчлөлт, ажлын байранд ур чадварын нийцэл зэргийг илрүүлэх зорилгоор хийгддэг<sup>13</sup>.

<sup>13</sup> <http://rilsp.gov.mn/tasudalгаа.php>

**Хүснэгт 3.36. Их, дээд сургуулийн төгсөгчдийн судалгаанд хамрагдалт**

Он	Судалгаанд оролцогчдын тоо	Төгссөн хичээлийн жил
2013	982	2010 - 2011
2014	1262	
2015	660	
2016	982	
2017	2781	2015 – 2016
2018	2781	
2019	2781	

Эх үүсвэр: *rilsp.gov.mn*

Энэхүү судалгаанд 2013 онд дээд боловсролын сургалтын байгууллагыг 2010-2011 оны хичээлийн жилд төгссөн 982 төгсөгчийг түүвэрлэн дөрвөн жил дараалан хамруулжээ. Харин 2017 оноос эхлэн 2015-2016 оны хичээлийн жилд их, дээд сургууль төгссөн 2781 төгсөгчдийг сонгон жил бүр судалгаанд хамруулжээ.

Бид энэхүү судалгааны тайланд тулгуурлан манай улсад дээд боловсролтой хүний нөөцийн хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал, тэдний хөдөлмөр эрхлэлтэд тулгарч буй бэрхшээлтэй асуудлуудад дүн шинжилгээ хийсэн.

**Хүснэгт 3.37.Төгсөгчдийн эдийн засгийн идэвх, хувиар**

№	Эдийн засгийн идэвх	2013	2014	2015	2016	2017	2018	2019
1	Хөдөлмөр эрхлэж буй	63.4	64.0	78.3	64.8	77.2	75.2	79.6
2	Ажилгүй	36.6	36.0	17.8	20.2	3.5	9.2	2.5
3	Эдийн засгийн идэвхгүй	-	-	3.9	15.0	19.3	15.6	17.9
<b>Нийт</b>		<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>

2019 оны байдлаар их, дээд сургуулийн төгсөгчдин эдийн засгийн идэвхийн хувьд 79.6 хувь нь хөдөлмөр эрхэлж, 2.5 хувь нь ажилгүй, 17.9 хувь нь эдийн засгийн идэвхгүй байна.

**Хүснэгт 3.38.Төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн харьцуулалт, хувиар**

№	Эдийн засгийн идэвх	2019 оныг өмнөх онуудтай харьцуулалт			
		2013	2015	2017	2018
1	Хөдөлмөр эрхэлж буй	16.1	1.3	2.4	4.4
2	Ажилгүй	(34.1)	(15.3)	(1.0)	(6.7)
3	Эдийн засгийн идэвхгүй	-	14	(1.8)	2.3

Харин 2019 оны статистик үзүүлэлтийг өмнөх онуудын статистик үзүүлэлтэй харьцуулбал. Үүнд:

**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**

- ✓ Их, дээд сургууль төгсөгчдийн хөдөлмөр эрхэлж буй байдал 2013 онтой харьцуулахад 16.1 хувиар, 2015 онтой харьцуулахад 1.3 хувиар, 2017 онтой харьцуулахад 2.4 хувиар, өмнөх онтой харьцуулахад 4.4 хувиар тус тус өсчээ.
- ✓ Их, дээд сургууль төгсөгчдийн ажилгүйдлийн хувьд 2013 онтой харьцуулахад 34.1 хувиар, 2015 онтой харьцуулахад 15.3 хувиар, 2017 онтой харьцуулахад 1.0 хувиар, өмнөх онтой харьцуулахад 6.7 хувиар тус тус буурчээ.
- ✓ Их, дээд сургууль төгсөгчдийн эдийн засгийн идэвхгүй байдлын хувьд 2015 онтой харьцуулахад 14.0 хувиар өмнөх онтой харьцуулахад 2.3 хувиар тус тус өсчээ. Харин 2017 онтой харьцуулахад 1.8 хувиар буурсан байна.

**Хүснэгт 3.39.Төгсөгчдийн ажлын байрны хэлбэрүүд, хувиар**

№	Ажлын байрны хэлбэр	2013	2014	2015	2016	2017	2018	2019
1	Байнгын	90.0	87.5	79.8	92.5	95.9	88.6	91.5
2	Улирлын чанартай	2.3	2.6	14.0	2.8	2.5	8.1	5.9
3	Түр	7.7	9.9	6.2	4.8	1.6	3.3	2.6
<b>Нийт</b>		<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>

2019 оны байдлаар их, дээд сургуулийн төгсөгчдин ажлын байрны хэлбэрийн хувьд 91.5 хувь нь байнгын, 5.9 хувь улиралын чанартай, 2.6 хувь нь түр ажлын байртай байна.

**Хүснэгт 3.40.Төгсөгчдийн ажлын байрны харьцуулалт, хувиар**

№	Ажлын байрны Хэлбэрүүд	2019 оныг өмнөх онуудтай харьцуулалт			
		2013	2015	2017	2018
1	Байнгын	1.5	11.7	(-4.4)	2.9
2	Улирлын чанартай	3.6	(8.1)	3.4	(2.2)
3	Түр	(5.1)	(3.6)	1.0	(0.7)

Харин 2019 оны статистик үзүүлэлтийг өмнөх онуудын статистик үзүүлэлтэй харьцуулбал. Үүнд:

- ✓ Байнгын ажлын байрны хувьд 2013 онтой харьцуулахад 1.5 хувиар, 2015 онтой харьцуулахад 11.7 хувиар, өмнөх онтой харьцуулахад 2.9 хувиар тус тус өсжээ. Харин 2017 онтой харьцуулахад 4.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- ✓ Улиралын чанартай ажлын байрны хувьд 2013 онтой харьцуулахад 3.6 хувиар, 2017 онтой харьцуулахад 3.4 хувиар тус тус өсч, 2015 онтой

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

харьцуулахад 8.1 хувиар, өмнөх онтой харьцуулахад 2.2 хувиар тус тус буурчээ.

- ✓ Түр ажлын байрны хувьд хувьд 2013 онтой харьцуулахад 5.1 хувиар, 2015 онтой харьцуулахад 3.6 хувиар тус тус буурчээ. Харин 2017 онтой харьцуулахад 1.0 хувиар өсжээ.

***Хүснэгт 3.41.Төгсөгчдийн ажилд ороход нөлөөлсөн хүчин зүйлс, хувиар***

№	Хүчин зүйлс	2013	2014	2015	2016	2017	2018	2019
1	Эзэмшсэн мэргэжил	20.1	19.3	22.1	17.8	19.8	19.3	19.8
2	Хувийн зан чанар	11.0	13.9	13.1	10.5	16.0	17.3	19.5
3	Ярилцлагын ур чадвар	13.1	14.5	10.7	6.5	11.3	11.9	13.0
4	Сурлагын голч дүн	11.9	8.6	12.5	19.5	9.1	12.2	10.8
5	Төгссөн сургууль	13.5	11.2	11.0	8.0	10.1	11.0	10.5
6	Мэргэжил, ур чадварын үнэмлэх	6.1	6.3	6.8	4.3	8.1	8.8	8.4
7	Ажлын дадлага туршлага	3.4	9.9	2.8	1.2	6.7	5.5	9.0
8	Гадаад хэлний мэдлэг, чадвар	7.1	2.7	4.3	4.2	4.3	5.1	4.4

Дээрх хүснэгтэд 2013 – 2019 оны хугацаанд их, дээд сургууль төгсөгчид ажилд ороход нөлөөлдөг найман хүчин зүйлийг харуулав. 2019 оны байдлаар ажилд ороход i) эзэмшсэн мэргэжил (19.8%), ii) хувийн зан чанар (19.5%), iii) ярилцлагын ур чадвар (13%), iv) төгссөн сургууль (10.5%), v) сурлагын голч дүн (10.8%) зэрэг нь хамгийн чухал шалгуур болж байна.

Харин ажилд ороход хувийн зан чанар нь 2013 онд 11.0 хувь байсан бол, 2019 онд 19.5 хувь буюу 8.5 нэгжээр өссөн нь ажил олгогчид шинээр ажил горилогчдын төлөвшлийг чухалчлах болсныг харуулж байна. Мөн ажлын дадлага туршлага нь 2013 онд 3.4 хувь байсан бол 2019 онд 9.0 хувь болж 5.6 нэгжээр өссөн нь шинээр сургууль төгсөгчид ажилд ороход хүндрэлтэй болж байгааг илтгэж байна.

***Хүснэгт 3.42.Төгсөгчдийн мэргэжил ба ажлын байрны нийцэл, хувиар***

№	Үзүүлэлтүүд	2013	2014	2015	2016	2017	2018	2019
1	Огт тохирдоггүй	7.7	7.0	9.3	11.5	13.3	4.9	6.4
2	Тохирдоггүй	33.5	34.5	26.5	21.4	16.9	16.0	11.3
3	Тохиромжтой	40.4	37.3	45.0	51.4	49.7	52.1	66.7
4	Маш тохиромжтой	18.5	21.3	19.2	15.8	20.1	16.9	15.6

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

Дээрх хүснэгтэд 2013 - 2019 оны хугацаанд их, дээд сургууль төгсөгчдийн эзэмшсэн мэргэжил ба ажлын байрны нийцлийн байдлыг харуулав. 2019 оны байдлаар эзэмшсэн мэргэжил ба ажлын байрны нийцлийг тохиромжтой байдал 66.7 хувь байгаа нь 2013 онтой харьцуулахад 23.7 нэгжээр, 2015 онтой харьцуулахад 11.7 нэгжээр, өмнөх онтой харьцуулахад 14.6 нэгжээр тус тус өсжээ.

***Хүснэгт 3.43.Төгсөгчдийн эзэмшсэн ур чадвар ба ажлын байрны шаардлагын нийцэл, хувиар***

№	Үзүүлэлтүүд	2013	2014	2015	2016	2017	2018	2019
1	Доогуур	18.2	9.7	11.9	10.8	16.7	15.6	12.8
2	Тохиромжтой	68.9	81.4	75.5	79.8	70.0	71.1	74.0
3	Өндөр	12.9	8.9	12.6	9.4	14.3	13.3	13.3

Дээрх хүснэгтэд 2013 - 2019 оны хугацаанд их, дээд сургууль төгсөгчдийн эзэмшсэн ур чадвар ба ажлын байрны шаардлагын нийцлийн байдлыг харуулав. 2019 оны байдлаар эзэмшсэн ур чадвар ба ажлын байрны шаардлагатай тохиромжтой байдал нь 74 хувь байгаа нь 2013 онтой харьцуулахад 5.1 нэгжээр өссөн боловч 2015 онтой харьцуулахад 1.5 нэгжээр буурсан, өмнөх онтой харьцуулахад 3.9 нэгжээр өсжээ.

***Хүснэгт 3.44.Төгсөгчдийн суралцах хугацаандаа олж авсан мэдлэгийн хэрэглээ, хувиар***

№	Үзүүлэлтүүд	2017	2018	2019
1	Тус болдог	69.0	71.0	70.5
2	Маш их тус болдог	17.0	13.0	13.8
3	Тус болдоггүй	10.0	12.0	9.6
4	Огт тус болдоггүй	4.0	4.0	6.1

Дээрх хүснэгтэд 2017 - 2019 оны хугацаанд их, дээд сургууль төгсөгчид суралцах хугацаандаа олж авсан мэдлэгийн хэрэглээг харуулав. Суралцах хугацаандаа олж авсан мэдлэг нь ажлын байранд тус бодлог гэж 2017 онд 86 хувь, 2018 онд 84 хувь, 2019 онд 84.3 хувь тус тус байна.

***Хүснэгт 3.45.Төгсөгчдийн ур чадвараа эзэмшсэн байдал, хувиар***

№	Хугацаа	2018	2019
1	Суралцах хугацаандаа	34.0	26.5
2	Ажил дээр гарсны дараа	66.0	73.5

Харин их, дээд сургууль төгсөгчид ур чадвар эзэмшсэн байдлыг ажил дээр гарсны дараа гэж 2018 онд 66 хувь, 2019 онд 73.5 хувь тус тус байна.

**Хүснэгт 3.46.Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт ба мэргэжил, хувиар**

№	Мэргэжлүүд	2013	2014	2015	2017	2018	2019
1	Барилга архетоктор	93.3	80.2	71.9	83.2	91.2	91.2
2	Тээвэр	85.0	74.5	72.0	72.7	85.7	88.6
3	Бүх төрлийн инженер	75.6	78.9	76.7	69.3	83.9	82.8
4	Нийгэм эдийн засаг	84.8	78.9	87.1	71.9	83.5	87.8
5	Компьютер	73.3	72.2	61.9	70.9	81.4	81.7
6	Мал эмнэлэг	75.6	65.9	62.4	69.9	80.5	86.6
7	Хууль эрх зүй	66.7	76.6	82.4	60.7	80.4	85.9
8	Физик, хими	75.6	76.1	78.3	71.5	79.2	88.1
9	Үйлдвэрлэлийн технологи	68.9	50.0	54.4	68.7	78.9	85.6
10	Биологи	68.9	63.0	63.3	67.5	77.5	83.5
11	Биеийн тамир	62.2	70.2	75.5	56.9	76.6	84.1
12	Багш,боловсрол	78.3	82.1	80.3	76.5	75.8	80.3
13	Мэдээлэл сэтгүүл зүй	80.0	62.5	80.9	63.0	75.7	89.5
14	Урлаг	77.8	70.0	63.7	60.7	75.0	82.7
15	Математик статистик	80.0	73.7	71.7	71.8	75.0	87.9
16	Хөдөө аж ахуй, ой	79.5	66.5	86.4	64.0	74.2	83.9
17	Байгаль , хамгаалал	63.6	60.8	66.2	61.9	72.9	78.9
18	Анагаах ухаан	82.2	71.4	63.2	71.3	71.5	74.3
19	Хүмүүнлэгийн ухаан	54.5	59.0	79.2	60.6	67.9	75.8
20	Бизнесийн удирдлага	77.8	67.0	66.9	64.0	67.2	71.9
21	Нийгмийн халамж	68.2	66.7	54.8	51.9	65.0	72.4
	<b>Дундаж</b>	<b>74.8</b>	<b>69.8</b>	<b>71.4</b>	<b>67.1</b>	<b>77.1</b>	<b>83.0</b>

Их, дээд сургууль төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн дундаж түвшин 2019 оны байдлаар 83.0 хувь байгаа нь 2013 онтой харьцуулахад 8.2 нэгжээр, 2015 онтой харьцуулахад 11.6 нэгжээр, 2017 онтой харьцуулахад 15.9 нэгжээр, өмнөх онтой харьцуулахад 5.9 нэгжээр тус тус өсжээ.

**Хүснэгт 3.47.Төгсөгчдийн мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлт, хувиар**

№	Мэргэжлийн чиглэл	2018	2019	Өөрчлөлт
1	Анагаах ухаан	87.5	91.7	4.2
2	Мал эмнэлэг	81.6	87.4	5.8
3	Урлаг	76.7	84.6	7.9


*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

4	Математик статистик	51.0	84.5	33.5
5	Багш,боловсрол судлал	78.4	83.0	4.6
6	Барилга, архитектур	77.2	82.7	5.5
7	Физик,хими, геологи, газарзүй	60.0	79.2	19.2
8	Үйлдвэрлэлийн технологи	65.7	77.9	12.2
9	Бизнесийн удирдлага	72.0	75.6	3.6
10	Хууль эрх зүй	72.0	75.3	3.3
11	Мэдээлэл сэтгүүл зүй	64.1	72.3	8.2
12	Бүх төрлийн инженер	59.1	71.9	12.8
13	Компьютер	54.1	71.8	
14	Тээвэр	68.9	70.5	1.6
15	Биеийн тамир,спорт,зарим	50.5	70.0	19.5
16	Нийгэм,эдийн засаг	58.3	69.8	11.5
17	Биологи	57.0	67.1	10.1
18	Хүмүүнлэгийн ухаан	51.4	66.7	15.3
19	Нийгмийн халамж,хангамж	53.8	61.9	8.1
20	Байгаль хамгаалал	32.6	51.2	0.1
21	Хөдөө аж ахуй, ой загасны аж ахуй	48.4	48.5	18.6
	<b>Дундаж</b>	<b>62.9</b>	<b>73.5</b>	<b>10.6</b>

Дээрх хүснэгтээс харвал их, дээд сургууль төгсөгчдийн мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлтийн дундаж түвшин 2018 онд 62.9 хувь, 2019 онд 73.5 хувь байгаа нь өмнөх оноос 10.6 нэгжээр өсжээ. 2019 оны байдлаар мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлтийн түвшин өндөр (80%-иас дээш) мэргэжил нь: i) Анагаах ухаан (91.7%), ii) Мал эмнэлэг (87.4%), iii) Урлаг (84.6%), iv) Математик статистик (84.5%), v) Багш боловсрол судлал (83.0%), vi) Барилга, архитектур (82.7%) байна. Харин мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлтийн түвшин доогуур (60%-иас доош) нь i) Байгаль хамгаалал (2018 онд 32.6%, 2019 онд 51.2%), ii) Хөдөө аж ахуй, ой загасны аж ахуй (2018 онд 48.4%, 2019 онд 48.5%) байна. Мөн доорх зурагт төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт ба мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлтийг харьцуулав



*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл” суурь судалгааны төслийн тайлан*



**Зураг 3.15. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт ба мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлтийн харьцуулалт, хувиар**

### 3.5. Дээд боловсрол ба ажил олгогчдын үнэлэмжийн судалгаа

Дэлхий дахины хөгжлийн чиг хандлагаас улбаалан хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал хурдацтай өөрчлөгдөж байна. Энэхүү хөгжлийн хандлагаас хамаарч ирээдүйн ажлын байранд шаардлагатай ур чадварыг суралцагчдад олгоход дээд боловсролын сургалтын байгууллагууд ихээхэн анхаарах болжээ. Ер нь дээд боловсролын сургалтын байгууллагууд төгсөгчид нь хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвартай байгаа эсэхийг ажил олгогчдын оролцоотой үнэлэх, улмаар сургалтын чанарын үнэлгээний системээр дамжуулан хэрэгжүүлэхэд ихээхэн анхаарч байна.

Иймээс бид их, дээд сургуулийн төгсөгчдийн ур чадвар нь ажил олгогчдын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодруулах зорилгоор энэхүү судалгааг явууллаа.

**Судалгааны арга зүй:** Асуулга судалгааны түүврийн зохистой хэмжээг сонгохдоо практик түгээмэл ашигладаг, түүвэрлэлтийн үндсэн таамаглал нь эх олонлогийг хэвийн тархалттай гэж үзээд, энгийн зорилтот түүврийн аргачлалаар түүврийн хэмжээг сонгон дараах томъёогоор тооцсон.

$$n = \frac{z^2 p(1-w)N}{e^2 N + z^2 p(1-p)}$$

энд:  $n$  - эх олонлогийг төлөөлөх зохистой түүврийн хэмжээ,  $z=1.96$  - 95 хувийн итгэх түвшин дэх  $t$  статистикийн тархалтын утга,  $p=0.5$  - түүврийн хэмжээг тооцоход ашиглах үндсэн үзүүлэлтийн эх олонлогт эзлэх хувийн жин буюу илрэх магадлал,  $e=0.05$  - түүврийн стандарт алдаа буюу нарийвчлал,  $N=1.53$  сая.хүн - эх олонлогийн хэмжээ буюу 20-60 насны хүн амын тоо.

Судалгааны асуулгын дэс дараалалтай, бөглөхөд хялбар байлгах зарчмыг баримтлан олон хэмжээст үнэлгээний аргыг ашиглаж, тухайн хариултыг сонгох хувийн жин:  $(P'_1:P'_2: \dots P'_n)$ , тэдгээрийн эх олонлогт харгалзах хувийн жин  $(P_1:P_2: \dots)$  нөхцөлийг  $|1-\beta|$  магадлалтай хангаж байх түүврийн зохистой хэмжээг тодорхойлох чухал юм.

$$\{|P_1 - P'_1| \leq e, |P_2 - P'_2| \leq e, \dots |P_n - P'_n| \leq e \}$$

Судалгааны мэдээллийг SPSS статистикийн программ хангамжаар боловсруулж, судалгааны үр дүнг ашиглан чанарын үнэлгээ хийхдээ жигнэсэн дунджийн аргыг ашигласан ба дараах томъёогоор тооцсон.

$$\bar{X} = \frac{\sum_{i=1}^n (X_i \cdot P_i)}{\sum_{i=1}^n (X_i)}$$

энд:  $\bar{X}$ -дундаж хэмжигдэхүүн буюу чанарын оноо,  $P_i$ -үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин,  $X_i$ -тухайн үзэгдлийн давтамж буюу судалгааны үр дүн,

Энэхүү судалгаанд их, дээд сургуулийн төгсөгчдийн ур чадварыг Ликертийн хэмжүүрээр 5 хүртэл шатлал (5-маш сайн, 4-сайн, 3-дунд, 2-муу, 1-маш муу)-аар үнэлсэн.

**Судалгаанд оролцогчдын мэдээлэл:** Судалгаанд аж ахуйн нэгж, байгууллагын захирал, удирдах түвшний менежерүүд болох 300 хүн хамрагдсанаас 20 хүн буюу 6.61 хувь нь 1-5 хүнтэй, 35 хүн буюу 11.8 хувь нь 6-19 хүнтэй, 46 хүн буюу 15.3 хувь нь 20-49 хүнтэй, 64 хүн буюу 21.2 хувь нь 50-149 хүнтэй, үлдсэн 136 хүн буюу 45.2 хувь нь 150-аас дээш ажилтантай аж ахуйн нэгжид тус тус ажилладаг байна. Судалгааны түүвэрлэлтийг аж ахуйн нэгжийн ажиллагчдын тоонд тулгуурлан 5 интервалд багцалж доорх хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 3.48. Судалгаанд хамрагдагчдын байдал*

№	Ажиллагчдын тооны интервал	ААНБ-ийн эзлэх хувь	Ажиллагчдын тоо, мян.хүн	Дүнд эзлэх хувь	Түүврийн хэмжээ
1	1 - 5	71.4	35.9	6.6	20
2	6 - 19	16.0	64.4	11.8	35
3	20 - 49	7.6	83.5	15.3	46
4	50 - 149	3.6	115.7	21.2	64
5	150+	1.3	246.9	45.2	136
	<b>Нийт</b>	<b>100</b>	<b>546.4</b>	<b>100</b>	<b>300</b>

**Төгсөгчдийн ерөнхий ур чадварын үнэлгээ:** Их, дээд сургууль төгсөгчдийн ерөнхий ур чадварыг 15 үзүүлэлтээр i) ажил олгогчдын хүсэж буй ур чадварын түвшин, ii) төгсөгчдийн өнөөгийн ур чадварын түвшин гэсэн байдлаар үнэлж, үр дүнг зурагт харуулав.

**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл” суурь судалгааны төслийн тайлан**



—●— Ажил олгогчдийн хүсэж буй ур чадварын түвшин —●— Төгсөгчдийн өнөөгийн ур чадварын үнэлгээ

**Тайлбар:** 5-маш сайн, 4-хангалттай, 3-дундаж, 2-хангалтгүй, 1-маш муу

**Зураг 3.16. Дээд боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийн ерөнхий ур чадварын үнэлгээ**

Дээрх зургаас харвал, ажил олгогчдын хүсэж буй ур чадварын түвшнийг 4.13-4.97 байх шаардлагатай гэж тодорхойлжээ. Харин их, дээд сургууль төгсөгчдийн ерөнхий ур чадварын өнөөгийн түвшнийг гадаад хэлний мэдлэг (2.43), бүтээлч хандлага, сэтгэлгээ (2.88) зэргийн хувьд хангалтгүй, харин бусад ур чадваруудын хувьд дундаж буюу 3.16-3.97 байдаг гэж үнэлсэн байна.

Их, дээд сургууль төгсөгчдийн ур чадварт зөрүүний шинжилгээг ажил олгогчдын хүсэж буй ур чадвар болон төгсөгчдийн өнөөгийн ур чадварын үнэлгээний үр дүнд тулгуурлан хийвэл:

- 1-5 ажиллагчидтай аж ахуйн нэгжүүдийн хувьд бие даан ажиллах (1.51), бүтээлч хандлага, сэтгэлгээ (1.45), цаг төлөвлөх, баримтлах (1.45) зэрэг ур чадваруудын хувьд зөрүү хамгийн их, харин гадаад хэлний мэдлэг хангалтгүй (2.86) гэж,
- 6-19 ажиллагчидтай аж ахуйн нэгжүүдийн хувьд бүтээлч хандлага, сэтгэлгээ (1.89), цаг гадаад хэлний мэдлэг (1.60), манлайлах (1.14) зэрэг ур чадваруудын хувьд зөрүү хамгийн их, харин бүтээлч хандлага,

сэтгэлгээ (2.00), гадаад хэлний мэдлэг (2.09), албан бичиг боловсруулах (2.77) зэргийг хангалтгүй гэж,


- 20-49 ажиллагчидтай аж ахуйн нэгжүүдийн хувьд манлайлах (2.12), бүтээлч хандлага, сэтгэлгээ (1.70), компьютер дээр ажиллах (1.54) зэрэг ур чадваруудын хувьд зөрүү хамгийн их, харин манлайлах (2.31), гадаад хэлний мэдлэг (2.31), асуудалд хариуцлагатай хандах (2.83), албан бичиг боловсруулах (2.87) зэргийг хангалтгүй гэж,
- 50-149 ажиллагчидтай аж ахуйн нэгжүүдийн хувьд асуудалд хариуцлагатай хандах (2.57), цаг төлөвлөх, баримтлах (2.16), бүтээлч хандлага, сэтгэлгээ (2.14) зэрэг ур чадваруудын хувьд зөрүү хамгийн их, харин бүтээлч хандлага, сэтгэлгээ (2.86), цаг төлөвлөх, баримтлах (2.84), асуудалд хариуцлагатай хандах (2.43), гадаад хэлний мэдлэг (2.38) зэргийг хангалтгүй гэж,
- 150-аас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгжүүдийн хувьд гадаад хэлний мэдлэг (1.91), манлайлах (1.56), онолын мэдлэгийн түвшин (1.45) зэрэг ур чадваруудын хувьд зөрүү хамгийн их, харин онолын мэдлэгийн түвшин (2.88), гадаад хэлний мэдлэг (2.50) зэргийг хангалтгүй гэж тус тус үнэлэгджээ.

Судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэвэл, аж ахуйн нэгжүүдийн хувьд гадаад хэлний мэдлэг (1.70), бүтээлч хандлага, сэтгэлгээ (1.64), манлайлах (1.41) зэрэг ур чадваруудын хувьд зөрүү хамгийн их, харин гадаад хэлний мэдлэг (2.43), бүтээлч хандлага, сэтгэлгээ (2.88) зэргийг хангалтгүй гэж үнэлжээ.

Их, дээд сургууль төгсөгчдийн ур чадварыг 15 үзүүлэлтээр үнэлж, үр дүнг аж ахуйн нэгжийн ажиллагчдын тоонд тулгуурлан 5 интервалд багцалж, үр дүнг дараах байдлаар нэгтгэн харуулав. Үүнд:

- i) их, дээд сургууль төгсөгчдийн ерөнхий ур чадварын нэгдсэн үнэлгээг хүснэгтээр (хүснэгт 18.2),
- ii) их, дээд сургууль төгсөгчдийн ерөнхий ур чадварын зөрүүний шинжилгээг зургаар (зураг 18.2),

**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**



**Зураг 3.17. Дээд боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийн ерөнхий ур чадварын зөрүүний шинжилгээ**

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

**Хүснэгт 3.49. Дээд боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийн ерөнхий ур чадварын нэгдсэн үнэлгээ**

№	Ур чадварууд	Ур чадварын үнэлгээ ба ажиллагчдын тоо															Нэгдсэн үнэлгээ		
		1-5			6-19			20-49			50-149			150+			Ажил олгогч	Төгсөгч	Зөрүү
		Ажил олгогч	Төгсөгч	Зөрүү	Ажил олгогч	Төгсөгч	Зөрүү	Ажил олгогч	Төгсөгч	Зөрүү	Ажил олгогч	Төгсөгч	Зөрүү	Ажил олгогч	Төгсөгч	Зөрүү			
1	Мэргэжлийн ур чадвар	4.77	3.98	0.79	4.93	3.88	1.05	4.86	4.69	0.17	5.00	3.14	1.86	5.00	3.86	1.14	<b>4.97</b>	<b>3.86</b>	<b>1.11</b>
2	Багаар ажиллах	4.00	3.57	0.43	4.11	3.38	0.73	4.33	4.25	0.08	4.49	3.74	0.75	5.00	3.75	1.25	<b>4.63</b>	<b>3.78</b>	<b>0.85</b>
3	Манлайлах	4.00	3.29	0.71	<b>4.52</b>	<b>3.38</b>	<b>1.14</b>	<b>4.43</b>	<b>2.31</b>	<b>2.12</b>	4.43	3.51	0.92	<b>4.81</b>	<b>3.25</b>	<b>1.56</b>	<b>4.60</b>	<b>3.19</b>	<b>1.41</b>
4	Асуудалд хариуцлагатай хандах	4.49	3.74	0.75	4.38	3.28	1.10	3.85	3.83	0.02	<b>5.00</b>	<b>2.43</b>	<b>2.57</b>	4.56	4.00	0.56	<b>4.53</b>	<b>3.55</b>	<b>0.98</b>
5	Бүтээлч хандлага, сэтгэлгээ	<b>4.71</b>	<b>3.26</b>	<b>1.45</b>	<b>3.89</b>	<b>2.00</b>	<b>1.89</b>	<b>4.70</b>	<b>3.00</b>	<b>1.70</b>	<b>5.00</b>	<b>2.86</b>	<b>2.14</b>	4.33	3.00	1.33	<b>4.52</b>	<b>2.88</b>	<b>1.64</b>
6	Компьютер дээр ажиллах	4.00	3.29	0.71	4.21	3.56	0.65	<b>4.74</b>	<b>3.20</b>	<b>1.54</b>	4.54	4.43	0.11	4.51	3.38	1.13	<b>4.50</b>	<b>3.60</b>	<b>0.90</b>
7	Интернэт орчинд ажиллах	4.00	3.29	0.71	3.91	3.90	0.01	4.00	3.66	0.34	4.85	4.43	0.42	4.66	3.56	1.10	<b>4.48</b>	<b>3.79</b>	<b>0.69</b>
8	Харилцааны соёл	4.00	3.00	1.00	4.32	3.55	0.77	4.86	3.85	1.01	4.54	3.92	0.62	4.33	4.25	0.08	<b>4.45</b>	<b>3.97</b>	<b>0.48</b>
9	Ёс зүйн төлөвшил	4.54	3.64	0.90	4.00	3.67	0.33	4.07	3.92	0.15	4.71	2.86	1.85	4.52	3.75	0.77	<b>4.45</b>	<b>3.58</b>	<b>0.87</b>

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

10	Цаг төлөвлөх, баримтлах	4.71	3.26	1.45	4.52	3.84	0.68	4.31	3.77	0.54	5.00	2.84	2.16	4.11	3.63	0.48	4.43	3.49	0.94
11	Бие даан ажиллах	4.75	3.24	1.51	4.59	3.63	0.96	4.23	3.54	0.69	5.00	4.71	0.29	4.11	2.86	1.25	4.43	3.48	0.95
12	Техник хэрэгсэл ашиглах	4.00	3.00	1.00	4.38	3.84	0.54	3.82	3.80	0.02	4.38	4.29	0.09	4.71	3.69	1.02	4.43	3.82	0.61
13	Албан бичиг боловсруулах	4.71	3.90	0.81	3.86	2.77	1.09	3.69	2.87	0.82	4.38	3.03	1.35	4.66	3.28	1.38	4.38	3.16	1.22
14	Онолын мэдлэгийн түвшин	3.90	3.57	0.33	4.48	3.66	0.82	4.14	4.00	0.14	4.31	3.49	0.82	4.33	2.88	1.45	4.30	3.33	0.97
15	Гадаад хэлний мэдлэг	4.00	2.86	1.14	3.69	2.09	1.60	3.57	2.31	1.26	4.14	2.38	1.76	4.41	2.50	1.91	4.13	2.43	1.70
	<b>Дундаж үзүүлэлт</b>	<b>4.31</b>	<b>3.39</b>	<b>0.92</b>	<b>4.25</b>	<b>3.36</b>	<b>0.89</b>	<b>4.24</b>	<b>3.53</b>	<b>0.71</b>	<b>4.65</b>	<b>3.47</b>	<b>1.18</b>	<b>4.54</b>	<b>3.44</b>	<b>1.09</b>	<b>4.48</b>	<b>3.46</b>	<b>1.02</b>

*Тайлбар: 5-маш сайн, 4-хангалттай, 3-дундаж, 2-хангалтгүй, 1-маш муу*



**Чадварлаг хүний нөөц бэлтгэх чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэх:** Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын хувьд байгууллагад шаардлагатай ур чадвар бүхий хүний нөөцийг бэлтгэн авах зорилгоор их, дээд сургуулиудтай хамтран ажиллах боломжийг нээлттэй байдлаар асуухад i) хамтарсан төсөл хэрэгжүүлэх гэж 55.2%, ii) оюутан дадлагажуулах хөтөлбөр хэрэгжүүлэх гэж 51.4 хувь, оюутнуудыг дадлагажуулж ажилд авах гэж 37.8 хувь, iv) сургалтын лаборатори, түшиц газар болох гэж 34.8 хувь нь тус тус тодорхойлжээ. Судалгааны үр дүнг нэгтгэн зурагт харуулав.



**Зураг 3.18. Аж ахуйн нэгжүүд их, дээд сургуулиудтай хамтран ажиллах боломж, хувиар**

“Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл” сэдэвт суурь судалгааны хүрээнд их, дээд сургууль төгсөгчдийн ур чадварын төлөв байдлыг тогтоох зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагын захирал, удирдах түвшний менежерүүд болох 300 хүнийг хамруулан судалгаа явууллаа.

Судалгааны үр дүнгээс ажил олгогчдын хүсэж буй ур чадварын түвшин 4.13-4.97 байгаа бол их, дээд сургууль төгсөгчдийн ерөнхий ур чадварын өнөөгийн түвшнийг гадаад хэлний мэдлэг (2.43), бүтээлч хандлага, сэтгэлгээ (2.88) зэргийн хувьд хангалтгүй, харин бусад ур чадваруудын хувьд дундаж буюу 3.16-3.97 байдаг гэжээ.

Харин аж ахуйн нэгжүүдийн хувьд гадаад хэлний мэдлэг (1.70), бүтээлч хандлага, сэтгэлгээ (1.64), манлайлах (1.41) зэрэг ур чадваруудын хувьд зөрүү

хамгийн их, харин гадаад хэлний мэдлэг (2.43), бүтээлч хандлага, сэтгэлгээ (2.88) зэргийг хангалтгүй гэж үнэлжээ.

XXI зууны ажлын байр болон шинэ, хуучин мэргэжлийн чиглэл, хандлагыг судлан ирээдүйн мэргэжлийн тэргүүлэх чиглэл, Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай ажил, мэргэжлийн жагсаалт, мэргэжилтний хэрэгцээг тодорхойлж, дээд боловсролын сургалтын байгууллагуудын хэрэгжүүлж байгаа бүх шатны сургалтын хөтөлбөрт үнэлгээ, дүн шинжилгээ хийж, боловсруулалтын түвшнийг үнэлэх шаардлагатай байна.

Улмаар төгсөгчдийнхөө эзэмшсэн байх чадварыг ерөнхий болон салбарын онцлогийг тусган тодорхойлох байдлаар төгсөгчдийн ахисан түвшний болон богино хугацааны сертификатын сургалтад хамрагдан мэдлэг, мэргэжил тасралтгүй дээшлүүлэх насан туршийн сургалтын тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэх нь чухал юм.

Сургууль төгсөгчдийн холбоо, ажил олгогч, төгсөгчдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, эргэх холбоог сайжруулах ажлыг зохион байгуулах, төгсөгчдийн сургуулийн хөгжлийн асуудалд хувь нэмрээ оруулах хүсэл, сонирхлыг өрнүүлэх ажил зохион байгуулахад анхаарах хандуулах шаардлага бий болжээ.

### **3.6. Дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн хандлагын судалгаа**

Дэлхий дахинд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвартай мэргэжилтэн бэлтгэхийн тулд дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээ болон чанарын баталгаажуулалтыг үр дүнд суурилсан боловсролын тогтолцоо руу шилжүүлж байна. Үр дүнд суурилсан боловсрол нь суралцагчид мэдлэг, чадвар, хандлага олж авахын төлөөх тэдний суралцах үйл ажиллагааг дэмжих тасралтгүй үйл явц юм.

Манай улсын хувьд дэлхий дахинд гарч буй өөрчлөлт, хөгжлийн чиг хандлагатай уялдуулан дээд боловсролын сургалтын системдээ багш төвтэй сургалтаас суралцагч төвтэй сургалтад шилжих, сургалтын үр дүнгийн чанарын баталгаажуулалтыг олон улсын аргачлалаар өөрийн орны онцлогтой уялдуулан хэрэгжүүлэх нийгмийн шаардлага бий болжээ. Ер нь дээд

боловсролын сургалтын байгууллагууд хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, шаардлагатай уялдуулсан байдлаар сургалтын чанарын үнэлгээний системийг төлөвшүүлэх, улмаар дотоод чанарын баталгаажуулалт нь төгсөгчдийн ур чадварыг дээшлүүлэхэд хэрхэн түлхэц болох зэрэг олон асуудалтай тулгарч байна.

Иймээс бид их, дээд сургуулийн сургалтын чанарын үнэлгээ хийхэд анхаарах асуудлыг тодруулах зорилгоор их, дээд сургууль төгсөгчдийн санаа бодлыг тандан судалсан юм.

**Судалгааны арга зүй:** Асуулга судалгааны түүврийн зохистой хэмжээг сонгохдоо практик түгээмэл ашигладаг, түүвэрлэлтийн үндсэн таамаглал нь эх олонлогийг хэвийн тархалттай гэж үзэх, энгийн зорилтот түүврийн аргачлалаар түүврийн хэмжээг сонгож, дараах томъёогоор тооцсон.

$$n = \frac{z^2 p(1-p)N}{e^2 N + z^2 p(1-p)}$$

Энд:  $n$  - эх олонлогийг төлөөлөх зохистой түүврийн хэмжээ,  $z=1.96$  - 95 хувийн итгэх түвшин дэх  $t$  статистикийн тархалтын утга,  $p=0.5$  - түүврийн хэмжээг тооцоход ашиглах үндсэн үзүүлэлтийн эх олонлогт эзлэх хувийн жин буюу илрэх магадлал,  $e=0.05$  - түүврийн стандарт алдаа буюу нарийвчлал,  $N=1.53$  сая.хүн - эх олонлогийн хэмжээ буюу 20-60 насны хүн амын тоо.

Судалгааны асуулгын дэс дараалалтай, бөглөхөд хялбар байлгах зарчмыг баримтлан олон хэмжээст үнэлгээний аргыг ашиглаж, тухайн хариултыг сонгох хувийн жин:  $(P'_1:P'_2: \dots P'_n)$ , тэдгээрийн эх олонлогт харгалзах хувийн жин  $(P_1:P_2: \dots)$  нөхцөлийг  $1-\beta$  магадлалтай хангаж байх түүврийн зохистой хэмжээг тодорхойлох чухал юм.

$$\{|P_1 - P'_1| \leq e, |P_2 - P'_2| \leq e, \dots |P_n - P'_n| \leq e\}$$

Судалгааны мэдээллийг SPSS статистикийн программ хангамжаар боловсруулж, судалгааны үр дүнг ашиглан чанарын үнэлгээ хийхдээ жигнэсэн дунджийн аргыг ашигласан ба дараах томъёогоор тооцно.

$$\bar{X} = \frac{\sum_{i=1}^n (X_i \cdot P_i)}{\sum_{i=1}^n (X_i)}$$


энд:  $\bar{X}$ -дундаж хэмжигдэхүүн буюу чанарын оноо,  $P_i$ -үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин,  $X_i$ -тухайн үзэгдлийн давтамж буюу судалгааны үр дүн,

**Судалгаанд оролцогчдын мэдээлэл:** Судалгаанд нийт 962 их, дээд сургууль төгсөгч хамрагдсанаас 588 буюу 61.1 хувь нь бакалавр, 318 буюу 33.1 хувь нь магистр, 56 буюу 5.8 хувь нь докторын боловсролтой байна. Судалгаанд оролцогчдыг боловсролын зэрэг болон эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр үндсэн 6 чиглэлд багцалж доорх хүснэгтээр харуулав.

**Хүснэгт 3.50. Судалгаанд хамрагдагчдын боловсролын байдал**

Боловсролын зэрэг		Бакалавр	Магистр	Доктор	Нийт	
					Тоо	Хувь
Нийгэм, хүмүүнлэг	Тоо	114	67	13	194	20.2
	Хувь	58.8	34.5	6.7	100	
Анагаах ухаан		87	51	5	143	14.9
Инженер, технологи		102	56	7	165	17.2
Хөдөө аж ахуй		93	49	10	152	15.8
Батлан хамгаалах		91	48	8	147	15.3
Байгалийн ухаан		101	47	13	161	16.7
Нийт	Тоо	588	318	56	962	100
	Хувь	61.1	33.1	5.8	100	-


Дээрх хүснэгтээс харвал, эзэмшсэн мэргэжлийн чиглэлийн хувьд ангаах ухаан гэж 14.9 хувь (143), инженер технологи гэж 17.2 хувь (165), хөдөө аж ахуй гэж 15.8 хувь (152), батлан хамгаалах гэж 15.3 хувь (147), байгалийн ухаан гэж 16.7 хувь (161), нийгэм, хүмүүнлэг гэж 20.2 хувь (194) гэж хариулжээ. Нийгэм, хүмүүнлэгийн чиглэлээр мэргэжил эзэмшсэн 194 хүн судалгаанд хамрагдсанаас 114 нь бакалавр (58.8%), 67 нь магистр (34.5%), 13 нь доктор (6.7%)-ын боловсролтой байна.



**Зураг 3.19. Судалгаанд хамрагдагчдын их, дээд сургууль төгсөгчдийн тоо**

Дээрх зургаас харвал, судалгаанд оролцогчдын 13.2 хувь буюу 127 хүн нь 1989 оноос өмнө, 19.5 хувь буюу 188 хүн нь 1990-1999 онд, 30.2 хувь буюу 291 хүн нь 2000-2009 онд, 37 хувь буюу 356 хүн нь 2010 оноос хойш тус тус их, дээд сургуулийг дүүргэсэн байна.

**Их, дээд сургууль төгсөгчдийн хандлага:** Судалгаагаар их, дээд сургууль төгсөгчдийн мэдлэг, чадвар нь ажил олгогчдын хэрэгцээ, шаардлагыг хэрхэн хангаж байгаа, улмаар хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадварт түлхэц болж чадаж буй эсэхийг судлан тодруулах зорилгоор хийгдэж, үр дүнг харуулж байна.



**Зураг 3.20. Их, дээд сургууль төгсөгчдийн чадамжийн өөрийн үнэлгээ**

Судалгаанд оролцогчид өөрсдийн чадамжийг онолын мэдлэг болон мэргэжлийн ур чадвар гэсэн байдлаар үнэлсэн үнэлгээний үр дүнг зураг болон хүснэгтээр харуулав.

**Хүснэгт 3.51. Их, дээд сургууль төгсөгчдийн чадамжийн өөрийн үнэлгээ, хувиар**

Төгсөлт		1989 оноос өмнөх	1990-1999 он	2000-2009 он	2010 оноос хойш	Нийт
Мэргэжлийн ур чадвар	Сайн	92.3	73.9	70.9	81.2	<b>79.6</b>
	Дунд	7.8	22.9	29.2	18.9	<b>19.7</b>
	Муу	0	1.7	0	0	<b>0.4</b>
	<b>Чанар</b>	<b>4.9</b>	<b>4.5</b>	<b>4.4</b>	<b>4.6</b>	<b>4.6</b>
Онолын мэдлэг	Сайн	79.8	73.7	60.7	78.9	<b>73.3</b>
	Дунд	20.2	12.2	23.4	21.1	<b>19.2</b>

**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**

	Муу	0	1.7	3.4	0	1.3
	<b>Чанар</b>	<b>4.6</b>	<b>4.1</b>	<b>3.8</b>	<b>4.6</b>	<b>4.3</b>
Ерөнхий үнэлгээ		<b>4.75</b>	<b>4.3</b>	<b>4.1</b>	<b>4.6</b>	<b>4.45</b>
		<b>A</b>	<b>B</b>	<b>B</b>	<b>A</b>	<b>B</b>

**Тайлбар:** *A-маш сайн, B-хангалттай, C-дундаж, D-хангалтгүй, F-маш муу*

Судалгааны үр дүнгээс харвал, 1989 оноос өмнө төгсөгчид дунджаар 4.75 гэж үнэлсэн нь хамгийн өндөр, 1990-1990 оны төгсөгчид дунджаар 4.3, 2000-2009 оны төгсөгчид дунджаар 4.1 гэж үнэлсэн нь хамгийн бага байна. Харин 2010 оноос хойш төгсөгчид дунджаар 4.6 гэж үнэлсэн өмнөх 2 үетэй харьцуулахад өсжээ (0.3-0.5 нэгж). Судалгаанд оролцогчид мэргэжлийн ур чадвараа (4.6) онолын мэдлэг (4.45)-ээс харьцангуй сайн (0.15) гэжээ.

Судалгаанд оролцогчдоос байгууллагад ажиллахад албан тушаал, мэргэжлээс үл хамаарсан зайлшгүй шаардлагатай байдаг нийтлэг ур чадваруудыг тодруулах зорилгоор Лакертийн аргачлалаар 5 хүртэлх оноогоор үнэлж, үр дүнг хүснэгтээр харуулав.

Ажил хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай нийтлэг ур чадваруудаас маш чухал гэж i) харилцааны соёл -4.7 \ хамгийн өндөр үнэлгээтэй\, ii) цаг төлөвлөх, баримтлах -4.6, iii) асуудалд хариуцлагатай байх -4.5, iv) багаар ажиллах -4.4, v) бүтээлч хандлага, сэтгэлгээ -4.4 гэжээ (хүснэгт 19.3).

Судалгаанд оролцогчдын тодорхойлсноор мэргэжлийн чиглэлтэй уялдуулан ажил хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай ерөнхий ур чадварыг харьцуулбал (хүснэгт 19.4). Үүнд:

- ✓ **Байгалийн ухаан:** нийтлэг 13 ур чадвараас 11 ур чадварыг маш чухал гэсэн ба i) ёс зүйн төлөвшил (4.8), ii) манлайлах (4.7), iii) багаар ажиллах (4.6), iv) бүтээлч хандлага, сэтгэлгээ (4.6) зэрэг нь хамгийн өндөр үнэлгээтэй байна.
- ✓ **Инженер, технологи:** нийтлэг 13 ур чадвараас 9 ур чадварыг маш чухал гэсэн ба i) харилцааны соёл (4.5), ii) бүтээлч хандлага, сэтгэлгээ (4.5), iii) бие даан ажиллах (4.5), iv) цаг төлөвлөх, баримтлах (4.5) зэрэг нь хамгийн өндөр үнэлгээтэй байна.
- ✓ **Хөдөө аж ахуй:** нийтлэг 13 ур чадвараас 8 ур чадварыг маш чухал гэсэн ба i) цаг төлөвлөх, баримтлах (4.8), ii) бүтээлч хандлага, сэтгэлгээ (4.8),

iii) бие даан ажиллах (4.7), iv) ёс зүйн төлөвшил (4.7) зэрэг нь хамгийн өндөр үнэлгээтэй байна.

- ✓ Анагаах ухаан: нийтлэг 13 ур чадвараас 11 ур чадварыг маш чухал гэсэн ба i) цаг төлөвлөх, баримтлах (4.7), ii) асуудалд хариуцлагатай байх (4.7), iii) харилцааны соёл (4.5) зэрэг нь хамгийн өндөр үнэлгээтэй байна.
- ✓ Батлан хамгаалах: 13 ур чадвараас 10 ур чадварыг маш чухал гэсэн ба i) асуудалд хариуцлагатай байх (4.9), ii) бүтээлч хандлага, сэтгэлгээ (4.9), iii) цаг төлөвлөх, баримтлах (4.8), iv) ёс зүйн төлөвшил (4.8) зэрэг нь хамгийн өндөр үнэлгээтэй байна.
- ✓ Нийгэм, хүмүүнлэг: 13 ур чадварыг маш чухал гэсэн ба i) цаг төлөвлөх, баримтлах (4.7), ii) асуудалд хариуцлагатай байх (4.6), iii) бүтээлч хандлага, сэтгэлгээ (4.5), iv) багаар ажиллах (4.5) зэрэг нь хамгийн өндөр үнэлгээтэй байна.

Улмаар судалгаанд оролцогчдоос ирээдүйд ажил хөдөлмөр эрхлэхэд их, дээд сургуульд суралцагчдад зайлшгүй эзэмшүүлэх шаардлагатай нийтлэг ур чадварыг тодорхойлох зорилгоор нээлттэй санал авахад 12 чиглэлээр 2558 санал ирүүлсэн. Эдгээр саналуудыг нэгтгэхэд хамгийн олон давтамжтайг дурдвал (хүснэгт 19.5). Үүнд:

- ✓ Мэргэжлийн ур чадвар гэж 648 санал буюу 67.4 хувь,
- ✓ Харилцааны англи хэл гэж 383 санал буюу 39.8 хувь,
- ✓ Логик, системийн сэтгэлгээ гэж 280 санал буюу 29.1%,
- ✓ Бүтээлч сэтгэлгээ, шинийг санаачлагч гэж 187 санал буюу 19.4 хувь,
- ✓ Манлайлал, багаар ажиллах гэж 184 санал буюу 19.1 хувь нь тус тус байна.

Их, дээд сургуулиуд хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэхийн тулд анхаарах асуудлыг үндсэн 9 чиглэлээр 2217 санал дэвшүүлснээс хамгийн олон давтамжтай саналуудыг дурдвал (хүснэгт 19.6). Тухайлбал:

- ✓ Сургалтын хөтөлбөр, зохион байгуулалтыг шинэчлэх гэж 412 санал буюу 42.8 хувь,

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

- ✓ Багш нарын хичээл заах арга зүй, оюутантай ажиллах арга барилыг өөрчлөх гэж 287 санал буюу 29.8 хувь,
- ✓ Гадаад хэлээр мэргэжлийн хичээл заадаг болох гэж 276 санал буюу 28.7 хувь,
- ✓ Оюутнуудыг практикт дадлагажуулах боломжийг бүрдүүлэх гэж 263 санал буюу 27.3 хувь,
- ✓ Оюутнуудыг төлөвшүүлэхэд чиглэсэн чөлөөт цагийн орчин нөхцөлийг бүрдүүлэх гэж 245 санал буюу 25.5 хувь нь гэжээ.

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэлийг тодорхойлохдоо сургалтын үйл ажиллагаанд оролцогч талуудын санал бодлыг судлах, улмаар тэдний оролцоог хангах анхаарах шаардлагатай юм. Иймээс энэ хүрээнд ажил олгогч, профессор багш нар, суралцагч оюутнууд, төгсөгчид, бодлого боловсруулагчид, элсэгчид болон тэдний эцэг эхчүүдийн санаа бодлыг тандан судлах судалгааг системтэй тогтмол зохион байгуулах нь чухал байна.

ЮНЕСКО-оос нийгэм, эдийн засгийн хөгжлийн бүхий хүрээнд дээд боловсролын гүйцэтгэх үүргүүдийг дараах байдлаар тодорхойлжээ. Тухайлбал:

- ✓ Оюутныг судалгаа хийх, багшлахад бэлтгэх,
- ✓ Эдийн засаг, нийгмийн хэрэгцээнд нийцүүлэн өндөр түвшний, тусгайлсан сургалтыг явуулах,
- ✓ Бүгдэд нээлттэй байх, илүү өргөн агуулгаар насан туршийн боловсролын олон талт мэдээллээр хангах,
- ✓ Судалгааны ажил, технологи, сүлжээ, хүмүүсийн чөлөөт урсгал, шинжлэх ухааны үзэл санаа зэргээр дамжуулан олон улсын хамтын ажиллагааг дэмжих,



*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

**Хүснэгт 3.52.Ажил хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай нийтлэг ур чадварууд**

№	Төгсөлт	Албан бичиг боловсруулах	Гадаад хэлний мэдлэг	Компьютер дээр ажиллах	Интернэт орчинд ажиллах	Ёс зүйн төлөвшил	Харилцааны соёл	Багаар ажиллах	Манлайлах	Бие даан ажиллах	Асуудалд хариуцлагатай	Бүтээлч хандлага, сэтгэлгээ	Техник хэрэгсэл ашиглах	Цаг төлөвлөх, баримтлах
1	1989 оноос өмнөх	4.6	<b>3.8</b>	<b>4.9</b>	4.0	4.2	<b>4.9</b>	<b>4.7</b>	4.4	4.2	4.4	4.4	4.3	4.5
		A	<b>B</b>	<b>A</b>	A	A	<b>A</b>	<b>A</b>	A	A	A	A	A	A
2	1990-1999 он	<b>4.6</b>	<b>3.9</b>	4.1	4.3	4.4	<b>5.0</b>	<b>3.9</b>	4.0	<b>3.7</b>	4.2	4.5	<b>3.8</b>	<b>4.7</b>
		<b>A</b>	<b>B</b>	A	A	A	<b>A</b>	<b>B</b>	A	<b>B</b>	A	A	<b>B</b>	<b>A</b>
3	2000-2009 он	4.2	4.2	4.3	4.0	4.2	<b>4.7</b>	<b>4.6</b>	<b>3.9</b>	4.4	4.5	4.5	4.0	<b>4.8</b>
		A	A	A	A	A	<b>A</b>	<b>A</b>	<b>B</b>	A	A	A	A	<b>A</b>
4	2010 оноос хойш	4.2	4.2	4.2	<b>3.7</b>	4.3	<b>4.5</b>	4.4	4.0	4.2	<b>4.6</b>	4.3	<b>3.8</b>	<b>4.5</b>
		A	A	A	<b>B</b>	A	<b>A</b>	A	A	A	<b>A</b>	A	<b>B</b>	<b>A</b>
5	<b>Дундаж</b>	<b>4.3</b>	<b>4.1</b>	<b>4.3</b>	<b>3.9</b>	<b>4.3</b>	<b>4.7</b>	<b>4.4</b>	<b>4.0</b>	<b>4.2</b>	<b>4.5</b>	<b>4.4</b>	<b>3.9</b>	<b>4.6</b>
		<b>A</b>	<b>A</b>	<b>A</b>	<b>B</b>	<b>A</b>	<b>A</b>	<b>A</b>	<b>A</b>	<b>A</b>	<b>A</b>	<b>A</b>	<b>B</b>	<b>A</b>

**Тайлбар:** A-маш чухал, B- чухал, C-чухал биш

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

**Хүснэгт 3.53. Ажил хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай нийтлэг ур чадвар ба мэргэжлийн чиглэл**

№	Мэргэжлийн үндсэн чиглэлүүд	Албан бичиг боловсруулах	Интернэт орчинд ажиллах	Компьютер дээр ажиллах	Гадаад хэлний мэдлэг	Техник хэрэгсэл ашиглах	Манлайлах	Бие даан ажиллах	Ёс зүйн төлөвшил	Багаар ажиллах	Харилцааны соёл	Асуудалд хариуцлагатай байх	Бүтээлч хандлага, сэтгэлгээ	Цаг төлөвлөх, баримтлах
1	Байгалийн ухаан	<b>3.5</b>	4.3	<b>3.8</b>	4.1	4.3	<b>4.7</b>	4.0	<b>4.8</b>	<b>4.6</b>	4.2	4.5	<b>4.6</b>	4.3
		<b>B</b>	A	<b>B</b>	A	A	<b>A</b>	A	<b>A</b>	<b>A</b>	A	A	<b>A</b>	A
2	Инженер, технологи	<b>3.2</b>	<b>3.5</b>	<b>3.6</b>	<b>3.4</b>	4.0	4.3	<b>4.5</b>	4.3	4.4	<b>4.5</b>	4.4	<b>4.5</b>	<b>4.5</b>
		<b>B</b>	<b>B</b>	<b>B</b>	<b>B</b>	A	A	<b>A</b>	A	A	<b>A</b>	A	<b>A</b>	<b>A</b>
3	Нийгэм, хүмүүнлэг	4.2	4.0	4.2	4.3	<b>4.5</b>	4.1	<b>4.5</b>	4.3	<b>4.5</b>	4.4	<b>4.6</b>	<b>4.5</b>	<b>4.7</b>
		A	A	A	A	<b>A</b>	A	<b>A</b>	A	<b>A</b>	A	<b>A</b>	<b>A</b>	<b>A</b>
4	Хөдөө аж ахуй	<b>3.5</b>	<b>3.5</b>	<b>3.6</b>	<b>3.9</b>	<b>3.7</b>	4.6	<b>4.7</b>	<b>4.7</b>	4.4	4.5	4.6	<b>4.8</b>	<b>4.8</b>
		<b>B</b>	<b>B</b>	<b>B</b>	<b>B</b>	<b>B</b>	A	<b>A</b>	<b>A</b>	A	A	A	<b>A</b>	<b>A</b>
5	Анагаах ухаан	4.4	<b>3.9</b>	4.3	4.0	4.2	4.0	4.1	<b>3.9</b>	4.4	<b>4.7</b>	<b>4.5</b>	4.3	<b>4.7</b>
		A	<b>B</b>	A	A	A	A	A	<b>B</b>	A	<b>A</b>	<b>A</b>	A	<b>A</b>
6	Батлан хамгаалах	<b>3.5</b>	4.0	4.1	4.1	4.2	4.6	<b>4.8</b>	<b>4.8</b>	4.5	4.6	<b>4.9</b>	<b>4.9</b>	<b>4.8</b>
		<b>B</b>	A	A	A	A	A	<b>A</b>	<b>A</b>	A	A	<b>A</b>	<b>A</b>	<b>A</b>

*Тайлбар: А-маш чухал, В- чухал, С-чухал биш*

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

**Хүснэгт 3.54. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад эзэмшүүлэх шаардлагатай ур чадварууд**

№	Ур чадварууд	Нийгэм, хүмүүнлэг		Анагаах ухаан		Инженер, технологи		Хөдөө аж ахуй		Батлан хамгаалах		Байгалийн ухаан		Нийт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Мэргэжлийн ур чадвар	8	2.1	82	20.4	71	32.4	142	50.5	285	28.5	60	22.2	648	67.4
2	Харилцааны англи хэл	82	21.2	67	16.7	38	17.4	19	6.8	143	14.3	34	12.6	383	39.8
3	Логик, системийн сэтгэлгээ	12	3.1	30	7.5	26	11.9	40	14.2	129	12.9	43	15.9	280	29.1
4	Бүтээлч сэтгэлгээ, шинийг санаачлагч	62	16.0	38	9.5	25	11.4	9	3.2	37	3.7	16	5.9	187	19.4
5	Манлайлал, багаар ажиллах	38	9.9	19	4.7	12	5.5	17	6	50	5	48	17.8	184	19.1
6	Мэргэжлийн программ дээр ажиллах	34	8.8	19	4.7	10	4.6	25	8.9	87	8.7	-	0.0	175	18.2
7	Илтгэх болон харилцааны чадвар	70	18.1	19	4.7	4	1.8	7	2.5	49	4.9	4	1.5	153	15.9
8	Интернэт орчинд ажиллах	20	5.2	26	6.5	7	3.2	1	0.4	71	7.1	1	0.4	126	13.1
9	Техник хэрэгсэл ашиглах	23	5.9	47	11.7	7	3.2	10	3.6	35	3.5	4	1.5	126	13.1
10	Цагийн менежмент	3	0.8	34	8.5	8	3.7	1	0.4	42	4.2	34	12.6	122	12.7
11	Төсөл бичих, хэрэгжүүлэх	5	1.3	19	4.7	11	5.0	9	3.2	60	6.0	3	1.1	107	11.1
12	Ёс зүй, хариуцлага	30	7.8	2	0.5	-	0.0	1	0.4	11	1.1	23	8.5	67	7.0
<b>Нийт</b>		<b>387</b>	<b>100</b>	<b>402</b>	<b>100</b>	<b>219</b>	<b>100</b>	<b>281</b>	<b>100</b>	<b>999</b>	<b>100</b>	<b>270</b>	<b>100</b>	<b>2558</b>	<b>100</b>

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

**Хүснэгт 3.55. Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын чанарыг сайжруулахад нөлөөлөх хүчин зүйлс**

№	Анхаарах асуудлууд	Мэргэжлийн үндсэн чиглэлүүд						Нийт		
		Батлан хамгаалах	Хөдөө аж ахуй	Инженер, технологи	Анагаах ухаан	Нийгэм, хүмүүнлэг	Байгалийн ухаан	Тоо	Хувь	
1	Сургалтын хөтөлбөр, зохион байгуулалтыг шинэчлэх	130	45	25	69	48	95	412	42.8	
2	Багш нарын хичээл заах арга зүй, оюутантай ажиллах арга барилыг өөрчлөх	33	24	20	67	76	67	287	29.8	
3	Гадаад хэлээр мэргэжлийн хичээл заадаг болох	20	51	38	45	90	32	276	28.7	
4	Оюутнуудыг практикт дадлагажуулах боломжийг бүрдүүлэх	15	47	57	83	25	36	263	27.3	
5	Оюутнуудыг төлөвшүүлэхэд чиглэсэн чөлөөт цагийн орчин нөхцөлийг бүрдүүлэх	22	34	59	31	76	23	245	25.5	
6	Шилдэг оюутнуудыг дэмжсэн тэтгэлэг бий болгох	34	46	42	33	31	45	231	24.0	
7	Орчин үеийн өндөр түвшний лаборатори байгуулах	24	24	49	35	19	43	194	20.2	
8	Төгсөгчидтэй эргэх холбоог тогтмолжуулах	24	39	17	25	21	33	159	16.5	
9	Оюутнууд бий дааж суралцах орчин бүрдүүлэх	16	27	31	33	18	25	150	15.6	
<b>Нийт</b>		<b>Тоо</b>	<b>318</b>	<b>337</b>	<b>338</b>	<b>421</b>	<b>404</b>	<b>399</b>	<b>2217</b>	<b>-</b>
		<b>Хувь</b>	<b>14.3</b>	<b>15.2</b>	<b>15.2</b>	<b>19.0</b>	<b>18.2</b>	<b>18.0</b>	<b>100</b>	<b>-</b>

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙГМИЙН УХААНЫ ЧИГЛЭЛЭЭР СУРГАЛТ ЯВУУЛДАГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАНАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ**

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”* суурь судалгааны төслийн хүрээнд хийсэн судалгаа, боловсруулалтын ажлын үр дүнд тулгуурлан “Нийгмийн ухааны чиглэлээр сургалт явуулдаг дээд боловсролын сургалтын байгууллагын чанарт үнэлгээ хийх талаар бодлогын зөвлөмж”-ийг санал болгож байна. Үүнд:

*Нэг. Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын талаар баримтлах бодлого хэрэгжүүлэх талаар:*

1. Боловсролын чанарын асуудал нь тухайн улс үндэсний соёлын онцлог, ард иргэдийн үнэлэмж, нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшнээс хамааран харилцан адилгүй байдаг тул манай улсын хувьд дээд боловсролын чанарын талаар үндэсний хэмжээнд нэгдсэн ойлголттой болох чухал юм.
2. Төрийн байгууллагаас дээд боловсролын сургалтын байгууллагуудад чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх, чанарын соёл төлөвшүүлэх, чанарын үнэлгээний нэгдсэн систем хөгжүүлэх болон чанарыг үнэлэх, сайжруулахад чиглэсэн зорилтот бодлогыг хэрэгжүүлэх байдлаар үндэсний дээд боловсролын чанарын түвшнийг дээшлүүлэхэд ихээхэн анхаарах шаардлагатай.
3. Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын менежментийг нэвтрүүлж, чанарын соёлыг төлөвшүүлэхийг дэмжсэн тогтолцоо бүрдүүлэхэд чанарын менежмент, түүний шалгуур үзүүлэлтүүдийг стандартчилж мөрдүүлэх нь чухал юм. Ийнхүү үндэсний хэмжээнд чанарын нэгдсэн бодлого, удирдамж, аргачлалыг мөрдлөг болгосноор нэгдсэн үнэлгээ хийх байдлаар дээд боловсролын сургалтын байгууллагуудын чанарын үнэлгээг салбарын хэмжээнд хийж, гүйцэтгэлийн үр дүнг харьцуулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд түлхэц болно.

4. Дээд боловсролын сургалтын байгууллагын өмнө нийгмийн хөгжлөөс улбаалсан суралцагчид, үр ашиг хүртэгчид болон сонирхогч талуудын ирээдүйн хэрэгцээ, хүлээлт (чанар)-д чиглэсэн инновацыг нэвтрүүлэхэд өнөөгийн уламжлалт бүтэц, үйл ажиллагааны хэв шинжийг шинэчлэх, улмаар интеграци хийх шаардлага тулгарч байна. Энэхүү интеграци нь дээд боловсролын сургалтын байгууллагад нэгдсэн менежментийн тогтолцоо нэвтрүүлэхэд чиглэх нь чухал бөгөөд бүтцийн нэгжүүд хоорондын үйл ажиллагааны уялдаа сайжрах, захиргааны зардал буурах зэргээр өрсөлдөх давуу байдлыг олж авахад түлхэц болох юм.
5. Нийгмийн институтийн тогтолцоонд дээд боловсролын сургалтын байгууллага нь “Сургалт - Судалгаа - Инновац” гэсэн хосолмол хэв шинжтэй үйл ажиллагаа эрхэлдэг болохыг харгалзан чанарын асуудлыг олон талт зарчмаар авч үзэх нь зохимжтой.
6. Дээд боловсролын сургалтын байгууллагад стандартад суурилсан чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх нь чанарын нийцлийг хангах “Үнэлгээ - Тохируулга - Сайжруулалт” бүхий дотоод чанарын баталгаажуулалтын систем бүрдэхэд түлхэц болно. Энэхүү дотоод чанарын баталгаажуулалтын системийг төлөвшүүлэхэд чанарын гарын авлага чухал үүрэгтэй ба зөвхөн захиргааны аргаар чанарын менежментийг шууд нэвтрүүлэх гэж оролдох нь чанарын зорилгод хүрэх, тасралтгүй сайжруулалт үр дүнгүй болох тул удирдлагын манлайллаар дамжуулан чанарын соёлыг төлөвшүүлэх, бүтцийн нэгжүүд чанарын тухай нэгдсэн ойлголттой болгоход онцгойлон анхаарах шаардлагатай.
7. Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын нэгдсэн менежментийн тогтолцоог үр дүнтэй нэвтрүүлэх нь бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг тогтоох, хангах, хүрсэн түвшинд хадгалах зорилгоор түүнийг бий болгох, ашиглах буюу хэрэглэх үед нөлөөлөх бүхий хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай ба бүтээгдэхүүний амьдралын орчлын үе шат бүрд чанарын менежментийн нэгдсэн тогтолцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх нь чухал юм.

8. Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай. Үүнд:
  - i. Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, сайжруулахын тулд удирдлага, менежер, судлаачдыг хамруулсан судалгааг үндэсний хэмжээнд зохион байгуулж, өнөөгийн нөхцөл байдлыг системтэй үнэлэх;
  - ii. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын менежментийн хэмжээс, түүний үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулж, найдвартай байдлыг турших, улмаар их, дээд сургуулиудын түвшинд чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэхэд тулгарч буй бэрхшээл, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тогтоох;
  - iii. Дээд боловсролын сургалтын байгууллагуудад чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэхэд удирдлага менежерүүдийг чадавхжуулах, шаардлагатай хүнийг нөөцийг мэргэшүүлэн хангах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах зэрэг болно.
9. Дээд боловсролын сургалтын байгууллагын эрхэм зорилго нь мэдлэгийн гурвалжин буюу *“Сургалт - Судалгаа – Инновац”* гэсэн үзэл баримтлалтай уялдах болсноор дотоод болон хөндлөнгийн чанарын үнэлгээг хэрхэн, яаж үр дүнтэй хийх, үнэлгээний шалгуур, аргачлалыг оновчтой сонгоход анхаарах нь чухал юм.
10. Дээд боловсролын сургалтын байгууллага нь сургалтын явц, үр дүнг үнэлэх шалгуур гэж үздэг нийтлэг үзэл баримтлалаас боловсролын үндсэн зорилго, үнэт зүйлсийн хүрээг хамарсан үзүүлэлтүүдийг тодорхойлох нь чанарын менежмент сайжрах нөхцөл бүрдэнэ.
11. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээг үр дүнтэй байлгахын тулд, түүний үйл явцыг тухайн байгууллагын эрхэм зорилгод нийцүүлэх байдлаар *“Бүтцийн нээж - Байгууллага -Нийгэм”* гэсэн гурван түвшинд цогц байдлаар авч үзэх нь чанарын үнэлгээ, сайжруулалтыг тасралтгүй системтэй хэрэгжүүлэхэд түлхэц болох, улмаар байгууллагын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд түлхэц болдог.

12. Дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалт болон хөндлөнгийн чанарын үнэлгээний уялдааг хангахад анхаарал хандуулах нь чухал. Ер нь дотоод чанарын баталгаажуулалт болон хөндлөнгийн чанарын үнэлгээг амжилттай хэрэгжүүлэхэд үнэлгээний үйл явцад оролцогч талуудын оролцоог хангах, гүйцэтгэх үүрэгт анхаарах нь тэднийг өөрсдийнхөн зорилгоор дамжуулан чанарын зорилго руу чиглүүлдэг болохыг анхаарах.
13. Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдлагын зүгээс магадлан итгэмжлэлийн гэрчилгээ авахын тулд өөрийн үнэлгээний тайлан бичих байдлаар чанарын менежментийг ёс төдий нэвтрүүлэх нь байгууллагыг эрсдэлд оруулах магадлалтай байдаг. Ер нь зөвхөн төрийн захиргааны болон магадлан итгэмжлэлийн байгууллагуудын шаардлагыг хангахад анхаарч ажилладаг удирдлагын арга барилаас татгалзах нь чухал юм.
14. Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын менежментийг нэвтрүүлж, чанарын соёлыг төлөвшүүлэхийг дэмжсэн тогтолцоо бүрдүүлэхэд чанарын менежмент, түүний шалгуур үзүүлэлтүүдийг стандартчилж мөрдүүлэх нь чухал юм. Ийнхүү үндэсний хэмжээнд чанарын нэгдсэн бодлого, удирдамж, аргачлалыг мөрдлөг болгосноор нэгдсэн үнэлгээ хийх байдлаар дээд боловсролын сургалтын байгууллагуудын чанарын үнэлгээг салбарын хэмжээнд хийж, гүйцэтгэлийн үр дүнг харьцуулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд түлхэц болно.

*Хоёр. Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын менежментийн тогтолцоо төлөвшүүлэх талаар:*

1. Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-аас боловсролын байгууллагуудад чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэхэд дэмжлэг болох үүднээс “ISO 21001:2018 Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо” стандартыг санал болгодог. Энэхүү стандартыг боловсролын байгууллага хэрэгжүүлснээр чанарын менежментийн тогтолцоогоор дамжуулан хэрэглэгчийн шаардлагыг хангах замаар сэтгэл ханамжийг дээшлүүлэх үйл явцуудыг тогтолцооны



хүрээнд ойлгох, тэдгээрийн харилцан үйлчлэлийг төлөвлөх, гүйцэтгэлийг бүхэлд нь хянах, сайжруулах боломж бүрдэх юм.

2. *ISO 21001:2018* стандарт нь суралцагчид болон бусад оролцогч талуудын шаардлагад нийцсэн, боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад зориулсан менежментийн хэрэгсэл болдог. Уг стандартын шаардлагууд нь ерөнхий бөгөөд сургах, суралцах, судалгаа шинжилгээ хийх замаар мэдлэг чадварыг хөгжүүлэхэд сургалтын хөтөлбөр ашиглаж, дэмжлэг үзүүлдэг ямар ч байгууллагууд төрөл, хэмжээ, хүргэх арга зэргээс үл хамааран хэрэглэх боломжтой тул байгууллагад сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлтийг ойлгож мэдрэх боломж олгодог.
3. Дээд боловсролын сургалтын байгууллагуудад *“ISO 21001:2018 Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо”* стандартыг нэвтрүүлэх нь зохимжтой тул санал болгож байна (*энэхүү стандартыг төслийн хүрээнд орчуулав*).

#### **4. Байгууллагын төлөв байдал**

##### **a. Байгууллагын төлөв байдлыг ойлгох**

Байгууллага өөрийн зорилго, нийгмийн хариуцлага ба стратеги чиглэлд хамааралтай бөгөөд боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны хүрээнд зорьсон үр дүнд хүрэх, чадварт нь нөлөөлөх гадаад ба дотоод асуудлыг тодорхойлсон байна. Байгууллага нь эдгээр гадаад болон дотоод асуудлуудад хамаарах мэдээлэлд мониторинг ба дүн шинжилгээ хийнэ.

##### **b. Сонирхогч талуудын хүлээлтийг ойлгох хэрэгцээ ба хүлээлтийг ойлгох**

Боловсролын бүтээгдэхүүн болон үйлчилгээг тууштай ба тогтвортой хангахад нь байгууллагын чадавхад нөлөөлөх боломжтой дараах асуудлыг байгууллага тодорхойлсон байна:

- a) Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоонд хамаарах сонирхогч талууд;
- b) Эдгээр сонирхогч талуудын боловсролын байгууллагын менежментийн тогтолцоонд хамааралтай шаардлага. Эдгээр сонирхогч талуудад:

- ✓ Суралцагчид,
- ✓ Бусад үр шим хүртэгчид,
- ✓ Байгууллагын ажилтнууд хамаарна.

Байгууллага нь эдгээр сонирхогч талуудад хамаарах мэдээлэл, тэдгээрт холбогдох шаардлагад мониторинг ба дүн шинжилгээ хийнэ.

### **с. Боловсролын байгууллагуудын менежментийн тогтолцооны хамрах хүрээг тогтоох**

Байгууллага хамрах хүрээг тогтоохын тулд боловсролын байгууллагын менежментийн тогтолцоонд хэрэглэх зааг хязгаар ба боломжийг тодорхойлно. Хамрах хүрээг тодорхойлохдоо байгууллага дараах зүйлсийг анхаарна.

- a) 4.1-д заасан гадаад болон дотоод асуудлууд;
- b) 4.2-т заасан сонирхогч талуудын шаардлага;
- c) Байгууллагын нийлүүлж буй бүтээгдэхүүн ба үйлчилгээ.

Байгууллага өөрийн тодорхойлсон боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны хамрах хүрээнд ашиглах боломжтой бол энэхүү баримт бичгийн бүх шаардлагыг хэрэглэнэ. Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны хамрах хүрээг баримтжуулсан мэдээлэл байдлаар хадгалж хэрэглэх ба хүртээмжтэй байна. Хамрах хүрээ нь хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтоох ба боловсролын байгууллагын менежментийн тогтолцоондоо энэхүү баримт бичгийн аль нэг шаардлагыг хэрэглэх боломжгүй гэж тодорхойлсон бол тэр үндэслэлээ гаргана. Хэрэглэх боломжгүй гэж тодорхойлсон шаардлага нь байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирол, суралцагчид болон бусад үр шим хүртэгсдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх явдлыг хангах байгууллагын чадвар ба хариуцлагад нөлөөлөхгүй тохиолдолд энэхүү баримт бичигт тохирсон гэж үзнэ. Боловсролын байгууллагаас суралцагчид болон бусад үр шим хүртэгсдийг хангаж буй бүх бүтээгдэхүүн болон үйлчилгээ нь энэ боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны хамрах хүрээнд орно.

### **d. Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо**

4.4.1 Байгууллага энэхүү баримт бичгийн дагуу шаардагдах үйл явцууд болон

тэдгээрийн харилцан үйлчлэл бүхий боловсролын байгууллагын менежментийн тогтолцоог бий болгож, хэрэгжүүлж, хадгалж, байнга сайжруулна. Байгууллага боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны үйл явцуудыг тодорхойлж, байгууллагын хэмжээнд хэрэглэх ба:

- a) Эдгээр үйл явцуудад шаардлагатай оролт болон хүлээгдэж буй гаралтыг тодорхойлно;
- b) Эдгээр үйл явцуудын дараалал, харилцан үйлчлэлийг тодорхойлно;
- c) Үр нөлөөтэй ажиллагаа ба эдгээр үйл явцуудын хяналтыг хангахад шаардагдах шалгуур ба аргуудыг (мониторинг, хэмжилт болон гүйцэтгэлийн холбогдох үзүүлэлтүүд зэрэг) тодорхойлох ба хэрэглэнэ;
- d) Эдгээр үйл явцуудад шаардагдах нөөцийг тодорхойлж, тэдгээрийн боломжийг хангана;
- e) Эдгээр үйл явцуудад зориулсан үүрэг хариуцлага, эрх мэдлийг хуваарилна;
- f) 6.1-д заасан дагуу тодорхойлсон эрсдэл болон боломжуудыг авч үзнэ;
- g) Эдгээр үйл явцуудыг үнэлж, тэдгээрийг зорьсон дүнд хүргэхэд шаардагдах өөрчлөлтүүдийг хэрэгжүүлнэ;
- h) Үйл явцууд болон боловсролын байгууллагын менежментийн тогтолцоог сайжруулна.

## **5. Манлайлал**

### **5.1 Манлайлал ба үүрэг амлалт**

5.1.1 *Ерөнхий зүйл:* Дээд удирдлага боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны талаар манлайлал ба үүрэг амлалтыг дараах байдлаар харуулна:

- a) боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны үр нөлөөтэй байдлыг хариуцах;
- b) байгууллагын төлөв байдал, стратегийн чиглэлтэй нийцсэн боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны бодлого ба зорилтуудыг тогтоох явдлыг хангах;
- c) байгууллагын бизнес үйл явцуудад боловсролын байгууллагын

- менежментийн тогтолцооны шаардлагыг нэгтгэх явдлыг хангах;
- d) үйл явцын арга, эрсдэлд суурилсан сэтгэлгээний арга хэрэглэхийг дэмжиж урамшуулах;
  - e) боловсролын байгууллагын менежментийн тогтолцоонд шаардагдах нөөцийн боломжийг хангах;
  - f) боловсролын байгууллагын үр нөлөөтэй менежмент болон боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны шаардлагад тохирсон байхын ач холбогдлыг мэдээлж харилцах;
  - g) боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо нь зорьсон үр дүнд хүрэх явдлыг хангах;
  - h) боловсролын байгууллагын менежментийн тогтолцоон үр нөлөөнд хувь нэмэр оруулахад нь хүмүүсийн оролцоог хангах, залж чиглүүлэх ба дэмжлэг үзүүлэх;
  - i) байнгын сайжруулалтыг дэмжиж урамшуулах;
  - j) өөрсдийн хариуцсан хэсгүүдэд манлайллаа харуулахад нь холбогдох бусад менежментийн ажил үүргийг дэмжих;
  - k) боловсролын алсын хараа, боловсролын бусад үзэл баримтлалыг тогтвортой хэрэгжүүлэхийг дэмжих;
  - l) байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулах, хөгжүүлэх, хадгалах;
  - m) суралцагчийн боловсролын шаардлага, түүний дотор тодорхой хэрэгцээг тодорхойлох ба авч үзэх явдлыг хангах;
  - n) нийгмийн хариуцлагын зарчмыг анхаарч үзэх.

5.1.2. *Суралцагчид ба бусад үр шим хүртэгчдэд төвлөрөх:* Дээд удирдлага нь дараах асуудлыг шууд хариуцаж:

- a) суралцагчид ба бусад үр шим хүртэгчдийн хэрэгцээ ба хүлээлтийг тодорхойлж, ойлгож, тууштай хангах, үүнийг тэдгээрийн сэтгэл ханамж ба боловсролын дэвшилд мониторинг хийх замаар нотолдог;
- b) бүтээгдэхүүн ба үйлчилгээний тохирол болон суралцагчид болон үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх чадварт нөлөөлж

болох эрсдэл болон боломжуудыг тодорхойлох ба авч үзэх явдлыг хангана.

**5.1.3 Боловсролын онцгой хэрэгцээнд зориулсан нэмэлт шаардлага:** Онцгой хэрэгцээт суралцагч гэдэг нь ердийн сургалт ба үнэлгээний арга барилаар хэрэгцээ нь хангагдахгүй байх боломжтой суралцагч (жишээ нь: зан байдал, харилцааны, оюуны, бие бялдар, авьяас билиг зэрэг онцгой авьяастнууд эсвэл тусгай боловсрол шаардагдах бусад суралцагчид; суралцагчид нэгээс илүү онцгой авьяастай байж болно). Энэ нь сонирхогч талууд өөрсдийн үйл ажиллагаандаа хэрэгцээтэй мэдээлэл олж авах боломжтой байхад зориулан мэдээлэл харилцааны сувгууд бий болгох явдлыг хангах хэрэгцээг харуулна. Дээд удирдлага нь:

- ✓ Сургалтын орчны хүртээмжийг дэмжих нөөц ба сургалтыг зохион байгуулна;
- ✓ Бусад суралцагчдын нэг адил боловсролын орчин ба байгууламжид нэвтрэх тэгш боломж олгохын тулд онцгой хэрэгцээтэй суралцагчдыг боломжийн байраар хангана.

## **5.2 Бодлого**

**5.2.1 Бодлого боловсруулах:** Дээд удирдлага нь дараах агуулгыг тусгасан боловсролын байгууллагын бодлогыг тогтоож, дүн шинжилгээ хийж, мөрдөж хадгална:

- a) Боловсролын байгууллагын эрхэм зорилго ба алсын харааг дэмжсэн;
- b) Байгууллагын зорилго ба төлөв байдалд тохирсон;
- c) Боловсролын байгууллагын зорилтуудыг тогтоох агуулга, хүрээгээр хангасан;
- d) Холбогдох шаардлагыг биелүүлэх үүрэг амлалтыг тусгасан;
- e) Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоог байнга сайжруулах үүрэг амлалтыг тусгасан;
- f) Холбогдох боловсрол, шинжлэх ухаан, ба техникийн хөгжлийг харгалзаж үзсэн;
- g) Байгууллагын нийгмийн хариуцлагыг хангах үүрэг амлалтыг

тусгасан;

- h) Оюуны өмчийг зохицуулах үүрэг амлалтыг тодорхойлох ба тусгасан;
- i) Холбогдох сонирхогч талуудын хэрэгцээ ба хүлээлтийг анхаарч үзсэн.

5.2.2 *Бодлогыг мэдээлж харилцах:* Боловсролын байгууллагын бодлого нь:

- a) Баримтжуулсан мэдээлэл байдлаар хүртээмжтэй байх ба мөрдөж хадгална;
- b) Байгууллагын хэмжээнд мэдээлсэн, ойлгомжтой ба хэрэглэдэг байна;
- c) Холбогдох сонирхогч талуудад боломжоороо хүртээмжтэй байна.

### **5.3 Зохион байгуулалтын үүрэг, хариуцлага, эрх мэдэл**

Дээд удирдлага холбогдох ажил үүрэгт хамаарах хариуцлага ба эрх мэдлийг тохоон хуваарилах явдлыг хангаж, байгууллагын хэмжээнд мэдээлж харилцсан байна. Дээд байгууллага нь дараах асуудлаар хариуцлага ба эрх мэдлийг хуваарилна:

- a) Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо нь энэхүү баримт бичгийн шаардлагад тохирсон байх явдлыг хангах;
- b) Боловсролын байгууллагын бодлого нь ойлгомжтой ба хэрэгжсэн байх явдлыг хангах;
- c) Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны үйл явцууд нь хүссэн гаралтуудыг нийлүүлэх явдлыг хангах;
- d) Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны гүйцэтгэл болон сайжруулах боломжууд (10.1)-ын талаар дээд удирдлагад тайлагнах (9.3.2);
- e) Суралцагчид болон бусад үр шим хүртэгчдэд төвлөрөхийг байгууллагын хэмжээнд дэмжих явдлыг хангах;
- f) Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны өөрчлөлтийг төлөвлөх ба хэрэгжүүлэх үед боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны нэгдмэл байдлыг хангах;
- g) Байгууллагын мэдээлэл харилцааг удирдах (7.4);
- h) Заах аргаас үл хамааран сургалтын бүх үйл явцыг нэгтгэсэн байх

явдлыг хангах;

- i) Баримтжуулсан мэдээллийг хянах (7.5);
- j) Онцгой хэрэгцээтэй суралцагчдын шаардлагыг зохицуулах.

## **6. Төлөвлөлт**

### **6.1 Эрсдэл болон боломжуудыг авч үзэх арга хэмжээ**

**6.1.1** Байгууллага нь боловсролын байгууллагын менежментийн тогтолцоог төлөвлөхдөө 4.1-д заасан асуудлууд, 4.2 ба 4.4-т заасан шаардлагыг анхааран үзэх ба дараах асуудлыг авч үзэхэд шаардагдах эрсдэл ба боломжуудыг тодорхойлно:

- a) Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо нь зорьсон үр дүнд хүрч чадахыг нотлох;
- b) Хүсэж буй үр нөлөөг сайжруулах;
- c) Хүсээгүй үр дүнгээс сэргийлэх эсвэл бууруулах;
- d) Байнгын сайжруулалтад хүрсэн байх;

**6.1.2** Байгууллага нь дараах арга хэмжээг төлөвлөсөн байна. Үүнд:

- a) эдгээр эрсдэл болон боломжуудыг авч үзсэн арга хэмжээнүүд
- b) хэрхэн:
  - ✓ тухайн арга хэмжээнүүдийг боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны үйл явцуудад нэгтгэх ба хэрэгжүүлэх;
  - ✓ эдгээр арга хэмжээнүүдийн үр нөлөөг үнэлэх.

Эрсдэл болон боломжуудыг авч үзэх арга хэмжээнүүд нь бүтээгдэхүүн ба үйлчилгээний тохиролд үзүүлэх боломжит нөлөө ба үүсэх магадлалтай уялдсан байна.

### **6.2 Боловсролын байгууллагын зорилтууд ба тэдгээрийг биелүүлэх төлөвлөлт**

**6.2.1** Байгууллага нь боловсролын байгууллагын менежментийн тогтолцоонд шаардлагатай холбогдох чиг үүрэг, түвшин, үйл явцуудад боловсролын байгууллагын зорилтуудыг тогтооно. Боловсролын байгууллагын зорилтууд:

- a) Боловсролын байгууллагын чанарын бодлоготой уялдсан байна;
- b) Хэмжигдэхүйц байна (хэрвээ боломжтой бол);
- c) Хэрэглэх шаардлагуудыг авч үзсэн байна;
- d) Бүтээгдэхүүн ба үйлчилгээний тохирол болон суралцагчид, ажилтнууд ба бусад үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийг сайжруулахтай хамааралтай байна;
- e) Байнга мониторинг хийдэг байна;
- f) Мэдээлдэг байна;
- g) Шаардлагатай бол шинэчилдэг байна.

Байгууллага боловсролын байгууллагын зорилтын талаарх баримтжуулсан мэдээллийг хөтөлж, мөрдөж хадгална.

6.2.2 Боловсролын байгууллагын зорилтуудыг хэрхэн биелүүлэхийг төлөвлөх үед байгууллага нь дараах зүйлсийг тодорхойлж, стратегийн төлөвлөгөөндөө тоймлон оруулна:

- a) Юу хийсэн байх;
- b) Ямар нөөц шаардагдах;
- c) Хэн хариуцах;
- d) Хэзээ хийж дуусах;
- e) Үр дүнг хэрхэн үнэлэх.

### **6.3 Өөрчлөлтийг төлөвлөх**

Хэрэв байгууллага боловсролын байгууллагын менежментийн тогтолцоондоо өөрчлөлтүүд хийх шаардлагатай гэж тодорхойлсон бол эдгээр өөрчлөлтүүдийг төлөвлөж хэрэгжүүлнэ (4.4). Байгууллага дараах зүйлсийг анхаарна:

- a) Өөрчлөлт хийх зорилго, түүний боломжит үр дагавар;
- b) Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны нэгдмэл байдал;
- c) Дотоод нөөцийн боломж ба бэлэн байдал;
- d) Хариуцлага болон эрх мэдлийн хуваарилалт ба дахин хуваарилалт;



- е) Өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд шаардагдах гаднын нийлүүлэгчийн боломж ба бэлэн байдал.

## **7. Дэмжлэг**

### **7.1 Нөөц**

7.1.1 *Ерөнхий зүйл*: Байгууллага нь боловсролын байгууллагын менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хадгалах, байнга сайжруулахад шаардагдах нөөцийг дор дурдсан асуудлуудыг тогтмол сайжруулах байдлаар тодорхойлох ба хангана:

- а) Сургалтыг сайжруулах ба сургалтын үр дүн амжилтад хүрэхийг урамшуулах үйл ажиллагаагаар дамжуулан суралцагчдын оролцоог хангах ба сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх;
- б) Сургалтыг хөнгөвчлөх зорилгоор ажилтнуудын чадамжийг сайжруулах үйл ажиллагаагаар тэдгээрийн оролцоог хангах ба сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх;
- в) Сургалтын нийгмийн үр шимд хувь нэмэр оруулах үйл ажиллагаагаар бусад үр шим хүртэгсдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх.

7.1.1.2. *Байгууллага аль нөөцийг*:

- а) уг байгууллага;
- б) гаднын нийлүүлэгч хангахыг тодорхойлох ба мониторинг хийнэ.

Байгууллага онцгой хэрэгцээтэй суралцагчдын хэрэгцээг харгалзан үзэх ба төрөл бүрийн хүртээмжийн шаардлагыг урьдчилан харах явдлыг хангана.

### **7.1.2 Хүний нөөц**

7.1.2.1 Дараах хүмүүсийг хамруулах хир хэмжээгээр нь хүний нөөцөд багтаана:

- а) байгууллагын орон тооны ажилтан;
- б) байгууллагад ажилладаг эсвэл хувь нэмэр оруулдаг сайн дурын ажилтан ба дадлагажигч;
- в) байгууллагад ажилладаг эсвэл хувь нэмэр оруулдаг гаднын нийлүүлэгчийн ажилтан.

#### *7.1.2.2 Байгууллага нь:*

- a) өөрийнхөө боловсролын байгууллагын менежментийн тогтолцоог үр нөлөөтэй хэрэгжүүлэх болон үйл явцуудыг ажиллуулах ба хянахад шаардагдах хүний нөөцийг тодорхойлох ба хангана;
- b) ажилтан элсүүлэх эсвэл сонгох шалгуурыг тодорхойлж, хэрэгжүүлэх ба нийтэлнэ, энэ нь сонирхогч талуудад хүртээмжтэй байна;
- c) ажилтан элсүүлэх эсвэл сонгоход хэрэглэсэн үйл явцын баримтжуулсан мэдээллийг мөрдөж хадгалах ба элсэлтийн үр дүнг бүртгэж хадгална.

#### *7.1.3 Барилга байгууламж*

7.1.3.1 Суралцагчийн шаардлагыг хангасан дараах зүйлсийг хэрэглэгдэх боломжоор нь барилга байгууламжид оруулна:

- a) барилга ба эзэмшлийн газар
- b) программ хангамж, техник хангамж зэрэг тоног төхөөрөмж
- c) нийтийн зориулалттай байгууламж ба төхөөрөмжүүд.

#### *7.1.3.2 Байгууллага нь:*

- a) аюулгүй барилга байгууламжийг тодорхойлж, хангах ба ажиллуулах ба энэ нь:
  - 1) суралцагчийн чадамж хөгжүүлэхийг дэмжих хүний нөөцөд тохиромжтой;
  - 2) суралцагчийн чадамжийн хөгжлийг сайжруулсан;
- b) барилга байгууламжийн хэмжээ нь тэдгээрийг хэрэглэгчдийн шаардлагад зохимжтой байх явдлыг хангасан.

7.1.3.3 Барилга байгууламж аль болохоор дараах үйл ажиллагаанд тохирсон байна:

- a) багшлах;
- b) бие дааж суралцах;
- c) мэдлэгийг хэрэгжүүлэх;

- d) амрах ба зугаацах;
- e) хооллох;

**7.1.4 Боловсролын үйл явцуудыг ажиллуулах орчин:** Байгууллага нь дараах хүчин зүйлсийг анхаарч үзэх замаар сонирхогч талуудын амгалан тухтай байдлыг ерөнхийд нь хангахын тулд тохиромжтой орчныг тодорхойлж, хангаж, хадгална:

- a) сэтгэцийн хүчин зүйлс;
- b) физик хүчин зүйлс.

**7.1.5 Мониторинг ба хэмжилтийн нөөц:**

**7.1.5.1 Ерөнхий зүйл:** Байгууллага нь бүтээгдэхүүн, үйлчилгээ шаардлагад тохирч байгааг нотлоход ашиглаж байгаа мониторинг, хэмжилтийн үр дүнгийн хүчин төгөлдөр, найдвартай байдлыг хангахад шаардлагатай нөөцийг тодорхойлж, хангана. Нөөц нь дараах шаардлагыг хангасан байх явдлыг байгууллага хариуцна:

- a) мониторинг ба хэмжилт хийх үйл ажиллагааны тодорхой төрөлд тохирсон байх; тухайлбал боловсрол олгох арга, төрөл болон боловсролын үйлчилгээний хугацаанд тохирсон байх;
- b) зорилгодоо тэдгээр нь үргэлжлэн нийцэх явдлыг хангахаар хэвийн ажиллуулах.

Байгууллага нь мониторинг ба хэмжилтийн нөөц зорилгодоо нийцэж байгааг нотлохын тулд зохих баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална.

**7.1.5.2 Хэмжилтийн нэгж дамжуулалт:** Хэмжилтийн нэгж дамжуулалтыг хангах тухай шаардлага тавигдаж байгаа, эсвэл хэмжилтийн үр дүнгийн хүчин төгөлдөр байдалд итгэл үнэмшилтэй байх нь байгууллагын үйл ажиллагааны салшгүй хэсэгт тооцдог бол хэмжилтийн нөөц нь дараах шаардлагыг хангасан байна:

- a) тодорхой давтамжтайгаар эсвэл ашиглахын өмнө олон улсын буюу үндэсний эталонд нэгж дамжуулах боломжтой эталоноор шалгадаг, тохируулга хийдэг эсвэл хоёуланг нь хийдэг байна; хэрэв ийм эталон байхгүй бол шалгаж, тохируулга хийсэн үндэслэлийг баримтжуулсан

мэдээлэл байдлаар хөтөлж хадгална;

- b) тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлохын тулд ялгаж тогтооно;
- c) тохируулга алдагдах, гэмтэх, муудах зэргээс болж тохируулгын төлөв байдал болон дараагийн хэмжилтийн үр дүн хүчингүй болохоос хамгаална.

Хэмжих тоног төхөөрөмж нь зориулалтдаа нийцэхгүйг тогтоосон үед өмнөх хэмжилтийн үр дүнгийн хүчинтэй байдалд сөрөг нөлөө үзүүлсэн эсэхийг байгууллага тодорхойлох ба шаардлагатай бол зохих арга авна.

**7.1.6.1 Ерөнхий зүйл:** Байгууллага нь үйл явцуудыг хэрэгжүүлэхэд болон бүтээгдэхүүн ба үйлчилгээний тохирлыг хангахад шаардагдах мэдлэгийг тодорхойлно. Энэ мэдлэгийг хэрэгцээт хэр хэмжээнд боломжтой байлгах ба хэрэглэнэ. Өөрчлөгдөж байгаа хэрэгцээ ба хандлагыг авч үзэхдээ байгууллага нь байгаа мэдлэгийг хянаж үзэх ба хэрэгцээт аливаа нэмэлт мэдлэг ба шаардагдах шинэчлэлийг хэрхэн олж авах буюу эзэмшихийг тодорхойлно. Байгууллага нь боловсрол олгогч ба ажилтнууд, ялангуяа ижил түвшний ажиллагсад хооронд харилцан мэдлэгээ солилцохыг хөхүүлэн дэмжинэ.

- a) дотоод эх үүсвэр (оюуны өмч; туршлагаар бий болсон мэдлэг; алдаатай болон амжилттай хэрэгжсэн төслийн сургамж; баримтжуулаагүй мэдлэг ба туршлагыг олж тогтоох ба хуваалцах; үйл явц, бүтээгдэхүүн ба үйлчилгээний сайжруулалтын үр дүн г.м);
- b) гадаад эх үүсвэр (стандартууд; судалгаа, шинжилгээ, хурал зөвлөгөөн, суралцагчдаас болон гаднын нийлүүлэгчээс цугларсан г.м).

**7.1.6.2 Сургалтын нөөц:** Байгууллага нь зохих сургалтын нөөцөөр хангах ба шаардлагатай үед нь ашиглах боломжтой болгоно.

- a) суралцагчид болон бусад ашиг хүртэгсэд ба боловсрол олгогчдын хэрэгцээ шаардлагыг тусгасан байна;
- b) шинэчилж байхын тулд төлөвлөсөн интервалаар дүн шинжилгээ хийдэг байна;
- c) каталогжуулсан ба лавлагаанд ашигладаг байна. Байгууллага нь оюуны өмчийн шаардлагыг эрхэмлэн үзэх ба нөөцийг дахин ашиглахыг урамшуулан дэмжинэ.

## **7.2 Чадамж**

7.2.1 *Ерөнхий зүйл:* Байгууллага нь дараах зүйлийг хэрэгжүүлнэ:

- a) боловсролын байгууллагын гүйцэтгэлд нөлөөлөх ажлыг өөрийн хяналт дорхийж байгаа ажилтны чадамжид тавих шаардлагыг тодорхойлох;
- b) зохих боловсрол, сургалт эсвэл туршлагад үндэслэн эдгээр ажилтнуудын чадамжийг хангах;
- c) ажилтнуудын гүйцэтгэлийг үнэлэх аргуудыг бий болгох ба хэрэгжүүлэх;
- d) хэрэгжүүлэх бололцоогоор нь шаардлагатай чадамжийг эзэмшүүлэх арга хэмжээ авах ба эдгээр арга хэмжээний үр нөлөөтэй байдлыг үнэлэх;
- e) холбогдох ажилтнуудын чадамжийг тасралтгүй хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах явдлыг хангах;
- f) чадамжийг нотлохын тулд зохих баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгалах.

7.2.2 *Онцгой хэрэгцээт боловсролд тавих нэмэлт шаардлагууд:*

Байгууллага нь дараах байдлаар боловсрол олгогчдыг дэмжих нөөцөөр хангана:

- a) онцгой хэрэгцээт суралцагчидтай харилцдаг боловсрол олгогч ба ажилтнуудыг зохих тусгай сургалтад хамруулах явдлыг хангах, үүнд:
  - 1) өөр өөр шаардлага бүхий суралцагчдын сургалтын хэрэгцээг хангах;
  - 2) ялгавартай сургалт ба үнэлгээ;
  - 3) бага багаар дасган сургах;
- b) мэргэжилтнүүдийн сүлжээнд нэвтрэх боломжоор хангах.

## **7.3 Мэдлэг ойлголт**

Байгууллага нь өөрийн хяналт дор ажиллаж байгаа холбогдох ажилтнуудад дараах зүйлийг танилцуулж ойлгуулна:

- a) боловсролын байгууллагын бодлого ба стратеги, боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны холбогдох зорилтууд;
- b) боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны үр нөлөөнд

тэдгээрийн оруулах хувь нэмэр, үүнд боловсролын байгууллагын гүйцэтгэл сайжирсны ашиг тус багтана;

- c) боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны шаардлагад тохироогүйгээс гарах үр дагавар.

#### **7.4 Мэдээлэл харилцаа**

7.4.1 *Ерөнхий зүйл:* Байгууллага нь боловсролын байгууллагын менежментийн тогтолцоонд хамаарах дотоод ба гадаад мэдээлэл харилцааны асуудлыг тодорхойлно, үүнд дараах зүйлс багтана:

- a) юу мэдээлж харилцах;
- b) яагаад мэдээлж харилцах;
- c) хэзээ мэдээлж харилцах;
- d) хэнд мэдээлж харилцах;
- e) хэрхэн мэдээлж харилцах;
- f) хэн мэдээлж харилцах.

7.4.2 *Мэдээлэл харилцааны зорилго:* Гадаад ба дотоод мэдээлэл харилцаа нь дараах зорилгыг агуулна:

- a) холбогдох сонирхогч талуудын санал сэтгэгдлийг олж авах санаа бодлыг өөрийн талдаа дагуулах;
- b) сонирхогч талуудад байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, стратеги бодлоготой нийцсэн холбогдох мэдээллийг сонирхогч талуудад үнэн зөв, цаг тухайд нь хүргэх;
- c) үйл ажиллагаа ба үйл явцуудыг холбогдох сонирхогч талуудтай байгууллагын дотор хамтрах ба зохицуулах.

7.4.3 Мэдээлэл харилцааны зохицуулалт

7.4.3.1 Байгууллага нь дор дурдсантай холбоотой асуудлаар суралцагчид болон бусад сонирхогч талуудтай үр нөлөөтэй мэдээлэл харилцааны зохицуулалтыг тодорхойлох ба хэрэгжүүлнэ:

- a) байгууллагын бодлого ба стратеги төлөвлөгөө;
- b) боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээний дизайн, агуулга

- ба хүргэлт;
- c) лавлагаа, өргөдөл, элсэлт ба бүртгэл;
- d) суралцагчдын гүйцэтгэлийн мэдээлэл, үүнд явцын ба хураангуй үнэлгээний үр дүн орно;
- e) суралцагч ба сонирхогч талуудын санал хүсэлт, үүнд суралцагчийн гомдол, суралцагч/сонирхогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа.

Байгууллага шийдэгдээгүй асуудал гарах тохиолдолд холбоо барих гаднах цэгүүдийн талаар суралцагчид ба бусад үр шим хүртэгсдэд мэдээлнэ

7.4.3.2 Төлөвлөсөн завсарлагатайгаар байгууллага нь:

- a) мэдээлэл харилцааныхаа хэрэгжилтэд мониторинг хийнэ;
- b) мониторингийн үр дүнд үндэслэн мэдээлэл харилцааны төлөвлөгөөг шинжлэх ба сайжруулна.

## **7.5 Баримтжуулсан мэдээлэл**

7.5.1 *Ерөнхий зүйл*: Байгууллагын боловсролын байгууллагын менежментийн тогтолцоонд:

- a) энэхүү баримт бичигт шаардсан баримтжуулсан мэдээлэл;
- b) боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны үр нөлөөг хангахад шаардлагатай гэж байгууллагаас тодорхойлсон баримтжуулсан мэдээлэл тус тус багтана

7.5.2 *Мэдээлэл бий болгох ба шинэчлэх*: Баримтжуулсан мэдээллийг бий болгож шинэчлэхдээ дараах зүйлийг зохих ёсоор хангана:

- a) тэмдэглэгээ ба тайлбар (нэр, огноо, зохиогч, дугаар г.м);
- b) онцгой хэрэгцээт хүмүүст хүргэх шаардлагыг харгалзан хэлбэр (хэл, программ хангамжийн хувилбар, график г.м) ба тээгч (цаас, цахим мэдээлэл г.м);
- c) тохиромж ба зохимжид дүн шинжилгээ хийх ба батлах.

7.5.3 *Баримтжуулсан мэдээллийн хяналт*: Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо болон энэхүү баримт бичигт шаардсан баримтжуулсан мэдээллийг дараах зорилгоор хянана:

- a) хэрэгцээтэй үед болон газарт хэрэглэхэд хүртээмжтэй болон тохиромжтой хэлбэрээр байгаа эсэх;
- b) зохих хэмжээнд хамгаалагдсан эсэх (нууцлал алдагдах, зүй бусаар ашиглах эсвэл бүрэн бүтэн байдал алдагдах эсвэл санамсаргүй өөрчлөгдөх г.м).

Баримтжуулсан мэдээллийг хянахын тулд байгууллага нь дараах үйл ажиллагаануудын аль тохирохыг авч үзнэ:

- a) түгээх, нэвтрэх, сэргээх, ашиглах;
- b) хамгаалалт ба аюулгүй байдал, үүнд илүүдэл багтана;
- c) байрлуулах ба гэмтлээс сэргийлэх, үүнд гаргацтай байдлыг хадгалах багтана;
- d) өөрчлөлтийг хянах (хувилбарын хяналт г.м);
- e) архивлах ба устгах;
- f) нууцлалыг хангах;
- g) хуучирсан мэдээллийг санамсаргүй ашиглахаас сэргийлэх.

Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны төлөвлөлт ба үр нөлөөтэй ажиллагаанд шаардагдах гаднын гаралтай баримтжуулсан мэдээллийг байгууллага зохих хэмжээнд тодорхойлох ба хянана. Тогтоосон хяналтыг баримтжуулсан мэдээлэл байдлаар хадгална.

## **8. Ажиллагаа**

### **8.1 Ажиллагааны төлөвлөлт ба хяналт**

8.1.1 *Ерөнхий зүйл:* Байгууллага нь боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээ эрхлэхэд шаардагдах үйл явц (4.4)-уудыг төлөвлөж, хэрэгжүүлж, хянах ба түүнчлэн 6.1-д тодорхойлсон арга хэмжээнүүдийг дараах арга замаар хэрэгжүүлнэ:

- a) боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээнд тавих шаардлагыг тодорхойлох;
- b) үйл явцад шалгуур тогтоох;
- c) боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээнд тавих шаардлагыг



хангахад хэрэгцээтэй нөөцийг тодорхойлох;

d) үйл явцуудыг шалгуурын дагуу хянах;

e) баримтжуулсан мэдээллийг:

1. үйл явц төлөвлөсний дагуу хэрэгжсэнд итгэл үнэмшилтэй байх;

2. боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээ нь тэдгээрт тавих шаардлагад тохирсныг харуулах хэр хэмжээнд тодорхойлж, хадгална.

Энэ төлөвлөлтийн гаралт нь байгууллагын ажиллагаанд тохирсон байна. Байгууллага нь төлөвлөсөн өөрчлөлтүүдийг хянах, санамсаргүй өөрчлөлтүүдийн үр дагаварт дүн шинжилгээ хийх, сөрөг нөлөөг шаардагдах хэмжээнд бууруулах арга хэмжээг авна. Байгууллага нь гаднаас гүйцэтгүүлсэн үйл явцуудыг хянах явдлыг хангана (8.4).

*8.1.2 Боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээний үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөлт ба хяналт:* Байгууллага нь боловсролын бүтээгдэхүүн ба дизайн, хөгжүүлэлт ба хүлээж буй үр дүнг төлөвлөнө, үүнд:

a) сургалтын үр дүн;

b) зохистой ба хүртээмжтэй заах арга ба сургалтын орчныг хангах;

c) сургалтын үнэлгээний шалгуурыг тодорхойлох;

d) сургалтын үнэлгээг хийх;

e) сайжруулах аргуудыг тодорхойлох ба хэрэгжүүлэх;

f) дэмжих үйлчилгээгээр хангах.

*8.1.3 Онцгой хэрэгцээт боловсролын нэмэлт шаардлагууд:* Байгууллага нь:

a) суралцагчийн ур чадвар, чадвар ба сонирхолд суурилсан суралцах үйл явцыг хамтран бүтээхийг дэмжих талаар уян хатан байдлыг харуулах, үүнд дараах аргуудыг багтаана:

1. дасан зохицох заавар;

2. товчилсон эсвэл баяжуулсан агуулга;

3. хоёр өөр хөтөлбөрөөр суралцах эсвэл боловсролын байгууллагуудад элсэхийг зөвшөөрөх;

4. бие даасан сургалтад тохирсон арга хэмжээ;
  5. суралцагчийн тодорхой мэдлэг ба ур чадварт тааруулан тухайн анги эсвэл сэдвийн хувьд жирийн насанд зохимжтой зэрэг эсвэл түвшний хүлээлтээс дээгүүр эсвэл доогуур болгон сургалтын төлөвлөгөөг тохируулах эсвэл боловсролын хөтөлбөрийг өөрчлөх;
  6. өмнөх сургалт ба туршлагыг хүлээн зөвшөөрөх;
- b) суралцагч бүрийн боломжит чадавхыг дэмжихийн тулд зохих нөөц бүхий багаар ажиллах орчныг бүрдүүлэх;
  - c) ажлын байран дахь боломжуудыг ашиглах холбоосоор хангах;
  - d) шаардлагатай хэмжээгээр эрүүл ба тэжээллэг хоол хүнсээр хангах.

## **8.2 Боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээнд тавих шаардлага**

*8.2.1 Боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээнд тавих шаардлагыг тодорхойлох:* Суралцагчид ба бусад үр шим хүртэгчдэд санал болгох боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээнд тавих шаардлагыг тодорхойлох тохиолдолд байгууллага нь дараах шаардлагуудыг багтаан боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээнд тавих шаардлагыг тодорхойлох явдлыг хангана:

- a) байгууллагын бодлого ба стратеги төлөвлөгөөний дагуу хэрэгтэй гэж авч үзсэн шаардлага;
- b) суралцагчид ба бусад үр шим хүртэгчдийг шаардлагыг (өнөөгийн болон ирээдүйн) тодорхойлохын тулд хийсэн хэрэгцээний шинжилгээний үр дүнгээс үүдэлтэй;
- c) олон улсын эрэлт ба хөгжлөөс үүдэлтэй;
- d) хөдөлмөрийн зах зээлийн үр дүнгээс үүдэлтэй;
- e) судалгааны үр дүнгээс үүдэлтэй;
- f) эрүүл мэнд аюулгүй байдлын шаардлага.

*8.2.2 Боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээний шаардлагыг мэдээлж харилцах:* Боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээг эхлэхдээ эсвэл хүргэхээс өмнө байгууллага нь суралцагчдад ба бусад холбогдох сонирхогч

талуудад мэдэгдэх бөгөөд шаардлагатай бол дараах зүйлсийн талаарх тэдний ойлголтыг шалгана:

- a) боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээний зорилго, хэлбэр ба агуулга, үүнд үнэлгээнд ашиглах арга хэрэгсэл ба шалгуурыг багтана;
- b) суралцагчид ба бусад үр шим хүртэгсдэд тавих үүрэг амлалт, хариуцлага ба хүлээлт;
- c) суралцаж мэдсэн ба үнэлсэн арга хэрэгслийг хүлээн зөвшөөрч баримтжуулсан мэдээлэл байдлаар хөтөлж хадгална;
- d) сонирхогч талууд сэтгэл ханамжгүй эсвэл боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо ба аливаа сонирхогч талуудын хооронд зөрчил үүссэн тохиолдолд хэрэглэх арга хэрэгслүүд;
- e) суралцах ба үнэлэхэд хэн дэмжлэг үзүүлэх болон хэрхэн дэмжих;
- f) сургалтын төлбөр, шалгалтын хураамж, сургалтын материалын худалдан авалт зэрэг зардлууд;
- g) шаардагдах ур чадвар (мэдээлэл харилцааны технологийн ур чадварыг оролцуулан), мэргэшил, мэргэжлийн туршлага зэрэг урьдчилсан нөхцөлүүд.

### 8.2.3 Боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээнд тавих шаардлагын өөрчлөлт

Байгууллага нь боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээнд тавих шаардлага өөрчлөгдсөн бол холбогдох баримтжуулсан мэдээллийг өөрчилж, холбогдох сонирхогч талуудыг энэ тухай мэдээллээр хангана.

## **8.3 Боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээний дизайн ба хөгжүүлэлт**

8.3.1 *Ерөнхий зүйл:* Байгууллага нь боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээг цаашид эрхлэх явдлыг хангахад тохирсон дизайн ба хөгжүүлэлтийн үйл явцыг бий болгож, хэрэгжүүлж, мөрдөнө.

8.3.2 *Дизайн ба хөгжүүлэлтийн төлөвлөлт:* Дизайн ба хөгжүүлэлтийн үе шат ба хяналтыг тодорхойлохын тулд байгууллага дараах зүйлсийг анхаарна:

- a) 8.2-т тодорхойлсон шаардлагууд;
- b) дизайн ба хөгжүүлэлтийн үйл ажиллагааны мөн чанар, үргэлжлэх хугацаа ба төвөгтэй байдал;

- c) шаардагдах үйл явцын үе шатууд, үүнд хэрэглэгдэх дизайн ба хөгжүүлэлтийн дүн шинжилгээ үүнд хамаарна;
- d) дизайн ба хөгжүүлэлтийг шалгах ба баталгаажуулах үйл ажиллагаа;
- e) дизайн ба хөгжүүлэлтийн үйл явцад оролцох хариуцлага ба эрх мэдэл;
- f) боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээний дизайн ба хөгжүүлэлтэд шаардагдах гадаад болон дотоод нөөц;
- g) дизайн ба хөгжүүлэлтэд оролцож буй хүмүүс хоорондын харилцааг хянах хэрэгцээ;
- h) суралцагчид ба бусад үр шим хүртэгсдийг дизайн ба хөгжүүлэлтэд татан оролцуулах хэрэгцээ;
- i) боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээг цаашид эрхлэхэд тавих шаардлага;
- j) дизайн ба хөгжүүлэлтийн явцад суралцагчид, бусад үр шим хүртэгсэд ба бусад сонирхогч талуудаас хүлээж болох хяналтын түвшин;
- k) дизайн ба хөгжүүлэлтэд тавих шаардлага хангасныг харуулахад хэрэгцээтэй баримтжуулсан мэдээлэл;
- l) нотолгоонд үндэслэсэн арга;
- m) ур чадвар, сонирхол ба чадавхад үндэслэн суралцах арга замыг хувь хүний болгоход суралцагчдаас шаардах хэр хэмжээ;
- n) сургалтын сэдэв боловсруулах, бэлтгэх ба хүргэх арга хэрэгслийг дахин ашиглах, нэвтрэх боломж, харилцан солилцох ба удаан хугацаанд хэрэглэх хэрэгцээ.

8.3.3 Дизайн ба боловсруулалтын оролтууд: Байгууллага нь тодорхой төрлийн боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээний дизайн ба хөгжүүлэлтэд чухал ач холбогдолтой шаардлагыг тодорхойлно. Байгууллага дараах зүйлсийг анхаарч үзнэ:

- a) чиг үүргийн болон гүйцэтгэлийн шаардлага;
- b) өмнөх ижил төстэй дизайн ба хөгжүүлэлтийн үйл ажиллагаанаас гаргаж авсан мэдээлэл;

- c) байгууллагаас хэрэгжүүлэхээр авсан үүрэг амлалтад хамаарах стандарт эсвэл дадлын дүрэм;
- d) боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээний мөн чанараас хамааран гарсан алдааны боломжит үр дагавар.

Оролтууд нь бүрэн ба хоёрдмол утгагүй бөгөөд дизайн ба хөгжүүлэлтэд тохирсон байна. Дизайн ба хөгжүүлэлтийн зөрчилтэй оролтуудыг шийдвэрлэсэн байна. Байгууллага нь дизайн ба хөгжүүлэлтийн оролтуудын талаарх баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална.

### 8.3.4 Дизайн ба хөгжүүлэлтийн хяналт

8.3.4.1 Байгууллага дараах зорилгоор дизайн ба хөгжүүлэлтийн үйл явцуудын хяналтыг хэрэглэнэ:

- a) хүрэх гэж буй үр дүнг тодорхойлсон байхыг;
- b) дизайн ба хөгжүүлэлтийн үр дүнгийн шаардлага хангах чадварыг үнэлэх зорилгоор дүн шинжилгээ хийсэн байхыг;
- c) боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээ нь тодорхой зориулалт ба хүссэн хэрэглээний болон тодорхой шаардлагыг биелүүлж байгааг хангахын тулд шалгалт ба баталгаажуулалтын үйл ажиллагаа хийж гүйцэтгэсэн байхыг;
- d) дүн шинжилгээ, шалгалт, баталгаажуулалтын үед гарсан аливаа асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байхыг.

Байгууллага нь дараах баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална:

- a) аливаа дүн шинжилгээ, шалгалт ба баталгаажуулалтын үйл ажиллагааны үр дүн;
- b) боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээнд тавих аливаа шинэ шаардлагууд.

8.3.4.2 *Боловсролын үйлчилгээний дизайн ба хөгжүүлэлтийн хяналт:* Дизайн ба хөгжүүлэлтийн үйл явцад хэрэглэх хяналт дараах зорилгыг хангана:

- a) анги эсвэл хөтөлбөрийн зорилго ба хамрах хүрээг суралцагчдын цаашдын судалгаа ба ажлын шаардлагыг хангах үүднээс

тодорхойлсон байх;

- b) урьдчилсан нөхцөл (хэрэв байгаа бол) тодорхойлсон байх;
- c) суралцагчдын мэдлэг ба ур чадварын үзүүлэлтийг тодорхойлсон байх;
- d) цаашдын судалгаа ба ажлын шаардлагыг мэддэг байх;
- e) боловсролын үйлчилгээ нь суралцагчдын шинж төлөвийг харгалзсан зорилго ба хамрах хүрээний шаардлагыг хангаж чаддаг;
- f) төгсөгчдийн мэдлэг ба ур чадварын үзүүлэлтийг тодорхойлсон байх.

**8.3.4.3 Хөтөлбөрийн дизайн ба хөгжүүлэлтийн хяналт:** Дизайн ба хөгжүүлэлтийн үйл явцад хэрэглэх хяналт дараах зорилгыг хангана:

a) сургалтын үр дүн:

- 1. сургалтын анги эсвэл хөтөлбөрийн хамрах хүрээнд нийцсэн байх;
- 2. сургалтын хөтөлбөрийг дүүргэх замаар суралцагчид эзэмшвэл зохих чадамжийн талаар тайлбарласан;
- 3. чадамжид хүрэх түвшнийг зааж оруулах;
- 4. тодорхой, хэмжигдэхүйц, гүйцэтгэх боломжтой, хамаарал бүхий бөгөөд хугацаа тогтоосон байх;

b) сургалтын үйл ажиллагаа:

- 1. боловсрол эзэмшүүлэх аргад тохирсон байх;
- 2. сургалтын үр дүнг хангахад зохимжтой байх;
- 3. тодорхой, хэмжигдэхүйц, гүйцэтгэх боломжтой, хамаарал бүхий бөгөөд хугацаа тогтоосон байх;

c) сургалтын үйл ажиллагааг амжилттай гүйцэтгэхэд шаардагдах бүх нөөцийг тодорхойлсон байх;

d) сургалтын дизайнд зохимжтой боломжуудыг оруулсан байх:

- 1. сургалтын үйл явцыг бий болгоход суралцагчдыг идэвхтэй оролцуулахын тулд;
- 2. үнэлгээ боловсруулах ба санал хүсэлт авахын тулд.

**8.3.4.4 Нийлбэр үнэлгээний дизайн ба хөгжүүлэлтийн хяналт:** Дизайн ба

хөгжүүлэлтийн үйл явцад хэрэглэх нийлбэр үнэлгээний хяналт нь дараах зорилгыг хангана:

- a) үнэлгээний дизайн ба сургалтын үр дүн хоорондын тодорхой холбоосыг харуулах бололцоотой ба энэ нь сургалтын үр дүнг үнэлэхээр зорьж байгаа, тохиромжтой үед энэ нь мөн суралцах үйл ажиллагаа дээр үндэслэдэг;
- b) үйл ажиллагааг ил тод байх, хүртээмжтэй байх, суралцагчийг хүндэлдэг байх, шударга, ялангуяа үнэлэхдээ шударга байх зарчмуудыг харгалзан үзэж явуулах;
- c) үнэлгээний системийг тодорхойлох ба баталгаажуулна.

8.3.5 *Дизайн ба хөгжүүлэлтийн гаралт:* Байгууллага дизайн ба хөгжүүлэлтийн гаралтыг дараах байдлаар хангана:

- a) оролтын шаардлагыг биелүүлэх;
- b) боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээ эрхлэх цаашдын үйл явцад тохирсон байх;
- c) мониторинг ба хэмжилтийн шаардлага (тохиромжтой бол) ба хүлээж авах шалгуурыг тусгах эсвэл эш татах;
- d) боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээний хүссэн зорилго ба тэдгээрийг аюулгүй ба зөв эрхлэхэд чухал ач холбогдолтой үзүүлэлтүүдийг тогтоох;
- e) баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгалах.

8.3.6 *Дизайн ба хөгжүүлэлтийн өөрчлөлт:* Байгууллага нь шаардлагад тохирсон байдал эсвэл үр дүнд сөргөөр нөлөөлөхгүй байх явдлыг байдлыг хангах хэр хэмжээнд боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээний дизайн ба хөгжүүлэлтийн явцад эсвэл дараа нь гарсан өөрчлөлтийг тогтоож, дүн шинжилгээ хийж, хянана. Байгууллага дараах баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална. Үүнд:

- a) дизайн ба хөгжүүлэлтийн өөрчлөлт;
- b) дүн шинжилгээний үр дүн;
- c) өөрчлөлт хийх зөвшөөрөл;

d) сөрөгнөлөөллөөс сэргийлэх арга хэмжээ.

#### **8.4 Гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн ба үйлчилгээний хяналт**

*8.4.1 Ерөнхий зүйл:* Байгууллага нь гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн ба үйлчилгээ нь шаардлагад тохирсон байх явдлыг хангана.

Байгууллага нь гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн ба үйлчилгээнд хэрэглэх хяналтыг дараах тохиолдолд тодорхойлно:

- a) гаднаас нийлүүлж буй бүтээгдэхүүн ба үйлчилгээг байгууллага өөрийнхөө бүтээгдэхүүн ба үйлчилгээтэй нэгтгэх;
- b) суралцагчид ба бусад үр шим хүртэгсдэд шууд хүргэх бүтээгдэхүүн ба үйлчилгээг гаднын нийлүүлэгч байгууллагын нэрийн өмнөөс хийж байгаа;
- c) үйл явц болон түүний хэсгийг байгууллагын шийдвэрийн дагуу гаднын нийлүүлэгч гүйцэтгэж байгаа.

Байгууллага нь шаардлагын дагуу үйл явц, бүтээгдэхүүн ба үйлчилгээг хангах гаднын нийлүүлэгчдийн чадварт үндэслэн тэдгээрийн гүйцэтгэлийг үнэлэх, сонгох, мониторинг хийх ба дахин үнэлэх шалгуурыг тодорхойлох ба хэрэглэнэ. Байгууллага эдгээр үйл ажиллагаа ба үнэлгээнээс үүдэн шаардлагатай гэж хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална.

*8.4.2 Хяналтын төрөл ба хэр хэмжээ:* Байгууллагын гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн ба үйлчилгээ нь байгууллагынхаа бүтээгдэхүүн ба үйлчилгээг суралцагчид ба бусад үр шим хүртэгсдэд тогтвортой хүргэх чадварт сөрөг нөлөө үзүүлэхгүй байх явдлыг хангана. Байгууллага нь:

- a) гаднаас нийлүүлж байгаа үйл явц нь боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны хяналтад байх явдлыг хангана;
- b) гаднын нийлүүлэгчид хэрэглэхээр зорьсон болон түүний үр дүнгийн гаралтад хэрэглэхээр зорьсон хяналт аль алийг нь тодорхойлно;
- c) дараах асуудлыг анхаарч үзнэ:

1. суралцагч болон бусад үр шим хүртэгчдийн шаардлагыг тууштай



хангах байгууллагын чадварт гаднаас нийлүүлж байгаа үйл явц, бүтээгдэхүүн ба үйлчилгээний үзүүлэх боломжит нөлөөлөл;

2. гаднын нийлүүлэгчдэд хэрэглэж байгаа хяналтын үр нөлөө;

d) гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн ба үйлчилгээ нь шаардлага хангаж буйг харуулахад шаардагдах шалгалт эсвэл бусад үйл ажиллагааг тодорхойлно.

**8.4.3 Гаднын нийлүүлэгчдэд зориулсан мэдээлэл:** Байгууллага дараах зүйлст зориулсан өөрийнхөө шаардлагын талаар гаднын нийлүүлэгчидтэй мэдээлж харилцана:

a) нийлүүлэх гэж байгаа үйл явц, бүтээгдэхүүн ба үйлчилгээ;

b) баталгаа:

1. бүтээгдэхүүн ба үйлчилгээ;

2. арга, үйл явцууд ба тоног төхөөрөмж;

3. бүтээгдэхүүн ба үйлчилгээг гаргах;

c) ажилтнуудын чадамж, тэдгээрийн мэргэшсэн байдал үүнд багтана;

d) гаднын нийлүүлэгчтэй байгууллагын харилцах харилцаа;

e) байгууллагаас хэрэглэх гаднын нийлүүлэгчийн гүйцэтгэлийн хяналт ба мониторинг;

f) гаднын нийлүүлэгчийн байранд байгууллага эсвэл түүний суралцагчид ба бусад үр шим хүртэгсэд гүйцэтгэхээр зорьсон үйл ажиллагааны шалгалт эсвэл баталгаажуулалт.

## **8.5 Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх**

8.5.1 Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний ажлын хяналт

**8.5.1.1. Ерөнхий зүйл:** Байгууллага үйлдвэрлэл ба үйлчилгээг хяналттай нөхцөлд хэрэгжүүлнэ. Хяналттай нөхцөлд дор дурдсанаас аль хэрэглэж болохыг нь оруулна:

a) дараах зүйлсийг тодорхойлсон баримтжуулсан мэдээллийн бэлэн байлгах:

1. бий болгох гэж байгаа боловсролын бүтээгдэхүүн, үзүүлэх гэж

буй боловсролын үйлчилгээ, эсвэл гүйцэтгэх гэж буй ажлын үзүүлэлтүүд;

2. хүрэх үр дүнгийн талаар;

- b) мониторинг ба хэмжилтийн зохимжтой ба баталгаатай нөөцийн хүртээмж ба хэрэглээ;
- c) мониторинг ба хэмжилтийн үйл ажиллагааны хэрэгжилт, үүнд үйл явц эсвэл гаралтын хяналтын шалгуурууд болон боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээг хүлээн авах шалгууруудыг шалгахын тулд гомдол ба бусад санал хүсэлт, зохих үе шатууд дахь үнэлгээний үр дүнг авч үзэх явдал багтана;
- d) үйл явцыг хэрэгжүүлэхэд тохиромжтой дэд бүтэц ба орчныг ашиглах;
- e) шаардагдах мэргэшил бүхий чадамжтай ажилтныг томилох (7.2);
- f) цаашдын мониторинг буюу хэмжилтээр үр дүнгийн гаралтыг нь шалгах боломжгүй бүтээгдэхүүн ба үйлчилгээ эрхлэхэд зориулсан үйл явцууд нь төлөвлөсөн үр дүнд хүрэх чадварыг баталгаажуулах, үе үе дахин баталгаажуулах;
- g) хүмүүсийг алдаа гаргахаас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- h) гаргах, нийлүүлэх ба нийлүүлсний дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

#### 8.5.1.2 Суралцагчдын элсэлт

*Элсэлтийн өмнөх мэдээлэл:* Боловсролын байгууллага нь суралцагчдыг элсэхээс нь өмнө дараах мэдээллээр хангана:

- a) байгууллагын шаардлага ба мэргэжлийн шаардлага, түүнчлэн нийгмийн хариуцлагын талаарх байгууллагын үүрэг амлалтыг харгалзан авч үзсэн хангалттай мэдээлэл;
- b) дараах чиглэлээр хангалттай бөгөөд тодорхой мэдээлэл:
  - 1. сургалтын зорилго, албан тушаал ахих хэтийн төлөв, боловсролын арга барил;
  - 2. сургалтын үйл явцад суралцагч болон бусад үр шим хүртэгчдийн зохистой оролцоо;

3. элсэлтийн шалгуур, боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээний өртөг;

*Элсэлтийн нөхцөл:* Байгууллага нь суралцагчдыг элсүүлэх үйл явцыг бий болгоно. Түүнчлэн 4.4.1-д заасан шаардлагаас гадна энэ үйл явц:

- a) дараах шаардлагад тохирсон элсэлтийн шалгуурыг тогтооно;
  - 1) байгууллагын шаардлага;
  - 2) мэргэжлийн чиглэлээс тавих шаардлага;
  - 3) хөтөлбөрийн агуулга ба/эсвэл заах арга зүйн агуулгаар тавих шаардлага;
- b) элсэлтийн шалгуур ба үйл явцыг бүх суралцагчид нэгэн жигд хэрэглэх явдлыг хангах;
- c) баримтжуулсан мэдээлэл байдлаар мөрдөж хадгалагдах;
- d) олон нийтэд нээлттэй байх;
- e) элсэлтийн шийдвэр бүрийг мөшгөх бололцоог хангах;
- f) элсэлтийн шийдвэрийн нотолгоог баримтжуулан мэдээлэл байдлаар хөтөлж хадгалах;

*8.5.1.3 Боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээг хүргэх:* Байгууллага нь дараах үйл явцыг бий болгоно:

- 1) сургах;
- 2) сурах үйл явцыг дэмжих;
- 3) сурахад захиргааны дэмжлэг үзүүлэх;

*8.5.1.4 Хураангуй үнэлгээ:* Байгууллага нь:

- a) бусдаас хуулах болон бусад зөрчилтэй үйлдлүүдийг илрүүлэх аргаар хангах энэ тухай суралцагчдад мэдээлнэ;
- b) суралцагчийн үнэлүүлсэн ажил ба өгсөн үнэлгээ хоорондын бодит холбоог тогтоохын тулд сурлагын амжилтыг мөшгөх явдлыг хангана;
- c) үнэлгээний баримтжуулсан мэдээллийг үнэлгээ өгсөн нотолгоо болгон хөтөлж хадгална;

- d) эдгээр баримтжуулсан мэдээллийг хадгалах хугацааг нийтэд нээлттэй байлгана.

**8.5.1.5 Үнэлэгдсэн сургалтыг хүлээн зөвшөөрөх:** Байгууллага нь хураангуй үнэлгээний дараа:

- a) үнэлгээний үйл ажиллагааны үр дүн ба үнэлгээний түвшний талаар суралцагчид мэдээлнэ;
- b) суралцагчдад үнэлгээний үйл ажиллагааны үр дүн ба үнэлгээний түвшнийг залруулах хүсэлт эсвэл гомдол гаргах боломж олгоно;
- c) суралцагчид үнэлүүлсэн ажил ба түүний нарийвчилсан үнэлгээний мэдээлэлд бүрэн нэвтрэх ба санал хүсэлт гаргах боломжийг бүрэн ашиглана;
- d) үнэлгээний үр дүнгийн нотолгоог суралцагчдад баримтжуулсан мэдээллээр байдлаар олгоно;
- e) үнэлгээний түвшин ба эцсийн үнэлгээний шийдвэрийн үндэслэлийг баримтжуулсан мэдээлэл байдлаар хадгална;
- f) баримтжуулсан мэдээллийг хадгалах тодорхой хугацааны туршид хадгална;
- g) баримтжуулсан мэдээллийг хадгалах хугацаа нийтэд нээлттэй байна.

**8.5.1.6 Онцгой хэрэгцээт боловсролын нэмэлт шаардлагууд:** Суралцагчид ба сонирхогч талуудын оролцоотойгоор, байгууллагын удирдлага, багшлах ба туслах ажилтнууд боловсролын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах алхмуудыг тодорхойлж болно. Байгууллага нь тодорхой хугацааны дотор юу боломжтой байж болох талаар зохих үндэслэлтэй шийдвэр гаргаж хэрэгжүүлнэ. Сургалтыг явуулахтай холбогдуулан байгууллага нь дараах зүйлсийг хэрэгжүүлбэл зохино:

- a) танхимд суралцагчдад зориулсан ялгавартай сургалтын стратегийг ашиглах;
- b) өөрийгөө танин мэдэх, өөрийгөө удирдах болон мета танин мэдэхүйн хөгжлийг дэмжих зорилгоор онцгой хэрэгцээт суралцагчдад санал болгодог аргуудыг ашиглах;

- c) суралцагч, боловсрол олгогчийн хэрэгцээ, сургалтын анги, том хүрээнд дахь (жишээ нь: хөтөлбөрийн шаардлага, үндэсний үнэт зүйлс) агуулга (орчин)-ын шаардлагыг тэнцвэржүүлэх;
- d) хэрэглэж болохуйц хувь хүний арга хэмжээг уян хатан хэрэгжүүлэх:
  - 1. сургалтын хөтөлбөрийг өөрчлөх;
  - 2. бие даах ба хараат бус байдлыг дэмжих;
  - 3. ганцаарчлан сургах ба халамжлах;

Сургалт үнэлэхтэй холбогдуулан байгууллага нь дараах зүйлсийг хэрэгжүүлбэл зохино:

- a) зааврын дагуу орсон сэдвээр өөрийн ур чадварыг харуулах олон төрлийн боломжийг суралцагчдад олгох;
- b) суралцагчдыг суралцах чадвараа хөгжүүлэх боломж олгодог шаталсан сургалтын үйл ажиллагаагаар хангах;
- c) үнэлгээний зохистой аргуудыг багтаасан бие даасан арга хэмжээг уян хатан байдлаар хэрэгжүүлэх

Сургалтын тохиролцсон үр дүнд хүрэхийн тулд тодорхой туслалцаа шаарддаг суралцагчдыг суралцагчийн шаардлага, сургалтын үр дүнгийн үнэн бүрэн байдал ба боловсролын байгууллагын чадавхыг тэнцвэржүүлэх байдлаар зохион байгуулна.

**8.5.2 Тэмдэглэх ба мөшгөх:** Боловсролын байгууллага нь дараах зүйлстэй холбогдуулан тэмдэглэх ба мөшгөх явдлыг хангана:

- a) байгууллагын хэмжээнд суралцагчдын ахиц;
- b) хэрэглэх боломжоор нь анги эсвэл хөтөлбөрийг дүүргэсэн эсвэл төгссөн хүмүүсийн сургалт ба ажил эрхлэлтийн судалгаа;
- c) дараах зүйлсийн ажилтнуудын гаргасан ажлын үр дүн: юу хийж хийсэн; хэзээ; хэн.

**8.5.3 Сонирхогч талуудад хамаарах эд хөрөнгө:** Боловсролын байгууллага нь өөрийн хяналтад байгаа эсвэл ашиглаж байгаа аливаа сонирхогч талын эд хөрөнгийг хамгаална. Боловсролын байгууллага нь аливаа эд хөрөнгийг өөрийн боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээнд ашиглах эсвэл зөвшөөрөл

авах гэж байгаа бол түүнийг тэмдэглэж, шалгаж, хамгаалах ба хөнөөлөөс сэргийлнэ. Сонирхогч талын эд хөрөнгө алдагдах, гэмтэх эсвэл ашиглах боломжгүй болгоход хүргэсэн бол байгууллага энэ тухай сонирхогч талд мэдээлэх ба зохих залруулах арга хэмжээ (8.5.5 ба 10.2) авч болсон явдлын тухай баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална.

**8.5.4 Хамгаалалт:** Байгууллага нь бүтээгдэхүүн ба үйлчилгээ эрхлэх явцад шаардлагын тохирлыг хангах хэр хэмжээнд гаралтуудыг хамгаална.

**8.5.5 суралцагчдын талаарх мэдээллийн хамгаалалт ба ил тод байдал:** Байгууллага суралцагчдын талаарх мэдээллийг хамгаалах ба ил тод байлгах аргыг тогтоож, түүнийг баримтжуулсан мэдээлэл хэлбэрээр мөрдөж хадгална. Энэ арга дараах зүйлсийг тогтооно:

- a) суралцагчийн ямар мэдээллийг цуглуулсан, мэдээллийг хэрхэн, хаана боловсруулсан ба хадгалсан;
- b) хэн мэдээлэлд нэвтэрсэн;
- c) суралцагчийн мэдээллийг ямар нөхцөлд гуравдагч талуудтай хуваалцаж болох;
- d) мэдээллийг хэр хугацаанд хадгалах аргууд орно.

Байгууллага суралцагчдын мэдээллийг зөвхөн тэдний тодорхой зөвшөөрөлтэйгөөр цуглуулж, бусадтай хуваалцана. Байгууллага нь суралцагчид ба бусад сонирхогч талуудад өөрсдийнхөө мэдээлэлд нэвтрэх, өөрсдийнхөө мэдээллийг залруулах эсвэл шинэчлэх бололцоо олговол зохино. Байгууллага суралцагчдын мэдээлэлд зөвхөн эрх бүхий хүмүүс нэвтрэх явдлыг хангах тохиромжтой арга хэмжээ авна. Технологийн хамгаалалтын арга хэмжээг баталгаажуулна. Байгууллага суралцагчид ба бусад сонирхогч талуудад өөрсдийнхөө мэдээлэлд нэвтрэх эрх олгоно.

**8.5.6. Боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээний өөрчлөлтийн хяналт:** Байгууллага нь үйлдвэрлэл эсвэл үйлчилгээ эрхлэх үеийн өөрчлөлтүүдийг нь шаардлагад үргэлжлэн тохирч байгааг хангах хэр хэмжээнд хянах ба дүн шинжилгээ хийнэ. Байгууллага нь эдгээр өөрчлөлтөд хийсэн дүн шинжилгээний үр дүн, өөрчлөлт хийх эрх бүхий ажилтны мэдээлэл, дүн шинжилгээний дагуу авсан арга хэмжээнүүдийг тайлбарласан баримтжуулсан

мэдээллийг хөтөлж хадгална.

## **8.6 Боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээг гаргах**

Төлөвлөсөн арга хэмжээ хангалттай хэрэгжиж дуусах хүртэл, суралцагчид ба бусад үр шим хүртэгсэд хэрэглэж болохуйц, холбогдох эрх бүхий этгээд зөвшөөрснөөс бусад тохиолдолд бүтээгдэхүүн ба үйлчилгээг суралцагчид ба бусад үр шим хүртэгсдэд гаргахгүй. Байгууллага нь бүтээгдэхүүн ба үйлчилгээг гаргасан талаар баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална. Баримтжуулсан мэдээлэлд дараах зүйлс орно:

- a) хүлээн авах шалгуурт тохирсны нотолгоо;
- b) гаргахыг зөвшөөрсөн хүнийг мөшгөх боломж.

## **8.7 Боловсролын үл тохирол бүхий гаралтын хяналт**

8.7.1 Байгууллага нь шаардлагад тохирохгүй гаралтуудыг хүсээгүй хэрэглээ ба нийлүүлэлтээс сэргийлж тэмдэглэх ба хянах явдлыг хангана. Байгууллага нь үл тохирлын мөн чанар болон түүний боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээний тохиролд үзүүлэх үр дагаварт тохирох арга хэмжээ авна. Энэ нь бүтээгдэхүүн нийлүүлсний дараа, үйлчилгээ эрхлэх үед эсвэл дараа нь тогтоогдсон боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээнд хамаарна.

8.7.2 Байгууллага үл тохирох гаралтуудыг дор дурдсан арга замуудаас нэг эсвэл хэд хэдийг хэрэглэн шийдвэрлэнэ:

- a) залруулга;
- b) бүтээгдэхүүн ба үйлчилгээ эрхлэхийг тусгаарлах, хязгаарлах, буцаах эсвэл түдгэлзүүлэх;
- c) суралцагчид ба бусад боловсролын үр шимийг хүртэгсдэд мэдээлэх;
- d) хүлээн авахыг тохиролцож зөвшөөрөл авах.

8.7.3 Байгууллага нь дараах баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална:

- a) хөтөлбөрийг хүргэсэн талаарх тайлбар;
- b) аливаа үл тохирол бүхий гаралтуудын талаарх тайлбар;
- c) авсан арга хэмжээний тухай тайлбар;
- d) тохиролцож зөвшөөрөл авсан талаарх тайлбар;

е) үл тохирлын талаар арга хэмжээ авах эрх мэдлийг тогтоосон талаар.

## **9. Гүйцэтгэлийн үнэлгээ**

### **9.1 Мониторинг, хэмжилт, шинжилгээ ба үнэлгээ**

*9.1.1 Ерөнхий зүйл:* Байгууллага дараах зүйлсийг тодорхойлно:

- a) ямар хэрэгцээнд мониторинг ба хэмжилт хийх; хүчинтэй үр дүнг хангахад хэрэглэх болохуйц нь мониторинг, хяналт, хэмжилт, шинжилгээ, үнэлгээний аргууд;
- b) хүлээн зөвшөөрөхөд хэрэглэх шалгуурууд;
- c) хэдийд мониторинг ба хэмжилт хэдийд хийх;
- d) хэдийд мониторинг ба хэмжилтийн үр дүнд шинжилгээ ба үнэлгээ хийх.

Байгууллага нь мониторинг, хэмжилт, шинжилгээ ба тэдгээрийн үр дүнгийн нотлох баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална. Байгууллага нь боловсролын байгууллагын гүйцэтгэл болон боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны үр нөлөөг үнэлнэ. Хүмүүст өөрсдийгөө хөгжүүлэхэд нь хувь нэмэр болгож ажилдаа бүтээлч ба ажил хэрэгч байдлаар дүн шинжилгээ хийх боломж олговол зохино.

*9.1.2 суралцагчид, бусад боловсролын үр шимийг хүртэгч ба ажилтнуудын сэтгэл ханамж*

*Сэтгэл ханамжийн мониторинг:* Байгууллага нь суралцагчид, бусад боловсролын үр шимийг хүртэгч болон ажилтнуудын сэтгэл ханамжид, түүнчлэн тэдгээрийн хэрэгцээ ба хүлээлт хэр хэмжээнд хангагдаж байгаа талаарх ойлголт төсөөлөлд мониторинг хийнэ. Байгууллага нь энэ мэдээллийг олж авах, мониторинг, дүн шинжилгээ хийх аргыг тодорхойлно.

*Гомдол ба заргыг шийдвэрлэх:* Боловсролын байгууллага нь гомдол ба зарга маргаан шийдвэрлэх аргыг бий болгож баримтжуулсан мэдээлэл хэлбэрээр мөрдөж хадгалах ба үүнийг сонирхогч талуудад мэдэгдэнэ. Энэ аргад дараах зүйлсийг тодорхойлох үзүүлэлтүүд багтана:

- a) уг аргыг холбогдох бүх сонирхогчдод мэдээлж харилцах;
- b) гомдол ба зарга хүлээн авах;
- c) гомдол ба заргыг мөшгөх;



- d) гомдол ба заргыг хүлээн зөвшөөрөх;
- e) гомдол ба заргад эхний үнэлэлт өгөх;
- f) гомдол ба заргыг шинжлэх;
- g) гомдол ба заргад хариулт өгөх;
- h) шийдвэрийг мэдээлэх;
- i) гомдол ба заргыг хаах;

Энэ арга нь гомдол гарагч ба заргалдагчийн нууцлал болон гомдол ба зарга шүүгчийн бодитой байдлыг хангана. Байгууллага нь хүлээн авсан гомдол ба зарга, мөн гаргасан шийдвэрийг нотлох баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална.

*9.1.3 Бусад мониторинг ба хэмжилтийн хэрэгцээ:* Байгууллага нь дараах санал хүсэлтийг холбогдох сонирхогч талуудаас шаардаж авах ба шаардлагатай бол тэдэнд эргэж мэдээлэх явдлыг хангана:

- a) боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээний талаарх санал хүсэлт;
- b) сургалтын тохиролцсон үр дүнд хүрэхэд тэдгээрийн үр нөлөөний талаарх санал хүсэлт;
- c) байгууллагын нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаарх санал хүсэлт.

Байгууллага нь хүлээн авсан санал хүсэлтийн түвшинд мониторинг хийх ба хангалтгүй тохиолдолд түвшнийг дээшлүүлэх арга хэмжээ авна.

*9.1.4 Мониторинг, хэмжилт, шинжилгээ болон үнэлгээ хийх аргууд:* Байгууллага нь дараах зүйлсийг тодорхойлно:

- a) гүйцэтгэлийн талаарх мэдээлэл олж авах, мониторинг ба дүн шинжилгээ хийх аргууд;
- b) гүйцэтгэлийг хэмжихэд харьцуулах зорилтууд.

Байгууллага нь:

- a) үнэлгээнд оролцсон эсвэл үнэлгээ нөлөөлсөн сонирхогч талуудыг тодорхойлсон байх;
- b) үнэлгээ хийж байгаа хүмүүс чадамжтай ба бодитой ханддаг байх;

- с) үнэлгээний тайлан ил тод бөгөөд, боловсролын бүтээгдэхүүн ба үйлчилгээ тэдгээрийн зорилтууд, үр дүн, мөн үр дүнг тайлбарлахад ашигласан үндэслэл ба арга, хэтийн төлөвийг тодорхой тайлбарласан байх;
- д) боловсролын үйлчилгээнд үзүүлэх нөлөөллийг тодорхойлохын тулд боловсролын үйлчилгээг үзүүлсэн төлөв байдал (сургалтын орчин г.м)-ыг нарийвчлан шалгасан байхыг хангана.

**9.1.5 Шинжилгээ ба үнэлгээ:** Байгууллага нь мониторинг ба хэмжилтийн үр дүнгээс гарах зохих өгөгдөл ба мэдээллийг шинжлэх ба үнэлнэ. Шинжилгээний үр дүнг дараах зүйлсийг үнэлэхэд ашиглана:

- а) бүтээгдэхүүн ба үйлчилгээний тохирол;
- б) боловсролын үр шимийг хүртэгчийн сэтгэл ханамжийн түвшин;
- с) ажилтны сэтгэл ханамжийн түвшин;
- д) боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны гүйцэтгэл ба үр нөлөө;
- е) төлөвлөлтийг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн байдал;
- ф) эрсдэл болон боломжийг авч үзсэн арга хэмжээний үр нөлөө;
- г) гаднын нийлүүлэгчийн гүйцэтгэл;
- h) боловсролын байгууллагын менежментийн тогтолцоог сайжруулах хэрэгцээ.

## **9.2 Дотоод аудит**

9.2.1 Байгууллага нь боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны талаар дор дурдсан мэдээллийг олж авахын тулд дотоод аудитыг төлөвлөсөн хугацаанд хийнэ:

- а) дараах шаардлагад тохирч байгаа эсэх:
  - 1. боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо нь байгууллагын өөрийн шаардлага;
  - 2. энэхүү баримт бичгийн шаардлага;
- б) үр нөлөөтэй хэрэгжиж, хэвийн ажиллаж байгаа эсэх.

### 9.2.2 Байгууллага нь:

- a) аудитын хөтөлбөрийг төлөвлөж, бий болгож, хэрэгжүүлж, мөрдөнө, үүнд давтамж, арга, хариуцлага, боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны зорилтууд, холбогдох үйл явцуудын ач холбогдол, байгууллагад нөлөөлж буй өөрчлөлтүүд, өмнөх аудитын үр дүнг анхаарч үзсэн төлөвлөлтийн шаардлага ба тайлагнал багтана.
- b) аудит тус бүрийн шалгуур, хамрах хүрээг тогтооно;
- c) аудитын үйл явцын бодит ба шударга байдлыг хангахын тулд аудиторруудыг сонгох ба аудитыг хийж гүйцэтгэнэ;
- d) аудитын үр дүнг холбогдох удирдлагад тайлагнах явдлыг хангана;
- e) сайжруулах боломжуудыг тодорхойлно;
- f) зохих залруулга ба залруулах арга хэмжээг хойшлуулалгүй авна;
- g) аудитын хөтөлбөр хэрэгжсэн тухай болон аудитын үр дүнгийн нотолгоо болох баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална.

### 9.3 Удирдлагын дүн шинжилгээ

9.3.1 *Ерөнхий зүйл:* Дээд удирдлага нь боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны тохиромж, зохимж ба үр нөлөө нь тасралтгүй хэрэгжилтийг хангахын тулд байгууллагын боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо ба стратегид төлөвлөсөн хугацаанд дүн шинжилгээ хийнэ.

9.3.2 *Удирдлагын дүн шинжилгээний оролтууд:* Удирдлагын дүн шинжилгээгээр дараах асуудлуудыг анхаарч үзнэ:

- a) өмнөх удирдлагын дүн шинжилгээний дагуу авсан арга хэмжээний төлөв байдал;
- b) боловсролын байгууллагын менежментийн тогтолцоонд хамаарах гадаад болон дотоод асуудлуудад гарсан өөрчлөлтүүд;
- c) боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны гүйцэтгэл ба үр нөлөөний талаарх мэдээлэл, үүнд дараах асуудлуудын хэтийн төлөв орно:
  1. суралцагч болон бусад боловсролын үр шим хүртэгчийн сэтгэл

ханамж болон суралцагч ба бусад боловсролын үр шим хүртэгчдийн шаардлагатай холбоотой санал хүсэлт;

2. зорилтууд биелэгдсэн хэр хэмжээ;
  3. үйл явцын гүйцэтгэл болон бүтээгдэхүүн ба үйлчилгээний тохирол;
  4. үл тохирлууд ба залруулах арга хэмжээнүүд;
  5. мониторинг ба хэмжилтийн үр дүнгүүд;
  6. аудитын үр дүнгүүд;
  7. гаднын нийлүүлэгчдийн гүйцэтгэл
  8. явцын ба хураангуй үнэлгээний үр дүн нөөцийн хангалттай байдал;
- d) нөөцийн хангалттай байдал;
- e) эрсдэл болон боломжийг авч үзсэн арга хэмжээний үр нөлөө (6.1);
- f) байнга сайжруулах боломжууд;
- g) өөрсдийн чадамжаа сайжруулах үйл ажиллагаатай холбогдуулан ажилтнуудаас ирсэн санал хүсэлт.

**9.3.3 Удирдлагын дүн шинжилгээний гаралтууд:** Удирдлагын дүн шинжилгээний гаралтад дараах асуудлуудтай холбоотой шийдвэрүүд хамаарна:

- a) байнга сайжруулах боломжууд;
- b) боловсролын байгууллагын менежментийн тогтолцоонд оруулах аливаа өөрчлөлтийн хэрэгцээ;
- c) нөөцийн хэрэгцээ.

## **10. Сайжруулалт**

**10.1.1 Үл тохирол ба залруулах арга хэмжээ:** Үл тохирол илрэх үед байгууллага нь дараах арга хэмжээг авна. Үүнд:

- a) үл тохирлын эсрэг доорх арга хэмжээний аль тохирохыг нь авч хэрэгжүүлнэ:
  1. хянаж, залруулах арга хэмжээ авах;
  2. үр дагаврыг арилгах;

- b) мөн дараах замаар үл тохирол хаа нэгтээ илрэх, дахин илрэхээс сэргийлэх зорилгоор түүний шалтгааныг арилгах арга хэмжээний хэрэгцээг үнэлэх,
  - 1. үл тохиролд дүн шинжилгээ хийх;
  - 2. үл тохирлын шалтгааныг тодорхойлох;
  - 3. ижил төстэй үл тохирлууд байгааг, эсвэл тохиолдож болохыг тодорхойлох;
- c) шаардлагатай аливаа арга хэмжээг авах;
- d) аливаа залруулах арга хэмжээний үр нөлөөнд дүн шинжилгээ хийх;
- e) шаардлагатай гэж үзвэл боловсролын байгууллагын менежментийн тогтолцоонд өөрчлөлт оруулах.

Залруулах арга хэмжээ нь илэрсэн үл тохирлын үр дагаварт тохирсон байна. Боловсролын байгууллага нь баримтжуулсан мэдээллийг:

- a) үл тохирлын мөн чанар, түүний дагуу авсан арга хэмжээнүүдийг ба;
- b) аливаа залруулах арга хэмжээний үр дүнг нотлох үүднээс хадгална.

*Гурав. Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлэх талаар:*

1. Дэлхийн улс орнууд дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын баталгаажуулалтын системийг төлөвшүүлэхэд европын холбооны баримт бичгийг жишиг болгон ашиглах хандлага түгээмэл байна.
2. Иймээс манай дээд боловсролын сургалтын байгууллагуудад “Европын дээд боловсролын орон зайн чанарын баталгаажуулалтын стандарт ба зөвлөмж” баримт бичигт үндэслэн өөрийн сургуулийн онцлог тохируулан нэвтрүүлэх нь үр дүнтэй тул санал болгож байна (энэхүү баримт бичгийг төслийн хүрээнд орчуулав).
3. *Европын дээд боловсролын орон зайн чанарын баталгаажуулалтын стандарт ба зөвлөмж*” баримт бичиг

**Нэг. Дотоод чанарын баталгаажуулалтын стандарт ба зөвлөмжүүд**

1.1. Чанарын баталгаажуулалтын бодлого

*Стандарт:* Дээд боловсролын сургалтын байгууллага нь стратегийн нэг хэсэг болгож, олон нийтэд мэдээлсэн чанарын баталгаажуулалтын бодлоготой байна. энэхүү бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд хөндлөнгийн болон дотоод оролцогч талуудыг холбогдох бүтэц, үл явцаар дамжуулан оролцуулдаг байна.

*Зөвлөмж:* Бодлого болон үйл явц нь тасралтын сайжруулалтын мөчлөгийг үүсгэж, байгууллагын хариуцлагыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг харилцан уялдаатай үндэсний чанарын баталгаажуулалтын тогтолцооны цөм юм. Энэ нь чанарын төлөөх хариуцлагыг дотоод оролцогч талууд бүгдээр ухамсарлаж, сургуулийн бүхий л түвшинд чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаанд гар бие оролцдог чанарын соёлыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Энэ утгаараа бодлого нь албан ёсны статустай олон нийтэд ил тод байх. Чанарын баталгаажуулалтын бодлого нь сургах - сургалцахуйн үйл явц болон судалгаа хоорондын харилцан хамаарлыг чухалчилж, тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын стратегийн зарчим, үйл ажиллагааны агуулга нь үндэсний суурь зарчимтай нийцтэй байх тохиолдолд үр дүнтэй хэрэгжинэ. Эдгээр бодлого нь дараах хүчин зүйлд дэмжлэг үзүүлдэг. Үүнд:

- a) чанарын баталгаажуулалтын тогтолцооны зохион байгуулалт,
- b) чанарын баталгаажуулалтад үүрэг хариуцлага хүлээж буй сургууль, бүтцийн нэгжүүдээс гадна сургуулийн удирдлага, профессор багш ажилтан, оюутнууд,
- c) академик эрч чөлөө, нэгдмэл байдал,
- d) профессор багш, ажилтан, оюутнуудыг ямар нэгэн байдлаар ялгаварлан гадуурхах байдлаас урьдчилан сэргийлэхэд;
- e) чанарын баталгаажуулалт дах хөндлөнгийн оролцогч талуудын оролцоог хангах.

Энэхүү бодлого нь сургуулийн бүх түвшин дэх оролцоог хангасан дотоод чанарын баталгаажуулалтын үйл явцын олон талт байдлаар дамжин хэрэгжинэ. Чанарын баталгаажуулалтын бодлого нь бусад гэрээлэгч болон хамтрагч талуудын гүйцэтгэж буй үйл ажиллагааг оролцуулаад сургуулийн бүхий үйл ажиллагааг хамарсан байх.

### *1.1 Хөтөлбөрийг боловсруулах ба албажуулах*

**Стандарт:** Сургууль нь өөрийн хөтөлбөрийг боловсруулах, хүлээн зөвшөөрөх тогтолцоотой байна. Тухайн хөтөлбөрөөс олгох ур чадвар, мэдлэгийг тодорхой заасан, харилцан уялдааг хадгалсан байна. Тухайн хөтөлбөр нь үндэсний мэргэжлийн хүрээ болон европын дээд боловсролыг орон зайн боловсролын мэдлэг, ур чадварын тогтолцооны зохих түвшнийг илэрхийлсэн байна.

**Зөвлөмж:** Сургалтын хөтөлбөр нь дээд боловсролын сургалтын байгууллагын багшлахуйн үндсэн зорилтын цөм нь байх. Хөтөлбөр нь оюутнуудад ирээдүйн ажил мэргэжилд хэрэглэгдэх, хувь хүний хөгжилд нөлөө үзүүлэх мэдлэг, чадварыг олгох. Үүнд:

- a) сургуулийн эрхэм зорилготой уялдсан хөтөлбөрт тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулагдах;
- b) хөтөлбөрийг боловсруулахдаа оюутан болон бусад оролцогч талуудын оролцоог хангах;
- c) хөндлөнгийн үнэлгээ болон жишиг шалгуурыг ашиглах;
- d) европын зөвлөлийн баталсан дээд боловсролын 4 зорилтыг тусгах;
- e) оюутны хөгжлийг жигд хангасан байхаар боловсруулагдах;
- f) оюутны зохист ачааллыг тодорхойлсон байх;
- g) оюутан дадлагажих боломжийг хангасан байх;

### *1.2 Оюутан төвтэй суралцах – сургахуйн үйл явц ба үнэлгээ*

**Стандарт:** Сургууль нь тухайн хөтөлбөрийн хэрэгжүүлэлтийн явцад оюутан мэдлэг бүтээх байдлаар идэвхтэй оролцох боломжийг дэмжсэн сургалтын арга хэлбэр, үнэлэх зарчмыг хадгалсан байна.

**Зөвлөмж:** Оюутан төвтэй сурах - сургах үйл явц нь оюутан өөрийгөө илэрхийлэх чадвар, сургалтын үйл явц дах оролцоог идэвхжүүлэхэд чухал үүрэгтэй. Энэ нь сургалтын хөтөлбөрийг боловсруулах, баталгаажуулах, үр дүнг үнэлэхдээ чухалчилж үзэх шаардлагатай. Үүнд:

- a) уян хатан сургалтын арга хэлбэрийг нэвтрүүлэн оюутнуудын хэрэгцээ шаардлагыг хүндэтгэх, оролцоог хангах,
- b) тохиромжтой, олон талт сургалтын арга хэлбэрийг хэрэгжүүлэх,

- c) заах аргын олон хэлбэрийг уян хатан ашиглах,
- d) тогтмол үнэлгээ хийж, сургалтын болон заах аргазүйн хэлбэрийг уялдуулах,
- e) суралцагчийн бие даасан байдлыг дэмжсэн зөвлөмж болон багшийн дэмжлэгийг бэхжүүлэх,
- f) суралцагч болон багш хоорондын харилцан итгэлцлийг дэмжих,
- g) оюутны санал хүсэлт, гомдлыг авч үздэг механизмтай байна.
- h) чанарын баталгаажуулалтын үйл явц нь оюутны хөгжил, тэдний ирээдүйн карьер, ажил мэргэжлийн үнэлэмжийг ач холбогдлыг авч үзэхдээ дараах зүйлсийг анхаарч үзнэ. үүнд:
  - i) шинжээчид нь одоо хэрэгжиж буй үнэлгээ, үнэлгээний аргачлалын талаар мэдлэгтэй, энэ чиглэлээр өөрийн ур чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг авдаг байх,
  - j) үнэлгээний шалгуур үзүүлэлт болон аргачлал, шалгуур үзүүлэлт нь урьдчилан хэвлэгдсэн ил тод болсон байх,
  - k) үнэлгээ нь оюутныг олж авсан мэдлэг, ур чадварынхаа хэмжээнд өөрийгөө илэрхийлэх боломжийг олгосон байх,
  - l) оюутан санал хүсэлтээ илэрхийлдэг, хэрэв шаардлагатай бол үүнийг нь сургалтын үйл явцад зөвлөмж хэлбэрээр тусгадаг байх,
  - m) үнэлгээнд аль болох олон шинжээчийг оролцуулах,
  - n) үнэлгээний журамд хөнгөвчлөх нөхцөлийг авч үзэх,
  - o) үнэлгээ нь тогтоосон журмын дагуу тогтмол хийгдэхээс гадна бүх оюутанд шударгаар хэрэглэгдэх,
  - p) оюутны санал гомдлыг хүлээх авах албан ёсны журамтай байх,

### *1.3 Оюутны элсэлт, хөгжил, бүртгэл, баталгаажуулалт*

*Стандарт:* Сургууль нь оюутны “амьдралын мөчлөг” -ийн бүх үе шат (элсэлт, сургалт, төгсөлт г.м)-ыг хамруулсан тогтсон журмыг баримталдаг байна.

*Зөвлөмж:* Оюутан өөрийн сонгосон мэргэжлээрээ хөгжихөд шаардлагатай урьдач нөхцөл, дэмжлэгийг хангах нь тухайн хөтөлбөр, сургуулийн чухал



асуудал юм. Энэ нь зорилтод нийцсэн элсэлт, үнэлгээ, төгсөлтийн үйл явц болон ялангуяа оюутан шилжин суралцахад чухал байдаг. Дээд боловсролын мэдлэг, ур чадвар, суралцсан, бэлтгэл хугацаа болон албан бус сургалтыг хүлээн зөвшөөрөх нь оюутан нь шилжин суралцах байдлаар мэргэжлээрээ чадавхжих боломжийг олгодог чухал хүчин зүйл болдог.

#### *1.4 Багшлах боловсон хүчин*

*Стандарт:* Сургууль багшлах боловсон хүчний чадамжийг өөрөө бие даан баталгаажуулна. Сургууль багшийн хөгжүүлэх, сонгон шалгаруулж авахдаа шударга, ил тод байдлыг баримталдаг байна.

*Зөвлөмж:* Оюутан мэдлэг, чадварыг өндөр түвшинд эзэмшихэд багшийн гүйцэтгэх үүрэг чухал. Иймээс оюутан төвтэй сурах – сургах үйл явцад багшийн үүрэг, оролцоо даган өөрчлөгдөж байдаг. Сургууль өөрийн багш, ажилтны чадавх, тэднийг үр бүтээлтэй ажиллах боломжийг бүрдүүлсэн орчин нөхцөлөөр хангахад онцгойлон анхаарах нь чухал ба энэ орчинд:

- a) багш, ажилтан сонгон шалгаруулж авах ил тод, шударга үйл явц, багшлахуйн ач холбогдлыг хүлээн зөвшөөрсөн нөхцөлийг бий болгох,
- b) багшлах боловсон хүчний мэргэжлийн хөгжлийг дэмждэг, холбогдох боломжуудыг санал болгодог байх,
- c) сургалт болон судалгаа хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх судалгааны үйл ажиллагааг урамшуулж дэмждэг байх,
- d) багшлах аргазүйд гарсан инновац, технологийн хэрэглээг дэмждэг байх.

#### *1.5 Сургалтын нөөц ба оюутны дэмжлэг*

*Стандарт:* Сургууль сурах – сургах үйл явцыг дэмжсэн санхүүжилттэй, сургалтын нөөц болон оюутныг дэмжих нөхцөлийг бүрдүүлсэн байна.

*Зөвлөмж:* Дээд боловсролын шилдэг туршлагаас харахад сургууль оюутныг суралцахад нь дэмжлэг үзүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх юм. Тухайлбал: номын сан, сургалтын хэрэглэгдэхүүн, мэдээлэл технологийн дэд бүтэц болон зөвлөх багш гэх мэт. Дэмжлэг үзүүлэх үйлчилгээний гүйцэтгэх үүрэг нь тухайн сургууль дотроо болон бусад сургуулиудад оюутан шилжин суралцах үйл явцыг хөнгөвчлөхөд түлхэц болдог. Оюутны дэмжлэг, сургалтын нөөцийг төлөвлөх, хуваарилах, хангахдаа оюутны хүн амзүйн (олон янз байдал: ахимаг

насны, хөдөлмөр эрхэлдэг, эчнээ, олон улсын, хөгжлийн бэрхшээлтэй г.м) хэрэгцээ шаардлага, оюутан төвтэй сургалтыг дэмжсэн сурах – сургах уян хатан хэлбэр зэргийг анхаарах шаардлагатай. Тухайн сургалтын байгууллагын онцлогоос хамаарч дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, орчин нөхцөлийг янз бүрээр зохион байгуулж болно. Гэхдээ дотоод чанарын баталгаажуулалт нь эдгээр нөөцтэй нийцтэй, зохистой байх нь оюутнууд энэ төрлийн үйлчилгээний талаарх мэдээллээр хангагдсан байдлаар баталгаажуулдаг. Дэмжлэг үзүүлэх үйлчилгээг хэрэгжүүлэхэд удирдах албан тушаалтны дэмжлэг, гүйцэтгэх үүрэг нэн чухал тул холбогдох албан тушаалтнууд энэ талаар чадавхажсан, өөрийн мэдлэг ур чадвараа хөгжүүлэх боломжоор хангагдсан байна.

### *1.6 Мэдээллийн удирдлага*

*Стандарт:* Сургууль өөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны үр өгөөжтэй удирдлагын талаарх холбогдох мэдээллийг цуглуулдаг, дүн шинжилгээ хийдэг, ашигладаг байх боломжийг хангасан байна.

*Зөвлөмж:* Найдвартай, үнэн зөв мэдээ баримт нь нотолгоонд суурилсан шийдвэр гаргах, хангалттай ажиллаж байгаа болох анхаарал хандуулах шаардлагатайг асуудлыг олж илрүүлэхэд чухал юм. Сургалтын хөтөлбөр болон бусад үйл ажиллагааны талаарх мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх үр дүнтэй арга хэлбэрүүд нь дотоод чанарын баталгаажуулалтыг дэмжиж байдаг.

### *1.7 Олон нийтийн мэдээлэл*

*Стандарт:* Сургууль нь хэрэгжүүлж буй хөтөлбөр, үйл ажиллагааны талаарх бодиттой зөв мэдээллийг сонирхогч бүхэн танилцаж болохуйц хүртээмжтэй хэвлэн нийтэлж түгээдэг байна.

*Зөвлөмж:* Сургуулийн үйл ажиллагааны тухай мэдээлэл нь элсэгч, оюутан, төгсөгчид болон бусад оролцогч талууд чухал юм. Иймд сургууль санал болгож буй хөтөлбөрүүд, тэдгээрт тавигдах шалгуур, зорьж буй үр дүн, оюутанд олгох мэдлэг ур чадвар, сурах – сургах үйл явц, үнэлгээний системийн талаарх мэдээллээс гадна оюутнуудад зориулсан боломж болон төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтэд чиглэсэн мэдээллээр хангаж байх шаардлагатай юм.

### *1.8 Байнгын хяналт болон хөтөлбөрийн шаталсан үнэлгээ*

**Стандарт:** Сургууль нь сургалтын хөтөлбөрт тавигдах зорилтод хүрч хэрэгжиж буй эсэхийг баталгаажуулах, оюутан, олон нийтийн хэрэгцээнд нийцүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдээ хянан үзэж, тасралтгүй үнэлгээ хийдэг байна. Төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд оролцогч бүх талуудыг оролцуулдаг байх.

**Зөвлөмж:** Сургалтын хөтөлбөрийн байнгын хяналт, үнэлгээ, сайжруулалтын зорилго нь сургалтын үйл ажиллагаанд тохирсон, дэмжлэг болох зарчмыг баримтлах, оюутанд үр өгөөжтэй, туслан дэмждэг сургалтын орчныг бүрдүүлэхэд оршино. Эдгээр хяналт, үнэлгээнд дараах зүйлс хамаарна. Үүнд:

- a) тухайн мэргэжил (салбар)-ийн сүүлийн үед хийгдсэн судалгаатай уялдуулсан хөтөлбөрийн агуулга нийцсэн байх,
- b) нийгмийн хувьсан өөрчлөгдөж буй эрэлт хэрэгцээ,
- c) оюутны ачаалал, ахиц, дүүргэлт,
- d) оюутны үнэлгээнд ашиглагдаж буй журмын үр өгөөж,
- e) хөтөлбөртэй холбоотойгоор оюутнаас хүлээх амжилт, тавих шаардлага ба сэтгэл ханамж,
- f) сургалтын орчин, дэмжих үйлчилгээ нь хөтөлбөрийн зорилттой уялдсан байдал,

Оюутан болон бусад оролцогч талуудын оролцоотойгоор хөтөлбөрийг тогтмол үнэлж, сайжруулах шаардлагатай. Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хөтөлбөрийг цаг үетэй нь нийцүүлж байх нь чухал. Өөрчлөлт оруулсан хөтөлбөрийн талаар олон нийтэд мэдээлэх.

### *1.9 Давтамжит хөндлөнгийн чанарын баталгаажуулалт*

**Стандарт:** Сургууль нь энэхүү чанарын баталгаажуулалтын стандарт ба зөвлөмжүүдэд нийцүүлэн хөндлөнгийн чанарын баталгаажуулалтыг тасралтгүй хийлгэнэ.

**Зөвлөмж:** Олон хэлбэрийн хөндлөнгийн чанарын баталгаажуулалт нь сургуулийн дотоод чанарын баталгаажуулалтын үр өгөөжийг батжуулж, холбогдох сайжруулалтын үүрэг гүйцэтгэх, сургуульд шинэ боломжийг санал болгодог. Мөн сургуулийн үйл ажиллагааны чанарыг баталгаажуулах

мэдээллээр сургууль болон олон нийтийг хангадаг. Сургууль холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, зохих хөндлөнгийн чанарын баталгаажуулалтад давтамжтайгаар оролцоно. Иймд тухайн тогтолцооноос хамаарч хөндлөнгийн чанарын баталгаажуулалт нь олон хэлбэртэй байхаас гадна байгууллагын өөр өөр түвшин (хөтөлбөр, факультет, сургууль г.м.) дээр төвлөрнө. Чанарын баталгаажуулалт нь хөндлөнгийн санал дүгнэлт, тайлагнал бүхий эсвэл сургууль доторх засан сайжруулах үйл явц бүхий тасралтгүй хийгдэх үйл ажиллагаа юм.

## **Хоёр. Хөндлөнгийн чанарын баталгаажуулалтад тавих стандарт ба зөвлөмжүүд**

### *2.1. Дотоод чанарын баталгаажуулалттай уялдуулах*

*Стандарт:* Хөндлөнгийн чанарын баталгаажуулалт нь энэхүү чанарын баталгаажуулалтын стандарт ба зөвлөмжийн нэгдүгээр бүлэгт заасан дотоод чанарын баталгаажуулалтын үр өгөөжийг авч үздэг байна.

*Зөвлөмж:* Дээд боловсролын чанарын баталгаажуулалт нь хэрэгжүүлж буй хөтөлбөр болон сургалтын чанарт хүлээх дээд боловсролын сургалтын байгууллагын хариуцлага дээр үндэслэдэг. Иймд хөндлөнгийн чанарын баталгаажуулалт нь чанарыг баталгаажуулахад хүлээх сургуулийн үүргийг хүлээн зөвшөөрч, дэмждэг байх нь чухал. Дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалт хоорондын уялдааг хангахын тулд хөндлөнгийн чанарын баталгаажуулалт нь нэгдүгээр бүлгийн стандартуудыг тусгасан байна. Тухайн хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын төрөл, онцлогоос хамааран энэхүү тусгал нь харилцан адилгүй байж болно.

### *2.2. Зорилтот нийцсэн аргачлалыг боловсруулах*

*Стандарт:* Хөндлөнгийн чанарын баталгаажуулалт нь холбогдох хууль тогтоомжид нийцүүлэхээс гадна тавьсан зорилго, зорилтод нь хүрэх боломжийг хангасан байхаар боловсруулсан байна. Энэхүү үйл явцад оролцогч талуудыг оролцуулдаг байна.

*Зөвлөмж:* Хөндлөнгийн чанарын баталгаажуулалт нь үр өгөөжтэй, зорилгодоо хүрэх боломжийг хангах үүднээс оролцогч талуудад хүлээн зөвшөөрөгдсөн зорилготой байх. Энэ үйл явцын зорилго, зорилт, хэрэгжилт нь дараах нөхцөлийг хангана. Үүнд:

- a) дээд боловсролын сургалтын байгууллагад очих ачаалал, өртгийн түвшнийг тооцсон байх,
- b) чанарыг сайжруулахын тулд сургуулийг дэмжиж байх шаардлагыг авч үзсэн байх,
- c) ахиц, дэвшлийг тодорхойлох боломжийг сургуульд олгох.

### 2.3. Хэрэгжүүлэх үйл явц

*Стандарт:* Хөндлөнгийн чанарын баталгаажуулалт нь баталгаажсан, үр өгөөжтэй, урьдчилан тодорхойлсон байх ба уялдаа холбоотойгоор хэрэгждэг, мэдээлэгддэг байна. Үүнд:

- a) Өөрийн үнэлгээ эсвэл үүнтэй тэнцэхүйц баримт бичиг,
- b) Шинжээч очиж ажиллах зэргээр хөндлөнгийн чанарын баталгаажуулалтыг ашигладаг байх,
- c) Хөндлөнгийн үнэлгээ дээр үндэслэн бичигдсэн тайлан,
- d) Уялдаа холбоо бүхий дагалдсан үйл ажиллагаа.

*Зөвлөмж:* Мэргэжлийн түвшинд системтэй ил тод хийгдсэн хөндлөнгийн чанарын баталгаажуулалт үр дүн хүлээн зөвшөөрөгдөхүйц байдаг. Хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын тогтолцооны онцлогоос хамааран, өөрийн үнэлгээ эсвэл баримт бүрдүүлэх мэдээлэл цуглуулах хэлбэрээр сургууль хөндлөнгийн чанарын баталгаажуулалт хийх үндсийг бүрдүүлнэ. Шинжээч ажиллах үеэр бичгээр үйлдэгдсэн баримт бичгийг нь ихэвчлэн оролцогч талуудтай хийх ярилцлагаар баталгаажна. Үнэлгээний үр дүн бичгээр үйлдэгдэх тайланд тусгагдана.

### 2.4. Хөндлөнгийн үнэлгээний шинжээчид

*Стандарт:* Оюутны төлөөллийг хамруулсан шинжээчдийн баг хөндлөнгийн чанарын баталгаажуулалтыг явуулна.

*Зөвлөмж:* Хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын цөм нь чанарын баталгаажуулалтын агентлагийн үйл ажиллагаанд олон талт хэлбэрээр дэмжлэг болж буй дээд боловсролын сургалтын байгууллагын төлөөлөл болох профессор багш, оюутнууд болон ажил олгогч буюу мэргэжлийн байгууллагын

төлөөллөөс бүрдэх шинжээчид юм. Шинжээчдийн ажлын уялдаа, үнэ цэнийг хадгалахын тулд дараах шаардлагыг хангана. Үүнд:

- a) Маш сайтар сонгон шалгаруулалт хийгдсэн байх,
- b) Шинжээчийн үүргийг гүйцэтгэхүйц мэдлэг ур чадвар, эрх мэдэлтэй байх,
- c) Холбогдох сургалт болон мэдээллээр хангагдсан байх.

Чанарын баталгаажуулалтын байгууллага нь ашиг сонирхлын зөрчлөөс ангид үйл ажиллагааг хэрэгжүүлэн шинжээчдийн хараат бус байдлыг хангахад анхаарах. Чанарын хөндлөнгийн баталгаажуулалтад олон улсын шинжээч орж ажиллах тохиолдолд тухайн үйл явцыг тодорхойлж хэрэгжүүлэхдээ нэмэлт шаардлагуудыг зааж өгсөн байвал зохино.

### *2.5. Үр дүнд тавигдах шалгуур*

*Стандарт:* Хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын үр дүн болон гарч буй шийдвэр нь албан ёсны шийдвэрт нөлөөлөхөөс үл хамааран системтэй ил тод, олон нийтэд мэдээлэгдсэн шалгуур дээр үндэслэсэн байна.

*Зөвлөмж:* Хөндлөнгийн чанарын баталгаажуулалт нь үнэлгээ хийлгэж буй сургууль, хөтөлбөрт бодит үр нөлөө үзүүлдэг байх нь чухал. Хөндлөнгийн чанарын баталгаажуулалт нь бодитой зөв баримтад суурилсан, уялдаа холбоотойгоор тайлбарлагдаг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтээр хийгдсэн. Тухайн хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын тогтолцооноос хамааран үр дүн нь өөр хэлбэр (зөвлөмж, шийдвэр г.м)-тэй байж болно.

### *2.6. Тайлагнал*

*Стандарт:* Шинжээчдийн тайлан нь сургуулийн нийт профессор багш, ажилтан, харилцагчид болон бусад сонирхсон хүмүүст нээлттэй ил тод байна. Хэрвээ чанарын баталгаажуулалтын байгууллага тайлан дээр үндэслэн албан ёсны шийдвэр гаргах бол шийдвэр нь тайлантай хамт олон нийтэд мэдээлэгддэг байна.

*Зөвлөмж:* Шинжээчдийн тайлан нь хөндлөнгийн үнэлгээг дагалдах үйл ажиллагааны үндэслэл болох ба сургуулийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг нийгэмд хүргэх хэлбэр юм. Тайлан цаашид хийх үйл ажиллагааны үндэслэл болохын хувьд тухайн үнэлгээ хийгдсэн бүтэц болон хэлний хувьд

нуршуу бус ойлгомжтой байдлаар бичигдэх ба дараах асуудлыг хамруулна.  
Үүнд:

- a) агуулгын тодорхойлолт (дээд боловсролын сургалтын байгууллага тодорхой нэг агуулгыг дагаж мөрдөхөд нь туслахуйц),
- b) шинжээчийн үйл ажиллагааны тодорхойлолт,
- c) баримт, дүн шинжилгээ, үр дүн,
- d) дүгнэлт,
- e) сургуулийн сайн туршлага,
- f) дагалдах үйл ажиллагаанд зориулсан зөвлөмж бүхий тайлан бэлтгэх үр дүнтэй байж болно.

### *2.7. Санал гомдол мэдүүлэх ба шийдвэрлэх*

*Стандарт:* Гомдол саналыг шийдвэрлэх үйл явц нь хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын үйл явцын нэг бүрэлдэхүүн хэсэг болохоос гадна сургуульд танилцуулагдсан байна.

*Зөвлөмж:* Сургуулийн эрх болон шийдвэр гаргах үйл явцыг баталгаажуулдаг тул хөндлөнгийн чанарын баталгаажуулалт нь ил тод хариуцлагатай хэлбэрээр явагддаг. Чанарын баталгаажуулалтын байгууллагатай холбоотой асуудлыг гаргаж тавих боломжийг олгосон үйл явцад оролцох боломжийг сургуулиудад олгох шаардлагатай. Чанарын баталгаажуулалтын байгууллага нь аливаа асуудлыг системтэйгээр мэргэжлийн хүрээнд шийдвэрлэдэг байх нь чухал юм. Гомдол мэдүүлэх журам нь сургуулийг хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааны талаар сэтгэл дундуур байгаага илэрхийлэх боломжийг олгодог. Гомдол мэдүүлэх үйл явц нь сургууль хаана үнэлгээний үр дүн бодит баримт дээр суурилаггүй, шалгуур үзүүлэлт үнэн зөвөөр хэрэглэгдээгүй, үйл явц уялдаа холбоогүйгээр хэрэгжсэн талаар тодруулах боломжийг бүрдүүлдэг.

**Гурав. Чанарын баталгаажуулалтын байгууллагад тавих стандарт ба зөвлөмжүүд**

### *3.6. Чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаа, бодлого, үйл явц*

*Стандарт:* Чанарын баталгаажуулалтын байгууллага нь энэхүү чанарын баталгаажуулалтын стандарт ба зөвлөмжүүдийн хоёрдугаар бүлэгт заасанчлан тогтмол хэлбэрээр хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг явуулна. Чанарын баталгаажуулалтын байгууллага нь олон нийтэд мэдээлсэн эрхэм зорилгын хүрээнд тодорхойлсон зорилго, зорилтуудыг ил тод нээлттэй байлгана. Энэхүү зорилго, зорилтууд нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд тогтмол мөрдөгдөж ажиллана. Чанарын баталгаажуулалтын байгууллага нь өөрийн засаглал болон үйл ажиллагаандаа оролцогч талуудын оролцоог хангасан байна.

*Зөвлөмж:* Хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын үр өгөөж, ач холбогдлыг батжуулахын тулд сургууль болон нийгэм Чанарын баталгаажуулалтын байгууллагад итгэх итгэл нэн чухал юм. Иймд чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааны зорилго, зорилт нь чанарын баталгаажуулалтын болон дээд боловсролын сургалтын байгууллагуудын хамтын үйл ажиллагааны цар хүрээ оролцогч талууд хоорондын уялдаа холбоо, мөн чанарт нийцүүлэгдэн боловсруулагдаж олон нийтэд мэдээлэгдсэн байна. Чанарын баталгаажуулалтын байгууллагын хороодод олон улсын экспертүүдийг оруулан ажиллуулж, байгууллагын мэргэжлийн чадавхыг бэхжүүлэх боломжтой.

### *3.7. Албан ёсны статус*

*Стандарт:* Чанарын баталгаажуулалтын байгууллага нь холбогдох эрх бүхий төр, олон нийтийн удирдах байгууллагаас чанарын баталгаажуулалтын байгууллага гэдгийг нь албан ёсоор хүлээн зөвшөөрсөн статус бүхий эрх зүйн чадамжтай байна.

*Зөвлөмж:* Хөндлөнгийн чанарын баталгаажуулалт нь зохицуулах үүрэг зорилгоор хийгдэж байгаа бол дээд боловсролын сургалтын байгууллагын дотооддоо хүлээн зөвшөөрч буй үйл ажиллагааны үр дүнг баталгаажуулж буй үйл ажиллагааны хэлбэр нь төр, оролцогч талууд, олон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байна.

### *3.8. Хараат бус байдал*

*Стандарт:* Чанарын баталгаажуулалтын байгууллага нь хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулна. Тухайн байгууллага нь гуравдагч талын



нөлөөгүйгээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болон үр дагаварт хариуцлага хүлээх чадвартай байна.

**Зөвлөмж:** дээд боловсролын сургалтын байгууллага нь хараат бус чанарын баталгаажуулалтын байгууллагатай түншилнэ. Чанарын баталгаажуулалтын байгууллага бие даасан байдлыг чухалчлах нь:

- a) байгууллагын бие даасан байдал: албан ёсны баримт бичигт дээд боловсролын сургалтын байгууллага, засгийн газар, бусад оролцогч талуудаас хараат бус бие даасан үйл ажиллагаа явуулахыг заасан байх,
- b) үйл ажиллагааны бие даасан байдал: Чанарын баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагаа, аргазүй, шинжээчийг нэр дэвшүүлэх, томилох үйл явц нь дээд боловсролын сургалтын байгууллага, засгийн газар, бусад оролцогч талуудаас хараат бусаар хэрэгждэг байх,
- c) Шийдвэр гаргах бие даасан байдал: холбогдох оролцогч талуудаас, тэр дундаа оюутны төлөөллөөс чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаанд оролцож буй тохиолдолд тухайн чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааны үр дүн, шийдвэр гаргах эрх нь чанарын баталгаажуулалтын байгууллагад бүрэн байх.

### **3.9. Нарийвчилсан дүн шинжилгээ**

**Стандарт:** Чанарын баталгаажуулалтын байгууллага нь хэрэгжүүлж буй хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааны нийтлэг ололт, дэвшлийг тодорхойлж, дүн шинжилгээ хийсэн тайланг олон нийтэд мэдээлдэг байна.

**Зөвлөмж:** Чанарын баталгаажуулалтын байгууллага нь үйл ажиллагааныхаа явцад сургууль болон хөтөлбөрийн талаар олж цуглуулсан мэдээллийг дан ганц чанарыг баталгаажуулах үйл ажиллагаанд ашиглахаас илүүтэй тухайн дээд боловсролын тогтолцоог хамарсан эмх цэгцтэй дүн шинжилгээний материал болгон ашиглах боломжтой. Эдгээр ололт, дүн мэдээ нь байгууллага, үндэсний болон олон улсын түвшинд чанарын баталгаажуулалтын бодлого, үйл ажиллагааг сайжруулахад, хүлээн зөвшөөрүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

### **3.10. Нөөц**

*Стандарт:* Чанарын баталгаажуулалтын байгууллага өөрийн үйл ажиллагаа явуулах хүний болон санхүүгийн хангалттай, хүртээмжтэй нөөцтэй байна.

*Зөвлөмж:* Чанарын баталгаажуулалтын байгууллага нь хангалттай, зохистой санхүүжилттэй байх, хүртээмжтэй нөөц нь хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг үр дүнтэй, өгөөжтэй хэлбэрээр удирдан явуулах боломжийг олгодог. Улмаар хүртээмжтэй нөөц (санхүү, хүний нөөц) нь чанарын баталгаажуулалтын байгууллага үйл ажиллагаагаа сайжруулах, олон нийтийг шаардлагатай мэдээллээр хангахад нь дэмжлэг болдог.

### *3.11. Дотоод чанарын баталгаажуулалт ба мэргэжлийн ёс зүй*

*Стандарт:* Чанарын баталгаажуулалтын байгууллага нь чанар болон үйл ажиллагааныхаа шударга ёс зүйтэй зарчимд нийцсэн байдлыг тодорхойлох, баталгаажуулах, бэхжүүлэхтэй холбоотой дотоод чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг хэвшүүлсэн байна.

*Зөвлөмж:* Чанарын баталгаажуулалтын байгууллага нь оролцогч талуудынхаа өмнө хариуцлага хүлээх ёстой. Иймээс чанарын баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн стандарт болон чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг шударга ёс зүйн зарчимд нийцүүлэх шаардлагатай. Чанарын баталгаажуулалтын байгууллага нь дотоод чанарын баталгаажуулалтын бодлогыг боловсруулж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх ба дараах нөхцөлийг хангана. Үүнд:

- a) чанарын баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх үүрэг баталгаажсан, мэргэжлийн өндөр ур чадвартай, ёс зүйтэй ажилладаг байх,
- b) чанарын баталгаажуулалтын байгууллага доторх байнгын хөгжилд чиглэсэн дотоод болон хөндлөнгийн санал хүсэлтийн механизмыг бүрдүүлсэн байх,
- c) бусдын үзэл бодлыг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг сахидаг байх,
- d) чанарын баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагаа явуулах эрхзүйн орчин, холбогдох эрх бүхий байгууллагатай харилцаа холбоотой байх,

- e) гэрээлэгч талаар гүйцэтгүүлж буй үйл ажиллагаа, тэдний боловсруулсан материал нь энэхүү чанарын баталгаажуулалтын стандарт ба зөвлөмжүүдэд нийцсэн байх,
- f) дээд боловсролын сургалтын байгууллагуудад хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаанд орсон гэдгийг хүлээн зөвшөөрсөн, батламжилсан статус олгох боломжийг чанарын баталгаажуулалтын байгууллагад олгосон байх.

*3.12. Давтамжит хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг байх*

*Стандарт:* Чанарын баталгаажуулалтын байгууллага нь энэхүү чанарын баталгаажуулалтын стандарт ба зөвлөмжүүдэд нийцэхийн тулд 5 жилд нэгээс доошгүй удаа хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг байна.

*Зөвлөмж:* Давтамжит хөндлөнгийн үнэлгээ нь чанарын баталгаажуулалтын байгууллагыг өөрийн үйл ажиллагаа, бодлогоо үнэлж дүгнэхэд нь дэмжлэг болдог.

## **ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ**

“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл” суурь судалгааны төслийн тайлан нь 4 бүлэг, 22 дэд бүлэг, ерөнхий дүгнэлт, ном зүй, хавсралтыг агуулсан нийт 271 хуудас бичвэр, 93 хүснэгт, 37 зураг, 6 хавсралтаас бүрдэж байна.

“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл” суурь судалгааны төслийг хэрэгжүүлэхдээ “ШУС - 2018/43” тоот гурван талт гэрээнд тусгагдсан “Төслийн үр дүнгийн даалгавар”, “Төслөөр гүйцэтгэх ажлын календарчилсан төлөвлөгөө” зэргийг үндэслэн боловсруулсан төслийн төлөвлөгөө ба зохион байгуулалт болон төслийн хүрээнд хийж гүйцэтгэх судалгаа, боловсруулалтын ажилд баримталсан судалгааны арга зүйн үндэслэл зэргийг тусгасан.

Харин дээд боловсролын сургалтын байгууллагын чанарыг үнэлэх онол, арга зүйн үндэслэлийг тодорхойлохдоо дараах үндсэн чиглэлээр судалгаа, боловсруулалтын ажлыг хийсэн. Үүнд:

- i) Дээд боловсрол, түүний чанар (2.1, 2.2),
- ii) Дээд боловсролын сургалтын байгууллагын чанар, чанарын менежментийн тогтолцоо, түүний стандартчилал (2.3, 2.4, 2.5, 2.6),
- iii) Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний систем, шалгуур үзүүлэлтүүд (2.7, 2.8),
- iv) Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарт нөлөөлөх хүчин зүйлс болох үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа (2.9), хөдөлмөрийн зах зээлийн эрэлт (2.10), их сургуулиудын рейтингийн үнэлгээ (2.11), судалгааны чанарын үнэлгээ (2.12), магадлан итгэмжлэл (2.13) зэрэг болно.

Харин монголын дээд боловсролын сургалтын байгууллагуудын чанарын өнөөгийн төлөв байдлын үнэлгээг дараах үндсэн чиглэлээр хийж, үнэлэлт дүгнэлт өгсөн. Үүнд:

- i) Дээд боловсролын сургалтын байгууллагуудын хөгжлийн өнөөгийн төлөв байдал (3.1),

- ii) Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарт үнэлгээ хийж буй өнөөгийн байдал (3.2),
- iii) Дээд боловсролын сургалтын байгууллагуудын чанарын төлөвшлийн үнэлгээ (3.3),
- iv) Дээд боловсрол ба хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт (3.4),
- v) Дээд боловсрол ба ажил олгогчдын үнэлэмжийн судалгаа (3.5),
- vi) Дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн хандлагын судалгаа (3.6) зэрэг болно.

Эцэст нь дээрх судалгаа, боловсруулалтын ажлын үр дүн болон олон улсад дээд боловсролын чанарын стандарт болон баримт бичгүүдийн суурь зарчимд тулгуурлан Нийгмийн ухааны чиглэлээр сургалт явуулдаг дээд боловсролын сургалтын байгууллагын чанарт үнэлгээ хийх талаарх зөвлөмжийг дараах үндсэн чиглэлээр боловсруулсан.

- i) Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын талаар баримтлах бодлого хэрэгжүүлэх,
- ii) Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын менежментийн тогтолцоо төлөвшүүлэх,
- iii) Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлэх зэрэг болно.

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”* суурь судалгааны төслийг хэрэгжүүлэхдээ “ШУС - 2018/43” тоот гурван талт гэрээнд тусгагдсан “Төслийн үр дүнгийн даалгавар”-ыг үндэслэн төслийн үр дүнг доорх хүснэгтээр нэгтгэн дүгнэв.

## ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

№	Төслөөр бий болох үр дүн	Тоо хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт	Биелэлтийн байдал
1	Нийгмийн ухааны чиглэлээр сургалт явуулдаг дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийж буй байдлыг судалсны үндсэн дээр онол, арга зүйн үндэслэл боловсруулагдана.	1	Арга аргачлал	<p>Нийгмийн ухааны чиглэлээр сургалт явуулдаг дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийж буй байдлыг дараах үндсэн чиглэлээр судалгаа боловсруулалтын ажлыг гүйцэтгэж, үр дүнг төслийн тайлан болон “Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ” бүтээлд хэвлэсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Олон улсад чанарын үнэлгээ хийж байгаа туршлагыг судлахдаа <ul style="list-style-type: none"> <li>✓ Дээд боловсролын чанарын үнэлгээний онол, арга зүйн талаар хийсэн судалгааны бүтээлд шинжилгээ хийсэн,</li> <li>✓ Олон улсад чанарын үнэлгээний талаар баримталж стандарт, баримт бичиг (“ISO 21001:2018 Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо /Educational organizations - Management systems for educational organizations - Requirements with guidance for use/” стандарт болон “Европын дээд боловсролын орон зайн чанарын баталгаажуулалтын стандарт ба зөвлөмж \Standards and Guidelines for Quality Assurance in the European Higher Education Area\”)-үүдийг орчуулсан.</li> <li>✓ Гадаадын их сургуулиудын туршлага судалж, семинарт оролцсон.</li> </ul> </li> <li>2. Манай улсад чанарын үнэлгээ хийж байгаа байдлын судалгааг дараах байдлаар хийсэн: <ul style="list-style-type: none"> <li>✓ Дээд боловсролын сургалтын байгууллагуудын хөгжлийн өнөөгийн байдал,</li> <li>✓ Дээд боловсролын сургалтын байгууллагуудад чанарын үнэлгээ хийж буй байдал,</li> <li>✓ Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал,</li> </ul> </li> <li>3. Оролцогчд талуудаас социологийн судалгааг дараах үндсэн чиглэлээр авч үр дүнг боловсруулсан:</li> </ol>

**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**

				<ul style="list-style-type: none"> <li>✓ Их, дээд сургууль төгсөгчдийн талаарх ажил олгогчдын үнэлэмжийн судалгаа (300 захирал, менежерүүдээс түүврийн аргаар асуулгын судалгаа авсан),</li> <li>✓ Их, дээд сургууль төгсөгчдийн хандлагын судалгаа (965 их, дээд сургууль төгсөгчдөөс түүврийн аргаар асуулгын судалгаа авсан),</li> <li>✓ Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ (200 хүн буюу 100 оюутан, 50 профессор багш, ажилтан, 50 төгсөгчөөс түүврийн аргаар асуулгын судалгаа авсан),</li> <li>✓ Дээд боловсролын байгууллагын чанарын үнэлгээний өнөөгийн байдал(320 профессор багш, ажилтнаас түүврийн аргаар асуулгын судалгаа авсан),</li> </ul> <p>Дээрх судалгаа, боловсруулалтын ажлын үр дүнд тулгуурлан дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэлийг тодорхойлж “Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ (2020)” эмхэтгэл болон төслийн үр дүнгийн тайланд хэвлэсэн.</p> <p><b>Гүйцэтгэл: 100%</b></p>
2	Нийгмийн ухааны чиглэлээр сургалт явуулдаг дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх талаар бодлогын зөвлөмж боловсруулагдана.	1	Зөвлөмж	<p>Төслийн хүрээнд хийсэн судалгаа, боловсруулалтын ажлын үр дүн болон олон улсын дээд боловсролын баримт бичгүүдэд тулгуурлан нийгмийн ухааны чиглэлээр сургалт явуулдаг дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх талаар зөвлөмжийг дараах үндсэн чиглэлээр боловсруулж төслийн тайланд тусгасан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын талаар баримтлах бодлого боловсруулж хэрэгжүүлэх талаар,</li> <li>2. Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын менежментийн тогтолцоо төлөвшүүлэх талаар,</li> <li>3. Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлэх талаар.</li> </ol> <p><b>Гүйцэтгэл: 100%</b></p>

**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**

3	Дээд боловсролын чанарт үнэлгээ хийх арга зүйг ашиглах чиглэлээр семинар, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулагдана.	2	Семинар, эрдэм шинжилгээ ний хурал	<p>Төслийн хүрээнд 2 эрдэм шинжилгээний хурал, 1 хэлэлцүүлэг зохион байгуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ “Нийгмийн ухааны дээд боловсролын чанарын үнэлгээний онол, практикийн асуудал” олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг 2018.06.20-ны өдөр зохион байгуулсан. Уг хуралд БСШУСЯ, БМИУЗ, Боловсролын хүрээлэн болон их, дээд сургууль зэрэг 15 байгууллагын төлөөлөл болох 30 гаруй хүн оролцсон.</li> <li>✓ “<u>Дээд боловсролын чанарын удирдлагын онол, практикийн асуудал</u>” эрдэм шинжилгээний бага хурлыг 2019.12.09-ны өдөр зохион байгуулсан. Уг хуралд БСШУСЯ, БМИУЗ, Боловсролын хүрээлэн болон их, дээд сургууль зэрэг 15 байгууллагын төлөөлөл болох 30 орчим хүн оролцсон.</li> <li>✓ Мөн төслийн хүрээнд “Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх арга зүй” сэдэвт семинарыг дөрвөн удаа зохион байгуулсан.</li> </ul> <p><b>Гүйцэтгэл: 100%</b></p>
4	Олон улсын болон үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлж, эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлнэ.	Өгүүлэл л 3-5 Илтгэл 3-5	Өгүүлэл, илтгэл	<p>Төслийн хүрээнд хийсэн судалгааны боловсруулалтын ажлын үр дүнгээр төслийн багийн гишүүд болон гэрээт судлаачдаар:</p> <p><b>Өгүүлэл:</b> Төслийн үр дүнгээр нийт 14 өгүүлэл хэвлүүлснээс олон улсын сэтгүүлд 2 өгүүлэл, үндэсний сэтгүүлд 12 өгүүлэл хэвлүүлсэн. Үүнд:</p> <p><u>Олон улсын сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• J.Togtokh, B.Bayarmaa “<i>The Context in Assessing Higher Education Quality</i>” Вестник Гуманитарного института, МГИ, Москва, 2020, р. 59 - 66.</li> <li>• J.Erkhemtuugs “<i>Quality Management in Higher Education</i>” Вестник Гуманитарного института, МГИ, Москва, 2020, р. 67 - 72.</li> </ul> <p><u>Үндэсний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл:</u></p> <p>“Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ” эмхэтгэл (2019)-д 11 өгүүлэл хэвлэгдсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Дээд боловсролын чанар ба олон улсын их сургуулиудын рейтингийн үнэлгээ (Доктор, дэд профессор Ж.Эрхэмтөгс),</li> </ul>



**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**

			<ul style="list-style-type: none"> <li>• Их сургуулийн судалгааны чанарын үнэлгээний үзүүлэлтүүд</li> <li>• (Доктор, профессор Н.Наранчимэг, Докторант Ж.Эрдэнэбат),</li> <li>• Дээд боловсролын магадлан итгэмжлэлийн олон улсын туршлага (Докторант А.Энхцэцэг),</li> <li>• Их сургуулийн сургалтын чанарын баталгаажуулалт ба магадлан итгэмжлэл (Магистр Д.Амарзаяа),</li> <li>• Дээд боловсролын чанар ба хөдөлмөрийн зах зээлийн эрэлт (Доктор, дэд профессор Ж.Эрхэмтөгс),</li> <li>• Нийгмийн ухааны чиглэлээр сургалт явуулдаг дээд боловсролын сургалтын байгууллагын өнөөгийн байдал (Доктор, профессор Ж.Тогтох, Докторант М.Энхээ),</li> <li>• Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарт үнэлгээ хийж байгаа өнөөгийн байдал (Доктор, профессор Ж.Тогтох, Докторант Б.Алтанчимэг),</li> <li>• Их сургуулийн инновацын чадавхын үнэлгээ (Доктор М.Заяа, Доктор(ScD), проф Л.Оюунцэцэг)</li> <li>• Их, дээд сургууль төгсөгчдийн ур чадварыг ажил олгогчдын оролцоотой үнэлэх нь (Доктор, дэд профессор Ж.Эрхэмтөгс, Докторант Б.Баярмаа),</li> <li>• Их, дээд сургууль төгсөгчдийн хандлагын тандан судалгааны зарим үр дүн (Доктор, дэд профессор Ж.Эрхэмтөгс, Докторант Б.Баярмаа)</li> </ul> <p>“Соёл, урлаг судлал” сэтгүүлд 1 өгүүлэл хэвлэгдсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ж.Эрхэмтөгс, Ж.Тогтох, Б.Баярмаа “Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарыг төгсөгчдийн ур чадвараар үнэлэх асуудалд” Монголын соёл, урлаг судлал Том XXXIII, Facs 1-48. -УБ, 2019, х. 20-26.</li> </ul> <p><b>Илтгэл:</b> Төслийн үр дүнгээр нийт 4 илтгэл хэлэлцүүлснээс олон улсын хуралд 2 илтгэл, дотоодын эрдэм шинжилгээний хуралд 2 илтгэл байна. Үүнд:</p>
--	--	--	--

**“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан**

				<p><b>“Нийгмийн ухааны дээд боловсролын чанарын үнэлгээний онол, практикийн асуудал”</b> Олон улсын эрдэм шинжилгээний хуралд 2 илтгэл хэлэлцүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний олон улсын туршлага (Ж.Эрхэмтөгс, төслийн удирдагч, доктор, дэд профессор),</li> <li>• Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын баталгаажуулалтын өнөөгийн байдал (Б.Алтанчимэг, Төслийн багийн гишүүн, докторант),</li> </ul> <p><b>“Дээд боловсролын чанарын удирдлагын онол, практикийн асуудал”</b> Эрдэм шинжилгээний бага хуралд 2 илтгэл хэлэлцүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний өнөөгийн байдалд хийсэн судалгааны зарим үр дүн (Ж.Эрхэмтөгс, төслийн удирдагч, доктор, дэд профессор),</li> <li>• Дээд боловсролын сургалтын байгууллагын чанар, түүнийг үнэлэх арга зүйн асуудал (Ж.Тогтох, Төслийн багийн гишүүн, док, проф)</li> </ul> <p><b>Гүйцэтгэл: 100%</b></p>
5	Судалгааны чиглэлээр нэг сэдэвт бүтээл хэвлэгдэнэ.	1	Нэг сэдэвт бүтээл	<p>Төслийн хүрээнд хийсэн судалгаа, боловсруулалтын ажлын үр дүнгээр 2 бүтээл хэвлэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ “Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ” эмхэтгэл (ISBN 978-99978-66-80-6, 8.1 х.х)-ийг 2018 онд төслийн хүрээнд хийгдсэн судалгааны ажлын үр дүнгээр хэвлэсэн. Уг бүтээлийг төслийн явцын тайлантай хамт ШУТС-д хүргүүлсэн.</li> <li>✓ “Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ” нэг сэдэвт бүтээл (ISBN 978-9919-23-870-4, 30 х.х)-ийг төслийн хүрээнд хийгдсэн судалгаа, боловсруулалтын ажлын үр дүнгээр хэвлэсэн. Эдгээр бүтээлүүдийг төслийн тайлангийн хамт хүргүүлсэн.</li> </ul> <p><b>Гүйцэтгэл: 100%</b></p>

*“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл”  
суурь судалгааны төслийн тайлан*

6	Төслийн эцсийн тайлан хүлээлгэн өгнө.	1	Эцсийн тайлан	<p>“Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл” суурь судалгааны төслийн тайлан нь 4 бүлэг, 21 дэд бүлэг, дүгнэлт, ном зүйн жагсаалт, хавсралт бүхий нийт 271 хуудас бичвэр, 93 хүснэгт, 37 зураг, 6 хавсралтаас бүрдэж байна.</p> <p>Төслийн санхүүгийн тайланг “Эрдэм шинжилгээний зардлын задаргааны маягт”-ын дагуу төсөв, гүйцэтгэлийг гаргаж, шаардлагатай санхүүгийн тайлан, нотлох баримтуудыг хавсаргасан болно.</p> <p><b>Гүйцэтгэл: 100%</b></p>
---	---------------------------------------	---	---------------	--

## **НОМ ЗҮЙ**

### **Нэг. Монгол хэлээр хэвлэгдсэн бүтээл**

1. А.Аюуш “Их сургуулийн урамшууллын системийн судалгаа” докторын дисс, УБ хот, 2018
2. Д.Алтайхүү “Монголын дээд боловсролын салбарын өсөлтийн байдал, түүнийг судалсан зарим үр дүн” докторын дисс, УБ, 2018
3. Д.Амарсайхан “Анагаахын сургалтын төлөвлөгөөг боловсронгуй болгох онол, арга зүйн зарим асуудал” докторын дисс, УБ, 2003
4. Л.Ариунжаргал “Монголын Боловсролын удирдлагын талаарх судалгаа 1990 ээд оноос хойших боловсролын шинэчлэл, хуулийн өөрчлөлтүүдийн нарийвчилсан судалгаа” докторын дисс, УБ, 2013
5. А.Заяадэлгэр, Боловсролын эдийн засаг, УБ, 2011
6. Д.Батчулуун “Их, дээд сургуулийн институцын шинэчлэл ба санхүүжилтийн асуудлууд” докторын дисс, УБ, 2016
7. А.Батцэнгэл “Их дээд сургуулийн чансааг үйлдлийн шинжилгээний аргаар үнэлэх”, УБ, 2012
8. Б.Батсайхан “20-р зууны Монголын сурган хүмүүжүүлэх боловсролын онол практик” докторын дисс, УБ, 2004
9. А.Баярмаа “Монголын дээд боловсролын чанарын удирдлагын судалгаа” докторын дисс, УБ, 2004
10. Ч.Байгалмаа “Боловсролын судалгааны арга зүй” УБ, 2015
11. Р.Бат-Эрдэнэ “Их сургуулийг үйлдвэрлэлтэй холбох менежментийн асуудлууд: Монголын дээд боловсролд голлох үүрэг гүйцэтгэж буй талуудын байр суурь” докторын дисс, УБ, 2004
12. Боловсролын магадлан итгэмжлэл (эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл), БМИҮЗ, 2019
13. Ц.Бүжидмаа “Монголын боловсролын философийн хөгжийн судалгаа”, УБ, 2001
14. Н.Бэгз “Глобальчлалын үеийн Монгол Улсын боловсролын хөгжлийн онол, аргазүйн үндсэн асуудал” докторын дисс, УБ, 2001
15. Ц.Ганбат “Кредит систем нэвтрүүлэх зохион байгуулалтын асуудал” докторын дисс, УБ, 2000

16. С.Даваадулам “Монголын боловсролын тогтолцооны философи шинжилгээ” докторын дисс, УБ, 2007
17. Н.Дуламжав “Их сургуулийн гадаад харилцааг хөгжүүлэх арга зам” докторын дисс, УБ, 2015
18. “Дээд боловсролын сургалтын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ ба чанарын удирдлагын тогтолцоо” БСШУЯ, 2007
19. Р.Кумар “Судалгааны арга зүй” УБ, 2019
20. М.Заяа “Байгууллагын инновацын чадавхын үнэлгээний арга зүйн асуудал” докторын дисс, УБ, 2016
21. Г.Жаргал, Н.Сэлэнгэ “Судалгааны арга зүйд өөрөө сурах бичиг” УБ, 2018
22. Ц.Лувсандорж “Сургалтын хөтөлбөр боловсруулалт болон боловсролын стандарчлалыг боловсронгуй болгох асуудал” докторын дисс, УБ, 2001
23. “Магадлан итгэмжлэлийн шаардлага, үнэлгээ (Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага)” БМИҮЗ, 2020
24. Б.Мэндхүү “Их, дээд сургуулийн сургалтын технологид загварчлалын аргаг хэрэглэх боломж”, УБ, 2014
25. Ж.Отгонбат “Их сургуулийн өрсөлдөх чадварыг рейтингээр үнэлэх арга зүйн асуудал /Монголын их сургуулиудын жишээн дээр/” докторын дисс, УБ, 2017
26. Ц.Оюун “Дээд боловсролын сургалтын байгууллагын рейтинг тогтоох арга зүйн зарим асуудал” докторын дисс, УБ, 2011
27. Б.Оюунцэцэг “Дээд боловсролын сургалтын байгууллагын бүртгэлийн мэдээлэл хувиргалт, хяналтын үүргийг боловсронгуй болгох нь” докторын дисс, УБ, 2005
28. Д.Өнөрнасан “Сурлагын үнэлгээний арга зүйн судалгаа” докторын дисс, УБ, 2014
29. Г.Пүрэвсүрэн “Оюутны мэргэжил сонголтын сэдэл ба мэргэжлийн чиг хандлагын холбоог судалсан дүнгээс” докторын дисс, УБ, 2015
30. С.Санжаабадам “Боловсролын чанар ба Монголын хүний хөгжлийн хамаарал” докторын дисс, УБ, 2001
31. “Сургалтын үйл ажиллагаа ба хөдөлмөрийн зах зээлийн судалгаа” гарын авлага, УБ, 2016
32. “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл” БМИҮЗ, 2010

33. Н.Туул “Дээд боловсролын байгууллага дахь багшийн хөгжлийн орчны менежментийн асуудалд” докторын дисс, УБ, 2004
34. У.Туяа “Боловсролын эрх зүйг судлах үндэслэл, агуулга арга зүйг тодорхойлсон нь” докторын дисс, УБ, 2007
35. М.Толя “Боловсролын тогтолцооны бүтэц үүргийн шинжилгээ”, докторын дисс, УБ, 2010
36. Г.Уянга “Боловсролын тогтолцооны бүтэц үүргийн шинжилгээ” докторын дисс, УБ, 2018
37. Ш.Шагдар “Монголын боловсролын түүхэн хөгжлийн зарим асуудал” докторын дисс, УБ, 2001
38. “Шинжээчийн гарын авлага (Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэл), БМИҮЗ, 2017
39. “Шинжээчийн гарын авлага (Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл), БМИҮЗ, 2019
40. Б.Энхтуяа “Монголын дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд бенчмаркинг хэрэглэх арга зүйн зарим асуудал” докторын дисс, УБ, 2006
41. Д.Эрдэнэцэцэг “Боловсролын агуулгыг арга билгийн сэтгэлгээний үүднээс шинжлэх нь” докторын дисс, УБ, 2008
42. “Тогтвортой хөгжил-дээд боловсрол” улсын II зөвлөгөөний эмхэтгэл, БСШУСЯ, 2018
43. Монгол улсын төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, МУЗГ (2015)
44. Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам БСШУЯ (2010).
45. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ, УБ, 2019
46. Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шаардлага, шалгуур БСШУЯ (2015)
47. Дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтын зөвлөмж, БМИҮЗ, 2016
48. Жоди Золл Кусек, Рей С. Рист “Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх 10 алхам” Дэлхийн банк., 2010
49. Кирк. В. Элифин “Нийгмийн статистикийн үндэс” Орчуулсан Солонго А., Энхбат Р., бусад. УБ, 2002

50. Үр дүнд суурилсан боловсрол, БСШУСЯ, 2016
51. “Тогтвортой хөгжил – дээд боловсрол” улсын хоёрдугаар зөвлөгөөний эмхэтгэл, БСШУСЯ, 2018
52. Монгол улсын статистикийн эмхэтгэл: 2009-2018, ҮСХ
53. Боловсрол, соёл, урлаг, шинжлэх ухаан, технологийн салбарын статистикийн мэдээллийн эмхэтгэл: 2007-2019, БСШУЯ
54. Үр дүнд суурилсан боловсрол, БСШУСЯ, 2016
55. “Тогтвортой хөгжил - дээд боловсрол” улсын хоёрдугаар зөвлөгөөний эмхэтгэл, БСШУСЯ, 2018
56. Боловсрол, соёл, урлаг, шинжлэх ухаан, технологийн салбарын статистикийн мэдээллийн эмхэтгэл: 2007-2014, БСШУЯ
57. Он цагийн түүх (1998-2018), БМИҮЗ, 2018,
58. Боловсролын салбарын 2007-2015 оны хичээлийн жилийн статистикийн эмхэтгэлүүд (I), БСШУЯ
59. Монгол улсын статистикийн эмхэтгэл: 2007-2019, ҮСХ
60. Хөдөлмөрийн зах зээлийн зарим үндсэн үзүүлэлтүүд, УБСЕГ, 2016
61. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа (2013-2019), ХНХСИ

### **Хоёр. Гадаад хэлээр хэвлэгдсэн бүтээл**

1. Academy, E. Understanding Research Metrics: Journal Level, Article Level, and Author Level, 2018
2. A. Craft, " International Developments in Assuring Quality in Higher Education: Selected Papers from an International Conference", Montreal. Falmer Press, 1993.
3. A. R. Arokiasamy, "Literature Review: Service Quality in Higher Education Institutions in Malaysia", International Journal of Contemporary Business Studies Vol.3, 2012
4. Amoako-Gyampah, K. and Meredith, J.R. "The operations management research agenda: an update", Journal of Operations Management, Vol. 8, 1989
5. Avdjieva, M. and Wilson, M. "Exploring the development of quality in higher education", Managing Service Quality: An International Journal, Vol. 12, 2002
6. A. Ishizaka and A. Labib, " Analytic Hierarchy Process and Expert Choice: Benefits and Limitations", ORInsight, 22(4), 2009.

7. A. R. Rodie, & S. S. Klein, Customer participation in services production and Delivery, Int. T. A. Swartz & D. Iacobucci (Eds.), Handbook of service marketing and management, 2000.
8. Ali, N.A., Mahat, F. and Zairi, M. “Testing the criticality of HR-TQM factors in the Bart Van Looy, Paolo Landoni, Julie Callaert, Bruno van Pottelsberghe, Eleftherios Sapsalis, Koenraad Debackere “*Entrepreneurial effectiveness of European universities: An empirical assessment of antecedents and trade-offs*” Research Policy 40, 2010
9. Barbara Kalar, Bostjan Antoncic “The entrepreneurial university, academic activities and technology and knowledge transfer in four European countries”,
10. Bamberger, Rugh, Church and Fort Shoestring evaluation: designing impact evaluation under budget, time and data constraints, *American Journal of Evaluation*, Vol.25(1), 2004.
11. Bengston and Fan, An innovative method for evaluating strategic goals in a public agency: Conservation leadership. *Evaluation Review*, 23(1), 1999
12. Berg *Qualitative research methods for the social sciences*. Allyn and Bacon, 1989.
13. Bozzo Evaluation resources for non-profit organizations. *Non-profit Management and Leadership*, 10(4), 2000.
14. Badri, M.A., Selim, H., Alshare, K., Grandon, E.E., Younis, H. and Abdulla, M. “The Baldrige education criteria for performance excellence framework. Empirical test and validation”, 2006.
15. Bayraktar, E., Tatoglu, E. and Zaim, S. “An instrument for measuring the critical factors of TQM in Turkish higher education”, *Total Quality Management & Business Excellence*, Vol. 19, 2008
16. Bayraktar, E., Tatoglu, E. and Zaim, S. “Measuring the relative efficiency of quality management practices in Turkish public and private universities”, *Journal of the Operational Research Society*, Vol. 64, 2013
17. Becket, N. and Brookes, M. “Quality management practice in higher education – what quality are we actually enhancing?”, *Journal of Hospitality, Leisure, Sport & Tourism Education*, Vol. 7, 2008
18. Bhat, K.S. and Rajashekhar, J. “An empirical study of barriers to TQM. Implementation in Indian industries”, *The TQM Magazine*, Vol. 21, 2009.



19. Borahan, N.G. and Ziarati, R. “Developing quality criteria for application in the higher education sector in Turkey”, *Total Quality Management*, Vol. 13, 2002.
20. Chelimsky *The Coming Transformations in Evaluation*, in Chelimsky & Shadish (eds.) *Evaluation for the 21st century. A Handbook*. Thousand Oaks: Sage Publications.1997.
21. Cobb-Clark and Crossley *Econometrics for evaluations: an introduction to recent developments*, *The Economic Record*, Vol.78 (247), 2003.
22. Creswell *Qualitative inquiry and research design: choosing among five traditions*. Thousand Oaks, Sage Publications. 1998.
23. Cronbach *Toward reform of program evaluation: aims, methods and institutional arrangements*. San Francisco, CA, Jossey-Bass.1980.
24. Calvo-Mora, A., Leal, A. and Roldán, J.L. “Relationship between the EFQM model criteria: a study in Spanish universities”, *Total Quality Management & Business Excellence*, Vol. 16, 2005.
25. Calvo-Mora, A., Leal, A. and Roldán, J.L. “Using enablers of the EFQM model to manage institutions of higher education”, *Quality Assurance in Education*, Vol. 14, 2006
26. Chen, S-H. “The establishment of a quality management system for the higher education industry”, *Quality and Quantity*, Vol. 46, 2012.
27. Conca, F.J., Llopis, J. and Tarí, J.J. “Development of a measure to assess quality management in certified firms”, *European Journal of Operational Research*, Vol. 156, 2004.
28. Cruickshank, M. “Total quality management in the higher education sector: a literature review from an international and Australian perspective”, *Total Quality Management*, Vol. 14, 2003.
29. Curkovic, S., Melnyk, S., Calantone, R. and Handfield, R. “Validating the Malcolm Baldrige National Quality Award framework through structural equation modelling”, *International Journal of Production Research*, Vol. 38, .2000
30. Cuthbert, R. “Failing the challenge of institutional evaluation: how and why managerialism flourishes”, in Saunders, M., Trowler, P. and Bamber, V. (Eds), 2011
31. C. Guru, “Tailoring e- service quality through CRM”, *Managing Service Quality*, Vol.13, 2003.

32. C. C. Wei, "Students Satisfaction towards the University: Does Service Quality Matters?" *International Journal of Education*, Vol. 3, 2011
33. Conference on Quality Engineering and Management, University of Guimaraes (Portugal) Guimaraes, September 15-16.
34. Denzin *The research act in sociology*. Chicago, Aldine. 1970
35. Denzin and Lincoln *Handbook for qualitative research*. Thousand Oaks, Sage Publications. 2000
36. Deem, R. "The knowledge worker, the manager-academic and the contemporary UK university: new and old forms of public management?", *Financial Accountability & Management*, Vol. 20, 2004.
37. Denyer, D. and Tranfield, D. "Using qualitative research to build an actionable knowledge base", *Management Decision*, Vol. 44, 2009.
38. Dereli, T., Durmusoglu, A., Delibas, D. and Avlanmaz, N. (2011), "An analysis of the papers published in total quality management & business excellence from 1995 through 2008",
39. Detert, J.R., Schroeder, R.G. and Cudeck, R. "The measurement of quality management culture in schools: development and validation of the SQMCS", *Journal of Operations Management*, Vol. 21, 2003.
40. Dick, G.P.M., Heras, I. and Casadesús, M. "Shedding light on causations between ISO 9001 and improved business performance", *International Journal of Operations and Production Management*, Vol. 28, 2008.
41. Education, University of Goteborg, Sweden, in G. F. Madaus, M. S. Scriven, & D. L. Stufflebeam (Eds.), *Evaluation models: Viewpoints on educational and human services evaluation*. Boston: Kluwer-Nijhoff, 1987.
42. Einar Rasmussen, Øystein Moen, Magnus Gulbrandsen "*Initiatives to promote commercialization of university knowledge*" *Technovation* 26 (2006), 2006
43. Franz Tödting "*The role of universities in innovation systems and regional economies*" presentation, Expert meeting on The future of academic research, Vienna, 2006.
44. Feller and Ruegg *A Toolkit for Evaluating Public R&D Investment Models, Methods, and Findings from ATP's First Decade*, 2003.
45. Fine, Thayer, and Coghlan, A. T. Program evaluation practice in the non-profit sector. *Non-profit Management and Leadership*, 2000

46. Foss Hansen Choosing evaluation models. A discussion on evaluation design, *Evaluation*, Vol 11(4), 2005.
47. Foskett, N. “Introduction to special issue of international journal of public sector management”, *International Journal of Public Sector Management*, Vol. 23, 2010,
48. Flynn, B.B., Schroeder, R.G. and Sakakibara, S. “A framework for quality management research and an associated measurement instrument”, *Journal of Operations Management*, Vol. 11,1994.
49. Galán Zazo, J.I. “Metodología de la economía de la empresa: algunas nociones”, *Investigaciones Europeas de Dirección y Economía de la Empresa*, Vol. 12, 2006,
50. Galvagno, M. and Dalli, D. “Theory of value co-creation: a systematic literature review”, *Managing Service Quality: An International Journal*, Vol. 24, 2014.
51. Grant, D., Mergen, E. and Widrick, S. “A comparative analysis of quality management in US and international universities”, *Total Quality Management & Business Excellence*, Vol. 15, 2004.
52. Greene, Benjamin and Goodyear The merit of mixing methods in evaluation, *Evaluation*, Vol.7(1), 2001
53. Garfield E Citation indexes for science; a new dimension in documentation through association of ideas. *Science*, 1955.
54. Harvey, L. and Williams, J. “Fifteen years of quality in higher education”, *Quality in Higher Education*, Vol. 16, 2010,
55. Heras-Saizarbitoria, I. and Boiral, O. “ISO 9001 and ISO 14001: towards a research agenda on management system standards”, *International Journal of Management Reviews*, Vol. 15, 2013.
56. Hills, J.M. and Steward-David, D. “A tool for total quality management of educational provision illustrated using advanced coastal management courses”, *The TQM Magazine*, Vol. 12, 2001.
57. Harvey, L. and Newton, J. “Transforming quality evaluation: moving on”, inWesterheijden, D.F., Stensaker, B. and Rosa, M.J. (Eds), *Quality Assurance in Higher Education. Trends in Regulation, Translation and Transformation*, 2007.
58. Henkel *Tests of significance*. Series: quantitative applications in the social sciences, Sage University Paper. 1976.

59. Henry Influential evaluations, *American Journal of Evaluation*, Vol.24(4), 2003.
60. Henry, Julnes and Mark (Eds.). Realist evaluation: An emerging theory in support of practice. *New Directions for Evaluation*, no. 78. San Francisco: Jossey-Bass 1997.
61. Hoefer Accountability in action? Program evaluation in non-profit human service agencies. *Non-profit Management and Leadership*, 11(2), 2000.
62. Holsti *Content analysis for the social sciences and humanities*, Reading, MA, Addison-Wesley Publishing Company. 1969.
63. House *Assumptions Underlying Evaluation Models*. In Madaus G.F., 1989 (Eds.), *The courts, validity, and minimum competency testing*, Boston, Kluwer-Nijhoff Publishing. 1989.
64. House The future perfect of evaluation, *Evaluation Practice*, Vol. 15, 1994.
65. House Unfinished business: causes and values, *American Journal of Evaluation*, Vol. 22, 2001.
66. H. K. Wachtel, “Student evaluation of college teaching effectiveness: A brief review”. *Assessment and Evaluation in Higher Education*, 23(2), 1998.
67. Henry Etzkowitz, Andrew Webster, Christiane Gebhardt, Branca Regina Cantisano Terra “*The future of the university and the university of the future: Evolution of ivory tower to entrepreneurial paradigm*” *Research Policy*, 2000,
68. Henry Etzkowitz, Chunyan Zhou “*Building the entrepreneurial university: A global perspective*” *Science and Public Policy* 35 (9), 2008
69. Henry Etzkowitz “*Research groups as ‘quasi-firms’: The invention of the entrepreneurial university*” *Research Policy*, 2003,
70. G.S. Sureshchander, C. Rajendran, R.N. Anatharaman, "The relationship between service quality and customer satisfaction: a factor specific approach" , *Journal of Services Marketing*, Vol. 16, 2002.
71. J. G. Palli, R. and Mamilla, "Students' Opinions of Service Quality in the Field of Higher Education", *Creative Education*, Vol.3, 2012.
72. J. Lu, " Measuring cost/benefits of e-business applications and customer satisfaction", 2001.
73. Jones, O. and Gatrell, C. "Editorial: the future of writing and reviewing for IJMR", *International Journal of Management Reviews*, Vol. 16, .2014,
74. "Job Quality and Small Enterprise Development" (Series on Job Quality in Micro and Small Enterprise Development), 1999

75. J. J. Cronin, S. A. Taylor, “Measuring service quality: A re-examination and extension”, *Journal of Marketing*, Vol. 56, 1992.
76. Kaplan Strategic performance measurement and management in nonprofit organizations. *Non-profit Management and Leadership*, 11(3), 2001.
77. Kuhn *The structure of scientific revolutions*. Chicago: University of Chicago Press. Evaluation: definitions, methods and models 37 1962.
78. Kanji, G.K. and Tambi, A.M.B.A. “Total quality management in UK higher education institutions”, *Total Quality Management*, Vol. 10, 1999,
79. Kaynak, H. “The relationship between total quality management practices and their effects on firm performance”, *Journal of Operations Management*, Vol. 21, 2003,
80. Kleijnen, J., Dolmans, D., Willems, J. and van Hout, H “Does internal quality management contribute to more control or to improvement of higher education?”, *Quality Assurance in Education*, Vol. 19, 2011.
81. Koch, J.V. “TQM: why is its impact in higher education so small?”, *The TQM Magazine*, Vol. 15, 2003.
82. Kuhn, T.S. *The Structure of Scientific Revolutions*, University of Chicago Press, Chicago, IL. Lagrosen, S., Seyyed-Hashemi, R. and Leitner, M. (2004), “Examination of the dimensions of quality in higher education”, *Quality Assurance in Education*, Vol. 12, 1962.
83. Library, C. U. *Measuring your research impact: Author Impact*. 2018.
84. Loukkola, T. and Zhang, T. *Examining quality culture: Part 1-Quality assurance processes in Higher Education Institutions*, European University Association (EUA) Publications , Brussels. 2010.
85. Lockett, A., Moon, J. and Visser, W. “Corporate social responsibility in management research: focus, nature, salience and sources of influence”, *Journal of Management Studies*, Vol. 43, 2006.
86. Linderman, K., Schroeder, R.G., Zaheer, S. and Choo, A.S. “Six Sigma: a goal-theoretic perspective”, *Journal of Operations Management*, Vol. 21, 2003
87. Lo, Q-Q. and Chai, K-H. “Quantitative analysis of quality management literature published in total quality management and business excellence (1996-2010)”, *Total Quality* 2012.

88. Lam, S.Y., Lee, V.H., Ooi, K. and Phusavat, K. “A structural equation model of TQM, market orientation and service quality: evidence from a developing nation”, *Managing Service Quality: An International Journal*, Vol. 22, 2012.
89. Leviton Evaluation use: advances, challenges and applications, *American Journal of Evaluation*, Vol.24(4), 2003.
90. Lincoln and Guba *Naturalistic inquiry*. Thousand Oaks, CA: Sage. 1985.
91. Lindenberg Are we at the cutting edge or the blunt edge? Improving 2001.
92. Love The future of evaluation: Catching rocks with cauldrons. *American Journal of Evaluation*, 22(3), 2001.
93. Mark and Henry The mechanisms and outcome of evaluation influence, *Evaluation*, Vol.10(1), 2004.
94. Mark, Henry and Julnes *Evaluation: An integrated framework for understanding, guiding, and improving public and non-profit policies and programs*. San Francisco: Jossey-Bass. 2000.
95. Mohr The qualitative method of impact analysis. *American Journal of Evaluation*, 20(1), 1999.
96. Morris Ethical challenges, *American Journal of Evaluation*, Vol.22, 105 - 106. 2001.
97. McCarthy, P.M. and Keefe, T.J. “A measure of staff perceptions of quality oriented organizational performance: initial development and internal consistency”, *Journal of Quality Management*, Vol. 4, 1999.,
98. Machuca, J.A.D., González-Zamora, M.M. and Aguilar-Escobar, V.G. “Service operations management research”, *Journal of Operations Management*, Vol. 25, 2007.
99. Malhotra, M.K. and Grover, V. “An assessment of survey research in POM: from constructs to theory”, *Journal of Operations Management*, Vol. 16, 1998.
100. Manatos, M., Sarrico, C.S. and Rosa, M.J. “A systematic literature review on quality management in higher education: a trend towards integration”, 1st International 2014.
101. Molina-Azorín, J.F., Tarí, J.J., Claver-Cortés, E. and López-Gamero, M.D. “Quality management, environmental management and firm performance: a review of empirical studies and issues of integration”, *International Journal of Management Reviews*, Vol. 11, 2009.



102. Meirovich, G. and Romar, E.J. “The difficulty in implementing TQM in higher education instruction. The duality of instructor/student roles”, *Quality Assurance in Education*, Vol. 14, 2006.
103. Mergen, E., Grant, D. and Widrick, S. “Quality management applied to higher education”, *Total Quality Management*, Vol. 11, 2000.
104. Molina Fernández, L.M., Llorens Montes, F.J. and Fuentes Fuentes, M.M. “La investigación en gestión de la calidad en España (1990-1999)”, *Cuadernos de Economía y Dirección de la Empresa*, Vol. 16, 2003.
105. M. Lalovic, an Abet Assessment Model using Six Sigma Methodology, A dissertation submitted to the Division of Research and Advanced Studies of the University of Cincinnati, Department of Mechanical, Industrial and Nuclear Engineering of the College of Engineering, Belgrade University, 2002.
106. M. Tsinidou, V. Gerogiannis, and P. Fitsilis, "Evaluation of the factors that determine quality in higher education: an empirical study", *Quality Assurance in Education*, Vol. 18, 2010.
107. M. E. Malik, “The Impact of Service Quality on Students’ Satisfaction in Higher Education Institutes of Punjab”, *Journal of Management Research*, Vol. 2, 2010.
108. M.S., Owlia, E.M. Aspinall, “A framework for the dimensions of quality in higher education”, *Quality Assurance in Education*, Vol. 4, 1996.
109. Maribel Guerrero, James A. Cunningham, David Urbano “Economic impact of entrepreneurial universities’ activities: An exploratory study of the United Kingdom”, Elsevier, *Research policy* 44, 2015
110. Maribel Guerrero, David Urbano “*The development of an entrepreneurial university*”, 2010
111. Narin F, O. D. *Bibliometrics/Theory, Practice and Problems*. Web of Science, 65. 1994.
112. Newcomer Tracking and probing program performance: fruitful path or blind alley for evaluation professionals?, *American Journal of Evaluation*, Vol.22, 2001.
113. Nair, A. Meta-analysis of the relationship between quality management practices and firm performance-implications for quality management theory development”, *Journal of Operations Management*, Vol. 24, 2006.

114. N. Cavus, S. Kanbul “Designation of Web 2.0 tools expected by the students on technology-based learning environment”, *Procedia-Social and Behavioral Sciences*, 2 (2), 2010.
115. O. J. Oliveira “Adaptation and application of the SERVQUAL scale in higher education”, POMS 20th Annual Conference, Orlando, Florida U.S.A, May 1 to 4, 2009.
116. Osseo-Asare, A.E., Longbottom, D. and Chourides, P “Managerial leadership for total quality improvement in UK higher education”, *The TQM Magazine*, Vol. 19, 2007.
117. Owlia, M.S. and Aspinwall, E.M. “TQM in higher education – a review”, *International Journal of Quality & Reliability Management*, Vol. 14, 1997.
118. Owlia, M.S. and Aspinwall, E.M. “A framework for measuring quality in engineering education”, *Total Quality Management*, Vol. 9, 1998.
119. Psomas, E.L., Pantouvakis, A. and Kafetzopoulos, D.P. “The impact of ISO 9001 effectiveness on the performance of service companies”, *Managing Service Quality: An International Journal*, Vol. 23, 2013.
120. “Promoting the Culture Sector through Job Creation and Small Enterprise Development in SADC Countries: The Music Industry” (Series on Upgrading in Small Enterprise Clusters and Global Value Chains), Cecile Lambert, 2003
121. Poh-Pam Wong, Yuen-Ping Ho, Annette Singh “Towards an “Entrepreneurial university” model to support knowledge-based economic development: The case of the National University of Singapore” *World Development* Vol.35, 2007
122. P. Wolf, A. Hill, F. Evers, *Handbook for Curriculum Assessment*, winter 2006,
123. Patton *Practical Evaluation*. Newbury Park: Sage Publications. 1982.
124. Patton *Utilization-focused evaluation: The new century text (3rd ed.)*. Thousand Oaks, CA: Sage Publications. 1997.
125. Poole, Nelson, Carnahan, Chepenik and Tubiak Evaluating performance measurement systems in non-profit agencies: The program accountability quality scale (PAQS). *American Journal of Evaluation*, 21(1), 2000.
126. Pratt, McGuigan and Katzev Measuring program outcomes: Retrospective pretest methodology. *American Journal of Evaluation*, 21(3), 341-349. 2000.
127. Quality Management in Curriculum Development and Delivery in African Universities Cheserek.pdf



128. Rosa, M., Sariva, P.M. and Diz, H. “Excellence in Portuguese higher education institutions”, *Total Quality Management & Business Excellence*, Vol. 14, 2003.
129. Rosa, M.J. and Amaral, A. “A self-assessment of higher education institutions from the perspective of the EFQM excellence model”, in Westerheijden, D.F., Stensaker, B. And Rosa, M.J. (Eds), *Quality Assurance in Higher Education. Trends in Regulation, Translation and Transformation*, pp. 2007.
130. *Reconceptualising Evaluation in Higher Education: The Practice Turn*, SRHE and Open University Press, Buckingham,
131. Renz Changing the face of nonprofit management. *Nonprofit Management and Leadership*, 11(3), 2001.
132. Rist *Program evaluation and the management of government*. Transaction Publishers. 1990.
133. Rossi and Freeman *Evaluation. A Systematic Approach*. Newbury Park: Sage Publications. 1993.
134. Rossi, Lipsey and Freeman *Evaluation: a systematic approach*. Thousand Oaks, Sage Publications. 2004.
135. Ryan Advantages and challenges of using inclusive evaluation approaches in evaluation practice. *American Journal of Evaluation*, 19(1), 1998.
136. *Skills of the future: How to thrive in the complex new world*, 2015
137. S. Lagrosen, R. S. Hashemi, & M. Leitner, "Examination of the dimensions of quality in higher education", *Quality Assurance in Education*, Vol. 12 Iss: 2, 2004.
138. S. Nyeck, M. Morales, R. Ladhari, & F. Pons, "10 years of service quality measurement: reviewing the use of the SERVQUAL instrument." from EBSCO host database. July 8, 2007.
139. S. M. Gilani, J.Ahmed, M. A. Abbas, "Electronic Document Management: A Paperless University Model", 2009.
140. Sawhill and Williamson Mission impossible? Measuring success in nonprofit organizations. *Nonprofit Management and Leadership*, 11(3), 2001.
141. Scriven Pros and Cons about Goal-free Evaluation, *The Journal of Educational Evaluation*, Vol. 4, 1972.
142. Scriven. *Evaluation thesaurus*. Beverly Hills, CA, SAGE Publications, 1991.
143. Shadish, Cook and Leviton *Foundations of Program Evaluation: Theories and Practice*. Newbury Park, SAGE Publications. 1991.

144. Shadish, Newman, Scheirer and Wye *Guiding principles for evaluators*, New Directions for Program Evaluation, N.66, San Francisco, CA, Jossey-Bass. 1995.
145. Smith Evaluation: Preview of the future #2. *American Journal of Evaluation*, 22(3), 2001.
146. Sonnichsen *High impact internal evaluation*. Thousand Oaks, sage Publications. 2000.
147. Stake *Program evaluation, particularly responsive evaluation*. Keynote address at the conference “New trends in evaluation,” Institute of 1973.
148. Stake How far dare an evaluator go towards saving the worlds, *American Journal of Evaluation*, Vol.25(1), 2004.
149. Stufflebeam The metaevaluation imperative, *American Journal of Evaluation*, Vol.22, 183-209. 2001.
150. Sahney, S., Banwet, D.K. and Karunes, S. “An integrated framework of indices for quality management in education: a faculty perspective”, *The TQM Magazine*, Vol. 20, 2008.
151. Sakthivel, P.B. and Raju, R. “Conceptualizing total quality management in engineering education and developing a TQM educational excellence model”, *Total Quality Management & Business Excellence*, Vol. 17, 2006.
152. Sakthivel, P.B., Rajendran, G. and Raju, R. “TQM implementation and students’ satisfaction of academic performance”, *The TQM Magazine*, Vol. 17, 2005.
153. Saraph, J.V., Benson, P.G. and Schroeder, R.G. “An instrument for measuring the critical factors of quality management”, *Decision Sciences*, Vol. 20, 1989.
154. Sila, I. and Ebrahimpour, M. “Examination and comparison of the critical factors of total quality management (TQM) across countries”, *International Journal of Production Research*, Vol. 41, 2003.
155. Sohail, M.S., Rajadurai, J. and Rahman, N.A.A. “Managing quality in higher education: a Malaysian case study”, *International Journal of Educational Management*, Vol. 17, 2003.
156. Srikanthan, G. and Dalrymple, J.F. “A conceptual overview of a holistic model for quality in higher education”, *International Journal of Educational Management*, Vol. 21, 2007.

157. Stensaker, B., Rosa, M.J. and Westerheijden, D.F. “Conclusions and further challenges”, in Westerheijden, D.F., Stensaker, B. and Rosa, M.J. (Eds), *Quality Assurance in Higher Education. Trends in Regulation, Translation and Transformation*, 2007.
158. Sultan, P. and Wong, H.Y. “An integrated-process model of service quality, institutional brand and behavioural intentions: the case of a university”, *Managing Service Quality: An International Journal*, Vol. 24, 2014.
159. Tambi, A.M.B.A., Ghazali, M.C. and Yahya, N.B. “The ranking of higher education institutions: a deduction or delusion?”, *Total Quality Management & Business Excellence*, Vol. 19, 2008.
160. Tarí, J.J. “Research into quality management and social responsibility”, *Journal of Business Ethics*, Vol. 102, 2011.
161. Teelken, C. “Compliance or pragmatism: how do academics deal with managerialism in higher education? A comparative study in three countries”, *Studies in Higher Education*, Vol. 37. 2012.
162. Teelken, C. and Lomas, L. “How to strike the right balance between quality assurance and quality control in the perceptions of individual lectures: a comparison of UK and Dutch higher education institutions”, *Tertiary Education and Management*, Vol. 15, 2009.
163. Thorpe, R., Holt, R., Macpherson, A. and Pittaway, L. “Using knowledge within small and medium-sized firms: a systematic review of the evidence”, *International Journal of Management Reviews*, Vol. 7, 2005.
164. Tranfield, D., Denyer, D. and Smart, P. “Towards a methodology for developing evidenceinformed management knowledge by means of systematic review”, *British Journal of Management*, Vol. 14, 2003.
165. Thompson *Benefit-cost analysis for program evaluation*. Beverly Hills, Sage Publications. 1980.
166. Torres and Preskill *Evaluation and organizational learning: Past, present, and future. American Journal of Evaluation*, 22 (3), 2001.
167. Tyler *Basic Principles of Curriculum and Instruction*. Chicago, MA, University Chicago Press. 1949.
168. *Total Quality Management & Business Excellence*, Vol. 22,
169. “The determinants of retail productivity: a critical review of the evidence”, *International Journal of Management Reviews*, Vol. 12,

170. T .L. Saaty, L.G. Vargas, Models, Methods, Concepts & Applications of the Analytic Hierarchy Process, Kluwer’s Academic Publishers, Boston, USA, 2001.
171. The Future of Jobs: Employment, Skills and Workforce Strategy for the Fourth Industrial Revolution, WEF, 2016
172. Venkatraman, S. “A framework for implementing TQM in higher education programs”, Quality Assurance in Education, Vol. 15, 2007.
173. Voss, C., Tsikriktsis, N., Funk, B., Yarrow, D. and Owen, J. “Managerial choice and performance in service management-a comparison of private sector organizations with further education colleges”, Journal of Operations Management, Vol. 23, 2005
174. Van der Knaap Policy Evaluation and Learning. Feedback, Enlightenment or Augmentation?, *Evaluation*, Vol. 1 (2), 1995.
175. Vedung *Public policy and program evaluation*, London, Transaction Publishers. 1997.
176. Wolf, P. and J. Christensen Hughes (Eds). Curriculum Development in Higher Education: Faculty Driven Processes and Practices. New Directions for Teaching and Learning. Volume 112, 2015
177. Webb, Campbell, Schwartz and Sechrest *Unobstrusive measures: nonreactive easures in the social sciences*. Chicago, Rand McNally. 1966.
178. Weimer and Vining *Policy Analysis: Concepts and Practice*. Englewood Cliffs, New Jersey, Prentice Hall. 1992.
179. Wholey Managing for results: Roles for evaluators in a new management era. *American Journal of Evaluation*, 22(3), 2001.
180. Wolcott *The art of fieldwork*. Walnut Creek, CA, Altamira Press. 1995.
181. Waugh, R.F. “Academic staff perceptions of administrative quality at universities”, Journal of Educational Administration, Vol. 40, 2002.
182. Z. Yang, L. Yan-ping and T. Jie,” Study on Quality Indicators in Higher Education: An Application of The SERVQUAL Instrument” IEEE publications, Service Systems and Service Management International Conf., Vol. 2, 2006.

#### Гурав. Интернэт эх үүсвэрүүд

1. <https://www.timeshighereducation.co.uk>
2. <https://www.shanhairanking.com>

3. <https://www.univcan.ca>
4. <https://www.highimpactuniversities.com>
5. <https://www.topuniversities.com>
6. <https://www.multirank.org>
7. <https://www.topuniversities.com>
8. <https://www.usnews.com>
9. <http://www.heeact.edu.tw>
10. <https://www.universityrankings.ch>
11. <https://www.timeshighereducation.com>
12. <http://nacte.org.pk>
13. <http://naeac.org>
14. <http://www.nbeac.org.pk>
15. <http://www.nceac.org>
16. <http://www.ntc-hec.org.pk>
17. <http://pakistanbarcouncil.org>
18. <http://pcatp.org.pk>
19. <https://www.pharmacycouncil.org.pk>
20. <http://www.pec.org.pk>
21. <http://www.pmdc.org.pk>
22. <http://pnc.org.pk>
23. <http://pvmc.org.pk>
24. <http://nchpakistan.gov.pk>
25. <http://www.nct.gov.pk>
26. <http://mecss.gov.mn>
27. <http://www.herp.mn>
28. <http://ontarioedudevelopers.wikispaces.com>
29. <http://www.saea.uottawa.ca>
30. <http://cfl.mcmaster.ca>
31. <http://www.ilo.org>
32. <http://accmon.mn>
33. <http://www.legalinfo.mn>
34. <http://www.1212.mn>
35. <https://flsc.ca/law-schools>
36. <http://oxforddictionaries.com>
37. <https://ec.europa.eu>
38. <http://ips.clarivate.com>